



Legum servi esse debemus, ut Liberi esse possimus

ХУУЛЬ ЗҮЙН ЭРГЭМ ШИНЖЛЭГЭЭ, СУДАЛГАА, ОНОЛ, ПРАКТИКИЙН СӨТГҮҮЛ

ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС

ЭНЭ ДУГААРТ:

- Гэр бүлийн эрх зүйн зарим төрлийн харилцаа
- Банкны эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал
- Солонгосын санхүүгийн эрх зүйн чиг хандлага болон тулгамдсан асуудал
- ОХУ-ын банкны үйл ажиллагааны эрүүгийн эрх зүйн хамгаалалтын онцлог
- Хуулийн этгээдэд эрүүгийн эрх зүйн шинжтэй арга хэмжээг хэрэглэх нь
- Онц байдал, түүний эргэн тойронд
- Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь өмгөөлөх, өмгөөлүүлэх эрх

Төрийн байгуулалтын хууль тогтоомж

ЧИНГИС МОНГОЛЫН НЭГДСЭН УЛС
БАЙГУУЛАХЫН ТӨЛӨӨ ТЭМЦЭЛД
ТАГНУУЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ
АШИГЛАСАН НЬ ТЭГ-ын дээд сургуулийн
Гүйцэтгэх ажлын тэнхимийн эрхлэгч

/М.Цогтоо/.....4

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ
Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах
хэлтсийн мөрдөн байцаагч, комиссар,
докторант /Д.Золжаргал/.....8

ТӨРИЙН АЛБАН ДАХЬ АШИГ СОНИРХЛЫН
ЗӨРЧЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ
"Засаглалыг дэмжих төсөл"-ийн зөвлөх
/П.Өнөрмаа/.....10

Иргэний хууль тогтоомж

ГЭР БҮЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗАРИМ ТӨРЛИЙН
ХАРИЛЦАА ХЗҮТ-ийн Иргэний хууль
тогтоомжийн секторын эрдэм шинжилгээний
ажилтан, хууль зүйн магистр /О.Отгонтуяа/.....16

ХӨДӨЛМӨРИЙН ХУУЛИЙГ ҮР ДҮНТЭЙ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ
ОХУ-ын Эрхүү мужийн Байгалийн эдийн
засаг, эрх зүйн Улсын их сургуулийн аспирант
/С.Боловсон/.....21

МОНГОЛ УЛСЫН ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ
ЗЭЭЛИЙН ТӨЛӨВШИЛ, ТУЛГАМДСАН
АСУУДАЛ Санхүүгийн зохицуулах хорооны
 гишүүн, дэд дарга /Д.Дүгэржав/.....24

БАНКНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ МУИС-ийн Хууль
зүйн сургуулийн Төр, захиргааны эрх зүйн
тэнхимийн багш (Ph.D) /Г.Банзрагч/.....32

ӨРСӨЛДӨӨНИЙ ЭРХ ЗҮЙ ДЭХ КАРТЕЛИЙН
АСУУДАЛ, ТҮҮНТЭЙ ТЭМЦЭХ АРГА ЗАМ
Шихихутуг Хууль зүйн сургуулийн багш,
магистрант /С.Батбуян/.....38
ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙ ДЭХ ИРГЭН, ХУУЛИЙН
ЭТГЭЭДИЙН ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТ Хан-
Уул дүүргийн нотариатч /С.Цэнд/.....43
ГЭР БҮЛИЙН ХОЛБОГДОЛТОЙ ХЭРЭГ
ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ
ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТҮҮХЭН
УЛАМЖЛАЛ Цагдаагийн академийн
магистрант /Ц.Мөнхзул/.....44

Олон улсын эрх зүй, харьцуулсан эрх зүй

СОЛОНГОСЫН САНХҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН
ЧИГ ХАНДЛАГА БОЛОН ТУЛГАМДСАН
АСУУДАЛ Корё Их сургуулийн профессор,
Санхүүгийн эрх зүйн нийгэмлэгийн тэргүүн
/Жон Чан Хён/.....49

ОХУ-ЫН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТЫН
ОНЦЛОГ Хууль зүйн шинжлэх ухааны доктор,
профессор, Ази номхон далайн орнуудын
харьцуулсан эрх зүйн төвийн шинжлэх
ухаан, судалгааны лабораторийн эрхлэгч,
Буриадын Улсын их сургуулийн Хууль зүйн
факультетын Эрүүгийн болон эрүүгийн
байцаан шийтгэх эрх зүйн тэнхимийн эрхлэгч
/Гармаев Юрий Петрович/.....52

ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛТ, ТУСЛАЛЦАА
ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Мэргэжилтэн /Ийзүка Миха/.....56

Криминологи

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ
ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ
Нийслэлийн шүүхийн Эрүүгийн хэргийн
танхимын тэргүүн /Б.Сарантуяа/.....58

ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН
ШИНЖТЭЙ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЛЭХ
НЬ ХЗҮТ-ийн Криминологийн судалгааны
секторын эрдэм шинжилгээний ажилтан,
хууль зүйн магистр /Б.Одонгэрэл/.....61

ОНЦ БАЙДАЛ, ТҮҮНИЙ ЭРГЭН ТОЙРОНД
ХЗҮТ-ийн Криминологийн судалгааны
секторын эрдэм шинжилгээний ажилтан,
хууль зүйн магистр /Г.Оюунболд/.....64

Эрх зүйн үйлчилгээ

НОТАРИАТААР ГЭРЭЭГ ГЭРЧЛҮҮЛЭХ
ХУУЛЬ ЗҮЙН АЧ ХОЛБОГДОЛ
Хуульч /Ч.Баянжаргал/..... 71

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ
АЖИЛЛАГААН ДАХЬ ӨМГӨӨЛӨХ,
ӨМГӨӨЛҮҮЛЭХ ЭРХ Нийслэлийн шүүхийн
шүүгч /Ц.Батцэрэн/..... 73

Монгол Улсын дээд шүүхийн тогтоол

ЭД ХӨРӨНГӨ ӨМЧЛӨХ ЭРХ, ТҮҮНТЭЙ
ХОЛБООТОЙ ЭД ХӨРӨНГИЙН УЛСЫН
БУРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ
ЗҮЙЛ, ХЭСЭГ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ
ТУХАЙ /Монгол Улсын дээд шүүхийн 2008
оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 45 дугаар
тогтоол/.....83

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХАРИЛЦААГ
ЗОХИЦУУЛСАН ХУУЛИУДЫН ЗАРИМ ЗҮЙЛ
ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ /Монгол
Улсын дээд шүүхийн 2008 оны 11 дүгээр сарын
25-ны өдрийн 47 дугаар тогтоол/.....86

CONTENTS:

State organization legislation

CHINGGIS USED THE INTELLIGENCE OPERATION IN THE STRUGGLE FOR ESTABLISHMENT OF MONGOLIAN EMPIRE. /M.Tsogtoo/ Head of executive work department of Central intelligence institute..... 4

THE PRESS FREEDOM /D.Zoljargal/ Inspector Independent Authority against Corruption, Ph.D candidate.....8

THE LEGAL REGULATION ON CONFLICTS OF INTERESTS IN STATE SERVICE /P.Unurmaa/ Advisor of Government supporting project.....10

Civil legislation

SOME RELATIONS OF THE FAMILY LAW /O.Otgontuya/ Researcher of Civil Legislation sector, NLC, Master of Law.....16

SOME ISSUES ON EFFECTIVELY IMPLEMENTATION OF LABOR LAW /S.Bolovson/ /Ph.D/, law and economy university of Irkutsk in Russian Federation.....21

THE FORMATION AND PROBLEMATIC ISSUES ON SECURITY MARKET OF MONGOLIA /D.Dugerjav/ member of Finance regulation committee, Deputy chairman.....24

THE CURRENT SITUATION ON BANKING LAW REGULATION /G.Banzragch/ (Ph.D), Lecturer of State and administration department, School of Law, National University of Mongolia.....32

ISSUES ON CARTEL AND THE WAYS TO RIGHT AGAINST IT IN COMPETITION LAW /S.Batbuyan/ teacher of Shihikhutug Law Institute, master student.....38

LEGAL PROTECTION ON CITIZEN AND LEGAL ENTITY IN CIVIL LAW /S.Tsend/ Notary of Khan-Uul district.....43

HISTORICAL TRADITION ON LEGAL REGULATION ON FAMILY LAW PROCEDURE /Ts. Munkhzul/ Master student of Police Academy.....44

International Law and comparative law

RECENT TRENDS AND PROBLEMATIC ISSUES ON FINANCIAL LAW IN KOREA /Chan-Hyung Chung/ Professor, College of

Law, Korea University and Director of Korea Association of Financial Law..... 49

SPECIALITY OF LEGAL PROTECTION OR BANK ACTIVITIES UNDER CRIMINAL LAW OF RUSSIAN FEDERATION /Garmaev yuri petrovich/ /Sc.D/ and professor, Head of science and research laboratory of comparative law center in Asia and Pacific country, Head of Criminal law and criminal law procedure department Buryat State University of Russia..... 52

THE IMPLEMENTATION AND OUTCOME OF PROJECT ON LEGAL REFORM AND ITS ASSISTANCE, SPECIALIST /Izuka Miha/... 56

Criminology

THE SITUATION OF SETTLED CRIMES ON HUMAN TRAFFICKING BY COURT /B.Sarantuya/ The Head of Criminal department of city court.....58

TO USE CRIMINAL SANCTIONS FOR THE LEGAL ENTITY /B.Odongerel/ Researcher of Criminology sector, NLC, Master of Law.....61

STATE OF EMERGENCY AND SOME ISSUES SURROUNDING IT /G.Oyunbold/ Researcher of Criminology sector, NLC, Master of Law.....64

Legal service

LEGAL BENEFIT OF WITNESSING CONTRACT BY NOTARY /Ch.Bayanjargal/ Lawyer.....71

RIGHTS TO DEFEND AND TO BE DEFENDED IN CRIMINAL PROCEDURE /Ts.Battseren/ Judge of criminal department of City Court.....73

Supreme Court's resolution

INTERPRETATION ON SOME PROVISIONS, ARTICLES, PARAGRAPHS OF LAW ON STATE REGISTRATION OF RIGHT TO PROPERTY AND IT'S RELATED ASSETS.....83

INTERPRETATION ON SOME PROVISIONS, ARTICLES PARAGRAPHS OF LAWS REGULATING SOCIAL INSURANCE RELATIONS.....86

СОНИН, СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:

Академич Ж.Амарсанаа

Сонин, сэтгүүлийн зөвлөлийн дарга

ГИШҮҮД:

- А.Баасан** - Хууль зүйн шинжлэх ухааны доктор, “Отгонтэнгэр” их сургуулийн эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал
- Г.Банзрагч** - Хууль зүйн доктор, Хууль зүйн үндэсний төвийн Хууль зүйн сургалтын төвийн эрхлэгч
- Ц.Батцэрэн** - Нийслэлийн шүүхийн шүүгч
- Ж.Бямбаа** - Хууль зүйн доктор, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн Эрүүгийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч
- А.Бямбаа** - Хууль зүйн доктор, Улсын дээд шүүхийн шүүгч
- Н.Гантулга** - Хууль зүйн доктор, Цагдаагийн академийн тэргүүн дэд захирал
- Д.Даваа-Очир** - Хууль зүйн доктор, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 461 дүгээр ангийн дарга
- Д.Зүмбэрэлхам** - Хууль зүйн доктор, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх, Хууль зүйн үндэсний төвийн Криминологийн судалгааны секторын эрхлэгч
- Т.Мөнхжаргал** - Хууль зүйн доктор, Философи, социологи, эрх зүйн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан
- Т.Мэндсайхан** - Хууль зүйн доктор, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн Олон улсын эрх зүйн тэнхимийн эрхлэгч
- А.Оюунчимэг** - Монголын нотариатчдын танхимын ерөнхийлөгч
- Ц.Сарантуяа** - Хууль зүйн шинжлэх ухааны доктор, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш
- Б.Цэрэнбалтав** - Улсын ерөнхий прокурорын орлогч
- С.Цэрэндорж** - Хууль зүйн доктор, Монголын өмгөөлөгчдийн холбооны дэд ерөнхийлөгч
- Б.Чимид** - Ардын багш, гавъяат хуульч, хууль зүйн доктор, профессор, Хууль зүйн үндэсний төвийн эрдэмтэн нарийн бичгийн дарга
- Ч.Энхбаатар** - Хууль зүйн шинжлэх ухааны доктор, Удирдлагын академийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч

Дугаарыг эрхэлсэн:

Б.Солонго - Сэтгүүлийн хариуцлагатай нарийн бичгийн дарга

Эрхлэн гаргасан:

Хууль зүйн үндэсний төв

Редакцын хаяг:

Улаанбаатар -46, Чингэлтэй дүүрэг,
Сүхбаатарын талбай-7

Утас:

315735

Факс:

315736

Веб сайт:

www.legalcenter.mn

И-мэйл:

magazine_info@legalcenter.mn

Улсын бүртгэлийн дугаар:279



Тагнуулын ерөнхий газрын
дээд сургуулийн Гүйцэтгэх
ажлын тэнхимийн эрхлэгч
М. ЦОГТО

Тусгай албад буюу гадаад тагнуул, сөрөг тагнуулын гэх мэт тагнуулын байгууллага нь тухайн улсын нийгэм-улс төрийн тогтолцоо, тэнд ноёрхогч үзэл суртлаас үл хамааран улс бүрд заавал байдаг төрийн механизмын нэн чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Тийм болохоор тусгай албагүй улс гэж байдаггүй.

Тагнуулын үйл ажиллагаа нь аюулгүй байдлаа хангах, болзошгүй дайсныхаа далд эрмэлзэл, аюул заналыг түүнд мэдэгдэлгүйгээр урьтан мэдэж, сэргийлэх, хамгаалахаас үүдэлтэй.¹

Хэдийгээр аль ч улсын тусгай албад тагнуулч, туршуул болон тагнуулын тусгай арга, хэрэгсэл ашигладаг нийтлэг, ижил төсөөтэй талуудтай ч тэдгээр нь бас өөр өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой. Тэдгээр өвөрмөц онцлог нь тухайн орны гадаад, дотоод нөхцөл байдал, улс төрийн тогтолцоо, дэглэм болон улс төрийн бодлого тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэх, Үндэсний аюулгүй байдлыг хангахад цэрэг

1. "Очерки внешней разведки" под редакцией академика Е.М.Примакова, Москва, 1986, С.13

ЧИНГИС МОНГОЛЫН НЭГДСЭН УЛС БАЙГУУЛАХЫН ТӨЛӨӨ ТЭМЦЭЛД ТАГНУУЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ АШИГЛААСАН НЬ

арми, тусгай албадын оролцоо, эзлэх байр суурь, гадаад тагнуул, сөрөг тагнуулын гэх мэт байгууллагын түүхэн уламжлал, туршлага гэх мэт олон хүчин зүйлээр тодорхойлогддог.

Монгол Улсын тусгай албад, тэдгээрийн үйл ажиллагаа нь дээрх нийтлэг хүчин зүйлээс ангид байсангүй. Өөрөөр хэлбэл Монголын тусгай албадын үүсэл, хөгжил, үйл ажиллагаа нь Монгол Улсын түүхэн хөгжилтэй салшгүй холбоотой юм. Монголын тусгай албадын гүйцэтгэж байсан үүрэг, зорилт, үйл ажиллагааны цар хүрээ, хүчин чадал, улс төрийн тогтолцоо ба үндэсний аюулгүй байдлыг хангахад эзэлж байсан байр суурь нь Монгол төр улсын хөгжил, хүчин чадал, гадаад, дотоод бодлого, дэлхийн улс төр, эдийн засгийн бодлогод эзэлж байсан байр суурь, нөлөө, улс орны дотоод нөхцөл байдал зэрэг олон хүчин зүйлээр тодорхойлогдож байжээ.

Монголд тагнуулын үйл ажиллагаа үүсч хөгжсөн нь бүр эртний улбаатай юм. Монгол угсаатны эртний Их Нирун улсын байлдах арга тактик, мэхийн тухай хятад эх сурвалжуудад "... харгулсан буюу тагнах гэх мэт хэллэг байна"² гэж академич, нэрт түүхч агсан Т.Сүхбаатар дурджээ. Их Нирун улсыг мөхөөсөн Түрэг улсын түүх, ялангуяа дайн байлдааны түүхийн зарим асуудлыг

2. Т.Сүхбаатар, "Их Нирун улс" (330-555 он), УБ., 1992 он, 108 дахь тал.

өгүүлсэн Тяньюкийн хөшөөний бичээсэнд "...мэдээ чимээ хураа", "...туршуул ирж хэлсэн нь...", "гурван туршуул ирэв. Тэдний мэдээ нэгэн адил авай"³ гэх мэтийг өгүүлсэн нь 550-иад онд хамаарах аж.

Монголд тагнуулын үйл ажиллагаа үүсч, хөгжихөд Монголчуудын дотоод, гадаад нөхцөл байдал, тухайлбал, дотоод шалтгаан нь аймгуудын хоорондын зөрчил, тэмцэл, байлдаан тулалдаан; гадаад шалтгаан нь бусад улсаас Монголчуудын эсрэг болон Монголчуудаас тэдгээрийн эсрэг явуулж байсан далд бодлого, төлөвлөгөө, цэрэг дайны болон бусад үйл ажиллагаа байсан гэж үзэж болох байна.

Эртний Монгол аймгууд хоорондоо дайтах нь цөөнгүй байснаас гадна Хонгирад зэрэг зарим хүчирхэг аймгад Зүрчидийн Алтан улстай байлдаад ялж байсан ч удаатай⁴ юм. Гадаадаас ч Монголчуудад учрах аюул, занал ч мундахгүй байв. Тухайлбал, 1130-аад онд Хабул хаантай хамаг Монгол улс байгуулагдаж, түүний хаанчлах хугацаанд Алтан улс Хамаг Монгол улсыг "цэргээр довтлон цохих", "Монголчуудыг монголоор нь устгуулах", "идэрчүүдийг нь хороох", "ихэс дээдсийг нь янз бүрийн аргаар барьж авч, илжгэнд хадаж

3. Т.Сүхбаатар, "Монголын түүхийн дээд бичиг" тэргүүн дэвтэр, УБ., 1992 он, 60 дахь тал.

4. Ч.Далай, "Монгол Улсын түүх". Дэд боть, УБ., 2003 он, 51 дэх тал.

цаазах” зэргээр устгах үйл ажиллагааг тасралтгүй явуулж байжээ.⁵ Тухайлбал, 1135 онд Алтан Улс Хамаг Монгол Улсад гэнэдүүлэн халдан довтолж, ихээхэн хохирол учруулсан⁶, түүнчлэн Хабул хааны ахмад хүү Охинбархад⁷ болон Амбагай хааныг татаруудаар бариулж, Алтан Улсад авчран тарчлаан зовоожцаазалсан⁸ гэхмэт баримт дурдаж болно. Монголчууд ч тэдний эсрэг цэрэг дайны болон бусад аргаар тэмцэж байжээ. Жишээ нь, Алтан Улсын гар, хөл болж, “Монголчуудыг монголоор нь устуулах”, Алтан Улсын бодлогыг хэрэгжүүлэхэд тусалж байсан Татаруудын эсрэг Хамаг Монгол Улсын хаан Хотула 13 удаа байлдаан боловч Амбагай хааны өшөөг авч чадсангүй гэж Монголын нууц товчоонд дурджээ.⁹

Хотулын хаанчлалын үед Зүрчидийн Алтан Улс Хамаг Монгол Улсын эсрэг 3 удаагийн халдан довтолсныг Хотула хааны цэрэг бут цохиж байв.¹⁰

Монгол Улс Татарын хооронд 70 жил үргэлжилсэн тэмцэл, дайн тулаан 1202 онд Тэмүүжин Татарыг бүрмөсөн байлдан дагуулснаар төгссөн байна.¹¹

Тэмүүжин бүх Монгол овогтныг нэгтгэх тэмцэл явуулсан 1185-1206 онд их, бага 32 удаагийн дотоодын байлдаан, тулалдааныг өнгөрөөсөн гэж “Монгол Улсын түүх”-ийн дэд ботид дурджээ.¹²

Тэмүүжин тийнхүү монгол

аймгуудыг нэгтгэхдээ өөрийн өмнөх үеийн монголчуудын цэрэг дайны арга туршлагад тулгуурлан цэрэг, зэвсгийн хүчээ гадна тагнан турших, хуурч мэхлэх буюу өнөөгийн тагнуулын мэргэжлийн үг хэллэгээр хуурч төөрөгдүүлэх болон дайснаа хагалан бутаргах, зөрчил, тэмцлийг нь ашиглах гэх мэт аргыг хэрэглэж байсан тухай мэдээ баримт цөөнгүй байна.

1196 онд Алтан Улс, Татарын хооронд дайн үүсч, Татарын Мэгүжин Сүүлт ялагдан хүчээ нөхөнсэлбэхийг оролдож байгааг мэдсэн Чингис Тоорил хаантай хамтран тэднийг сөнөөсөн. “Тэмүүжиний цэрэг дайны анхны энэхүү том амжилтын үндсэн шалтгааны дотор түүний тулсаалаар дайсны цэргийн байр байдлыг нарийвчлан заншиж байсан явдал зүй ёсоор орно.”¹³ гэж эрдэмтэн Эринжен Хара-Даваан өгүүлжээ.

Хэрэйдийн Ван хантай шийдвэрлэх тулаан хийхийн өмнө Чингисийн талд зугтан ирсэн дүү Хасарынхаа нэрийг ашиглан түүний элчийн дүрээр Халиудар, Чахурхан нарыг Ван ханд турушуулаарилгээж, “Ванхан болгоомж ажиггүй, алтан тэрэг босгоод хуримлаж байгаа”¹⁴ тандан мэдсэнийхээ дараа тэдэн рүү гэнэдүүлэн довтолж, Хэрээд аймгийг үндсэнд нь сөнөөсөн байна. Харьцангуй цөөхөн цэрэгтэй байсан Тэмүүжин Найман Улстай байлдахын өмнөх хэд хоногт шөнийн цагт цэрэг бүр таван хэсэг гал түлэх тушаал өгснөөр Найманы туршуулууд түүнд хууртагдан Монгол цэрэг тэнгэрийн одноос олон байна гэсэн мэдээг Таян

хандаа хүргэжээ.¹⁵

Нууц товчоонд Чингис юу ярилцсаныг нь дурдаагүй, Туркестаны худалдаачин Хасантай хийсэн нууцлаг уулзалт 1204 он буюу Монгол аймгуудыг нэгтгэхийн төлөө тэмцлийн үед хийсэн нь тэр үед түүнийг өрсөлдөгчдөө тагнах зорилгод ашиглаж байсан ч байж болох юм. Академич Ш.Нацагдорж “Чингис Таян хааны төлөвлөгөөг мэдмэгц ... Дундад Азийн худалдаачдаар дамжуулан Найманы улс төр, цэргийн байдлыг тагнан мэдэхийн хамт өөрийн цэргийн хүчийг эмхлэн цэгцлэв”¹⁶ гэжээ. Энэ нь Чингис Монгол аймгуудыг нэгтгэх тэмцэлдээ Дундад Азийн худалдаачдыг тагнуул хийхдээ ашигладаг байсныг нотолж байна. Тийнхүү Тэмүүжин бүр монгол туургатныг нэгтгэх тэмцлийнхээ явцад цэргийн урлаг, түүний чухал хэсэг болох тагнуулын ажил явуулах арга ухаан, туршлагатай болсон нь тодорхой байна.

Монгол аймгуудыг нэгтгэхийн төлөө Тэмүүжин алхинч ашиглаж байсан тухай баримтыг Монголын нууц товчоонд нэг бус удаа дурдсан байдаг. Тэмүүжин эсрэг талаа тагнан турших үйл ажиллагаандаа “Алхинч”-ийг өргөн ашигладаг байжээ. Монголын нууц товчооны 171, 183, 193, 208, 247, 257, 273, 275, 276, 281 гэх мэт 10 гаруй зүйлд “Алхинч” ашигласан тухай өгүүлсэн байна. “Алхинч” гэдэг үгийг Монгол үгсийн язгуурын тольд “мэдээ занги авагч” гэсэн утгатай манж гаралтай хэмээн тайлбарласан байна¹⁷. Монголын нууц товчоо судлаач манай нэрт эрдэмтэн Ц.Дамдинсүрэн,

5. Мөн тэнд, 55 дахь тал.

6. Мөн тэнд, 57 дахь тал.

7. “Монголын нууц товчоо”, § 53

8. Лувсанданзан, “Алтан товч”, УБ., 1990 он, 18 дахь тал

9. “Монголын нууц товчоо”, § 58

10. Редактор Ч.Далай, “Монгол Улсын түүх” Дэд боть, УБ., 2003 он, 62 дахь тал

11. Мөн тэнд, 61 дэх тал

12. Мөн тэнд, 95-96 дахь тал

13. Эринжен Хара-Даваан, “Сод жанжин Чингис хаан, түүний үлдээсэн өв”,

Ч.Баатар, Н.Ням-Очир нарын орчуулга.

УБ., 2003 он. 34 дэх тал

14. Монголын нууц товчоо, §183-185.

15. Ш.Нацагдорж, “Чингис хааны цаг”, УБ., 1991 он, 83 дахь тал

16. Мөн тэнд.

17. “Монгол үгсийн язгуурын толь”. Өвөрмонголын хэвлэлийн хороо. 1998 он. 101 дэх тал

Ш.Гаадамба, Д.Цэрэнсодном зэрэг эрдэмтэн уг үгийг "туршуулч", "тагнуул", "мэдээ чимээ сураглах хүн", "харуул", "тэргүүн хайгуул", "хошууч болон тэргүүнд явуулагч", "мэдээлэгч" гэх мэтээр өнөөгийн монгол хэлнээ буулгажээ. Одоо Монголын нууц товчоонд алхинч ашигласан тухай өгүүлсэн зарим баримтсыг дурдъя.

Тэмүүжин Монгол Улсын Чингис хаан болсон ёслолын арга хэмжээний үед "Улс төрийг байгуулалцсан урьдын гавьяат нөхдөө угсаатан ноёд болгож, ... мянганы ноёд болгох зарлиг болсны" дараа, "өмөг туст нөхдөө өөр соёрхлыг" өгөхдөө, Жорчидай түүний "бүтээсэн эрхэм тусыг" дурдсаны дотор "... жич, Балжин нуураас Жорчидайг туршуул (алхинч) болгож, Хэрэйдэдявуулсан билээ. Тэнгэр, газрын ивээлээр бид номхтон дагуулав" ... "Хэрэйдийн Наха-Жамба харьяат нараа авч үлдэв. Гэтэл тэр дайсангаж одсон тул Жорчидай нэхэж, ... Наха-Жамбыг зальт аргаар барьж тонилгов... Жорчидайн бас нэг тус энэ" гээд түүнд Ибага-бэхи хатнаа соёрхож өгчээ.¹⁸ Энэ нь Жорчидай туршуулын үүргийг сайн гүйцэтгэж, Хэрэйдийг дарахад их хувь нэмэр оруулсныг харуулж байна.

Бас Жамуха, Алтан хучар, Тоорил, Хачиун бэх, Нялха Сэнгүм нар Тэмүүжинийг "багалзуур ид" гэж болзож ирүүлэн устгахыг оролдоод чадаагүй болохоор түүнийг барьж авч устгахаар шийдсэн тухай мэдээг адууч Бадайгаас ам дамжин сонссон адууч Хишилиг уг мэдээ үнэн эсэхийг зориуд биечлэн явж тодруулан шалгаж, үнэн болохыг тогтоогоод, хуйвалдаанд оролцогчдын уяж

хоноод өглөө эрт мордох ёстой "зүс заасан хоёр морийг нь унаж, Бадайгийн хамт Тэмүүжинд ирж: "Чингис хаан соёрхвол, бидний үгэнд эргэлзэх явдалгүй, Хомрон ирж таныг барья гэж хэлэлцэж тогтсон магадтай үнэн" гэж мэдээлдэг. Хишилиг болон түүний гавьяа, зүтгэлийн тухай Нууц товчоонд дурдсан зүйл байхгүй билээ. Гэтэл Монгол Улсын хаан болсон ёслолын арга хэмжээний үед мянганы ноён болгосон, "улс төрийг байгуулалцсан урьдын гавьяат, мятралгүй зүтгэсэн хайрт нөхдийн" 57, 58-д нь Бадай, Хишилиг нар орсон байна¹⁹.

Хишилиг, Бадай нар адуучин байгаад мянганы ноён болсон болон Чингисийг барих гэж байгаа тухай мэдээг дам сонсоод түүний үнэн эсэхийг биечлэн явж, шалгаад маргааш нь Чингисийг барих ажиллагаанд ашиглахаар бэлтгэсэн морьдыг нь унаж, Чингист ирж мэдээ дуулгаж, түүнд нь Чингис итгэж байгаа зэргээс үзэхэд Хишилиг, Бадай мөн л туршуулаар ахиллаж байжээ гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

Хаан болсон Чингис хүмүүсийг албан ажилд томилохдоо "Архайхасар, Тахар. Сүхэхэйжүн, Чахурхан дөрвийг" "Холын холбогч, ойрын оточ (Хол ойрыг сурвалжаа газарч) болтугай" гэжээ.²⁰

Чингис судлаач, Өвөрмонголын эрдэмтэн Сайшаал хятад, монгол, орос, япон эх сурвалжийг, ялангуяа бусад орны судлаачид төдийлөн ашиглаж чаддаггүй хятад хэл дээрх асар их эх сурвалжийг судлан ашиглаж бичсэн "Чингис хааны товчоон" гэдэг бүтээлдээ Монголын нууц товчооны дээрх зүйлийг Чингис хаан "холбооч,

туршуулч, газарч" гэсэн тусгай албан тушаал тогтоожээ хэмээн тайлбарласан байна.²¹ Энэ нь Чингис хаан туршуулч, холбоочин гэх мэт тагнуулын ажил эрхэлсэн албан тушаалтантай байсныг нотолж байна.

Хаан болохоосоо өмнө Чингис дээрх 4 хүнээр холбооч, элч, туршуулчийн үүрэг гүйцэтгүүлж байсан гэх үндэслэлтэй юм. Учир нь Чингис Ван хан, Ван ханы хүү Сэнгүм, Жамуха, Алтан, Хучар нарт түүхч нарын нэрлэдгээр "алдарт илгээлт"-ээ хүргүүлэхдээ Архайхасар, Сүхэхэйжүн хоёрыг элч болгон явуулж байжээ.²²

Чингисийн энэ илгээлт нь эрдэмтдийн тэмдэглээд байдаг шиганц цагхожиж, хүчээсэлбэх, морьдоо цагтах зорилготой байгаагүй бололтой. Учир нь Архайхасар илгээлтээ хүргээд буцаж, харин Сүхэхэйжүн Ван ханы хүрээнд байсан гэр бүлдээ санаа зовжбуйлхалхавчаарүлдсэн нь академич Ш.Нацагдоржийн дурдсанаар Ван ханы ордонд түүний эсрэг том хуйвалдааныг мэдэж байсан Чингис хаан²³ уг хуйвалдааныг судлах, дэвэргэх зорилготой байсан байж болох юм. Өөрөөр хэлбэл, Сүхэхэйжүн нь зөвхөн илгээлт хүргэж өгөх биш, бас Ван ханы тэнд үлдэж, тэдний талыг тагнах, түүний эсрэг хуйвалдааныг дэвэргэх зорилготой байжээ.

Жү Яотингуай түүнийг нотолж, "Даридай, Тоорил, Тахай хурхай нар угаас ван хан, Тэмүжиний дунд гүйвж дайдаг байв. Тэмүжиний элч Сүхэхэйжүн тэдэнтэй холбоо тогтоон төрийн эргэлт хийхийг зөвлөжээ"²⁴ гэсэн

21. Сайшаал, "Чингис хааны товчоон" тэргүүн дэвтэр. УБ., 2004 он, 178 дахь тал

22. "Монголын нууц товчоо", §181

23. Ш.Нацагдорж, "Чингис хааны цагд", УБ., 1991 он, 7 дахь тал.

24. Жү Яотин, "Чингис хааны түүх шаштир". УБ., 2002 он, 155 дахь тал

18. "Монголын нууц товчоо", §208

19. Мөн тэнд, §202

20. Мөн тэнд, 77, 124 дэх тал

байна.

Чингис Ван ханы ордонд түүний эсрэг хуйвалдаан үүсч байгааг мэдэж байсан нь тэнд Чингисийн туршуул бас байсныг харуулж байна.

Чингис өөрийн дүү Хасарын нэрээр Ван ханд илгээлт хүргэх хоёр элчийн нэгний халхавчаар явах туршуулын үүргийг мөн Чахурханаар гүйцэтгүүлсэн билээ.²⁵ Дээрх илгээлтийг хүргүүлэхэд Чахурхан, Халиудар нарыг явуулсныхаа дараа Чингис хаан өмнө нь Хэрэйдэд туршуулаар ажиллаж, чухал үүрэг гүйцэтгэсэн Жорчидайг болон хожим туршуулч, холбоочин албан тушаалд томилогдсодын нэг Архайхасар нарыг тэргүүн хайгуул²⁶ болгон мордуулсан байна.

Дээрх бүх баримт нь хаан болоод Чингис Архайхасар, Сүхэхай, Чахурхан нарыг "холын холбооч, ойрын отчоор" томилсон нь тохиолдлынх биш бөгөөд тэдгээр хүмүүс өмнө нь тагнан турших ажлаар мэргэшин ажиллаж байжээ гэдэг дүгнэлт хийж болох байна.

Тийнхүү хаан болохоосоо өмнө Тэмүүжин тагнуулын мэргэшсэн гэж хэлж болох хүмүүстэй байсан бөгөөд Хаан болоод тэдгээрийг албан ёсны болгон туршуулч, холбооч гэх мэт албан тушаалд томилов.

Монголын нууц товчоонд "Өгөөдэй хаан Алтан хааныг мөхөөж, Сяо-Сы (зарц) нэрийг өгч, алт, мөнгө, алтайн хээтэй уурс таваар, агт морь, албат зарцыг хурааж аваад захирагч, мэдээлэгч нарыг томилоод Нанжин, Жунду ба зүг зүгийн хотод дарга нарыг тавьж, төвшин мэндээр буцаж, Хар Хорум хотод ирж буув"²⁷ хэмээснээс үзэхэд

Өгөөдэй хааны үед ч мэдээлэгч гэдэг байнгын албан тушаал байсан ажээ.

Түүгээр ч барахгүй мэдээллийнүнэнбодитойгүнэлэх шалгуурыг хуульчлан тогтоосон байв. Тухайлбал, "... гурван хүн ам авалцан зөвшөөрсөн хэргийг хаа ч өгүүлж болмой. Тийм бус болбоос батланитгэж болохгүй"²⁸ гэсэн нь гурван эх сурвалжаас авсан мэдээлэл агуулга нэгтэй байвал түүнийг үнэн бодитойд тооцох хэрэгтэй байжээ. Мөн мэдээллийн аюулгүй байдлын нэг чухал хэсэг болох төрийн нууцаа хуульчлан хамгаалж, задруулсан этгээдэд "100 шийдэм хүнд шийдэмдэх" ял онохоор заасан байна.

Чингис монгол аймгуудыг нэгтгэж, нэгдсэн Монгол Улс байгуулахын төлөө тэмцэлдээ өөрийн итгэлт дотно анд нөхдөөсөө мэргэшүүлэн ажиллуулах, эсрэг талынхаа хүмүүсийн дунд өөрийн итгэмжит хүнийг бий болгон ашиглах зэрэг аргаар тагнан турших үйл ажиллагааг өргөн ашиглажээ. Уг үйл ажиллагаандаа эсрэг талаа хуурч төөрөгдүүлэх, задлан бутаргах зэрэг тагнуулын аргыг чадамгай хэрэглэж байсан байна.

- -оОо- -

МЭДЭЭ

СЕМИНАР БОЛОВ

Монгол Улсын ХЗДХЯ нь ОХУ-ын Хууль зүйн яамтай хамтын ажиллагааны хүрээнд "Монгол Улс, Оросын Холбооны Улсын хууль зүйн салбарын боловсон хүчин бэлтгэх асуудал" сэдэвт семинарыг ОХУ-ын хууль зүйн яам, Монголын Улсын ХЗДХЯ, Хууль зүйн үндэсний төв хамтран 2008 оны 12 дугаар сарын 15-ны өдөр Хууль зүйн үндэсний төвд зохион байгууллаа.

Уг семинар нь Монгол Улс ОХУ-тай хууль зүйн боловсон хүчин бэлтгэх асуудлаар харилцан туршлага солилцож цаашдаа ОХУ-д хууль зүйн салбарын боловсон хүчин бэлтгэх асуудлыг шийдвэрлэхэд чиглэж байгаа юм. Ингэхдээ ОХУ-ын хууль зүйн яамны харьяа Эрх зүйн академид суралцуулах болон мэргэжил дээшлүүлэх асуудлын хүрээнд ХЗДХЯ болон харьяа агентлаг байгууллагуудын ажилтнуудыг хамруулах талаар ч ярилцлаа. Түүнчилэн Хууль зүйн салбарын боловсон хүчин бэлтгэх асуудлаар ОХУ-ын Хууль зүйн яамтай хамтран зохион байгуулсан уг семинар нь цаашдаа хууль зүйн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх талаар ихээхэн ач холбогдлоо өгөх юм.

- -оОо- -

²⁵ Монголын нууц товчоо, § 18

²⁶ Мөн тэнд, § 183

²⁷ Монголын нууц товчоо § 273

²⁸ Эзэн Богд Чингисийн Их засаг, МУИС-ийн Хууль зүйн дээд сургууль, УБ., 1995 он, III бүлэг, 35 дахь тал.

**Д.ЗОЛЖАРГАЛ**

(Авлигатай тэмцэх газрын
Мөрдөн шалгах хэлтсийн
мөрдөн байцаагч,
комиссар, докторант)

Бие даасан чөлөөт хэвлэл мэдээлэл

Мэдээлэлгүйгээр хариуцлага үгүй. Мэдээлэл бол эрх мэдлээ хадгалж байх хэрэгсэл. Мэдээллийг олон хүн эзэмших тусам эрх мэдэл тэр хэмжээгээр тархдаг. Ард түмэн мэдээлэл олж авах бололцоотой байна гэдэг бол улс үндэстэндээ итгэлтэй байх нэгэн тулгуур зарчим болдог. Олон нийтэд мэдээлэл хүргэх зарчмын гол хэрэгсэл нь хараат бус, чөлөөт хэвлэл мэдээлэл юм.

Нийгмийн зүгээс аливаа үйл ажиллагаа хэдий чинээ нээлттэй, ил тод хэв маягийг бий болгоно төдий чинээгээр олон нийтэд мэдээллийн хүртээмж нэмэгдэнэ. Нөгөө талаар хэт их мэдээллийн урсгал нь хамгийн идэвхитэй иргэний хувьд ч гэсэн нийгэмд болж буй бүх үйл явдлын талаар мэдээлэлтэй байх боломж олгодоггүй. Парламентын болон төр засгийн төв болон орон нутгийн байгууллагын үйл ажиллагаа, шүүхийн хуралдаан, хувьцаат компанийн ажил энэ бүгд байж болох боловч иргэн бүр эдгээрт бүгдэд нь биечлэн оролцоно гэдэг хэзээ ч бүтэшгүй нь ойлгомжтой. Ийм тохиолдолд бидний ганц найдвар нь бүрэн төгс, мэргэжлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН

ЭРХ ЧӨЛӨӨ

мөн бөгөөд эдгээр нь өдөр тутам гарч буй их мэдээллийг шигшин, олон нийтийн сонирхол татах мэдээллээс бидэнд хэрэгтэйг нь маш оновчтой ухаалгаар сонгон улмаар шударга, хариуцлагатайгаар хүргэх үүрэгтэй. Мэдээж хэвлэл мэдээллийнхувьднэгталаасолон түмэнд мэдээлэх гэсэн Үндсэн хуулиар олгогдсон чиг үүрэг. нөгөө талаас олон уншигчийг өөртөө татах, аль болох өргөн реклам сурталчилгаа тавих, бодит орлоготой байх гэдэг ашиг сонирхлын зөрчил байсаар байх болно.

Чөлөөт хэвлэл мэдээлэл нь хараат бус шүүх эрх мэдлийн нэгэн адил улс төрчдийн өмнө хариуцлага хүлээх ёсгүй хоёр эрх мэдлийн нэг юм. Хоёул нийгмийн амьдралд авилгатай тэмцэх хүчирхэг зэвсэг юм. Гэхдээ хувийн эзэмшилд байгаа хэвлэл мэдээллийг шүүгч, улсын яллагч нар шиг улс төрчид томилдог буку баталдаггүй. Төрийн мэдлийн хэвлэл мэдээллийн хэрэгслээс бусад нь өөрийн томилгоотой бөгөөд хувийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн бүтээгдэхүүнийг олон нийт хэрэгтэй гэж үздэг учраас олон нийтийн дэмжлэг дээр тогтдог ба нийгэм эдийн засгийн хувьд хурдацтай хөгжиж байгаа нийгмийн хөгжлөөс хамааранилүү боловсронгуйгаар оршин тогтнодог юм. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь нэг талаар хувийн эзэмшилд байгаа нь аюултай юм. Энэ нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл цөөн хүний гарт төвлөрч олон нийтийн мэдээллийн хэрэгслийн **конгломерат** үүсэх явдал юм. Энэ байдал нь ардчилалд шууд заналхийлж болдог, учир нь хэрэв тэд хүсвэл сонгогчдын санаа бодлыг залуурдах чадвартай, гол улс

төрийн намууд барьцаанд нь байдаг хүчирхэг хүмүүс болдог. Иймээс хэвлэл мэдээллийн хэрэгсэл хоорондоо нэгдэх, нэг нь нөгөөгөө өөртөө уусган авах зэргийг хязгаарласан хатуу зарчимч хуулийн зохицуулалт байх шаардлагатай бөгөөд улс орон хэвлэл мэдээллийн зах зээлд ямагт өрсөлдөөн байх явдлыг баталгаажуулах ёстой. Даяарчлагдсан дэлхий ертөнцөд ялангуяа, телевизийн эрин зуунд үүнийг хэрэгжүүлэхэд улам бэрхшээлтэй болж байна. Гэвч интернэт хөгжихийн хэрээр мэдээллийг түгээх явдал зарим нэг талаараа ардчилгагдаж байна. Энэ үзэгдэл нь зарим бэрхшээл учруулж байгаа боловч гол нь дэлхий нийтийн мэдээллийн харилцаа нь хүчирхэг ашиг сонирхлын бүлгүүдийн дагнасан эрх мэдэл байхаанзгэнт болжээ. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл ямар хэмжээнд байгааг тэрээр төрийн албан хаагчдын үйл ажиллагааг хянах хочот нохойн үүргээ хэрхэн биелүүлж чадаж байгаагаар хэмжих ёстой. Хууль тогтоох байгууллага нь гүйцэтгэх эрх мэдлийг өдөр тутам хянаж байх ёстойн нэгэн адил хэвлэл мэдээлэл хууль тогтоогчид болон гүйцэтгэх эрх мэдлийг хоёуланг /Гесвийн буку нийтийн хөрөнгө мөнгөөр санхүүждэг бүх албан тушаалтан/ анхааралтай хянаж байх үүрэгтэй.

Улс төрчид болон төрийн албан хаагчдын үйлдэл нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр ил тод бичигдэхгүй, олон түмний шахалтад өртөх аюул байхгүй гэдэгт итгэлтэй байх тусам тэд бүгд өөрийн албан тушаалын байдлыг хувийн ашиг сонирхолд ашиглах сонирхолтой бөгөөд боломжтой болдог. Улс төрчид дээрх байдлыг зорилго болгохдоо хэвлэл мэдээллийн амыг боох оролдлого ямагт

хийсээр байдаг нь нууц биш юм.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийг **цензурдэг**, хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаанд олон хориглосон хууль тогтоомж хэрэгжиж байгаа мөн өөрийн өндөр албан тушаалтантай холбоотой нийтлэл бичсэн сэтгүүлчдээ шүүх, цагдаагийн байгууллагаар дарамтлуулан айлган сүрдүүлэх байдалтай байгаа нь өнөөгийн нийгэмд ил тод байна.

Мөн улсын нууцын тухай хууль гаргаж төр засгийн тухай иргэд мэдээлэл авах, хэвлэн нийтлэх эрхийг нь ихээхэн хэмжээгээр хязгаарлах явдлыг дэмждэг эрх мэдэлтнүүд өөрийгөө нээлттэй гэж тунхагладаг бөгөөд тэд хэвлэлийнхэн хариуцлагагүй үйлдэл хийж магадгүй гэдгээр үүнийгээ хаацалдаг юм. Жишээлбэл: Мексик, Энэтхэг зэрэг улс оронд сэтгүүлчид

хариуцан сурвалжилдаг байгууллагаасаа урамшуулал авч бага цалиндаа нэмэрлэдэг байна. Иймэрхүү байдал нь сэтгүүлчдийн зүгээс төрийн дэзгүүр өндөрлөгт гарч буй зүй бус үйлдлийг сурвалжлах хүсэлгүй болгох том хүчин зүйл болдог.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хараат бус байдал гэдэг бол маш адармаатай зарчим юм. Ерөнхийдөө энэ нь сэтгүүлчид мэргэжлийнхээ ажил үүргийг биелүүлэхдээ аливаа хэлбэрийн нөлөөллөөс ангид байх ёстой гэсэн үндэслэл дээр төвлөрдөг. Гэтэл бодит байдалд хэвлэл мэдээллийн хэрэгслийг эзэмшигчид сэтгүүлчдийн өдөр тутмын ажилд хөндлөнгөөс оролцож байдаг. Гадаадын улс оронд Засгийн газар нь өөрөө хэвлэл мэдээллийн хэрэгслийн хамгийн том эзэмшигч байдаг нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн

жинхэнэ хараат бус байх зарчмыг алдагдуулдаг.

Төрийн өмчийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ажилладаг сэтгүүлчдийн эрх, эрх чөлөөт байдлын хэмжээг дандаа биш гэхэд зарим тохиолдолд хуулиар хамгаалж баталгаажуулсан байдаг юм. Манай нийгэмд хариуцлагатай хариуцлагагүй сэтгүүл зүй нь хоорондоо маш нарийн шижмээр холбогддог ба цаг хугацаа, хаана болж байгаа зэрэг нь үүний үнэлгээнд нөлөөлөх чухал хүчин зүйл байх учиртай. Тиймээс хариуцлагатай хэвлэл мэдээлэлтэй байхын тулд шүүхийн хүчээр хэвлэлийг дарж байхын оронд "Хэвлэлийн зөвлөл"-ийн ёс суртахууны хүчин зүйлээр нөлөөлөх нь илүү үр дүнтэй арга зам юм.

- оОо -

ЭРХ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ДОКТОРЫН ЗЭРЭГ ХАМГААЛУУЛАХ ЭРДИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН БАТЛАГДЛАА

БСШУ-ны сайдын 2008 оны 173 дугаар тушаалын 13 дугаар хавсралтаар Эрх зүйн шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалуулах эрдмийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталсан байна. Зөвлөлийн бүрэлдэхүүнд:

Зөвлөлийн дарга:

1. Академич Ж.Амарсанаа,

Орлогч дарга:

2. Академич С.Нарангэрэл,

Эрдэмтэн нарийн бичгийн дарга:

3. Л.Баасан Доктор (Sc.D),

Гишүүд:

4. О.Амархүү Доктор (Sc.D),

5. И.Дашням Доктор (Sc.D),

6. Ж.Долгорсүрэн Доктор (Sc.D),

7. С.Жанцан Доктор (Sc.D),

8. Н.Лүндэндорж Доктор (Sc.D),

9. Д.Лүндээжанцан Доктор (Sc.D),

10. Т.Сэнгэдорж Доктор (Sc.D),

11. Ч.Энхбаатар Доктор (Sc.D),

12. Ж.Бямбаа Доктор (Ph.D),

13. Н.Жанцан Доктор (Ph.D),

14. Ц.Сарантуяа Доктор (Ph.D),

15. Б.Чимид Доктор (Ph.D) нар багтдаг юм байна.

—оОо—

ДОКТОРАНТУРЫН ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН БАТЛАГДЛАА

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн "Докторантурын хороог нэгтгэх, докторантурын хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай" 389 дугаар тушаалаар Хууль зүйн докторантурын хорооны бүрэлдэхүүнийг баталсан байна. Хууль зүйн докторантурын хорооны бүрэлдэхүүнд:

1. **Дарга** Монгол Улсын Их сургуулийн Эрх зүй, төрийн онол, түүхийн тэнхимийн эрхлэгч,

2. **Орлогч дарга** Цагдаагийн академийн Эрүүгийн эрх зүйн

тэнхимийн эрхлэгч,

3. **Нарийн бичгийн дарга** Монгол Улсын Их сургуулийн Иргэний эрх зүйн тэнхимийн эрхлэгч, **Гишүүд:**

4. Монгол Улсын Их сургуулийн Олон улсын эрх зүйн тэнхимийн эрхлэгч,

5. Монгол Улсын Их сургуулийн Төр, захиргааны эрх зүйн тэнхимийн эрхлэгч,

6. Монгол Улсын Их сургуулийн Эрүүгийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч,

7. Их засаг Их сургуулийн Докторантурын сургалтын албаны дарга,

8. Отгонтэнгэр Их сургуулийн Эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал

—оОо—



П.ӨНӨРМАА /"Засаглалыг дэмжих төсөл"-ийн зөвлөх/

1. Ойлголт ба өнөөгийн

байдал

2. Бусад орны туршлага


3. Дүгнэлт ба зөвлөмж

1. ОЙЛГОЛТ БА ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Авлигатай тэмцэх үйл ажиллагааны хүрээнд төрийн албан дахь ашиг сонирхлын зөрчил (АСЗ)-ийн асуудлыг шийдвэрлэх шаардлага зүй ёсоор урган гардаг. Учир нь авлига гарахад нөлөөлдөг олон хүчин зүйлүүдийн нэг нь ашиг сонирхолын зөрчил юм. Төрийн албан хаагчийн "Ашиг сонирхлын зөрчил" гэдэгт төрийн албан хаагч нь албан үүргээ гүйцэтгэх буюу үүрэг даалгавар биелүүлэх явцад өөрийн хувийн ашиг сонирхолтой холбоотой асуудлаар шийдвэр гаргах буюу шийдвэр гаргахад оролцох, эсхүл үүрэг даалгавар биелүүлэх болсон байдлыг хэлдэг. Ашиг сонирхлын зөрчил нь дор дурдсан төрөлтэй. Үүнд:

Иргэд, олон нийтийн дунд ашиг сонирхлын зөрчлийн тухай ойлголт ямар түвшинд байна вэ - "Монголд цөөн тооны хүн л ашиг сонирхлын зөрчлийн тухай зохих ойлголттой байдаг." "Төрийн алба болон хувийн хэвшлийн хоорондын

ТӨРИЙН АЛБАН ДАХЬ АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ



Эдгээр нь цаг хугацаа болон гарах магадлалын хувьд өөр өөр байдаг.

зааг, хязгаарлалт бүдгэрч, ашиг сонирхлын зөрчил газар авсан нь авлига гарах нэг шалтгаан болсон" гэж 2005 онд АНУ Олон улсын хөгжлийн агентлагаас явуулсан "Монгол Улс дахь Авлигын байдалд хийсэн үнэлгээ" судалгаанд дурджээ. Мөн судлаачдын дүгнэн хэлснээр: "Одоогийн тогтолцоо нь хөрөнгө чинээтэй хүмүүсийг баялаг бүтээх, хуримтлуулахад хүч чадлаа зориулах, зам мөрөөс салгаж, харин улс төрийн карьер, эрх мэдэл рүү ямар ч үнээр хамаагүй зүтгэгчдийн армийг төрүүлсээр байна." "Дуртай үедээ төрийн албанд орж, гардаг... сонгуульд өрсөлдөөд ялагдсан тохиолдолд буцаж, төрийн мэргэшсэн албан хаагч учир ажлаа хийнэ... гэж зүтгэдэг" байдал гэм биш зан болжээ.

Монгол Улс дахь 2002 оны

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, авлигатай тэмцэх талаарх олон нийтийн санаа бодлыг тандах мониторингийн судалгааны саналасуулгад нийторлогосдын 79.0 хувь нь шүүгч, 78.5 хувь нь гаалийн байцаагч, 76.9 хувь нь прокурорын ажилтнууд, 10,3 хувь нь банкны ажилтнууд авлигад өртөх магадлал ихтэй гэж үзсэн нь шүүх, гааль, прокурорын ажилтнуудыг ашиг сонирхлын зөрчилд орох магадлал харьцангуй өндөр болохыг харуулж байна. Мөн тус судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 57 хувь нь тендер шалгаруулалтад заавал хөндлөнгийн нөлөөлөл ордог гэж хариулсан байна.

Ашиг сонирхлын зөрчлийн эрх зүйн зохицуулалт - Монгол Улсын Төрийн албаны тухай хууль (ТАТХ)-ийн 4, 10, 15, 26, 40 дүгээр зүйлд төрийн албан дахь ашиг сонирхлын зөрчлийн эрх зүйн гол тулгуур зохицуулалтыг тусгасан байдаг. Жишээлбэл: Төрийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлд ашиг сонирхлын зөрчлийн зарим

1. Төрийн албан дахь ашиг сонирхлын зөрчлийн үг сурвалж, "Зууны мэдээ" сонин 2008 он, №126

2. Төрийн жинхэнэ албан хаагчдыг улс төрийн намаас түлгээлзүүлсэн, Н.Чадраабал, "Төрийн албаны мэргэжлийн шалгалтын төв комиссын даргын ярилцлага", "Монголын мэдээ" сонин 2008 он, №264

хэлбэрийг (тухайлбал албан тушаалынхаа бүрэн эрхийг хэрэгжүүлсний төлөө бусдаас шагнал, шан харамж авах, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа гардан эрхлэх, орон тооны ажил, албан тушаал хавсран гүйцэтгэх зэрэг) жагсаан нэрлэж, төрийн жинхэнэ албан хаагчдад эдгээр үйл ажиллагааг явуулахыг хоригложээ. Ерөнхийдөө хууль тогтоомжид дор дурдсан ашиг сонирхлын зөрчлийн хэлбэрийг заасан байна. Үүнд:

1. Албан тушаал, албаны бүрэн эрхээ хувийн ашиг сонирхолд урвуулан ашиглах;
2. Бусдаас бэлэг, хандив, үйлчилгээ хүлээн авах;

3. Тодорхой харилцаанд байгууллага, хувь хүнийг төлөөлөх;

4. Ажил хавсран гүйцэтгэх;

5. Албаны болон албаны шугамаар олж авсан мэдээллийг хувийн зорилгод ашиглах;

6. Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, орлого олох;

7. Ажлаас гарсны дараа тодорхой хугацаанд тодорхой үйл ажиллагаа эрхлэхийг хориглох.

Монгол Улсын Авлигын эсрэг хуульд *"Албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, ирээн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг"* авилга гэж тодорхойлсон. Иймд ашиг сонирхлын зөрчил нь авилга гарахад нөлөөлөх хүчин зүйлийн нэг бөгөөд төрийн албан хаагчийн хувийн ашиг сонирхлоо албан үүргээсээ дээгүүр тавьж үзэх нь өөр бусад олон гэмт хэрэг, эрх зүйн зөрчлийн үндэс болдог.

Монгол Улс 2005 онд, Авлигын эсрэг НҮБ-ын конвенцыг соёрхон баталсан бөгөөд гишүүн улсын хувьд уг конвенцын үзэл санааг үндэсний хууль тогтоомжид *"тусгах"* үүрэг хүлээсэн юм. Тус конвенцын 8 дугаар зүйлийн 2-т заасны дагуу *"Оролцогч улс бүр төрийн үүргийг зөв, эрхэм бөгөөд зохистой байдлаар биелүүлэх ёс зүйн хэм хэмжээ буюу стандартыг өөрийн байгууллага болон эрх зүйн тогтолцооны хүрээнд хэрэглэхийг эрмэлзэнэ"* мөн зүйлийн 5-д: *"Оролцогч улс бүр өөрийн дотоодын хууль тогтоомжийн тулгуур зарчимд нийцүүлэн шаардлагатай тохиолдолд төрийн албан тушаалтан өөрийнх нь чиг үүргийн хувьд ашиг сонирхлын зөрчил үүсгэж болох албан үүргээс гадуурх үйл ажиллагаа, ажил эрхлэлт, хөрөнгө оруулалт, эд хөрөнгө, чинээлэг бэлэг буюу давуу талыг холбогдох байгууллагад тайлагнаж байх систем болон арга хэмжээг тогтоохыг эрмэлзэнэ"* гэж заасан. Энэхүү олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу Монгол Улс ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх цогц систем буюу тогтолцоо бий болгох ажлыг хийж эхлээд байна. Тухайлбал, 2007 оноос эхлэн төрийн албан хаагчид өөрсдийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг гаргадаг болсон юм. Харин уг мэдүүлгийг ашиг сонирхлын зөрчлийг шийдвэрлэхэд хэрхэн ашиглах талаар дорвитой алхам хийгдээгүй байна.

1999 оноос эхлэн Азийн хөгжлийн банк (АХБ), Эдийн засгийн хамтын ажиллагаа,

хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ) хамтран *"Ази, номхон далайн бүс нутгийн авлигын эсрэг санаачилга"* нэртэй хөтөлбөр хэрэгжүүлж байгаа ба үүнийхээ хүрээнд *"Ази, номхон далайн бүс нутгийн авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө"*-г 2000 онд батлан хэрэгжүүлж байгаа бөгөөд Монгол Улс 2001 оны 11 дүгээр сард уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр амлалт авсан байна. Энэхүү төлөвлөгөөнд 3 үндсэн чиглэлийн цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан ба 1 дүгээр чиглэл нь Төрийн үйлчилгээн дэх "Үр дүнтэй, ил тод тогтолцоог бүрдүүлэх цогц үйл ажиллагаа юм. Үүний хүрээнд ашиг сонирхлын зөрчлийг хууль бус нөхцөл байдал хэмээн тусгасан ёс зүйн болон захиргааны дүрэм боловсруулж мөрдөхөөр заасан. Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулахдаа дараах чиглэлээр арга хэмжээ авах хэрэгтэйг заасан байна. Үүнд:

-Хувийн өмч хөрөнгө ба өр зээлийн талаарх мэдүүлэг гаргах, эсвэл тодорхой хяналт тавих замаар төрийн албаны ил тод байдлыг дээшлүүлэх;

-Татвар, гааль гэх зэрэг авлигад өртөмтгий, хамгийн их эрсдэлтэй салбар дахь төрийн албан хаагч нарыг аливаа зүй бус гадны нөлөөнд автахас урьдчилан сэргийлэх захиргааны систем нэвтрүүлэх;

-Олон улсын стандарт болон тухайн улсын уламжлалт соёлыг тусгасан ёс зүйн хэм хэмжээний дүрмийг боловсруулж мөрдөх, холбогдох сургалт, дадлага болон хяналтыг тасралтгүй явуулах;

-Авлигын үйлдэл гарсныг мэдсэн төрийн албан хаагч энэ тухайгаа зохих албан тушаалтан,

байгууллагад мэдээлж байх, мэдээлэл өгсөн албан хаагчийн аюулгүй байдлыг хамгаалах, албан тушаалын баталгааг зөрчихгүй байх тогтолцоо бий болгох зэрэг болно.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас гаргасан "Төрийн албан тушаалтны ёс зүйн олон улсын дүрэм"-д Ашиг сонирхлын зөрчлийн асуудлыг тусгайлан заасан байдаг. Уг дүрэмд төрийн албан хаагчийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулахдаа дор дурдсан асуудалд голлон анхаарахыг чухалчилжээ. Үүнд:

1. Төрийн албан хаагч өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хувийн буюу санхүүгийн ашиг сонирхлын төлөө албаны бүрэн эрхээ зүй бусаар ашиглахыг хориглоно. Тэд өөрсдийн ажил, үүргээ гүйцэтгэх ажиллагаанд харшлах ямар нэг хэлцэл байгуулах, албан тушаал эрхлэх, бусдын төлөө үүрэг гүйцэтгэх, тэдгээртэй адилтгах санхүү, арилжааны сонирхол бүхий бусад үйл ажиллагаа явуулж болохгүй.

2. Төрийн албан хаагч албан тушаалынхаа хүрээнд, хууль болон захиргааны бодлогод нийцүүлэн ашиг сонирхлын зөрчил үүсгэж болох бизнес, арилжаа, санхүүгийн сонирхол, санхүүгийн ашиг олох үйл ажиллагааны тухай мэдүүлнэ. Төрийн албан хаагчийн албаны үүрэг, хувийн сонирхлын хооронд ашиг сонирхлын зөрчил үүсгэж болох буюу үүсгэсэн нөхцөлд тэд үүссэн ашиг сонирхлын зөрчлийг багасгах буюу арилгах арга хэмжээ авна.

3. Төрийн албан хаагч албаны үүргээ гүйцэтгэх явцдаа буюу гүйцэтгэсний үр дүнд олж авсан нийтийн мөнгө, эд хөрөнгө, үйлчилгээ буюу мэдээллийг

ажил, албатай холбогдолгүй үйл ажиллагаанд зүй бусаар ашиглаж болохгүй.

4. Төрийн албан хаагч албан тушаалаас гарсны дараа урьд тухайн ажлыг эрхэлж байсан давуу байдлаа зүй бусаар ашиглахгүй байх талаар хууль болон захиргааны актаар тогтоосон хэм хэмжээг мөрдөнө.

Ашиг сонирхлын зөрчил ба төрийн албан хаагчийн ёс зүй – Ашиг сонирхлын зөрчлийн асуудлыг авлига гэхээсээ илүүтэйгээр албан хаагчийн ёс зүйн асуудалтай нягт уядуулан авч үзэх хэрэгтэй. Монгол Улсын төрийн байгууллагуудын ёс зүйн дүрмийг шинжлэн үзэхэд ихэнх нь ёс зүйн үндсэн зарчим, ашиг сонирхлын зөрчлийн хэлбэрийг нэрлэн тодорхойлсон боловч ашиг сонирхлын зөрчлийг илрүүлэх, шийдвэрлэх механизмын асуудлыг тусгайлан заалгүй орхигдуулсан нийтлэг дутагдал ажиглагдаж байна. Тухайлбал практикт зөвхөн зөрчил гаргасан албан хаагч хариуцлага хүлээдэг болохоос зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар арга хэмжээ авах үүргээ биелүүлээгүй албан тушаалтан хариуцлага хүлээдэггүй. Гэтэл Швед Улсад аливаа байгууллагын дарга нь хуульд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой бүхий л асуудлаар ажилтнуудад заавар, зөвлөгөө өгөх үүрэгтэй байдаг.³ Манай Улсын хувьд УИХ-д суудалтай 3 нам, бие даан нэр дэвшигчийг оролцуулан хамтран ажлын хэсэг байгуулж, ёс зүйн дүрмийг сайжруулах ажлын хүрээнд ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлыг илүү нарийвчлан оруулахаар ажиллаж байна.

Ашиг сонирхлын зөрчил ба хөрөнгө, орлогын мэдүүлэг -

2006 онд Монгол Улсын Авлигын эсрэг хууль батлагдан гарснаар хөрөнгө, орлогын мэдүүлгийн эрх зүйн үндэс тавигдсан. Урьд нь энэ тухай асуудал гагцхүү сонгуульд нэр дэвшигчид л хамаарч байсан байна. Зарим оронд мэдүүлгийг 3 тохиолдолд, тухайлбал ажилд орохын өмнөх, ажиллаж байх хугацаанд, ажлаас гарах үед тус тус гаргаж өгдөг. Манай улсад тодорхой албан тушаалд шинээр томилогдсон, сонгогдсон үед, мөн жил бүр мэдүүлгийг гаргадаг. Ажиллаж байх хугацааны буюу жил бүрийн мэдүүлгээр ашиг сонирхлын зөрчлийг шийдвэрлэх боломжгүй юм. Мэдүүлгийг хуульд заасан хугацаанд гаргаж өгдөг бол ашиг сонирхлын зөрчил хуульд захирагдалгүйгээр хэдийд ч гарах магадлалтай. Иймд ашиг сонирхлын зөрчил гарч болзошгүй буюу нэгэнт үүссэн бол тухай бүр шууд удирдлагадаа мэдүүлэх замаар шийдвэрлэдэг. Өөрөөр хэлбэл, хөрөнгө орлогын мэдүүлэг нь ашиг сонирхлын зөрчлөөс нийтлэг байдлаар урьдчилан сэргийлэхэд ач холбогдолтой байдаг.

Авлигын эсрэг хуулийн 3 дугаар бүлэгт Хөрөнгө, орлогын мэдүүлгийг гаргах, бүртгэх, хадгалах болон хянан шалгах, хариуцлага хүлээлгэх нийтлэг журмыг заасан байна. Авлигатай тэмцэх газар хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтэд хяналт тавьж, дүн шинжилгээ хийнэ. Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх эрх бүхий албан тушаалтан мэдүүлэг засваргүй, бүрэн гүйцэд бөглөгдсөн, хугацаандаа өгсөн эсэхэд хяналт тавьж, мэдүүлгийг зохих журмын дагуу гаргаж өгөхийг шаардах, хууль зөрчсөн гэж үзэх үндэслэл байвал бүрэн

эрхийнхээ хүрээнд хянан шалгах буюу Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн шалгуулах үүрэгтэй. Авлигатай тэмцэх газар шаардлагатай тохиолдолд өөрийн санаачилгаар өргөдөл, гомдол, мэдээллийн мөрөөр шалгалт явуулж болно³. Мэдүүлэг гаргах үүрэг бүхий этгээд хөрөнгө, орлогын мэдүүлгээ хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл эх үүсвэрийг нь заагаагүй буюу түүнийг хэрхэн олсон талаар тайлбар өгч чадаагүй бол Авлигатай тэмцэх газар тухайн мэдүүлэг гаргагчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг шалгана.

Авлигын эсрэг хуульд зааснаар хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хадгалах журмыг Улсын Их Хурал баталсан⁴. Анхных гэдэг утгаараа ч тэр үү энэ маягт нь хуулийн шаардлагад бүрэн нийцээгүй бөгөөд хэд хэдэн дутагдалтай, тухайлбал: маягтыг бөглөсөн болон бүртгүүлсэн огноог тавих, мэдүүлэгчийн гарын үсгийг бичих шаардлагатай "мартсаны" зэрэгцээ, "их хэмжээний өөрчлөлт" гэж ямар хэмжээг ойлгохыг журамд заагаагүй байна. Үүнээс гадна одоогийн Хөрөнгө орлогын мэдүүлгийн маягт агуулгын хувьд хэт ерөнхий бөгөөд ашиг сонирхлын зөрчлийг илрүүлэхэд ашиглах мэдээллийг өгч чадахгүй байна. Өөрөөр хэлбэл: Төрийн албаны тухай хуульд заасан төрийн жинхэнэ албан хаагчид хориглох үйл ажиллагааны тухай заалтыг бодит байдал дээр хэрхэн биелүүлж байгааг

шалгах бололцоо дутмаг байна. Бусад оронд Эрх бүхий албан тушаалтнууд Хөрөнгө орлогын мэдүүлгийг шалгасны дараа Ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, зохицуулах талаар зөвлөгөө, заавар, анхааруулга өгдөг байна. Ингэхгүйгээс Хөрөнгө орлогын мэдүүлгийн ач холбогдол алдагдаж, архивт хадгалагдах цаас болж хувирсан байна.

Мэдүүлгээс тухайн жилд болж өнгөрсөн зарим нэг ач холбогдол бүхий үйл явдал (одоо байгаа буюу мэдүүлэг гаргах үеийн зээл, ажил эрхлэлт, хөрөнгө шилжүүлэлт г.м)-ыг мэдэх боломжгүй байна. Уг нь мэдүүлэг тухайн жилд болсон ач холбогдол бүхий бүх үйл явдал, өөрчлөлтийг хамрах хэрэгтэй байна. Жишээлбэл, Төрийн байгууллагад бараа нийлүүлж, үйлчилгээ үзүүлэх гэрээ хэлцэлд оролцсон эсэх, Маягтын үйл ажиллагааны орлого хэсгээс мөнгөний дүндл харагдана. Хэнтэй ямар гэрээ байгуулсан нь тэр бүр тодорхой харагдахгүй байна. Өөрөөр хэлбэл: Ашиг сонирхлын зөрчлийг шийдвэрлэхэд орлогын дүн бус харин ямар замаар уг орлогыг олсон нь илүү чухал мэдээлэл байдаг.

Nepotism—хууль тогтоомжоор зөвшөөрснөөс бусад тохиолдолд албан үүргийн хувьд нэг нь нөгөөдөө шууд захирагдах буюу шууд хяналт тавих албан тушаалтантай гэр бүл, төрөл, садангийн хүн нь тухайн ажлын албаны нэгжид хамт ажиллахыг хориглоно. Энэ хязгаарлалтын хэрэгжилтийг Хөрөнгө орлогын мэдүүлгээс мэдэх боломжгүй юм. Филиппин Улсад төрийн албанд ажилладаг төрөл, садны тухай мэдүүлэгт бичих ёстой байдаг.

Мэдүүлгийн агуулга

дэлгэрэнгүй, байх тусам: хувь хүний нууцыг чандлан хадгалах ёстой. Монгол Улсын хувьд Авлигын эсрэг хуулийн 14 дүгээр зүйлд зааснаар мэдүүлгийн хувь хүний нууцад хамаарахаас бусад хэсэг нь олон нийтэд нээлттэй байна. Иргэд бичгээр, амаар, цахим мэдээллийн сүлжээгээр дамжуулан мэдээлэл авч болох бөгөөд тэдгээрт мэдээлэл өгөх журмыг Авлигатай тэмцэх газар батална.

Хөрөнгө, орлогын мэдүүлгээ хугацаа хожимдуулж гаргасан, эсхүл бүртгүүлээгүй буюу санаатай худал мэдүүлсэн бол түүнийг албан тушаалаас нь огцруулах, түдгэлзүүлэх, халах үндэслэл болно. Эндээс харахад хугацаа хожимдуулж гаргасан эсхүл санаатай худал мэдүүлсэн хоёрт яг адил санжц ногдуулахаар байна. Мөн, "Хүндэтгэн үзэх шалтгаанаар хугацаа хожимдуулж гаргасан" бол хармуцлага хүлээх юм шиг харагдаж байна.

Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хяналт тавих үүргээ биелүүлээгүй, эсхүл холбогдох материалыг хуульд заасан хугацаанд ирүүлээгүй эрх бүхий албан тушаалтныг 100000-150000 төгрөгөөр торгоно. Харин уг эрх бүхий албан тушаалтанд цалингийн нэмэгдэл олгох талаар эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

2. БУСАД ОРНЫ ТУРШЛАГА

Ашиг сонирхлын зөрчил ба эрх зүйн зохицуулалт - Хятад, Латви, Литва зэрэг орон 1999 оны үеэс эхлэн ашиг сонирхлын зөрчлийн асуудлыг тусгайлан авч үзэж бие даасан хууль гаргасан байна. Эдгээр хуульд ашиг сонирхлын зөрчлийн асуудлыг нэн тэргүүний ээлжинд төрийн

3.Шведийн Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 4 дүгээр зүйл.

4.Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-13.4 дэх хэсэг

албанд иж бүрнээр зохицуулахыг чармайжээ. Энэ нь Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцын үзэл санаатай нягт холбоотой.

Өмнөд Солонгост, байгууллагын ёс зүйн ажилтан албан хаагчдад ёс зүйн асуудлаар зөвлөгөө өгөх, сургалт явуулах үүрэгтэй ба Өмнөд Солонгосын Авлигын эсрэг бие даасан комисс тухайн байгууллагын ёс зүйн дүрэм зохих шаардлага хангахгүй байгаа тохиолдолд түүний өөрчлөх тухай заавар, зөвлөгөө өгөх эрхтэй байдаг. Хятадад төрийн албан хаагчийн хууль бус үйлдэл, эс үйлдэхүйн хэргийг тухайн байгууллагын дарга хянан шийдвэрлэж, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд албан хаагчид шаардлага тавьж, биелүүлээгүй тохиолдолд арга хэмжээ авдаг.

Олон улсын түвшинд ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх ажлын нэг чухал хэсэг бол албан тушаалтнуудын ашиг сонирхлын мэдүүлэгт хяналт тавих явдал гэж үздэг. Энэ нь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажиллагаанд хүчтэй эерэг нөлөө үзүүлдэг. Удирдах албан тушаалтнууд өөрийн болон гэр бүлийнхээ гишүүний ашиг сонирхлын мэдүүлгээ үнэн зөв гарган өгч, тэд зөвхөн төрийн эрх ашгийн үүднээс шударга шийдвэр гаргах нь төрийн албанд ашиг сонирхлын зөрчил үүсэхгүй байх нөхцөлийг бүрдүүлнэ гэж үздэг.

Бэлэгний зохицуулалт

Олон улсын практикт бэлэгний үнэ, өгч авч буй талууд, байгууллага, хүмүүсийн хоорондын харилцааг тусгай дүрэм, журмаар иж бүрэн зохицуулсан байдаг. Жишээлбэл, Сингапурт төрийн албан хаагч албан үүргээ гүйцэтгэсэний

төлөө бусдаас ямар нэг төлбөр, үйлчилгээ хүлээн авахыг хориглосон байдаг.⁵ "Хэрэв өгч, авч байгаа талын аль нэг нь бэлэгэнд хариу байна гэж итгэж байгаа бол бэлэг авах, өгөхийг хориглоно. Хэрэв бэлэг, дурсгалын зүйл нь зан заншил, протоколын чанартай бол тодорхой үнийн хязгаар тогтоож, авах буюу өгөхийг зөвшөөрнө. Хэрэв тогтоосон хэмжээнээс илүү өндөр үнэтэй боловч эргээд хариу үйлдэл хүсээгүй түүнчлэн авахгүй бол хүнийг зөвгүй байдалд оруулах байдал үүсвэл бэлгийг хүлээн аваад түүнийгээ холбогдох байгууллагад хураалгаж болох юм." Ерөнхийдөө бусад оронд бэлэг дурсгалын зүйлийн үнийн хэмжээ 25-50 ам долларын хооронд байна.⁶ Жишээлбэл Литвад 100 лита буюу 41 орчим ам доллар, АНУ-ын Илинойс мужид \$ 50, Дэлхийн Банкны ажилчдын хувьд \$ 50 -аас дээш үнэтэй бэлэг авч болохгүй буюу мэдүүлэх үүрэгтэй байдаг. Түүнчлэн дэлхий нийтэд бэлгийн хэмжээг албан тушаалтан, байгууллага бүрт өөр өөр байгааг эрс шүүмжилдэг.

Ер нь бэлгийн талаар нийтлэг жишиг гаргаад ашиг сонирхлын зөрчилд илүү ихээр өртөх магадлалтай албан тушаалтнуудаа тухайлбал гааль, шүүх, парламент, газрын

5. Төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Латвийн БНУ, 2002 он.
Төрийн албан хаагч ашиг сонирхлын зөрчлөөс татгалзах тухай хууль, БНХАУ, 2000 он.

Төрийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг хооронд нь уялдуулан зохицуулах тухай хууль, Литвийн БНУ, 1999 он.

6. Төрийн албан хаагчийн зарчимд байрлал хангах тухай ёс зүйн дүрмийн 23.2 зүйл, 2003 он.

7. Төрийн албан хаагч ашиг сонирхлын зөрчлөөс татгалзах тухай хууль, 10 дугаар зүйл, БНХАУ, 2000 он.

алба, цагдаа⁷ арай хатуу шаардлага тавих нь зүйтэй. Бэлгийг мэдүүлэх ёстой гэхээсээ илүүтэйгээр бусдаас авахыг хатуу хориглох нь илүү үр дүнтэй. Авлига авахын эхний алхам бол бэлэг авах явдал юм⁸.

Төрийн албан хаагчийн төлөөллийн үйл ажиллагаа

Манай орны хувьд одоогийн эрх зүйн зохицуулалт нь тун хангалтгүй байна. Учир нь төлөөллийн үйл ажиллагааг ашиг сонирхлын зөрчлийн үүднээс авч үзээгүй учир энэ талын хязгаарлалт зохицуулалт бараг алга байна. Зарим албан хаагчийн төлөөллийн үйл ажиллагаа зарим тохиолдолд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөлийг бүрдүүлдэг. Латвийн Бүгд Найрамдах Улсын Төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд⁹:

1. Тухайн албан хаагч, түүний төрөл садан шалгах гэж буй асуудалд санхүүгийн болон өөр бусад хувийн сонирхолтой, мөн тухайн албан хаагч, түүнийн төрөл садан албан хаагчийн төлөөлдөг төр болон нутгийн удирдлагын байгууллагатай ашиг сонирхлын зөрчилтэй харилцаанд,

2. Албан хаагч болон түүнийн төрөл саданд орлого оруулдаг хувь хүн хуулийн этгээдтэй холбогдолтой харилцаанд,

3. Бусад ашиг сонирхлын зөрчил үүсгэж болох харилцаанд албан хаагч төрийн байгууллагыг төлөөлөхгүй гэж заасан байдаг.

Түүнчлэн Өмнөд Солонгост төрийн албан хаагч ажил эрхгийн

8. Агуулга болон гүйцэтгэх үүргийн хувьд хөрөнгө орлогын мэдүүлгээс ялгаатай.

9. Corrupt Practice Investigation Bureau, "Does and don'ts to public officers" <http://app.cpiib.gov.sg/>

харьцаатай этгээдийг ажил үүргийн хувьд харьцдаг албан хаагчтай танилцуулах замаар өөрт болон гуравдагч этгээдэд ашиг олохыг хориглосон байдаг.¹⁰

Хонгконгт төрийн албан хаагчийг ажил үүргээ гүйцэтгэхэд нь сөргөөр нөлөөлөх ямар нэг төлбөртэй буюу төлбөргүй ажил хавсран гүйцэтгэхийг хориглодог.¹¹ Харин "сөргөөр нөлөөлөх" эсэхийг хуулиар буюу эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр тогтоодог жишиг нэгэнт тогтжээ.

Төрийн албан хаагчид хэтэрхий бага цалин өгөх нь заримтохиолдолд хуулиас гадуур эдийн засгийн үйл ажиллагаа явуулах, хээл хахууль авах, эд хөрөнгө завших зэрэг үйлдлийг хийхэд хүргэдэг.¹²

Канад, Сингапур, Литва, Латва зэрэг оронд төрийн албан хаагч алба хашиж байхдаа ажил хэргийн хувьд харьцаж байсан хувийн болон бусад байгууллагад ажлаасаа гарсны дараа тодорхой хугацаанд алба хашихийг хориглодог. Ялангуяа энэ заалт төрийн өмчийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд оролцож байсан албан хаагчдад үйлчилдэг.¹³

3. ДҮГНЭЛТ БА САНАЛ ЗӨВЛӨМЖ

1. Авлигын эсрэг хууль батлагдан гарснаар авлига болон ашиг сонирхлын зөрчилд хамгийн их өртөх магадлалтай

10. Дэлхийн банкны Монгол Улсын авлигын эсрэг хуулийн төсөлд өгөх санал, 2005.05.11, 5 дахь тал.

11. Дэлхийн банкнаас Монгол Улсын авлигын эсрэг хуулийн төсөлд өгөх санал, 5 дахь тал.

12. Монгол Улсын Засгийн газар, НҮБХХ, Монгол дахь олон нийтийн санаа бодол, хандлагын судалгаа, 1999, 2000 он.

13. СИГМА, Ашиг сонирхлын зөрчлийн асуудлын талаар баримтлах бодлого, хэрэгжилт ба ерөнхий хорооны 9 орон, харьцуулсан судалгаа, СИГМА-№36, 2006 он, 30 дахь тал.

албан хаагчид хөрөнгө орлогын мэдүүлгээ гарган өгөх болсон нь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны эхний алхам болсон хэдий ч хөрөнгө орлогын мэдүүлгийг ашиг сонирхлын зөрчлийг илрүүлэх, шийдвэрлэхэд зохистой ашиглах талаар тодорхой ажил хийх шаардлагатай хэвээр байна.

2. Төрийн албаны тухай хуулийн нэг гол дутагдал нь уг хуулиар тогтоосон ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой зохицуулалт нь гагцхүү төрийн жинхэнэ албан хаагч¹⁴-д хамаарч байгаа явдал юм. Өөрөөр хэлбэл, энэ хууль төрийн улс төрийн болон үйлчилгээний албан хаагч, цаашлаад олон нийтийн байгууллага, хувийн хэвшилд ажилласдаг үйлчилдэггүй. Гэтэл "бараа бүх шатанд ашиг сонирхлын зөрчилдөөн тодорхой салбар болон системийг бүхэлд нь хамарсан шинжтэй болсноор улсын ба хувийн хэвшлийн хоорондох зааг хязгаар нэлээд бүдгэрсэн байна."¹⁵

3. Манай оронд Нийгмийн дэвшил, эмэгтэчүүдийн хөдөлгөөнөөс гаргасан "Төрийн албан дахь сонирхлын зөрчлийн менежментийн гарын авлага"-ыг эс тооцвол ашиг сонирхлын зөрчлийн талаар хийгдсэн судалгааны ажил, материал маш хомс байдаг. Үүнээс харахад ашиг сонирхлын зөрчлийн талаар олон нийт төдийгүй хуульч судлаачдын мэдлэг хомс байна гэж үзэж болохоор байна.

Монголд төрийн албанд ашиг сонирхлын зөрчил дор дурдсан зарим шалтгаанаас үүсдэг байна. Үүнд:

• Төрийн албаны үйл ажиллагаанд гарч буй ихэнх зөрчилд хариуцлага хүлээдэггүй байдал,

• Төрийн албан хаагчийн цалин хөлс нь тэдний амьжиргаанд нь хүрэлцдэггүй байдал,

14. Төрийн захиргааны болон тусгай албан хаагч юм.

15. АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг, Монгол Улс дахь Авлигын байдлыг хийсэн үнэлгээ, эцсийн тайлан, 2005.8.31, Dfd-1-00-03-00139-00, 1 дэх тал.

• "Цөөн" төрийн албан хаагчийн хариуцлагагүй, ёс зүйгүй, шударга бус үйл ажиллагаа,

• Монголын ард түмний эртнээс уламжлан ирсэн гэр бүлсрэг харилцаа, нутгархах байдал,

• Төрийн үйл ажиллагаанд дахь улс төрийн хэт нөлөөлөл,

• Төрийн үйлчилгээний үйлчилгээ хүрэлцээгүй, шуурхай бус, чанаргүй болон үйлчилгээний уян хатан бус байдал,

• Төрийн зарим байгууллагын дотоод хяналт шалгалт сул, ил тод бий байдал.

Ашиг сонирхлын зөрчил нь нийгэмд шинээр бий болсон зүйл биш бөгөөд сайн хууль тогтоомж гаргаснаар "устгах" үзэгдэл биш юм. Харин оновчтой зохицуулалт хийснээр ашиг сонирхлын зөрчлийг хамгийн бага хэмжээнд байлгаж, зөв шийдвэрлэх боломжтой юм. Үүнд: төрийн албан хаагчийн дотоод итгэл үнэмшил, ард түмний төлөө үйлчлэх ухамсар, олон нийтийн хяналт, төрийн үйл ажиллагааны ил тод байдал, эрх зүйн нарийн зохицуулалт зэрэг олон зүйл нөлөөлдөг. Өөрөөр хэлбэл, ашиг сонирхлын зөрчлийн асуудал нь гагцхүү төрийн албанд хамааралтай зүйл биш бөгөөд төрийн албан хаагчийн гэр бүл, найз нөхөд зэрэг нийгмийн бусад харилцаанд оролцогчид ч үүнийг нэгэн адил ойлгон ухамсарлаж, төрийн албан хаагчийг үүргээ биелүүлэхэд аливаа зүй бус аргаар нөлөөлөхгүй байх хэрэгтэй байна.

Санал – Юуны өмнө төрийн албан дахь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг шийдвэрлэх эрх зүйн зохицуулалт болон механизм бүрдүүлэх хэрэгтэй байна. Өөрөөр хэлбэл, авлигын нэг гол хүчин зүйл болсон ашиг сонирхлын зөрчлийг шийдвэрлэх асуудалд онцгой ач холбогдол өгч, түүний эрх зүйн зохицуулалтыг эргэн харж, улам боловсронгуй болгох үүднээс ашиг сонирхлын зөрчлийн асуудлыг иж бүрнээр зохицуулах эрх зүйн акт гаргах шаардлага зүй ёсоор урган гарч байна.



**ХЗҮТ-ийн Иргэний хууль
тогтоомжийн секторын
эрдэм шинжилгээний
ажилтан, хууль зүйн
магистр О.ОТГОНТУЯА**

Энэхүү нийтлэл нь гэр бүлийн эрх зүйн зарим төрлийн харилцаа болох гэрлэлт сэргээх, эцэг, эх тогтоолгох, үрчлэлтийн асуудал тэр дундаа хүүхдийг Монгол Улсын болон гадаадын улсын иргэнд үрчлүүлсний бүртгэл хэрхэн хийгдэж байгааг хөндөхийг зорилоо.

Гэрлэлт сэргээх асуудал:

Улсын дээд шүүх, Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв зэрэг байгууллагаас ирүүлсэн албан бичигт шүүхээр гэрлэлт сэргээлгэсэн гэрлэгчдийн тоог, гэрлэлт сэргээсний бүртгэл

ГЭР БҮЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗАРИМ ТӨРЛИЙН ХАРИЛЦАА

хийлгэсэн гэрлэгчдийн тоог гаргах боломжгүй гэсэн хариу ирүүлсэн.

Харин гэр бүлийн маргааныг шийдвэрлэсэн хавтаст хэрэгтэй танилцах явцад Сонгинохайрхан дүүргийн шүүхэд 2006 оны 12 дугаар сарын 12-ны өдөр нэхэмжлээ гаргаж, 2007 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр гэрлэлтийг сэргээхээр шийдвэрлэсэн байна.

Энэ хэргийг дэлгэрэнгүй авч үзвэл: Нэхэмжлэгч нь эмэгтэй, 49 настай, дээд боловсролтой, хариуцагч эрэгтэй, 49 настай, ямар боловсролтой талаархи мэдээлэл байхгүй, зохигчдыг хөдөлмөр эрхэлдэг эсэх талаар дурдаагүй байна. Зохигчид 2003 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн шүүхээр гэрлэлтээ цуцлуулсан бөгөөд хэн аль гэр бүл бололгүй 2004 оны 6 дугаар сараас хамтдаа амьдарч байгаад 2.5 жилийн дараа гэрлэлтээ сэргээлгэхээр шүүхэд нэхэмжлэл гаргасан

байна. Зохигчид 1981 онд гэр бүл болж, 1992 онд гэрлэлтээ бүртгүүлсэн байна. 1992 онд төрсөн хүү, 1998 онд төрсөн охинтой.

Гэр бүлийн маргааныг шийдвэрлэсэн тодорхой хэргүүдтэй танилцах явцад гэрлэлт сэргээсэн өөр тохиолдол байхгүй байсан нь Гэр бүлийн тухай хуульд зааснаар гэрлэгчид Иргэний гэр бүлийн бүртгэлийн байгууллагаар гэрлэлтээ сэргээсэн байх талтай бөгөөд цаашид энэ асуудлаар судалгаа хийх шаардлагатай харуулж байна.

Эцэг, эх тогтоолгох асуудал:

Гэр бүлийн хуульд зааснаар эцэг, эхийг шүүхийн болон захиргааны журмаар тогтооно. Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвөөс авсан статистик тоогоор захиргааны журмаар 2006 онд 2535, 2007 онд 2768 иргэнийг эцгээр тогтоосон байх бөгөөд энэ нь өмнөх оныхтой харьцуулбал 9.1 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгтээс үзвэл: Эцэг тогтоолт

№	Нэрс	1999	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007
1.	Архангай	25	11	9	30	4	40	21	9	13
2	Баян-Өлгий	22	-	-	-	1	-	-	2	-
3.	Баянхонгор	28	46	102	38	59	88	228	132	166
4.	Булган	41	11	14	32	27	4	58	71	42
5.	Говь-Алтай	3	19	38	42	50	82	152	80	123
6	Дорноговь	10	12	7	5	5	54	35	41	37
7.	Дорнод	4	26	6	4	3	1	10	8	22
8	Дундговь	9	7	-	2	-	3	8	12	35
9.	Завхан	21	2	-	2	-	3	8	12	25
10.	Өмнөхангай	12	44	61	51	35	86	244	347	168
11.	Өмнөговь	44	-	6	-	5	-	19	7	37
12.	Сүхбаатар	3	2	-	2	-	3	8	12	25
13	Сэлэнгэ	3	19	9	26	5	6	28	13	65

14.	Тов	39	21	30	61	82	138	150	99	93
15.	Увс	13	3	1	8	4	5	23	18	29
16.	Ховд	3	16	26	20	27	43	103	53	58
17.	Ховсгол	9	59	22	26	15	57	241	183	190
18.	Хэнтий	45	10	54	17	16	77	125	56	60
19.	Дархан	23	59	47	52	67	144	183	114	95
20	Улаанбаатар	2328	3047	2084	784	1335	888	1165	784	1096
21.	Орхон	-	-	-	-	1	170	417	349	286
22.	Говьсүмбэр	-	6	5	-	4	3	30	33	29
	Дүн	2685	3420	2541	1245	1805	1971	3395	2535	2768

Нийслэлийн шүүхийн архивын хавтаст хэрэгт судалгаа хийж үзэхэд Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн шүүхээр эцэг тогтоологхоор шийдвэрлэсэн нийт 9 хэрэг байгаа бөгөөд эцэг тогтоологхтой хамтатган тэтгэлэг гаргуулахыг хүссэн байх нь Гэр бүлийн хуульд эцэг, эх нь хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх үүрэгтэй гэж заасныг бодит байдалд хэрэгжүүлэхийн үндсэн нөхцөл болгон шүүхэд нэхэмжлэл гарган шийдвэрлүүлсэн нь хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хангахад чухал ач холбогдолтой байна.

Эцэг тогтоологхтой холбоотой хавтас хэрэгт дүн шинжилгээ хийсэн байдал

/Сонгинохайрхан, Чингэлтэй, 2007 онд шийдвэрлэсэн 9 хэрэг/

Эцэг тогтоологхоор шийдвэрлэсэн хавтаст хэрэгт дүн шинжилгээ хийхэд	Судалж үзэхэд
Гэр бүлийн тухай хуульд зааснаар эцэг тогтоологх нэхэмжлэлийг хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, төрөл, садангийн хүн, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах байгууллага буюу 14 нас хүрсэн хүүхдийн хэн нэгний өргөдлийг үндэслэн шүүх тогтооно. Эцэг, эх тогтоох маргааныг шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэнэ.	Шүүхэд хүүхдийн эцгийг тогтоологх тухай нэхэмжлэлийг хэн гаргасан эсэх: Хүүхдийн эх-9 /100 хувь/
Зохигчдын талаархи мэдээлэл /нас, хүйс, боловсрол, хөдөлмөр эрхэлдэг эсэх/	Нэхэмжлэгчийн нас: • 25-30 /4-44.5 хувь/ • 31-36 /2-22.2 хувь/ • 37-оос дээш /3-33.3 хувь/ Хариуцагчийн нас: • 25-30 /5-55.6 хувь/ • 31-36 /1-11.1 хувь/ • 37-оос дээш /2-22.2 хувь/ /1-11.1 хувь хэрэгт хариуцагчийн насыг дурдаагүй байна/ Нэхэмжлэгчийн боловсролын байдал: • Бүрэн дунд /4-44.4 хувь/ • Дээд /1-11.1 хувь/ /4 хэрэг буюу 44.5 хувь нэхэмжлэгчийн боловсролын байдлыг дурдаагүй байна/ Хариуцагчийн боловсролын байдал: • Бүрэн дунд /4-44.4 хувь/ /5-55.6 хувь хэрэгт хариуцагчийн боловсролын байдлыг дурдаагүй байна/ Нэхэмжлэгчийн хөдөлмөр эрхлэлтийн байдал: • Ажилтай /2-22.2 хувь/ • Ажилгүй /2-22.2 хувь/ /5-55.6 хувь хэрэгт нэхэмжлэгчийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг дурдаагүй байна/ Хариуцагчийн хөдөлмөр эрхлэлтийн байдал: • Ажилтай /2-22.2 хувь/ • Ажилгүй /2-22.2 хувь/ /5-55.6 хувь хэрэгт хариуцагчийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг дурдаагүй байна/

Үрчлэлт:

Гэр бүлийн хуульд зааснаар хүүхдийн эрх, ашиг сонирхлын үүднээс үрчлүүлнэ гэж заасан.

Иргэний бүртгэл, мэдээллийн

улсын төвөөс авсан статистик тоогоор улсын хэмжээнд 2006 онд 1838, 2007 онд 2378 хүүхэд Монгол Улсын иргэнд үрчлэгдсэн байна. Энэ нь өмнөх оноос 29.3 хувиар өссөн байна.

Үрчлэлт

№	Нэрс	1999	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007
1.	Архангай	43	49	65	46	37	99	289	69	106
2.	Баян-Өлгий	113	87	107	101	81	113	134	158	147
3.	Баянхонгор	35	69	74	23	49	41	348	86	111
4.	Булган	65	38	54	28	36	21	171	61	46
5.	Говь-Алтай	59	46	36	33	64	66	117	61	46
6.	Дорноговь	8	19	7	8	8	6	16	17	6
7.	Дорнод	2	5	45	41	69	46	117	74	96
8.	Дундговь	7	52	12	18	15	8	54	17	96
9.	Завхан	10	8	30	45	39	60	152	65	70
10.	Өвөрхангай	36	35	45	44	42	84	190	74	89
11.	Өмнөговь	77	7	5	13	4	-	12	12	36
12.	Сүхбаатар	1	22	28	26	14	35	43	15	34
13.	Сэлэнгэ	29	18	16	41	53	3	102	45	93
14.	Төв	12	38	30	62	46	81	142	90	83
15.	Увс	43	27	25	19	25	43	136	50	55
16.	Ховд	36	87	82	70	71	106	201	81	87
17.	Хөвсгөл	164	75	64	65	37	72	460	147	167
18.	Хэнтий	118	28	56	24	14	89	222	83	85
19.	Дархан	22	29	22	19	28	73	119	44	89
20.	Улаанбаатар	439	305	355	340	570	484	757	555	822
21.	Орхон	67	31	29	42	26	51	66	41	47
22.	Говьсүмбэр	14	4	1	-	4	-	19	10	17
	Дүн	1400	1079	1188	1108	1332	1581	3867	1838	2378

Монгол Улсын иргэнд хүүхэд үрчлүүлж байгаа дэлгэрэнгүй судалгааг (үрчлэгчийн нас, хүйс, гэр бүлтэй эсэх зэрэг) Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвөөс гаргах боломжгүй гэсэн.

Гадаад улсын иргэнд хүүхэд

үрчлүүлэх талаар Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв, Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны статистик тоо авахад зөрүүтэй байна.

Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвөөс авсан статистик

тоогоор 2007 онд 54 хүүхдийг гадаад улсын иргэнд үрчлүүлсэн нь өмнөх оныхоос 38.7 хувиар буурсан байна. Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албанаас авсан тоогоор 407 хүүхэд гадаад улсын иргэнд үрчлэгдсэн байна.

Гадаадын иргэнд үрчлэгдсэн хүүхдийн тоо

Он	Нийт хүүхдийн тоо
1999	17
2000	15
2001	42
2002	60
2003	91
2004	75
2005	93
2006	88
2007	54
Бүгд	407

Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албанаас авсан тоогоор 1999-2008 оны 5 дугаар сарын 8-ны өдөр хүртэл 174 гэр бүлд 182 хүүхэд үрчлэгдсэн

байна. Хүйсийн байдлыг авч үзвэл эмэгтэй хүүхэд 92 буюу 50.6 хувь, эрэгтэй хүүхэд 90 буюу 49.4 хувь байна. Үрчилж авсан улсаар нь авч үзвэл Америкийн Нэгдсэн Улс хамгийн их буюу 129

хүүхдийг үрчилж авсан байна.

Дээрх судалгааг хүснэгтээр үзүүлбэл:

1999 оноос 2008 оны 5 дугаар сарын 8-ны өдөр хүртэлх хугацаанд үрчлэгдсэн хүүхдийн судалгаа /хүйсээр/

№	Оноор	1999		2000		2001		2002		2003		2004		2005		2006		2007		2008.5.8.		Нийт	
		Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм
1	Үрчлэгдсэн хүүхэд хүйсээр	5	4	2	4	4	4	12	16	18	17	16	14	10	11	12	14	3	5	8	3	90	92
2	Үрчлэгдсэн хүүхдийн нийт тоо	9		6		8		28		35		30	21			26		8		11		182	
3	Хүчингүй болгосон үрчлэлт	-		-		-		-		-		-	1			-		1		-		2	

**1999 оноос өнөөг хүртэлх хугацаанд үрчлэгдсэн
хүүхдийн судалгаа /улсаар/**

№	Улсаар	Тоо
1.	АНУ	129
2.	ХБНГУ	16
3.	Франц	9
4.	Бельги	3
5.	Австрали	3
6.	БНСУ	6
7.	Англи	3
8.	Нидерланд	4
9.	Дани	1
10.	Итали	3
11.	Япон	1
12.	Испани	1
13.	Канад	3
Нийт		182

Гадаад улсын иргэнд үрчлэгдсэн хүүхийн насны байдал нь ихэвчлэн 0-4 насны хүүхэд байдаг байна.

Дээрх байгууллагаас ирүүлсэн тооны зөрүү нь 225 байгаа бөгөөд Монгол Улс хүнээ бүрэн бүртгэж нэгдсэн мэдээлэл хөтөлж чадахгүй байгааг харуулж байна.

Судалгааны баг Нийслэлийн шүүхийн архивт сууж шүүлт хийхэд Баянзүрх, Чингэлтэй дүүргийн шүүхээр 1999-2007 онд үрчлэлтийг хүчингүйд тооцуулахаар гаргасан нэхэмжлэл 32 байна.

Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албанаас ирүүлсэн статистик тоонд 2005, 2007 онд 2 хүүхдийн үрчлэлтийг хүчингүй болгосон байна. Ямар үндэслэлээр

үрчлэлтийг хүчингүй болгосон нь тодорхой бус байна.

Дүгнэлт:

1.Гэр бүлийн тухай Монгол Улсын хуулийн 15 дугаар зүйлд заасан гэрлэлт сэргээх асуудлыг ямар субъект шийдвэрлэх талаар нарийн зохицуулж шаардлагатай. Учир нь Иргэний бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд гэрлэлт сэргээхэд бүрдүүлэх баримт бичгийг зааж өгсөн ба үүнд гэрлэлт цуцалсан шийдвэрийг хүчингүй болгосон тухай шүүхийн шийдвэрийн хуулбар гэж заасан нь Иргэний бүртгэлийн байгууллага сэргээж болно гэсэн заалттай зөрүүтэй байна.

2.Гадаад улсын иргэнд хүүхэд үрчлүүлсэн тоо Иргэний бүртгэл, мэдээллийн улсын

төв болон Гадаадын иргэн харьяатын асуудал эрхлэх албаны статистик тоо зөрүүтэй байгаа нь Монгол Улс малаа сайн тоолж байгаа атлаа хүнээ хэрхэн тоолж эрх зүйн хамгаалалт үзүүлж байгааг харж болох юм. Иймд үрчлэгдэж байгаа хүүхдийн талаар дэлгэрэнгүй судалгааг тогтмол хийж, мэдээлэл, статистикийн архивтай болох шаардлагатай.

--оОо--



ОХУ-ын Эрхүү мужийн
Байгалийн эдийн засаг, эрх зүйн
Улсын их сургуулийн аспирант
С.БОЛОВСОН

Эдүгээ 16 жилийн нүүр үзэж буй Монгол Улсын Үндсэн хуулийн "Хүний эрх, эрх чөлөө" гэсэн 2 дугаар бүлгийн 16 дугаар зүйлд "Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй" хэмээн тусгасан нь иргэдийн хөдөлмөрлөх эрхийн эрх зүйн үндсийг баталгаажуулж өгсөн. Энэхүү үзэл санаанд үндэслэгдсэн Монгол Улсад хөдөлмөрийнгэрээгээр хөдөлмөр эрхлэгч иргэдийн хөдөлмөрлөх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулагч гол хууль нь Хөдөлмөрийн тухай хууль билээ.

Уг хууль нь ажилтны эрхийг харьцангуй хамгаалсан, бас дэмжсэн агуулгатай боловч ерөнхийдөө стандарт буюу жишиг хуулийн тоонд хамаарагддаг гэсэн манай улсын эрдэмтэн судлаачдын үзэл бодолтой би ч бас санал нэгтэй байдаг. Тухайлбал, долоо хоногийн ажлын цаг нь 40 хүртэл байна. Ердийн ажлын өдрийн үргэлжлэл

ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ

найм хүртэл цаг байна.¹ гэсэн заалт нь ажилтны нэг долоо хоногийн буюу нэг өдөрт ажиллах цагийн зөвхөн дээд хязгаарыг л тогтоосон хэрэг. Өөрөөр хэлбэл ажлын нэг өдөрт эсвэл ажлын нэг долоо хоногт тухайн ажилтан хэдэн цаг ажиллах вэ? гэдгээ ажил олгогчтойгоо харилцан тохиролцох эрхтэй байхаар хуульчилсан гэж ойлгож болох талтай.

Хөдөлмөрийн хууль шинэчлэгдэн мөрдөгдсөнөөсөө хойш даруй 10 шахам жилийн нүүр үзэх гэж байгаа ч, 1999 онд батлагдсанаасаа хойш өнөөдрийг хүртэлх хугацаанд нийтдээ 4 удаа, (2001, 2002, 2003, 2007 онд) түүний 50 шахам зүйл, хэсэг заалтад нь өөрчлөлт орсон байна. Энэ нь нийгмийн харилцааг даган тухайн харилцааг зохицуулагч хууль тогтоомж боловсронгуй болж байгаагийн илрэл юм.

Энд би дараахь цөөн хэдэн зүйлийг хөндөх гэсэн юм. Нэгдүгээрт "Хөдөлмөрийн тухай хууль"-ийн "Хөдөлмөрийн хяналт" гэсэн 14 дүгээр бүлгийн зүйл заалтад голчлон анхаарлаа хандуулахыг зорилоо.

Энэ бүлэгт хөдөлмөрийн хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгааг хяналт тавих эрх бүхий субъектын талаар заасан. Уг заалтаар Хөдөлмөрийн хяналт нь:

1. Улсын хяналт;
 2. Орон нутгийн хяналт;
 3. Олон нийтийн хяналт
- гэсэн хэлбэртэй байж болохоор харагдаж байна.

1. Хөдөлмөрийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэг. 2 дахь заалт.

• Улсын хяналтыг Улсын Их Хурал, Засгийн газар, бүх шатны Засаг дарга, хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, хуулиар эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан хэрэгжүүлнэ², гэснээс үзэхэд улсын мэргэжлийн хяналтын байгууллага, түүний эрх бүхий албан тушаалтан болох хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч нар хөдөлмөрийн хяналтыг хэрэгжүүлэгч гол субъект болох юм.

• Орон нутаг дахь хяналтыг аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга, хяналтын алба хэрэгжүүлнэ³ гэсэн нь мөн орон нутаг дахь мэргэжлийн хяналтын албад түүний эрх бүхий албан тушаалтан хэрэгжүүлж байгаа нь дамжиггүй билээ. Харин хуулиар эрх олгогдсон өөр бусад субъект болох аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргын хөдөлмөрийн хяналтыг хэрэгжүүлж байгаа үйл явц нь өнөөдөр төдийлөн тодорхой биш байна.

• Олон нийтийн хяналтыг ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах байгууллага, төрийн бус байгууллага, олон нийт хэрэгжүүлнэ⁴, гэсэн нь манай улсад хөдөлмөр эрхэлж буй иргэний хөдөлмөрлөх эрхийг төлөөлөн хамгаалах байгууллага болох Монголын Үйлдвэрчний эвлэл, Монголын чөлөөт үйлдвэрчний эвлэл, тэрчлэн үндэсний комисс

2. Монгол Улсын Хөдөлмөрийн хуулийн 139 дүгээр зүйлийн 139.1.1 дэх заалт.

3. Монгол Улсын Хөдөлмөрийн хуулийн 139 дүгээр зүйлийн 139.1.2 дахь заалт.

4. Хөдөлмөрийн хуулийн 139 дүгээр зүйлийн 139.1.3 дахь заалт.

гэх мэт байгууллага өөр өөрийн үйл ажиллагааныхаа зорилго чиглэлтэй уялдуулан хөдөлмөрийн хяналтыг хэрэгжүүлж байгаа. Энд энэ чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага байж болох юм.

Хуулийн дээрх заалт, түүний практик хэрэгжилт зэргийг харьцуулан үзэхэд хөдөлмөрийн хяналтыг хэрэгжүүлэгч субъект нь голчлон төрийн гэх статус бүхий байгууллага байна. Үүнээс үндэслэн ерөнхийдөө хөдөлмөрийн хяналтыг Засгийн газрын байгууллага хэрэгжүүлдэг гэж үзэж болох юм. Хөдөлмөрийн хяналтыг хэрэгжүүлэх процедур нь олон зүйлд чиглэгддэг учраас энд мэдээж бүгдийг нь авч үзэх боломжгүй билээ.

Хөдөлмөрийн хяналтыг хэрэгжүүлж буй байгууллагын гол зорилго нь хүний эрхийг хангах нөхцөлийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг болсон иргэдэд хөдөлмөр эрхлэх боломж нөхцөл бий болгох, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандарт заавар, журмыг төгс ойлгуулан, мөрдүүлж хэвшүүлэх явдал байдгаас улбаалан зөвхөн хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа болон хөдөлмөрлөх зарим эрхийн хэрэгжилтийн талаар хяналт тавьж буй зарим асуудлын талаар авч үзлээ.

Хоногийн гуравны нэгээс илүү хугацаагаа зарцуулдаг ажилтны ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчны нөхцөлийг сайжруулах асуудлыг хөдөлмөрийн хуулийн биелэлтэд хяналт тавих ажлыг өөрийн ажил үүргийн хүрээнд хариуцдаг гол

субъект болох хөдөлмөрийн хяналтын байцаагч, хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох стандартыг хэрхэн биелүүлж буйг шалгах замаар хэрэгжүүлдэг байна. Жишээлбэл, хөдөлмөрийн хяналтын чиглэлээр улсын мэргэжлийн хяналтын газар 2004 онд 6085 байгууллагад шалгалт хийж, 22.2 мянган зөрчил илрүүлж, уг зөрчлийн 81.6 хувийг арилгуулсан. Үүнээс хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн ноцтой зөрчил гаргасан 9 аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг бүрмөсөн, 56 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоож холбогдох арга хэмжээг авчээ⁵.

Сүүлийн жилүүдэд ажлын байрны сөрөг хүчин зүйлийн нөлөөллөөс болж үйлдвэрлэлийн осол болон мэргэжлээс шалтгаалах өвчний тоо ихэссээр байна. Ялангуяа сүүлийн 5 жилд мэргэжлээс шалтгаалах өвчнөөр өвчлөгсдийн тоо 463-522-оор нэмэгдсэн буюу 2.3 мянган хүн мэргэжлээс шалтгаалсан өвчтэй гэсэн онош тогтоолгон улмаар ажлын нөхцөлөө өөрчлүүлж, зарим нь хөдөлмөрийн чадвараа 40-75 хувиар алдсан⁶ гэсэн тоо баримт байна.

Энэ байдлыг салбараар нь авч үзвэл уул уурхай зарим эрчим хүч, барилгын салбарт ажиллагсдад зонхилон тохиолдож байгаа ба эдгээр салбарт ажиллагсдын 90 хувь нь уг өвчнөөр өвчилсөн байна⁷.

5. Улсын мэргэжлийн хяналтын газрын тайлан мэдээ, 2005 он.

6. Хүний эрх сэтгүүл, 2005 он, №4

7. Улсын мэргэжлийн хяналтын газрын тайлан мэдээ, 2005 он.

Шилжилтийн эдийн засагтай манай орны хувьд ажилгүйдэл ядуурлын байдлаас үүдэлтэйгээр гагцхүү өөрийнхөө наад захын амьжиргааг өөрөө хангах үүднээс буюу амин зуулгаа таслахгүй байхын эрхэнд олдож л байвал юу ч болов хамаагүй хийхэд бэлэн байгаа иргэдийн аргагүй байдлыг зарим ажил олгогчид овжноор ашиглан иргэн хүний хөдөлмөрлөх эрхийг нь зөрчин ажиллуулах явдал их байгаа. Зарим тохиолдолд албан бусаар /гар аргаар алт олборлох г.м/ эрх зүйн орчин бүрдээгүй хөдөлмөрийг ихээр эрхлэх болсон. Үүний нэг тод жишээ бол Хүний эрхийн үндэсний комисс, Монголын үйлдвэрчний эвлэлийн хороо, ажил олгогч эздийн нэгдсэн холбоо зэрэг газар хамтран нүүрсний 28 уурхай болон жонш, хайрганы үйлдвэр, хувиараа алт олборлогч 3800 гаруй иргэнийг хамруулан хөдөлмөрлөхтэй холбогдсон эрхийн төлөв байдал ямар байгаа, гол нь хүний суурь эрх хэрхэн хангагдаж буйд хяналт шалгалт хийхэд дараахь нийтлэг дутагдал илэрсэн байсан байна. Үүнд:

• Хөдөлмөрийн гэрээний агуулга нь хөдөлмөрлөх эрхийн зарим шаардлагыг хангахгүй байгаагийн зэрэгцээ хөдөлмөрийн гэрээг хөдөлмөрийн хууль болон хамтын гэрээ хэлэлцээрт нийцүүлдэггүй, хугацаатай гэрээний хугацааг тохирдоггүй, гэрээг албан ёсоор /гарын үсэг зурдаггүй/ болгон баталгаажуулж, ажилтанд нэг хувийг нь өгдөггүй.

• Хөдөлмөрийн гэрээний гол нөхцөлийг ажил олгогч ажилтан тохиролцон тусгах ёстой байтал ажил олгож буй

тал дангаараа урьдчилан бичиж гарын үсэг зуруулдаг.

•Ажил олгож буй байгууллага хөдөлмөрийнхөө дотоод журамд ажилтны албан тушаал, гүйцэтгэх ажлын онцлогт тохирсон эдлэх эрх, тэдэнд үзүүлэх хөнгөлөлт, тусламжийн талаар тодорхой нэр зааж тусгаагүй буюу бүрхэг байдлаар тусгасан.

•Зарим үед ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулахгүйгээр ажил үүрэг гүйцэтгүүлсэн.

•Илүү цагаар ажиллуулдаг атлаа илүү цагийн хөлс олгодоггүй буюу нөхөн амруулдаггүй.

•Байгууллага дээрээ хөдөлмөрийн маргаан таслах комисс ажиллуулдаггүй гэх мэт зөрчил маш элбэг байсан байна. Үүнтэй холбогдуулан судалгаа хийхэд уг судалгаанд оролцогсдын 30.7 хувь нь дараахь нийтлэг зөрчил буюу бэрхшээл тохиолддог гэж хариулжээ:

а.Гол төлөв гадаа ажилладаг тул хүйтэнд даарч халуунд хэт их халдаг.

б.Байнга чийгтэй нөхцөлд ажилладаг.

в.Хийж буй ажил дуу чимээ чичиргээ ихтэй.

г.Байнга босоогоор ажилладаг.

д.Байшинд ажилладаг цөөн хэсэг нь агааржуулалт хангалтгүй гэсэн байна.

Судалгаанд хамрагдагсдын 61 хувь нь ээлжийн амралтаа биеэр эдэлж чаддаггүй, 9.4 хувь нь ээлжийн амралтын олговроо авч чадаагүй, ахуйн

байр, хүйтэн, тохьгүй зэрэг нь бидний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна⁸ гэжээ.

Монгол Улсад хөдөлмөр эрхэлж буй хүн амын хөдөлмөрлөх орчин буюу хөдөлмөрийн секторыг албан болон албан бус гэсэн 2 хэсэгт хуваан авч үзэж болох юм. Тэгвэл өнөөдөр манай улсын хөдөлмөрийн насны хүн амын тэнхагасшахуунь хөдөлмөрийн албан бус салбарт ажиллаж байгаа бөгөөд хамгийн их зөрчил дутагдал гарч байгаа салбар нь мөн л хөдөлмөрийн албан бус сектор байгаа нь дээрх баримтаас харагдаж байна. Энэ их зөрчил дутагдал нь тодорхой нэг удаагийн буюу хэсэгхэн хугацааны үзлэг шалгалтаар л илэрч буй хэрэг. Хэдийгээр хөдөлмөрийн хяналтын талаар тодорхой заалт хуульд тусгагдсан ч тэрхүү хяналтыг хэрэгжүүлэх арга зам, мэргэжлийн байгууллагын хяналтын чиг үүрэг, түүний хэлбэрийг тусгасан заалт бараг байдаггүй.

Хүмүүс ихэнхдээ аливаа дутагдал зөрчил хуулийн "цоорхой", "хийдэл"-ийг олж хардаг боловч гарах арга замыг нь төдийлөн авч үздэггүй билээ. Иймээс дараахь хэдэн саналыг дэвшүүлж байна.

Нэгдүгээрт, Хөдөлмөрийн тухай хууль, түүний хэрэгжилтийг хангах, хянах эрх бүхий байгууллагын чиг үүргийг тодорхой болгох. Тухайлбал, Хөдөлмөрийн хяналтын олон нийтийн оролцоо, ялангуяа төрийн бус байгууллагуудын хяналтын оролцоог нэмэгдүүлэхэд чиглэгдсэн тодорхой заалтыг

хөдөлмөрийн хуульд тусгах;

Хоёрдугаарт, Хуулийг хэрэгжүүлэхэд хэрэглэж буй арга, хэрэгслүүд төдийлөн үр дүнтэй биш байгаа учраас Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох стандартыг өнөөгийн нөхцөлд нь зохицуулан ялангуяа ажил олгогч нарт нөлөөлөхүйц арга хэмжээ болох хариуцлага хүлээлгэх өөр төрлийн хэлбэр хэлбэрийг тусгаж өгөх, өөрөөр хэлбэл Хөдөлмөрийн хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын төрөл хэлбэрийг төгөлдөршүүлэх, өөрчлөлт оруулах, торгуулийн хэмжээг өөрчлөх шаардлагатай;

Гуравдугаарт, Зах зээлийн буюу одоо ч шилжилтийн эдийн засагтай байгаа манай улсын албан бус секторт ажиллагчдын хөдөлмөрлөх үйл ажиллагаатай холбогдсон асуудлыг хөдөлмөрийн тухай хуульд бүрэн дүүрэн тусгах, тодруулбал, энэ талаар тодорхой бүлэг, зүйл, заалтыг хуульд нэмэлтээр оруулах шаардлагатай. Тухайлбал, хувийн секторт ажиллаж буй эмэгтэйчүүдэд олгох жирэмсний амралт, ээлжийн амралт, өвчний чөлөө, хууль ёсны тэтгэмжүүдийн талаар тусгах гэх мэт. Дурдсан санал нь хууль тогтоомжийн үйлчлэл, түүнийг мөрдөх, хэрэгжүүлэх, хянах үйл явцтай харилцан хамааралтай асуудал тул хөдөлмөрийн хуулийг үр дүнтэй хэрэгжүүлж болох бас нэг алхам байж болох юм.

- -оОо- -

8. Хүний эрхийн үндэсний комисс. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний шлгэл, 2004 он.

**Д.ДҮГЭРЖАВ**

(Санхүүгийн зохицуулах
хорооны гишүүн, дэд дарга)

НЭГ. Үнэт цаасны зах зээлийн өнөөгийн байдал

Улс орны эдийн засгийг хувийн өмчид суурилсан зах зээлийн харилцаанд шилжүүлэх стратегийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд 1991 онд баталсан "Өмч хувьчлах хөтөлбөр"-ийн дагуу өмч хувьчлах ажлыг эхэлсэн нь Монгол Улсад үнэт цаасны зах зээл бий болох эх үүсвэрийг тавьсан билээ.

Үнэт цаасны зах зээлийн үүслийн шатыг үндсэн 2 хэсэгт хувааж болно.

1.Өмч хувьчлах хөтөлбөрийн хүрээнд томоохон үйлдвэрийн газрыг компанийн хэлбэрт оруулан өөрчлөн байгуулж, тэдгээрийн хувьцааг Хөрөнгийн биржид бүртгэн, нийт иргэдийг хувийн өмчтэй болгох зорилгоор үнэгүй тараасан нэг удаагийн төлбөрийн хэрэгсэл болох их хувьчлалын "Хөрөнгө оруулалтын эрхийн бичиг" буюу ард түмний нэрлэж заншсанаар "цэнхэр тасалбар"-аар худалдаж, иргэд компаниудын хувьцаа эзэмшигч болох үйл ажиллагаа явагдсан 1991-1995 он буюу эхний үе.

МОНГОЛ УЛСЫН ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВШИЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Хувьцааг хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр худалдах үнэт цаасны анхдагч зах зээлийн анхны арилжаа Монголын хөрөнгийн бирж дээр 1992 оны 2 дугаар сарын 7-нд эхэлснээс хойш 1995 оны 5 дугаар сар хүртэл 3 жил гаруй хугацаанд 193 удаагийн арилжаагаар 475 компанийн нийт 195,8 сая ширхэг хувьцаа арилжаалсан бөгөөд Монгол Улсын 1,2 сая гаруй иргэн хувьцаа эзэмшигч болсон юм. Эдгээр 475 компанийн 241-ийг бүрэн хувьчилж, 234 компанийн хувьцааны 5-90 хувь нь төрийн эзэмшилд үлдсэн.

2.Эзэмшсэн хувьцаагаа иргэд хоорондоо болон бусад этгээдэд бэлэн мөнгөөр худалдах арилжаа буюу үнэт цаасны хоёрдогч зах зээлийн үе.

1995 оны 8 дугаар сарын 28-ны өдрөөс "цэнхэр тасалбар"-аар худалдсан хувьцааг бэлэн мөнгөөр арилжих үйл явц буюу хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн ба өнгөрсөн 13 жилийн хугацаанд нийт дүнгээр 299.4 тэрбум төгрөгийн үнэт цаас арилжаалагдсан байна.

1996 оноос Засгийн газрын бонд, 2001 оноос компанийн бонд арилжаалагдаж эхэлсний зэрэгцээ 2005 оноос хаалттай компаниуд нээлттэй болж биржид бүртгэгдэн, хувьцаагаа нийтэд санал болгон худалдаж эхэлсэн бөгөөд энэ нь үнэт цаасны зах зээлийн хөгжлийн шинэ шатны эхлэл болсон юм. Өөрөөр хэлбэл үнэт цаасны

зах зээл нь өмч хувьчлалыг хэрэгжүүлэх арга хэрэгсэл байсан бол компаниудын хувьд санхүүжилтийн урт хугацааны тогтвортой, харьцангуй хямд эх үүсвэртатах, иргэд байгууллагын хувьд сул чөлөөтэй хөрөнгөө өсгөх хөрөнгө оруулалтын нэг сонголт, шинэ арга хэрэгсэл болж сонгодог утгаараа хөгжих эхлэл тавигдсан юм.

2006 оноос гадаадын хөрөнгө оруулагчдын оролцоо, сонирхол идэвхжиж, нэлээд хөрөнгө орж ирэх болсноор эрэлт нэмэгдэж, арилжааны ханш, хэмжээ өсөх хандлага бий болсон. Ялангуяа 2007 оны 7 дугаар сараас энэ хандлага тодорхой мэдрэгдэж байна.

Гэсэн хэдий ч үнэт цаасны зах зээл нь улс орны эдийн засаг, бодит салбарын санхүүжилтэд мэдэгдэхүйц үүрэг гүйцэтгэж чадахгүй хэвээр байгааг үнэт цаасны зах зээлийн арилжааны хэмжээ болон улс орны үнэт цаасны зах зээлийн хөгжлийн түвшинг тодорхойлох гол үзүүлэлт болох зах зээлийн үнэлгээг дотоодын нийт бүтээгдэхүүнд харьцуулсан үзүүлэлтийн өнөөгийн түвшин харуулж байна.

Үнэт цаасны арилжааны сүүлийн 5 жилийн үзүүлэлт дараах байдалтай байна:

Үндсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	2003 он	2004 он	2005 он	2006 он	2007 он
Үнэт цаасны арилжааны нийт дүн	Сая ₮	25 606.7	15 893.8	11 978.7	18026.7	102576.8
	ДНБ-д эзлэх хувь	0.019	0.009	0.005	0.567	2.2
ЗГ-ын бондын арилжааны дүн	Сая ₮	21 722.5	12 463.8	6 767.7	4 461.5	39599.3
	ДНБ-д эзлэх хувь	0.016	0.007	0.003	0.142	0.87
Компанийн бондын арилжааны дүн	Сая ₮	2 988.3	2 776.5	2 663.7	960.9	850.7
	ДНБ-д эзлэх хувь	0.002	0.002	0.001	0.032	0.018
Хувьцааны арилжааны дүн	Сая ₮	895.9	654.0	2 547.3	12604.3	62126.8
	ДНБ-д эзлэх хувь	0.001	0.0004	0.001	0.397	1.36
Бүртгэлтэй компаниуд	тоо	403	402	395	387	386

Хүснэгтээс харахад үнэт цаасны арилжаа 2002 он хүртэл идэвхжиж байснаа дараагийн 3 жилд нь эрс буурч, 2006 оноос өсөх хандлагатай болж, 2007 онд 102.6 тэрбум төгрөгт хүрсэн нь арилжаа хамгийн оргилдоо хүрсэн 2002 оны бүтэн жилийн хэмжээнээс 2 гаруй дахин илүү байна.

Он	Дотоодын нийт бүтээгдхүүн		Зах зээлийн үнэлгээ		ДНБ-д эзлэх хувь
	Өсөлт %	Нэрлэсэн үнэ /тэрбум ₮/	тэрбум ₮	сая US\$	
1995	6.3	550.3	12.80	27.1	2.33
1996	2.4	646.6	18.0	25.9	2.78
1997	4.0	832.6	43.3	53.2	5.20
1998	3.5	817.4	35.9	39.8	4.39
1999	3.2	925.3	34.4	32.1	3.72
2000	1.1	1 018.9	40.5	36.9	3.97
2001	1.0	1 115.6	41.3	37.5	3.70
2002	4.0	1 240.8	35.8	31.9	2.89
2003	5.5	1 362.5	49.5	42.4	3.63
2004	10.6	1 808.0	30.0	24.8	1.66
2005	6.2	2 489.2	55.7	45.6	2.20
2006	8.4	3 172.4	131.2	112.1	4.1
2007	9.9	4557.5	716.3	614.8	15.7

Бүртгэлтэй компанийн зах зээлийн үнэлгээ

Эх үүсвэр: Үндэсний статистикийн газар, Монголын хөрөнгийн бирж

Хүснэгтээс харахад зах зээлийн үнэлгээ хамгийн оргил үедээ 1997 онд 53.2 сая ам.долларт хүрч, ДНБ-ийн 5.2-ийг эзэлж байсан бөгөөд 2001 оныг дуустал харьцангуй өндөр түвшин хадгалагдаж байсан нь 1997-2001 онуудад компанийн хувьцааны хяналтын багцыг эзэмших, үнийн өсөлтөөс ашиг олохыг эрмэлзсэн хөрөнгө оруулагчдын зах зээл дээрх идэвхтэй үйл ажиллагааны үр дүнд үнэт цаасны эрэлт, түүнийг дагаад үнэ нь тасралтгүй өсч байсантай холбоотой.

Энэ үйл явцын дүнд хувьчлагдсан компаниудын хувьцааны хяналтын багц үндсэндээ цөөн тооны томоохон хөрөнгө оруулагчдын эзэмшилд төвлөрч, олон тооны жижиг хувьцаа эзэмшигчид цөөн хувьцаатай үлдсэн байна. Үүнийг дараах хүснэгтээс харж болно.

Хувьцааны төвлөрлийн судалгаа

/2008.02.02-ны байдлаар/

Эзэмшиж байгаа хувьцааны тоо	Хувьцаа эзэмшигчдийн тоо	Нийт дүнд эзлэх хувь
1-10 ширхэг хувьцаатай	70 792	18,9
11-50 ширхэг хувьцаатай	120 008	32,1
51-100 ширхэг хувьцаатай	71 317	19,1
101-1000 ширхэг хувьцаатай	107 480	28,7
1001-5000 ширхэг хувьцаатай	2 504	0,67
5001-10000 ширхэг хувьцаатай	417	0,11
10000-50000 ширхэг хувьцаатай	900	0,24
50001-100000 ширхэг хувьцаатай	221	0,06
100001-ээс дээш ширхэг хувьцаатай	307	0,08
Хувьцаа эзэмшигчдийн тоо	374 126	100,0

Эх үүсвэр: "ҮЦТТХТ" ХХК

Хүснэгтээс харахад нийт хувьцаа эзэмшигчдийн 98,8 хувь нь 1000 хүртэл, үүний дотроос 51 хувь нь дөнгөж 50 хүртэл тооны хувьцаа эзэмшиж байгаа бөгөөд бүртгэлтэй 386 хувьцаат компанийн хувьцааны хяналтын багц 1400 гаруй иргэний өмчлөлд төвлөрчээ. Ойролцоогоор нэг гэр бүлийн 3-4 гишүүн хувьцаа эзэмшигч байгаа, зарим гэр бүл хэд хэдэн компанийн хувьцааны хяналтын багцыг эзэмшиж байгааг харгалзан үзвэл бүртгэлтэй компанийн хяналт нь 400 орчим гэр бүлийн мэдэлд төвлөрөөд байна.

Үнэт цаасны зах зээлийн хөгжлийн түвшинг илэрхийлдэг үндсэн үзүүлэлт нь зах зээлийн үнэлгээг Дотоодын нийт бүтээгдэхүүнд харьцуулсан харьцаа байдаг.

Дэлхийн өндөр хөгжилтэй болон шилжилтийн эдийн засаг бүхий Улс орны хувьд дээрх харьцааг үзүүлэхэд:

Улс	Зах зээлийн үнэлгээ /сая ам. доллараар/		Зах зээлийн үнэлгээ ба ДНБ-ийн харьцаа /сая ам.доллараар/	
	2000	2005	2000	2004
Болгар	617	5,086	4.9	11.6
Чех	11,002	38,345	19.7	28.8
Герман	1,270,243	1,194,517	66.8	43.6
Унгар	12,021	32,576	25.8	28.5
Япон	3,157,222	3,678,262	66.5	79.6
Казахстан	1,342	3,941	7.3	9.7
Өмнөд Солонгос	171,587	718,180	33.5	63.1
Монгол	37	45.6	3.9	1.7
Польш	31,279	93,873	18.8	29.3
ОХУ	38,922	548,579	15.0	46.1
Их Британи	2,576,992	2,815,928	179.2	132.6
АНУ	15,104,037	16,323,726	154.7	139.4
Дэлхийн	32,187,883	38,904,431	103.1	96.3

Эх үүсвэр: Хөрөнгийн зах зээлийн мэдээллийг Standard & Poor's Global Stock Markets Fact book 2 2005

Дотоодын нийт бүтээгдэхүүний мэдээлэл ба Дэлхийн банкны мэдээллийн сан

Дээрх хүснэгтээс харахад өндөр хөгжилтэй Герман, Япон, Өмнөд Солонгос, Их Британи, АНУ зэрэг улсын хувьд хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2005 онд 718,2-1632,7 тэрбум ам.долларт хэлбэлзэж, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь нь 2004 онд 43.6 – 139,4 хувь байгаа ба Их Британи, АНУ-ын хувьд дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээг давсан үзүүлэлттэй байна.

Хөрөнгийн зах зээлийг жинхэнэ утгаар нь хөгжүүлэх нь эдийн засгийн өндөр хөгжлийн нэг чухал хүчин зүйл байдгийг дээрх баримт нотолж байна.

Манай оронтой нэгэн адил 1990-ээд оноос зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж буй Улс

орнуудын тухайд Чех, Польш, Унгар улсын зах зээлийн үнэлгээ нь ДНБ-дээ эзлэх хувь нь 2004 онд 28,5 – 29,3 хувьтай байна.

1998 оны эдийн засгийн хямралаас хойш ОХУ **нэгдүгээрт**, хөрөнгийн зах зээлийнхээ хөгжилд төрөөс онцгой анхаарч цогц бодлого хэрэгжүүлсэн, **хоёрдугаарт**, зах зээлийн багтаамж ихтэй, **гуравдугаарт**, гадаадынхан хөрөнгө оруулах сонирхолтой зэргийн улмаас хөрөнгийн зах зээл нь асар хурдтай хөгжиж байгаа бөгөөд дээрх үзүүлэлтүүд Чех, Польш, Унгар зэрэг орноос хол давж, хөрөнгийн зах зээлийн үнэлгээ нь 2005 онд 548,6 тэрбум ам.долларт хүрч, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 46,1 хувь болжээ.

Манай хөрөнгийн зах зээлийн хөгжил хуучин социалист Улс орнуудаас хол хоцорч, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь дөнгөж 15 хувь орчим байгаа нь үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх цогц бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Хөрөнгийн биржид бүртгэлтэй компанийн тоо олон боловч нэлээд хэсэг нь үнэн хэрэгтээ дампуурч, ямар ч хөрөнгөгүй болсон боловч хувьцаа нь хөрөнгийн биржид бүртгэлтэй хэвээр байгаа, барагталнь дөнгөж зардлаа нөхөх төдий хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг, цөөн хэдхэн компанийн хувьцаа идэвхтэй арилжаалагдаж байгаа нь хөрөнгийн биржийн листингийн шаардлагыг шинэчилж, бүртгэлтэй компанийг зэрэглэх, зэрэглэл бүрт тохирсон арилжааны тусгай хуваарь боловсруулж мөрдөх арга хэмжээ авах шаардлагатай болсныг харуулж байна. Энэ нь хөрөнгө оруулагчдын ашиг сонирхлыг хамгаалахад чухал ач холбогдолтой юм.

Бүртгэлтэй хувьцаат компанийн дийлэнх олонх нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа хийдэггүй, жижиг хувьцаа эзэмшигчдийг мэдээллээр хангадаггүй, хяналтын багц

эзэмшигчид нь бусдынхаа хувьцааг худалдан авахаар санал гаргах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байгаагийн зэрэгцээ компанийн хөрөнгийг дур мэдэн өөрийн эрх ашигт нийцүүлэн зарцуулах, ашигтай ажилласан ч ногдол ашиг хуваарилахгүй байх зэргээр олон тооны жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хохироох явдал түгээмэл байна.

Нөгөө талаар үнэт цаас гаргасан компани хувьцаа эзэмшигчдийнхээ өмнө хуулиар хүлээсэн үүргээ, хариуцлага болон үнэт цаасны талаар бүрхэг ойлголттой, олон тооны жижиг хувьцаа эзэмшигчдийн зүгээс компанийн үйл ажиллагаанд тавих хяналт сул байгаа нь компанийн удирдлага хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх нэг шалтгаан болж байна.

Өнгөрсөн 15 жилийн хугацаанд анх бүртгэгдсэн 475 хувьцаат компаниас 140 гаруй нь Хорооны бүртгэлээс хасагдаад байна. Хувьцаат компаниудын засаглалын байдлад хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулсан, санхүүгийн тайлангаа Хороонд ирүүлж, хэвлэлд нийтлүүлсэн, ногдол ашиг хуваарилсан, хувьцаа эзэмшигчдийн зүгээс үндэслэлтэй гомдол гаргаагүй зэрэг үзүүлэлтээр дүгнэлт хийж үзэхэд сайн засаглалтай 15, дунд 133, муу гэж дүгнэгдсэн компани 241 байна.

2006 оны эцэс, 2007 оны эхээр Хорооноос тусгай төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн үзлэг, шалгалтын зэрэгцээ үзэхэд бүртгэлтэй компанийн бараг 50-д хувийнх нь үйл ажиллагаа зогссон, 70 шахам компанийн хөрөнгө үрэгдэж, цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болсныг тогтоож, үйл ажиллагаа нь бүрэн зогссон, хувь нийлүүлэгчдийн хурлаа хуралдуулдаггүйгээс удирдлагынх нь бүрэн эрх дуусгавар болсон 166 хувьцаат компанийн үнэт цаасны арилжааг **нэгдүгээрт**, найдваргүй үнэт

цаас худалдан авч алдагдал хүлээхээс хөрөнгө оруулагчдыг хамгаалах, **хоёрдугаарт**, Хөрөнгийн биржийн бүртгэлийг олон улсын нийтлэг жишигт хүргэх бэлтгэлийг хангах зорилгоор зогсоох арга хэмжээ авалда байна.

Цаашид эдгээрийг Хөрөнгийн биржийн бүртгэлээс хасах, татан буулгах ажиллагааг хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт нийцсэн хэлбэрээр хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

20 хүрэхгүй жилийн өмнөөс хувьцаа хэлбэрээр хувийн өмчтэй болсон хөрөнгийн зах зээл, үнэт цаасны тухай ойлголт мэдлэг хомс жижиг хувьцаа эзэмшигчдийн зүгээс өмчлөх эрхээ хэрэгжүүлэх идэвх туйлын хангалтгүй, үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхээ хэрэгжүүлэх талаар ойлголтгүй, мэдээлэл авах боломж муу байгаа нь үнэт цаасны зах зээлийн хөгжлийг сааруулах нэг хүчин зүйл болж байгаа юм.

Иргэдийн идэвх оролцоо сул байгаагийн нэг жишээ нь өмч хувьчлалын үр дүнд хувьцаа эзэмшигч болсон нийт иргэдийн 40 хувь нь өнөөг хүртэл төвлөрсөн хадгаламжид дансаа ч нээлгээгүй байгаа явдал юм.

Компанийн бонд

Монголын хөрөнгийн зах зээл дээр анх 2001 онд Барилга корпораци “Шинэ зуун” бонд гарган арилжаалсан нь компанийн бондын зах зээлийн эхлэл болсон. Түүнээс хойш нийт 9 компани бонд гарган амжилттай арилжаалсан бөгөөд ихэнх нь барилгын салбарт ажилладаг компаниуд байна.

2007 оны байдлаар нийт 1 748 428 ширхэг бонд бүртгэгдсэн бөгөөд 2002 онд хамгийн их буюу 727 700 ширхэг бонд гаргасан. Нийт гаргасан бондын 32 хувийг Шинэ зуун бонд, 31 хувийг “Нийслэл өргөө бонд”, 35,1 хувийг бусад бонд тус тус эзэлж байна.

Зах зээлд тодорхой байр суурь эзэлсэн нэр хүндтэй компанийн бонд идэвхтэй арилжаалагдаж,

Тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагууд

Мэргэжлийн байгууллага	2001 он	2002 он	2003 он	2004 он	2005 он	2006 он	2008 он
Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага буюу "МХБ" ХК	1	1	1	1	1	1	1
"Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК /ҮЦТТХТ/	0	0	1	1	1	1	1
Брокер дилерийн компани	42	34	25	25	25	25	39
Андеррайтерийн компани	0	0	0	1	1	2	15
Хөрөнгө оруулалтын сан	6	2	2	2	0	0	0

санхүүгийн хямд эх үүсвэрийг богино хугацаанд олж болохыг "MCS электроникс" хариуцлагатай хувьцаат компани, "Говь" хувьцаат компанийн жишээ харуулсан.

Компанийн бондын арилжаа 2004 он хүртэл өссөнөө сүүлийн 2 жилд буурч эхэлсэн байна. Энэ нь банк бонд гаргаж байгаа компаниудад харьцангуй бага хүүтэй зээл санал болгосонтой холбоотой гэж мэргэжилтнүүд таамаглаж байна. Өөрөөр хэлбэл компаниуд бонд гаргасан явдал нь банкны зээлийн хүү буурахад тодорхой хэмжээгээр нөлөөлж байна. Компанийн бондыг Хороонд бүртгэхдээ бондыг эргэн төлөх баталгааг онцлон анхаардаг учраас хөрөнгө оруулагчдын эрсдэлийг багасгахад нөлөөлж байна. Үнэт цаасны зах зээл дээр гаргаж арилжаалсан компанийн бондын үндсэн болон хүүгийн төлбөр зарим үед хугацаа алдсан тохиолдол байсан боловч 100 хувийн эргэн төлөлтэй байгаа нь үүнийг гэрчилж байна.

Компанийн бондын хүү банкны зээлийн хүүгээс бага, хадгаламжийн хүүгээс их байдаг нийтлэг жишиг манай зах зээл дээр мөн ажиглагддаг. Компаниуд хөрөнгийн зах зээл дээр бонд гаргах замаар сард дунджаар 1.64 хувийн хүүтэй,

бонд гаргах зардлаа нэмээд сард дунджаар 1.85 хувийн өртөгтэйгээр харьцангуй урт хугацааны санхүүжилтийн эх үүсвэр олох боломж байгааг судлагаа харуулсан.

Харин банкны зээлийн хүү сард дунджаар 2,1-3,1 хувьтай байгаа учраас бондын санхүүжилт харьцангуй хямд байгаа юм.

Хөрөнгө оруулагчдын хувьд мөнгөө хадгаламж хэлбэрээр байршуулахын оронд компанийн бонд худалдах авах нь сард 0,44 хувиар илүү өгөөжтэй хөрөнгө оруулалт болно. Түүнээс гадна компанийн бондын хүүг 3, 6 сараар төлөх нөхцөлөөр гаргаж байгаа нь хөрөнгө оруулагчид хүүгээ богино хугацаанд аваад хэрэгцээндээ зарцуулах буюу дахин хөрөнгө оруулалт хийх боломж олгож байгаа давуу талтай.

Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн байгууллагууд

Санхүүгийн зах зээлийн бусад салбарын адил Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн зуучлагч байгууллагууд чухал үүрэг гүйцэтгэдэг.

2006 онд Санхүүгийн зохицуулах хорооноос "Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай" журмыг шинээр баталсантай

холбогдуулан мэргэжлийн байгууллагын тусгай зөвшөөрлийг шинэчлэн олгож байна. Мөн 2007 он гарсаар хэд хэдэн компани, түүний дотор Япон, Өмнөд солонгос, Малайз зэрэг гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл шинээр аваад байна.

Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн байгууллагын тоо цөөнгүй боловч санхүү, хүний нөөц, техник, программ хангамжийн хувьд өнөөгийн шаардлагад нийцэж байгаа компани цөөн, хувьцааны эрчимтэй төвлөрлийн үе буюу 1996-2000 онд үнэт цаасны мэргэжлийн байгууллагын ажилтнууд иргэдийн хувьцааг зөвшөөрөлгүй зарах, тэдгээрийн дансанд байсан мөнгөн хөрөнгийг шамшигдуулах, дотоод хяналт, эрсдэлийн удирдлага хангалтгүй байснаас Хөрөнгийн бирж 1.035 тэрбум төгрөгийг эрсдэлд оруулсан зэрэг хууль бус ажиллагаа, зөрчил гаргаж байсан нь үнэт цаасны зах зээлийн нэр хүнд унах, зах зээлд итгэх олон нийтийн итгэл алдагдахад нөлөөлсөн бөгөөд энэ итгэлийг сэргээхэд ихээхэн хүч чармайлт шаардах юм.

Мөн түүнчлэн хөдөө орон нутгийн харилцагчдад

үйлчилгээ хүрч чадахгүй хэвээр байна. Иймээс мэргэжлийн байгууллагын санхүүгийн чадавхи, техник программ хангамжийн байдал, үйлчилгээний соёл, ажиллаж буй мэргэжилтнүүдийн ёс зүй болон мэргэжил мэдлэг, ур чадварыг өнөөгийн шаардлагад нийцүүлэх талаар цогц арга хэмжээ авах шаардлагатай байна.

Манай орны хувьд одоогоор хамтын/институциональ/хөрөнгө оруулалтын байгууллага байхгүй байна. 90-ээд оны дундуур 16 Хөрөнгө оруулалтын санд эрх олгосон боловч эдгээр сангуудын үйл ажиллагаа тогтмолжиж чадалгүй татан буугдсан.

Даатгал, тэтгэврийн сангууд болон жижиг хөрөнгө оруулагчдын хөрөнгийг удирдан Үнэт цаасны зах зээлд оновчтой багцбүрдүүлэн, байршуулах, үнэт цаас гаргагчдын үйл ажиллагаа, зах зээлийн арилжааны явц, ханш тогтолтод өөрийгөө зохицуулах байгууллагын зүгээс үр нөлөөтэй хяналт тавихад чухал үүрэг гүйцэтгэх чадвартай хамтын хөрөнгө оруулалтын байгууллагуудыг бий болгон хөгжүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Олон улсын үнэт цаасны хороодын байгууллага¹ (IOSC) – ааставьсан үндсэн 3 зорилгойн нэг бол системт эрсдэлийг бууруулах буюу мэргэжлийн байгууллагууд дампуурах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, дампуурсан тохиолдолд харилцагчид, хөрөнгө оруулагчдад хохирол багатайгаар асуудлыг шийдвэрлэх боломжийг хангах явдал гэж үздэг боловч манай зах зээлийн хувьд энэ асуудал шийдвэрлэгдээгүй хэвээр байна.

¹ Манай улсын үнэт цаасны зах зээлийг зохицуулагч байгууллага 2003 онд тус байгууллагын гишүүнээр элссэн.

ХОЁР. МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

Дээр дурдсаныг үндэслэн Монголын үнэт цаасны зах зээлд тулгарч буй асуудлыг доорх хэдэн чиглэлээр тодорхойлж болно.

1. Монгол Улсын санхүүгийн салбар тэнцвэртэй хөгжлийн замд гарч чадаагүй, банк давамгайлсан өрөөсгөл бүтэцтэй, үүний улмаас өртөг өндөртэй хэвээр байна.

Сүүлийн үед Монголын хөрөнгийн зах зээл дээрх гадаадын хөрөнгө оруулагчдын оролцоо нэмэгдсэний үр дүнд цөөн хэсэг компанийн үнэт цаасны арилжаа идэвхжиж, ханш өссөнийг дагаад зах зээлийн үнэлгээ нэлээд нэмэгдэж байгаа боловч бүртгэлтэй компанийн тоотой харьцуулахад бага, ДНБ-д эзлэх хувь ялхгүй хэвээр байгаа нь олон улсын нийтлэг жишгээс ихээхэн зөрүүтэй байгаа бөгөөд эдийн засгийн бодит салбарын санхүүжилтэд хөрөнгийн зах зээл нөлөө үзүүлж чадахгүй байна.

2. Хөрөнгийн зах зээлийн зохицуулалт шаардлагын түвшинд хүрээгүй байна.

Хөрөнгө оруулагчид, ялангуяа жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, зах зээлийн эрсдэлийг бууруулах, үнэт цаас гаргагчид мэргэжлийн оролцогчдод тавих шаардлага, хүлээх хариуцлагыг өндөрсгөж, зах зээлд оролцогч байгууллагын санхүүгийн тайлагналд олон улсын стандартыг бодитой нэвтрүүлэх, аудитийн үйл ажиллагааг чанарын шинэ шатанд гаргах замаар зах зээлийн мэдээллийн бодит байдлыг хангах, мэдээллийг нээлттэй болгох, зохицуулах

байгууллагын эрх мэдлийг өргөжүүлэх чиглэлээр зах зээлийг зохицуулах хууль тогтоомжийг боловсронгуй болгох, зохицуулах байгууллагын чадавхийг бэхжүүлэх шаардлагатай байна. Зах зээлд өөрийн зохицуулалтын тогтолцоо бүрэлдэн тогтож чадаагүй байна. Зохицуулалтын энэ тогтолцоог дэмжиж, төрийн зохицуулалттай зөв уялдуулах шаардлагатай байна.

Хорооны зохицуулах чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал байна.

3. Дараах шалтгааны улмаас үнэт цаасаар хөрөнгө оруулалт хийх боломж хязгаарлагдмал, энэ зах зээлийн талаар хөрөнгө оруулагчдын мэдлэг, ойлголт сул, мэдээлэл авах боломж муу байгаа учраас хөрөнгө оруулагчид Хадгаламж зээлийн хоршоо мэтийн өндөр хүү амласан, эрсдэлтэй хэлбэрээр хөрөнгө оруулж хохирол хүлээх үзэгдэл гарч байна.

-Хөрөнгө оруулагчийн эрэлт хэрэгцээнд нийцэхгүйц үнэт цаасны зах зээлийн – бүтээгдэхүүний нийлүүлэлт бага;

-Хамтын хөрөнгө оруулалтын байгууллага буюу хөрөнгө оруулалтын сан хөгжөөгүй.

-Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах эрх зүй, зохицуулалтын найдвартай тогтолцоо байхгүйгээс эрсдэл өндөр;

-Бүртгэлтэй компанийн засаглалын байдал зах зээлийн хөгжилд тушаа болох хэмжээнд байгаа нь хөрөнгө оруулагчдын итгэлд саад учруулж байгаа;

-Үнэт цаас гаргагч, зуучлагч зэрэг зах зээлийн оролцогч байгууллагын нягтлан бодох бүртгэл, тайлагнал нь олон улсын стандартад нийцээгүй, аудитийн үйлчилгээний чанар шаардлагын түвшингээс хол

хоцорсон зэргээс хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах үндэслэл болдог мэдээллийн бодит байдлаа хангагдаагүй, зах зээлийн мэдээллийн тогтолцоо байхгүй учраас мэдээлэл авах боломж муу;

Биет, биет бус хөрөнгө газар эзэмших эрхийн болон бизнесийн үнэлгээний эрх зүйн зохицуулалт, онол арга зүй практик шаардлагын түвшинд хүрээгүй учраас үнэт цаас гаргагчийн ирээдүйн байдалд бодитой дүгнэлт өгөхөд хүндрэлтэй;

Энэ салбарт мэргэжлийн үйлчилгээ үзүүлж байгаа этгээд хариуцлагын даатгалд, хөрөнгө оруулагчдын хөрөнгийг хөрөнгийн даатгалд хамруулах тогтолцоо бүрдээгүй, эрсдэл өндөр зэрэг байдаг байна.

4. Үнэт цаас гаргах замаар санхүүжилтийн эх үүсвэр татах боломжийг бизнес эрхлэгчид болон бусад этгээд тэр бүр ашиглаж чадахгүй байгаагаас зах зээлийн нийлүүлэлт бага байна.

Зах зээлийн эрэлтэд нийцсэн Засгийн газрын үнэт цаасны гаргалт бага, Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээл хөгжөөгүй хэвээр байна. Бүртгэлтэй үнэт цаасны 70 гаруй хувь нь төрийн болон орон нутгийн өмчлөлд байгаа учраас эргэлтэд ордоггүй, төрийн болон орон нутгийн өмчийн болон эдгээр өмчийн оролцоотой компаниуд бонд гаргах, хувьцааны хяналтын биш багцыг худалдах, нэмж хувьцаа гаргах замаар үнэт цаасны зах зээлээс өртөг багатай санхүүжилт авах боломжийг ашиглах санаачилга гаргахгүй байна. Аймаг, нийслэлийн Засаг дарга нар үнэт цаас гаргах замаар тодорхой төслийг санхүүжүүлэх

боломж байгаа боловч, үнэт цаас гаргасан тохиолдол байхгүй байна.

Бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний тодорхой зах зээлд байр сууриа эзэлж, олонд танигдсан компаниуд нийтэд санал болгон хувьцаа гаргах замаар нээлттэй хувьцаат компани болон өөрчлөгдөж, санхүүжилтийн тогтвортой, харьцангуй хямд эх үүсвэртэй болох боломжтой боловч үүнийг ашигласан тохиолдол цөөн, тогтмол нийлүүлэлт хийх боломжтой арилжааны үнэт цаас гаргах эрх зүйн зохицуулалт байхгүй байгаа.

Ашигт малтмалын стратегийн орд газрын ашиглалтын лицензийг эзэмшигчид "Ашигт малтмалын тухай" хуульд заасны дагуу хувьцаагаа Монголын хөрөнгийн биржид бүртгүүлж арилжаалах үйл явц эхлээгүй, нэг үнэт цаасыг хэд хэдэн орны бирж дээр зэрэг арилжаалах боломж олгодог хадгаламжийн бичиг гаргах зэрэг зах зээлийн арга хэрэглүүрийг ашиглах эрх зүйн зохицуулалт байхгүй байгаагаас Монголын компаниуд гадаадын зах зээлд үнэт цаасаа гаргах нь идэвхжиж байна. Энэ зохицуулалтыг аль болох богино хугацаанд шийдвэрлэх нь ашигт малтмалын орд газрын ашиглалттай холбоотой улс төржсөн маргаан мэтгэлцээн, Монголын хөрөнгө оруулагчдын оролцооны асуудлыг ил тод шийдвэрлэх боломж олгож, хөрөнгийн зах зээлийн нийлүүлэлтийг олон зуу дахин нэмэгдүүлэн зах зээлийн хөгжлийг шинэ шатанд гаргах болно.

5. Үнэт цаасны зах зээлийн дэд бүтэц өнөөгийн шаардлагад нийцэн төлөвшиж чадаагүй, зах зээлд үйл ажиллагаа явуулж

буй мэргэжилтнүүдийн мэдлэг чадвар, ёс зүй хангалтгүй байна. 1990-ээдоноосхойш өнөөг хүртэл ажиллаж байгаа үнэт цаасны компаниудын санхүү, хүний нөөц болон техник, технологийн чадавхи, үйлчилгээний чанар өнөөгийн шаардлагаас хол хоцорч байна. Хөрөнгийн биржийн арилжааны болон үнэт цаасны төлбөр тооцооны техник, программ хангамж, технологи ч шаардлагын түвшинд хүрээгүй байна. Хөдөө орон нутагт үнэт цаасны зуучлалын үйл ажиллагаа хүрч чадахгүй байгаагаар холбогдож байна.

Зах зээлийн мэргэжлийн оролцогч байгууллагад тавих өөрийн хөрөнгө, санхүүгийн шалгуур үзүүлэлт, хүний нөөцийн болон техник, технологийн шаардлага сул, арилжаа, үнэ ханш тогтолт, дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцож байгаа эсэхэд тавих хяналтын тогтолцоо бүрэлдэн тогтож чадаагүй байна.

Цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ
Үнэт цаасны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр:

1. Зах зээлд зохих байр суурь эзэлж, нийтэд танигдсан компаниуд болон аймаг нийслэлийн Засаг дарга нар тодорхой төслийг санхүүжүүлэхээр үнэт цаас гаргахыг дэмжих, Засгийн газрын дунд болон урт хугацааны бонд гарган нийгмийн чиглэлийн арга хэмжээг санхүүжүүлэх бодлого баримталж, хоёрдогч зах зээлийг идэвхжүүлэх, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниуд хувьцаа бонд гаргах, төрийн мэдлийн хувьцааны хяналтын бус багцыг зах зээлийн үнийн өсөлттэй уялдуулан зах зээлд гарган худалдаж, санхүүжилтийн нэмэлт

эх үүсвэр бий болгох талаар уян хатан бодлого баримтлах, үл хөдлөх эд хөрөнгийн барьцаагаар баталгаажсан үнэт цаасны тухай хууль батлан гаргаж, ипотекийн үнэт цаасны хоёрдогч зах зээлийг хөгжүүлэх боломж бүрдүүлэх зэргээр үнэт цаасны зах зээлийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх;

2. Ашигт малтмалын стратегийн орд газрын ашиглалтын лицензийг эзэмшигчид "Ашигт малтмалын тухай" хуульд заасны дагуу хувьцаагаа Монголын хөрөнгийн биржид бүртгүүлж, арилжаалах ажиллагааг эхлүүлэх, нэг үнэт цаасыг хэд хэдэн орны бирж дээр зэрэг арилжаалах боломж олгодог хадгаламжийн бичиг гаргах зэрэг зах зээлийн арга хэрэглүүрийг ашиглах эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

3. Үнэт цаас гаргагч компанийн үйл ажиллагаанд компанийн засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээг төлөвшүүлэх замаар үнэт цаас гаргагчдын үйл ажиллагааг бүх оролцогч болон хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх, ашиг сонирхолд нийцсэн, ил тод байх явдлыг хангах;

4. Үнэт цаас гаргах боломжтой этгээдийн зах зээлийн талаарх ойлголт мэдлэгийг дээшлүүлэх, ажилтнуудыг нь сургах, давуу талыг сурталчлах;

5. Үнэт цаасны зах зээлийг идэвхжүүлэхэд чиглэсэн татварын бодлого боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байна;

Зах зээлийн дэд бүтцийн чиглэлээр:

1. Хөрөнгө, санхүү, техник технологийн болон хүний нөөцийн талаар мэргэжлийн байгууллагад тавих шаардлага, үйлчилгээний стандартыг өндөрсгөх замаар тэдгээрийн өрсөлдөх чадварыг

нэмэгдүүлэх, үйлчилгээний чанарыг шинэ шатанд гаргах;

2. Хамтын хөрөнгө оруулалтын хэлбэрийг /хөрөнгө оруулалтын сан, тэтгэврийн хуримтлалын сангууд/ хөгжүүлэх таатай орчин, хамтын хөрөнгө оруулалтын болон хөрөнгө итгэмжлэн удирдах харилцааны эрх зүйн орчныг бүрдүүлэх;

3. Хөрөнгийн биржийн арилжааны болон үнэт цаасны төлбөр тооцооны техник, программ хангамж, технологийг боловсронгуй болгох хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, үнэт цаасны төлбөр тооцоог суурхай, эрсдэлгүй гүйцэтгэх боломжийг судлан шийдвэрлэх;

4. Арилжааны банкууд Үнэт цаасны зах зээлд санхүүгийн зуучлалын үйлчилгээ үзүүлэх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх;

5. Зах зээлийн мэдээллийн нэгдсэн тогтолцоо бий болгох;

6. Мэдээллийн технологийн аюулгүй байдлыг хангах, электрон гарын үсгийн тухай зэрэг олон жил яригдсаар байгаа хуулийн төслийг батлан гаргах нь хөрөнгийн зах зээлийн үйлчилгээг хөдөө орон нутгийн иргэд, гадаадад байгаа нутаг нэгтнүүддээ хүргэх таатай орчныг бүрдүүлэх болно.

Хөрөнгө оруулагчдыг гэгээрүүлэх, мэдээллээр хангах, эрх ашгийг хамгаалах чиглэлээр:

1. Үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийх талаар олон нийтийг гэгээрүүлэхэд чиглэсэн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;

2. Хөрөнгө оруулагчдын мэдээллээр хангах талаар үнэт цаас гаргагчид, мэргэжлийн байгууллагын үүрэг хариуцлагыг тодорхой болгон хэрэгжилтийг хангуулах;

3. Хөрөнгө оруулагчдын эрх

ашгийг хамгаалах эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох, зохицуулах байгууллагын эрх мэдэл, чадавхийг дээшлүүлэх;

4. Мэргэжлийн байгууллагын дампууралтай холбогдон хөрөнгө оруулагчдад учрах эрсдэлийг зохицуулах асуудлыг судалж, шийдвэрлэх;

5. Мэргэжлийн үйл ажиллагааны хариуцлага, харилцагчдын хөрөнгийг даатгалд хамруулах асуудлыг судалж шийдвэрлэх.

Зах зээлийн хяналт зохицуулалтыг сайжруулах талаар:

1. Үнэт цаасны зах зээлийг зохицуулах, хянах эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгож, хяналт, зохицуулалтыг олон улсын стандартад нийцүүлэх;

2. Өөрөө зохицуулах тогтолцоо бүрдүүлэх, төрийн болон өөрөө зохицуулах байгууллагуудын үйл ажиллагааг зөв уялдуулах;

3. Үнэт цаасны арилжаа, зуучлалын шударга бус практикийг таслан зогсоож, дотоод мэдээлэл эзэмшигчдийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах;

4. Нягтлан бодох бүртгэл, үнэлгээ, аудитийн олон улсын стандартыг нэвтрүүлж, санхүүгийн мэдээллийн бодит байдлыг хангах;

5. Зохицуулах байгууллагын бүрэн эрхийг өргөжүүлэх замаар хөрөнгө оруулагчдын эрх ашгийг найдвартай хамгаалдаг тогтолцоо бүрдүүлэх нь зүйтэй байна.

- оОо -



МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Төр, захиргааны эрх зүйн тэнхимийн багш, Г.БАНЗРАГЧ (Ph.D)

1. Монгол Улсын санхүүгийн эрх зүйн хөгжлийн өнгөрсөн, одоо, ирээдүйн төлөвийн тухайд:

Монгол Улсад санхүүгийн эрх зүй нь 1977 оноос бие даасан салбар шинжлэх ухаан, эрх зүйн хэмжээнд хөгжих эхлэл нь тавигджээ.¹ БНМАУ-ын санхүүгийн эрх зүй гэдэгт социалист төрөөс мөнгөн хөрөнгийг төлөвлөгөөтэйгээр хуримтлуулах, хуваарилах, ашиглах хийгээд эдгээрт тавих хяналт шалгалтыг хэрэгжүүлэх явцад үүссэнийг мийн харилцааг зохицуулагч хэм хэмжээний нийлбэр цогцыг ойлгож байсан бөгөөд түүний ерөнхий анги нь 1/терийн санхүүгийн үйл ажиллагаа, түүний арга хэлбэр, улсын санхүү-зээлийн систем, санхүүгийн үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллага, тэдгээрийн эрх хэмжээ, 2/ санхүүгийн эрх зүйн зохицуулах зүйл, систем, 3/санхүүгийн эрх зүйн хэм хэмжээ, харилцаа, 4/санхүүгийн эрх зүйн хөгжил, 5/санхүүгийн хяналт шалгалт, түүний төрлөөс; харин тусгай анги нь 1/төсвийн эрх зүй, 2/ 1.1977 онд Д.Даваажуу, Д.Цэрэнпил нарын БНМАУ-ын санхүүгийн эрх зүй, 1987 он. С.Төмөр, Н.Банзрагч, С.Лүндэн нарын "Санхүүгийн эрх зүй" сурах бичиг хэвлэгдэжээ.

БАНКНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

улсын орлогын эрх зүй, 3/улсын зээллэгийн эрх зүй, 4/улсын даатгалын эрх зүй, 5/улсын зарлага, төсвийн санхүүжилтын эрх зүй, 6/банкны зээл, тооцооны эрх зүйн үндэс, 7/мөнгөний гүйлгээ, валютын хууль тогтоомж гэсэн хэсгүүдээс бүрдэж байжээ.² 1990 оныг хүртэл санхүүгийн эрх зүйн талаарх уг ойлголт, түүний тогтолцоо нь харьцангуй тогтонги байдалтай байсан гэж үзэж болно. Санхүүгийн эрх зүйн ач холбогдол, түүний чиг үүрэг ч нэлээд өндөрт тавигдаж байсан.

Харин 1990 оноос Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжсэнээр нийгэм, эдийн засгийн тогтолцоо бүхэлдээ шинэчлэгдсэн нь санхүүгийн тогтолцоонд, цаашлаад санхүүгийн эрх зүйн тогтолцоонд тодорхой өөрчлөлт гарах зайлшгүй нөхцөл бүрдсэн билээ. Нэг үгээр хэлбэл Монгол Улсын санхүүгийн эрх зүй нь шинэ чиг хандлагаар хөгжих үндэс бүрэлдсэн. Үүнийг тодруулбал, зах зээлийн эдийн засагт шилжин өмчийн олон хэлбэрийг хүлээн зөвшөөрснөөр санхүүгийн тогтолцооны бүрдэл болох банк, даатгал зэрэг салбарт төрийн монопольт байдал үгүй болсон, төрийн өмчийн үйлдвэр, аж ахуйн газрууд хувьчлагдсанаар хувийн санхүүгийн тогтолцоо бүрэлдсэн, түүнчлэн мөнгөн хөрөнгийн зарцуулалтыг үр ашигтай болгох зорилгоор төсвийн гадуурхи тусгай зориулалтын санг бүрдүүлсэн, түүнчлэн гаалийн эрх зүйн зохицуулалтыг хөгжүүлсэн зэрэг нь санхүүгийн тогтолцоонд өмнө байгаагүй шинэ институтыг бий 2.С.Төмөр, БНМАУ-ын санхүүгийн эрх зүй, 1987 он, 19-20, 32 дахь тал.

болгосон байна.³

Санхүүгийн эрх зүйг өнөөдөр "нийтийн ашиг сонирхлын тусын тулд төрөөс зорилт, чиг үүргээ хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай мөнгөн хөрөнгийн төвлөрсөн болон төвлөрсөн бус санг бүрдүүлэх, хуваарилах, ашиглах, түүнд хяналт тавих үйл ажиллагааны явцад үүсэх нийгэм, эдийн засгийн харилцааг зохицуулагч хэм хэмжээний цогц гэж үзэж байна.⁴ Монгол Улсын санхүүгийн эрх зүйн тусгай анги нь ерөнхийдөө:

- 1.төсвийн эрх зүй;
- 2.татварын эрх зүй;
- 3.төвлөрсөн төсвийн гадуурхи сангуудын эрх зүйн зохицуулалт;
- 4.терийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгжүүдийн санхүүгийн зохицуулалт;
- 5.нийгмийн даатгалын эрх зүйн зохицуулалт;
- 6.банкны үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, үүнд зээлийн болон мөнгөн гүйлгээ, тооцооны эрх зүйн зохицуулалт,
- 7.валют ба үнэт цаасны эрх зүйн зохицуулалт;
- 8.гаалийн эрх зүйн зохицуулалтаас бүрдэж байна.⁵ Эндээс үзвэл нэг талаас Монгол Улсын төрийн санхүүгийн өмнөх тогтолцоонд өөрчлөлт гарснаар төрийн санхүүгийн хүрээ харьцангуй цомхон болсон

3.Г.Банзрагч, Монгол Улсын санхүүгийн эрх зүйн хөгжлийн чиг хандлага, "Эрх зүй" сэтгүүл, №2-3, 2000 он 56-57 дахь тал.

4.Харьц С.Төмөр, Санхүүгийн эрх зүй, 2002 он, 7 дахь тал; Ш.Цогтоо, Б.Ургацаа, "Санхүүгийн эрх зүйн үндэс" УБ, 1999 он, 18 дахь тал. Г.Банзрагч, Монгол Улсын санхүүгийн эрх зүйн хөгжлийн чиг хандлага, 54 дахь тал

5.Мөн тэнд

боловч нөгөө талаас өмнө нь байгаагүй шинэ дэд салбарууд бий болсноор харин ч өргөжсөн мэт харагдаж байна. Энэхүү хэлбэрийн өөрчлөлтөөс гадна агуулгын буюу зарчмын гол өөрчлөлт нь өмнөх нийгмийн тогтолцоонд санхүүгийн эрх зүй нь үндсэндээ төрийн эрх ашгийг хангахад илүү чиглэгддэг байсан бол өнөөгийн санхүүгийн эрх зүй нь нийтийн эрх ашгийг хангах, санхүүгийн эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх ашгийг хамгаалах үүднээс захиран тушаах аргын зэрэгцээ диспозитив аргыг хослуулан хэрэглэх, иргэд, хуулийн этгээдүүдийн хууль ёсны ашиг сонирхол, өмчийн эрхийг нь хүндэтгэх, хамгаалах зарчимд тулгуурлаж байна. Түүнчлэн манай улсын санхүүгийн тогтолцоонд (тодруулбал төсөвт) олон улсын зээл, тусламж чухал байр суурь эзлэх болсноор олон улсын эрх зүйн хэм хэмжээ нь санхүүгийн эрх зүйд мөн тодорхой хэмжээгээр нөлөөлж байгааг дурдах хэрэгтэй болов уу.

Дээрхээс үүдэн Монгол Улсын санхүүгийн эрх зүй нь цаашид энэ чиг хандлагаар хөгжих үү эсвэл түүнд тодорхой өөрчлөлтүүд гарах хандлага, шаардлага байна уу гэсэн асуулт та бүхний анхаарлыг татаж магадгүй юм. Үүнд судлаачийн хувьд дараахь байдлаар хариулахыг оролдъё.

Дээрдурдсанхоёр өөр нийгэм, эдийн засгийн тогтолцооны үеийн санхүүгийн эрх зүйн талаарх тодорхойлолтоос үзвэл санхүүгийн эрх зүй нь өмнө нь ч, одоо ч нэгэн нийтлэг шинжтэй харилцааг зохицуулж байна. Энэ нь төрийн мөнгөн хөрөнгийн санг бүрдүүлэх, түүнийг хуваарилах, ашиглахтай холбоотой мөнгөөр илэрч байдаг эдийн засгийн харилцааны нэг төрөл юм.

Санхүү гэдэг нь латин үгнийхээ гарлын хувьд "finire" буюу мөнгөний маргааныг эцэслэх буюу мөнгийг төлөх

гэсэн утгаар анх дундад зууны үед, дараа нь XVI зууны үеэс төрд заавал төлөх татвар гэж нэрлэх болсон тэр үеэс нийтэд түгэн дэлгэрчээ. XVII зуун гэхэд санхүү гэдэг нэр томьёог төрийн орлого, зарлагын харилцаа буюу төрийн төлбөрийн хэрэгсэл хэмээн нийтлэг байдлаар ойлгох болсон байна. Харин XIX зууны үеэс уг нэр томьёо нь хувийн эдийн засгийн хүрээнд мөн хувь хүмүүсийн төлбөрийн хэрэгсэл хэмээн ойлгогдох болжээ.⁶

Эндээс үзвэл санхүү гэдэг нь төрийн хувьд өөрийн зардлаа хаах мөнгөн хөрөнгийн сан буюу шууд утгаараа төсвийг бүрдүүлэх, түүнийг аль болох үр ашгтай зарцуулах үйл ажиллагаа гэж ойлгогдож байна. Гэтэл орчин үеийн санхүүгийн эрх зүйн бүрдлүүдийг харвал төрийн санхүү нь өөрийн үндсэн утгаасаа хэт өргөн хүрээнд хэрэглэгдэж байна. Тухайлбал, банкны үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, түүнтэй холбоотой мөнгө зээлийн бодлого, валют ба үнэт цаасны эрх зүйн зохицуулалт нь төрийн санхүүгийн үйл ажиллагаа гэхээсээ илүү төрөөс эдийн засгийн харилцаанд оролцох эрх зүйн үндэс нь болж байгаараа агуулга, чиг үүргийн хувьд өргөн хүрээтэй гэж үзэх үндэслэлтэй юм. Үүнтэй холбоотойгоор "эдийн засгийн эрх зүй", "эдийн засгийн захиргааны эрх зүй"⁷ хэмээх шинэ ойлголт, салбар эрх зүйг хөгжүүлэх шаардлага үүсэж байна. Учир нь эдийн засаг нь нийгмийн оршин тогтнох үндэс, ард түмний амьдралын түвшинг ахиулах хөшүүрэг гэдэг нь нийтэд нэгэнт хүлээн зөвшөөрөгдсөн билээ. Төрөөс эдийн засгаа хөгжүүлэх, хөрөнгийн эх үүсвэрийг бэхжүүлэх, улмаар ард түмнийхээ амьдралыг

дээшлүүлэх нь эргээд төрийн санхүүг бүрдүүлэх гол суурь нь болох нь тодорхой юм. Үүнээс үүдэн төрөөс эдийн засгийн харилцаанд оролцогчдын үйл ажиллагааг зохицуулах, дэмжих түүнчлэн хянах нь зайлшгүй бөгөөд энэ харилцааг зохицуулсан хэм хэмжээний цогцыг "эдийн засгийн захиргааны (буюу удирдлагын) эрх зүй" гэнэ.⁸ Иймээс цаашид санхүүгийн эрх зүй нь төрийн орлого зарлагыг бүрдүүлэх хүрээнд төсөв, татвар, гаалийн эрх зүй зохицуулалтыг хамрах байдлаар, харин банк санхүүгийн байгууллагын зохион байгуулалт, мөнгө зээлийн бодлого, үнэт цаас, валютын эрх зүйн зохицуулалтын асуудлыг эдийн засгийн захиргааны эрх зүйн хүрээнд хамруулан хөгжүүлэх боломжтой гэж үзэж байна.

2. Банкны эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжсэнээр төрийн мөнгө, зээлийн бодлого, түүнийг хэрэгжүүлдэг банкны байгууллагын тогтолцоонд зарчмын үндсэн өөрчлөлт орсноор эрх зүйн цоо шинэ зохицуулалт бүрэлдэн бий болсон. Үүнд: Үндсэн хууль (тухайлбал, Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 25.1), Төв банкны тухай хууль (1996), Банкны тухай хууль (1996), Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль (1995), Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль (2002), Валютын зохицуулалтын тухай хууль (1994), Векселийн тухай хууль (1995), Хоршооны тухай хууль (1998), Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль (2005) зэргийг дурдаж болж байна.

6. Christoph Groepel, Allgemeines Steuerrecht, Finanzstaat, x.1, Ш.Цомоо, Б.Урзаацаа, "Санхүүгийн эрх зүйн үндэс", 7 дахь тал.

7. Эсвэл "Эдийн засгийн удирдлагын эрх зүй" гэж тодорхойлж болох юм.

8. Харцы, Rolf Stober, Allgemeines Wirtschafts-verwaltungsrecht, 1998 он, 10 дахь тал Werner Frotscher, Wirtschafts-verwaltungs- und Wirtschafts-verwaltungsrecht, 1994 он, 4 дахь тал

Монгол Улсын банкны тогтолцоо нь төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэгч Төв банк, иргэд, хуулийн этгээдтэй харилцах арилжааны банкууд гэсэн хоёр шатлалаас бүрдэнэ. Түүнээс гадна санхүүгийн харилцаанд банк бус санхүүгийн үйл ажиллагааг хэрэгжүүлэгч этгээд болон хоршоо нь санхүүгийн зарим төрлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэн оролцдог.

1.Төв банк

Монгол Улсын хэмжээнд төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагыг Монгол Улсын Төв банк гэх бөгөөд түүнийг Монгол банк гэж нэрлэдэг (хууль, 3 дугаар зүйл).

Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангах бөгөөд энэ хүрээнд санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй (хууль, 4 дүгээр зүйл). Төв банк нь дараахь чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг. Үүнд:

1/мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах;

2/эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлтийг зохицуулах замаар мөнгөний бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;

3/Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх;

4/банкны үйл ажиллагаанд хяналт тавих;

5/банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах;

6/гадаад валютын улсын нөөцийг эзэмшиж, зохицуулах (Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 5 дугаар зүйл).

Монголбанкны өөрийн гол чиг үүрэг болох мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхдээ а.банкны заавал байлгах нөөцийн хувь, хэмжээг тогтоох, б.банкинд олгох зээлийн хэмжээг тогтоох, в.зээл, үнэт цаасныхуу болон хямдруулалтын

хувиар дамжуулан хүүгийн нэгдсэн бодлого явуулах, г.нээлттэй зах зээлийн үйл ажиллагаагаа явуулах, д.банкаас олгох зээлийн үлдэгдэлд хязгаарлалт хийж болдог (Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 11 дүгээр зүйл). Харин иргэн, хуулийн этгээдэд санхүүгийн буцалтгүй тусламж үзүүлэх; ашиг олох зорилгоор хөдлөх ба үл хөдлөх хөрөнгө худалдан авах, худалдах; Засгийн газар болон банкнаас бусад хуулийн этгээд, иргэнд зээл, төлбөрийн болон банкны баталгаа гаргах; хуулийн этгээд, иргэний дотоод, гадаадаас авах зээлийг дэмжих зорилгоор алт болон нөөц активыг барьцаалах; улсын төсөвт тусгагдаж Улсын их хурлаар батлагдсан, хуулиар зөвшөөрснөөс бусад хуулийн этгээд, иргэний эдийн засгийн буюу арилжааны үйл ажиллагааг дэмжсэн тэнцлийн болон тэнцлийн гадуурхи аливаа гүйлгээ хийхийг Төв банкинд хориглодог (Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 23 дугаар зүйл).

Төв банкны хараат бус байдлыг хангах үүднээс түүнээс бусад төрийн байгууллага болон хувийн эрх зүйн хуулийн этгээдтэй хэрхэн харилцах талаар хуулиар зохицуулсан байдаг.

а/Монголбанк нь Улсын их хурал /УИХ/-тай харилцахдаа:

- М о н г о л б а н к н ы ерөнхийлөгчийг Улсын их хурлын даргын өргөн мэдүүлснээр Улсын их хурал 6 жилийн хугацаатайгаар томилох бөгөөд тэрээр үйл ажиллагаагаа Улсын их хурлын өмнө хариуцан тайлагнана. (хуулийн 26 дугаар зүйлийн 26.1).

-Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч болон дэд ерөнхийлөгчийг Монголбанкны ерөнхийлөгчийн санал болгосноор мөн Улсын их хурлаас 6 жилээр томилдог (хуулийн 26 дугаар зүйлийн

26.2).

-Ерөнхийлөгчдийг хуульд заасан үндэслэлээр Улсын их хурлаас албан тушаалаас нь чөлөөлнө (хуулийн 26 дугаар зүйлийн 26.6).

-Монголбанк нь төрийн мөнгөний бодлого, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, мөнгө, зээлийн байдлын талаар Улсын их хуралд улирал тутам танилцуулна (хуулийн 30 дугаар зүйлийн 30.1).

-Төрийн мөнгөний бодлогод тодорхойлсон үзүүлэлт нь Монголбанкны үйл ажиллагаанаас үл шалтгаалан эдийн засагт бий болсон нөхцөл байдлаас хамааран хэрэгжээгүй тохиолдолд энэ талаар Улсын их хуралд танилцуулна (хуулийн 30 дугаар зүйлийн 30.2).

-Монголбанк санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангаа жил бүр Улсын их хуралд танилцуулна (хуулийн 30 дугаар зүйлийн 30.3, 27 дугаар зүйлийн 1.9.4.)

-Улсын их хурал Монголбанкны үйл ажиллагаа хууль тогтоомжтой нийцжэ байгаа эсэхэд хяналт тавьж, дээр дурдсан тайлан, танилцуулгатай танилцах бөгөөд ингэхдээ төрийн мөнгөний бодлого хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцохгүй (хуулийн 30 дугаар зүйлийн 30.4).

Эндээс дүгнэвэл Монголбанк нь удирдлага, зохион байгуулалтын хувьд Улсын их хурлаас харьцангуй хараат боловч үндсэн чиг үүрэг болох мөнгөний бодлогоо бие даан хэрэгжүүлэх эрх зүйн баталгаатай байна. Түүнчлэн Монголбанкны Ерөнхийлөгч нь "албан тушаалтны хувьдаа" үйл ажиллагаагаа УИХ-ын өмнө хариуцна, харин Төв банк нь санхүүгийн болон үйл ажиллагааныхаа тайланг УИХ-д "танилцуулна" (тайлагнах юмуу хариуцах бус) гэснээс харвал Монголбанк нь хууль тогтоох байгууллагаас шууд хараат

бус, төрийн удирдлагын хэвтээ шугаман тогтолцоонд төвлөрсөн нэгдмэл удирдлагад үндэслэсэн мөнгө, зээл, валютын үйл ажиллагаа явуулдаг⁹ байгууллага хэмээн дүгнэж болохоор байна.

6/Монголбанк нь Засгийн газартай харилцахдаа:

-Монголбанк Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүргийг гүйцэтгэх, Засгийн газарт зээл олгох, гадаад валютын улсын нөөц нь УИХ-аас тогтоосон хэмжээнээс багассан, эсхүл гадаад валютын бодлогыг хэрэгжүүлэх болон улсын гадаад төлбөр тооцоог шуурхай явуулах боломжолд байсан Монголбанк тодорхойлсон нөхцөлд Засгийн газартай хамтран холбогдох арга хэмжээ авна. (хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1).

-Засгийн газрын шийдвэр төрийн мөнгөний бодлогод харшилж байвал Монголбанк энэ талаар Засгийн газарт мэдэгдэнэ. (хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3).

-Монголбанкны Ерөнхийлөгч Монголбанк болон банкны үйл ажиллагаатай холбогдох асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэхэд зөвлөх эрхтэй оролцож болно (хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4).

-Монголбанк нь мөнгөний статистик мэдээлэл болон жилийн тайлангаа Засгийн газарт хүргүүлнэ. (хуулийн 31 дүгээр зүйлийн 31.5).

-Монголбанк Засгийн газраас хараат бус байна (хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2).

Дээрхээс дүгнэвэл, Монголбанк нь удирдлага, зохион байгуулалтын хувьд Засгийн газартай огт хамааралгүй, үйл ажиллагааны хувьд бие даасан, шаардлагатай бол түүнтэй эрх тэгш субьектын хувьд хамтран ажиллах эрхтэй байна.

в.Монголбанкнаас арилжааны банктай харилцахдаа:

-Монголбанк нь мөнгөний бодлогоо хэрэгжүүлэх хүрээнд
9 С.Төмөр, "Санхүүгийн эрх зүй", УБ.,
182 дахь тал.

арилжааны банкны заавал байлгах нөөцийг тогтоон түүнд хяналт тавих, зээл олгох, банкнаас олгох зээлийн үлдэгдэлд хязгаарлалт хийх (тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 12. 13, 16.)

-Монголбанк нь банкны үйл ажиллагаанд хяналт тавих. Үүнд хадгаламж эзэмшигч, харилцагчдын эрх ашгийг хамгаалах, банкинд зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, хязгаарлалт хийх, шаардлага тавих гэх мэт (хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.) Монголбанк нь энэхүү хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулж буй банкны дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцож болохгүй (хуулийн 32 дугаар зүйлийн 32.2).

-Монголбанк нь банк хоорондын төлбөр тооцоог хийх (хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.)

Эдгээр зохицуулалтаас харвал Монголбанк нь арилжааны банкуудтай босоо харилцаанд буюу зохицуулагч, хянагчийн байр сууринаас харилцдаг байна.

2. Арилжааны банкууд

Арилжааны банк гэдэг нь хувь нийлүүлэгчдийн оруулсан мөнгөн хөрөнгөөс бүрдсэн дүрмийн сантай, хувь нийлүүлэгчид нь оруулсан хөрөнгийнхөө хэмжээгээр санхүүгийн хариуцлага хүлээдэг, бусдын мөнгөн хөрөнгийг хуримтлуулан хадгалж, өөрийн нэрийн өмнөөс зээл олгох, төлбөр тооцоо зэрэг санхүүгийн зуучлалын ажил, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг Монголбанкны тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлдэг, ашгийн төлөө хуулийн этгээд юм. (Банкны тухай хуулийн 3 дугаар зүйл). Төсвөөс санхүүждэг хуулийн этгээд, шашны болон олон нийтийн байгууллага, энэрэнгүй үйлсийн сангаас бусад хуулийн этгээд, иргэн нь хуульд заасан баримт бичгийг

бүрдүүлэн Монголбанкнаас зөвшөөрөл авсны үндсэн дээр банк байгуулж болно. (Банкны тухай хуулийн 17, 18, 20 дугаар зүйл.) Банк үүсгэн байгуулахад бүрдүүлэх баримт бичигт өргөдөл; үүсгэн байгуулах гэрээ; банкны дүрэм; эдийн засгийн үндэслэл; үүсгэн байгуулагч болон тухайн банкны дүрмийн сангийн 10 буюу түүнээс дээш хувийг эзэмших этгээдийн нэр, хаяг, хувь нийлүүлэгч аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны сүүлийн 2 жилийн аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан; Монголбанкнаас баталсан маягтын дагуу бүрдүүлж өгсөн банкны удирдлага, боловсон хүчин, техник, тоног төхөөрөмж, ажлын байрны талаархи тодорхойлолт хамаарна (Банкны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.) Гадаадын хөрөнгө оруулалттай банк, банкны салбар, төлөөлөгчийн газар байгуулах зөвшөөрөл авахад дээр дурдсан баримт бичгээс гадна Монгол Улсын нутаг дэвсгэр дээр банк, банкны салбар, төлөөлөгчийн газар байгуулах тухай гадаадын банк, санхүүгийн байгууллагын гаргасан шийдвэр; банк, санхүүгийн байгууллагыг тухайн Улс орондоо бүртгэгдсэн болохыг нотлох баримт, аудитын байгууллагаар баталгаажуулсан сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан болон хуульд заасан бусад баримт бичгийг нэмж бүрдүүлнэ (Банкны тухай хуулийн 19 дүгээр зүйл.)

Арилжааны банк нь Монголбанкны зөвшөөрөлтэйгээр мөнгөн хадгаламж; зээл; төлбөр тооцоо; өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргах; гадаад валют худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах; үнэт металл, эрдэнийн чулуу худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах; үнэт зүйл хадгалах; гадаад төлбөр тооцоо хийх; үнэт цаас гаргах, худалдах,

худалдан авах; хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөмж мэдээлэл өгөх; хууль тогтоомжоор хориглоогүй бөгөөд Монголбанкнаас зөвшөөрсөн санхүүгийн бусад ажил үйлчилгээ эрхэлж болдог (Банкны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.)

Банк нь ашиг олох зорилгоор банкны бус үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно. Банк, түүний харилцагч болон гуравдагч этгээд нууц гэж үзсэн аливаа мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд бусад гаргаж өгөх, задлах, ашиглахыг банкны хувь нийлүүлэгч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал, ажилтанд хориглоно. Түүнчлэн дангаараа буюу бусадтай хамтран санхүүгийн зах зээл дээр ноёрхох, өөр хоорондоо, эсхүл гуравдагч этгээдэд шударга бусаар давуу байдал бий болгоход чиглэсэн үйл ажиллагаа явуулах, ийм үйл ажиллагаанд оролцох; өөрийн үйл ажиллагааны талаар буруу ташаа зар сурталчилгаа хийх, мэдээлэл өгөх; улс төрийн аливаа нам, эвсэлд хандив өгөхийг хориглодог. (Банкны тухай хуулийн 7 дугаар зүйл.) Банкны дүрмийн сан нь хувь нийлүүлэгчдийн оруулсан мөнгөн хөрөнгөөс бүрдэх бөгөөд түүний доод хэмжээ нь 1 тэрбум төгрөг байна (Банкны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2.)

3. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээд

Банк бус санхүүгийн үйл ажиллагааг эрхлэх этгээд гэдэг нь Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж буй Монгол Улсын болон гадаад улсын хуулийн этгээдийг хэлнэ. (Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.)

Уг үйл ажиллагаа эрхлэхийг хүсэж буй этгээд нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай

зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д заасан болон Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан бичиг баримтыг бүрдүүлэн Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлнэ. Санхүүгийн зохицуулах хороо нь баримт бичгийг 30 хоногийн дотор хянаад, хэрэв уг үйл ажиллагааг эрхлэх этгээдийн дүрмийн сан нь Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хэмжээнд хүрсэн; бизнес төлөвлөгөөнд банк бус санхүүгийн үйл ажиллагааг амжилттай эрхлэх стратеги, нөлөөлөх хүчин зүйлийг оновчтой тусгаж чадсан; тухайн банк бус санхүүгийн байгууллагын удирдлага нь зээлийн гэрээ буюу баталгаагаар хүлээсэн, хугацаа хэтэрсэн аливаа өргүй, ял шийтгэлгүй, ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь банк бус санхүүгийн байгууллагыг удирдахад харшлахгүй байх шалгуурыг хангасан; гүйцэтгэх удирдлага нь банк, санхүүгийн мэргэжилтэй, тухайн салбарт ажилласан туршлагатай; уг үйл ажиллагааг явуулахад шаардагдах техник, тоног төхөөрөмж, аюулгүй ажиллагааны шаардлагыг зохих түвшинд хангасан бол тусгай зөвшөөрөл олгоно (Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.)

Банк бус санхүүгийн үйл ажиллагаанд зээл; факторингийн үйлчилгээ; төлбөрийн баталгаа гаргах; төлбөр тооцооны хэрэгсэл гаргах; цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ; гадаад валютын арилжаа; итгэлцлийн үйлчилгээ; богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх; хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагаа хамаарна. (Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1)

Банк бус санхүүгийн

байгууллага нь (ББСБ) тусгай зөвшөөрөлд зааснаас өөр үйл ажиллагаа эрхлэх; өөрийн үйл ажиллагааны талаар буруу ташаа зар сурталчилгаа хийх, мэдээлэл өгөх; иргэн хуулийн этгээдээс хадгаламж авах, хадгаламжийн данс нээх; чек, карт, вексель зэрэг төлбөрийн хэрэгслээр хадгаламж авах; банк бус санхүүгийн байгууллагын тайлан тэнцэлд тусгаагүй эх үүсвэрийг өөрийн үйл ажиллагаанд ашиглахыг хориглоно. (Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.)

4. Хоршоо

Санхүүгийн үйл ажиллагаа эрхлэгч бас нэгэн хуулийн этгээд бол Хоршоо юм. Хоршоо гэдэг нь эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн этгээд сайн дураараа нэгдсэн, ардчилсан, хамтын удирдлага, хяналт бүхий, дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар хамтран байгуулсан хуулийн этгээдийг хэлнэ. (Хоршооны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.) Хоршооны эрхэлж болох үйл ажиллагааны нэг төрөл нь хадгаламж, зээл юм (Хоршооны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4.3.) Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоо нь 20-оос доошгүй гишүүнтэй байна (Хоршооны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48-1.1.)

Хадгаламж, зээлийн хоршооны өөрийн хөрөнгө нь гишүүдийн оруулсан хувь хөрөнгө, нөөц сан, хуваарилдагагүй орлого, хандив, нийгмийн хөгжлийн сан болон тухайн жилийн цэвэр ашгаас бүрдэнэ (Хоршооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.) Хадгаламж зээлийн хоршоо үйл ажиллагааныхаа улмаас бий болсон үүргийг өөрийн хөрөнгөөр хүлээнэ (Хоршооны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.)

Хоршоо нь зохион байгуулалт бүтэц, үйл ажиллагааны хувьд арилжааны банк болон банк бус санхүүгийн байгууллагатай харьцуулбал харьцангуй бие даасан (тусгай зөвшөөрөл авах шаардлагагүй, үйл ажиллагааныхаа зарчмыг өөрсдөө тодорхойлдог) боловч үзүүлэх үйлчилгээний хамрах хүрээ нь хязгаарлагдмал (зөвхөн өөрийн гишүүдэд, зөвхөн хадгаламж болон зээл олгох боломжтой) шинжтэй юм.

5. Санхүүгийн зохицуулах хороо

Санхүүгийн зохицуулах хороо нь (СЗХ) санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага юм. (Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.)

Санхүүгийн зохицуулах хороо нь Улсын их хурлаас хараат, түүний дор ажилладаг байгууллага болох нь дараахь харилцаанаас харагдана:

- Санхүүгийн зохицуулах хорооны удирдлага, үйл ажиллагааг нь Улсын их хурлаас тодорхойлдог. Санхүүгийн зохицуулах хорооны даргад нь Улсын их хурлын дарга, 6 гишүүдэд Улсын их хурлын Эдийн засгийн байнгын хороо хоёр хүний, Хууль зүйн болон Төсвийн байнгын хороо, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монголбанкны ерөнхийлөгч тус бүр нэг хүний нэр дэвшүүлж, УИХ-аас 5 жилээр томилоно. (Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2, 12 дугаар зүйлийн 12.1.)

- Хороо нь эргээд Улсын их хуралд хуулийн хэрэгжилт, санхүүгийн болон үйл ажиллагааныхаа талаар жил

түтэм тайлагнадаг. (Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.)

- Улсын их хурлаас түүний үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд хяналт тавьдаг (Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.)

Харин Санхүүгийн зохицуулах хороо нь Засгийн газар, Монголбанк, санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай хараат бус, харилцан тэгш эрхийн зарчим дээр хамтран ажилладаг гэж хэлж болно. Тухайлбал, Хороо нь Монголбанк, санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, түүнийг хөгжүүлэх, зохицуулах, хяналт тавих чиглэлээр өөр хоорондоо уялдсан үйл ажиллагаа явуулах, үр ашгийг нь нэмэгдүүлэх зорилгоор хамтран ажиллах гурван талт харилцан ойлголцох санааж бичгийг үйлдэн, түүнийгээ удирдлага болгон ажилладаг (Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.) Засгийн газрын хуралдаанд холбогдох асуудлаар зөвлөх эрхтэйгээр оролцдог байна. (Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.)

Санхүүгийн зохицуулах хороо нь банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд болон хоршооны хадгаламж, зээлийн үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий этгээд юм.

Тэрээр банк бус санхүүгийн байгууллагатай харилцахдаа:

- түүнд санхүүгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох (Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.) хуульд заасан тохиолдолд банк бус санхүүгийн байгууллагыг өөрчлөн байгуулах, татан буулгах зөвшөөрөл олгох (Банк

бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.)

- эрхлэх үйл ажиллагааных нь талаар дүрэм, журам гаргах (тухайлбал, дүрмийн санг тогтоох, санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг тогтоох)

- үйл ажиллагаанд нь хяналт тавих, шалгалт хийх, зөрчилд арга хэмжээ авах (Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 19 дүгээр зүйл),

- холбогдох хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, өөрийн шийдвэрийн биелэлтэд хяналт тавих, шалгалт хийх, хуульд заасан тохиолдолд хариуцлага хүлээлгэнэ. (Санхүүгийн зохицуулах хорооны тухай хуулийн 24 дүгээр зүйл, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 20 дугаар зүйл.)

Түүнчлэн Санхүүгийн зохицуулах хороо нь өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар банк бус санхүүгийн байгууллагуудын хооронд болон Банк бус санхүүгийн байгууллага, түүний үйлчлүүлэгчдийн хооронд үүссэн маргааныг урьдчилан шийдвэрлэх эрхтэй. (Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.)

Санхүүгийн зохицуулах хороо нь хадгаламж, зээлийн хоршоотой Хоршооны тухай хуульд заасан хадгаламж, зээлийн үйл ажиллагаанд хяналт тавих байдлаар харилцана. (Санхүүгийн зохицуулах хорооны тухай хуулийн 3.1.5, 6.1.1 зүйл.)

Энэ бүхнээс үзвэл Монгол Улсын банкны эрх зүйн өнөөгийн зохицуулалт нь банкны тогтолцооны олон улсын нийтлэг жишигт хүрэх, мөнгөний бодлогыг зохистой хэрэгжүүлэх, банк санхүүгийн эрүүл орчинг бүрдүүлэх улмаар эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалахад зохих чиг үүргээ гүйцэтгэж байна.

- - ОО - -



**"Шихихутуг" ХЗДС-ийн багш,
Хууль зүйн магистрант**

С.БАТБУЯН

Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжээд даруй 17 дахь жилтэйгээ золгож байна. Энэ хугацаанд нийгмийн амьдралд шинэ шинэ өөрчлөлт гарсны нэг нь өмчийн олон хэвшил бүрэлдэн тогтож, зах зээлийн харилцааны жам ёсоор өрсөлдөөний зарчмаар хөгжих нөхцөлийг бүрдүүлж, эрх зүйн орчныг баталгаажуулж, УИХ-аас 1993 онд Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль баталсан нь өрсөлдөөнт зах зээлийн орчин бүрдэх үндэс тавигдсан.

Судалгааны ажлын зорилго: Өрсөлдөөний эрх зүй дэх картелийн тухай ойлголт, түүний хор уршиг, гадаад улс орны практикт энэ асуудлыг хэрхэн зохицуулсныг судалгааны түүхчлэх, социологийн, харьцуулалтын аргаар судалж, Монгол Улсад түүнтэй тэмцэх боломж, арга замыг эрэлхийлж дүгнэлт өгөхийг зорилгоо.

Судлах шаардлага: Бизнесийн харилцаанд картелийн тухай нэгдсэн ойлголт хомсбатүүнтэй тэмцэх арга замыг холбогдох хууль тогтоомжид хангалттай зохицуулаагүйн улмаас өнөөдрийн үүсээд байгаа зах зээлийн гажиг тогтолцоо болох үнийн өсөлтийг бий

ӨРСӨЛДӨӨНИЙ ЭРХ ЗҮЙ ДЭХ КАРТЕЛИЙН АСУУДАЛ, ТҮҮНТЭЙ ТЭМЦЭХ АРГА ЗАМ

болгож, хэрэглэгчийг хохироож байна. Өрсөлдөөний эрх зүй дэх картелийн талаарх нэгдсэн ойлголтыг тодотгож, түүнтэй тэмцэх арга замыг санал болгох нь тус сэдвийн судалгааны ач холбогдолтой шууд холбоотой юм.

1.Картелийн тухай Картель (Cartel) монгол хэлэнд үгсэн хуйвалдах гэж орчуулагдах энэ ойлголт өрсөлдөөний эрх зүйн гол судлагдахуун бөгөөд дараах тодорхойлод анхаарлаа хандуулъя.

Тодорхойлолт 1/ Картель гэдэг нь борлуулалтын нэгдмэл бодлого барьж, үнэ тогтоох замаар бараа бүтээгдэхүүний зах зээл дээр нөлөөлөх зорилго бүхий санхүү, эд хөрөнгийн, үйлдвэрлэл, үйлчилгээний хувьд бие даасан, харилцан хамааралгүй хуулийн этгээдүүдийн гэрээний үндсэн дээр нэгдэх хэлбэр юм¹.

Тодорхойлолт 2/

Өрсөлдөгчид үнэ тогтоох, өөрт ашигтай үнийн санал хийх, үйлдвэрлэлийг хязгаарлах, түүнд квот тогтоох, зах зээлийг хэрэглэгчид, нийлүүлэгчид, газар нутаг, арилжааны байдлаар хуваах зэрэг өрсөлдөөний эсрэг гэрээ, хэлэлцээр хийх, хамтарсан практик үйл ажиллагаа болон бусад арга хэмжээ авахыг "хүнд хэлбэрийн картель" гэнэ². /OECD Council Recommendation 1998/

Тодорхойлолт 3/ Картель гэдэг нь бизнесийнхэн бие биетэйгээ өрсөлдөхгүй байх тухай өөр хоорондоо тохиролцсон гэрээ хэлэлцээр юм³. /ICN- Олон улсын өрсөлдөөний сүлжээ/

Дээрх тодорхойлолт дээр үндэслэн картель нь доорхи элементийг агуулж болохыг улс орны өрсөлдөөний хуулиудад тусгажээ.⁴

өрсөлдөгчдийн хоорондох үйл ажиллагаа/

өрсөлдөөнийг хязгаарласан байх. Картель буюу үгсэн хуйвалдах үйл ажиллагаанд эдгээр элемент зайлшгүй тусгагддаг байна. Эдийн засагт учруулах хохирол хэр хэмжээг харгалзан картелийг "хүнд хэлбэрийн картель" /hard core cartel/, "хөнгөн хэлбэрийн картель" /soft core cartel/ гэж ангилах хандлага дэлхийн нийтийн жишигт тогтсон байна. Манайд "Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуульд" картелийг сонгодог утгаар зохицуулаагүй ч гэсэн картельтэй холбогдох заалтыг судлахаа:

а/Хүнд хэлбэрийн картелийн

төрөл:

-үнэ тогтоох, үнийг тогтвортой барих, үйлдвэрлэлийг хязгаарлах;⁵

-Зах зээлийг хуваарилах, худалдааны нөхцөлийг тодорхойлох;⁶

3. "БНСУ-д 2005 оны 12 дугаар сарын 7-9 нд зохиогдсон семинарын материал"...

4. MRFTA "Korean Competition Law" Article 19

5. "Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль" УБ, 1993 он. "7.1.1. Бэрр бүтээгдэхүүний үнийг харилцан тохиролцох, эсхүл үйлдвэрлэл үйлчилгээ хязгаарлах;"

6. "ШЕӨХТ хууль" УБ, 1993 он. "7.1.2. зах зээлийг нутаг дэвсгэр, үйлдвэрлэл."

1. Graham Bannock, R.E. Baxter and Evan Davis "The Pentium Dictionary of Economics" Fifth Edition, 1992.

2. "Гадаад улс орнууд дахь эдийн засгийн хамтын ажиллагааны зөвлөмж", 1998 он.

-Уралдаант шалгаруулалтад өөрт ашигтай үнэ тогтоох.⁷ **Б/Хөнгөн хэлбэрийн картелийн төрөл**

-Хэлэлцээрээс хамсан татгалзах;⁸
-Бүтээгдэхүүнийг бусдад худалдах, худалдан авахыг хязгаарлах⁹ зэрэг багтдаг. Өрсөлдөөн нь маш өргөн ойлголт бөгөөд нийгэмд шударга бусаар өрсөлдөх процесс олон асуудлыг хамардаг ба картелийг шударга өрсөлдөөний гажуудал гэж судлаачид үздэг.

Картель буюу үгсэн хуйвалдах үйл ажиллагаа нь хэрэглэгчид, бизнес эрхлэгчид хийгээд оролцогчид, нийт эдийн засагт ямар хор уршигтай болохыг авч үзье. Хэрэглэгчдийн хувьд картелийн үйл ажиллагаа явуулснаар бараа бүтээгдэхүүний үнэ өсөж, шинэ соргог бүтээгдэхүүн ховорддог бол бизнесийн байгууллага өөрийн хүссэнээр бизнесийн үйл ажиллагаа явуулахад саад учирч, компанийн өрсөлдөх чадвар дотооддоо буурдаг учраас дэлхийн хэмжээнд өрсөлдөх асуудал бүр ч бэрхшээлтэй болдог.

Өдөр тутмын жишээ, элсэн чихэр импортолдог хоёр компани хоорондоо нууцаар зөвшилцөн, зах зээлийн үнэ болох 1000₮ үнээс илүү 1300₮ худалдаж эхэлбэл хоёрхон нийлүүлэгчтэй, хяналтын механизм, хариуцлагын тогтолцоо хөгжөөгүй манай улсад хэрэглэгч кг тутамд 300 ₮ үйлчилгээ борлуулалт, барааны нэр, төрөл, хэрэглэгчийг хуваарлах;⁷
7. "Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль" 1993 он, "7.1.4. уралдаан буюу дуудлага худалдаанд үнийг урьдчилан тохиролцож оролцох, бусад өрсөлдөгчөө дээрх үйл ажиллагааны бодит нөхцөлөөс төөрөгдүүлэх, тэдэнд дарамт шахалт үзүүлэх"
8. Мөн хуулийн 7.1.3. өрсөлдөөнд чухал ач холбогдол бүхий хэлцэл, тохиролцооноос хамсан татгалзах;⁸
9. Мөн хуулийн "барааг гуравдагч тэгээд худалдах болон худалдан авахыг хязгаарлах."⁹

хохирох юм.

Картель нь бизнест амжилт олох аливаа шинэ санаа, санаачилгыг үгүйсгэж, эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлж, нөөц хөрөнгийг буруу хуваарилж, эдийн засгийн хүрээнд бүтцийн өөрчлөлт хийхэд хүндрэл учруулдаг. Америкийн эрдэмтэн Жон Конорын хийсэн судалгааны дүнд картелийн уршаар дотоодод бараа, бүтээгдэхүүний үнэ дунджаар 18%, олон улсын зах зээлд 30%-аар нэмэгддэг болохыг тогтоожээ. Картелийн үйл ажиллагаа хөгжиж байгаа улсуудад маш их хохиролтой бөгөөд 1990-ээд оны үед картелийн нөлөөгөөр хөгжиж байгаа улс орнуудын импортод 81.1 тэрбум долларын хохирол учирсан гэдгийг судалгааны дүн харуулжээ¹⁰.

2.Өрсөлдөөний эрх зүй дэх картелийн асуудалтай тэмцэж байгаа гадаад улс орны туршлага. Өнөөдрийн өндөр хөгжилтэй улс орнууд картелийг маш эртнээс бодлогын түвшинд тавьсан болох нь АНУ-ын эрх зүйн зохицуулалтаас харагддаг.¹¹ Тус улсад картелийн үйл ажиллагааг гэмт хэрэг гэж үзэж ийм үйлдэл хийсэн этгээдэд захиргааны шийтгэл оногдуулахаас гадна гурван жил хүртэл хорих ял оноодог. ХБНГУ-ын Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуульд зааснаар бизнесийн үйл ажиллагаанд холбоотой хуурамч зүйл болон худал мэдээлэл олон нийтэд тараасан этгээдийг 2 жил хүртэл хугацаагаар хорих ял эдлүүлэх эсвэл торгох хүртэл хариуцлага хүлээлгэдэг. БНСУ-ын Шударга бус өрсөлдөөнийг 10.БНСУ-ын Сөүл хотноо 2005 оны 12-р сарын 7-9 нд болсон сургалтад тавьдсан илтгэлээс.
11. United state of American "Sherman act" 1890. АНУ-д 1890 оноос картелийг бодлогын түвшинд тавьж хамгийн анх "Sherman act"-ыг баталсан бөгөөд "Муж дамнанс гадаадад хийх худалдааг гажуудуулах, хуйвалдах хоёр өөр бүлгийн итгэлцлийн гэрээ, зөвшилцөл хууль бус" гэж хуульчилсан байна

худалдааны комисс картелийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох, картель явагдаж байгааг нотлох баримт бүхий мэдээллийг комисст хүргэх ба мэдээлэгчийг хамгаалах, урамшуулахтай холбогдсон хөтөлбөр хэрэгжүүлж, картелийн үйл ажиллагааг нотлоход маш чухал мэдээлэл өгсөн мэдээлэгчийг 1 сая хүртэл ам.долларыг хууль зөрчсөн ноцтой байдал, нотлох баримтын үнэ цэнэ зэрэгт тулгуурлан олгодог¹². Картелийн илрүүлэлтийг сайжруулах нэг арга бол боловсон хүчний тоог нэмэгдүүлэх гэж үздэг бөгөөд Солонгосын Шударга худалдааны комисст картелийн хэлтэс ажиллах ба бүтцийн хувьд: 1.Картелийг судлах товчоо 2.Картелийн бодлогын баг /12 ажилтантай/ 3.Үйлдвэрийн картелийн баг /10 ажилтантай/ 4.Үйлчилгээний картелийн баг /10 ажилтантай/ гэсэн бүтэцтэй ажилладаг. БНСУ-ын Өрсөлдөөний хуулийн 19 дүгээр зүйлд: "Өрсөлдөөнийг шударга бусаар хязгаарлаж байгаа гэрээ, хэлэлцээр, шийдвэр болон хууль эрх зүйн баримт бичигт хамтарсан санал өгөх бусад ямар нэг хэлбэрийн үйл ажиллагаа явуулахыг бусдад зөвшөөрөх зэргээр бизнес эрхлэгч харилцан зөвшилцөж болохгүй" гэж заасан нь доорх жишээг дурдахад хүргэлээ.

Жишээ 1. Майкрософт корпораци БНСУ-д Windows үйлдлийн системийг борлуулахдаа түүнд Windows Messenger болон Windows Media player программуудын нэг хувилбарыг дагалдуулан багцлан худалдаалжээ. БНСУ-ын Шударга худалдааны комисс энэ багцалсан худалдаа нь тус 2 программын бусад хувилбарыг сонгох эрхийг хясан боогдуулсан, 12. MRFTA "Korean Competition Law" БНСУ-ын "Өрсөлдөөний тухай хуулиас"

солонгосын бусад программ үйлдвэрлэдэг компаний өрсөлдөх байдлыг үгүйсгэж монополь тогтоож, шударга бусаар өрсөлдсөн зах зээлд хэрэглэгчийг хувиарилсан гэсэн үндэслэлээр буруутгаж 33.6 сая долларын торгууль ногдуулжээ.

Тайваньд Шударга худалдааны хуулийн 7 дугаар зүйлд "Хамтарсан арга хэмжээ" гэдгийг ямар нэгэн аж ахуйн нэгж өөр аж ахуйн нэгжээ хамтран гэрээ, хэлцэл хийх замаар бараа үйлчилгээний үнийг хамсан тодорхойлох, худалдаа хийх газар нутгийг хязгаарлах, харилцан бие биенийхээ үйл ажиллагааг хязгаарлах арга хэмжээг хэлнэ." Хуулийн энэ заалтыг зөрчөл 50000-250 сая тайвань доллароор торгодог. Картелийн үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгж хууль зөрчсөн үйлдлээ зогсоох, засах зэрэг шаардлагатай арга хэмжээ аваагүй тохиолдолд Тайваний Шударга худалдааны комисс дээрх хуульд заасан торгууль ногдуулахаас гадна үргэлжлүүлээд 10000-500 сая тайвань долларын торгуулийг ногдуулна¹³.

Жишээ 2. Тайванийн дотоодын зах зээлд нефтийн бүтээгдэхүүн нийлүүлдэг хятадын корпораци, Тормоза нефть химийн корпораци гэсэн 2 нефть боловсруулах үйлдвэрт Тайванийн Шударга худалдааны хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу комисс шалгалт хийхэд эдгээр 2 корпораци АИ92,95 маркийн бензин, хийн түлш болон дизель түлшний бөөний үнийг удаа дараа хамтран өөрчилсөн явдал нь хууль зөрчсөн үйлдэл болохыг тогтоож комисс 500 сая тайвань долларын торгууль оногдуулсан байна

Картелийн үйл ажиллагаа явагдсан бодит тохиолдлыг

дурдахад ийм байна. Харин түүнийг илрүүлэхтэй холбоотой оновчтой арга замуудыг судлахад олон улсын практикт дараах хэд хэдэн арга зам үр дүнтэйд тооцогддог.

1.Нарийн зохицуулалт бүхий эрх зүйн орчинг бүрдүүлэх;

2.Картельтэй тэмцэх тусгай бие даасан нэгж байгуулж, шаардлагад нийцсэн чадварлаг боловсон хүчин ажилуулах;

3.Мэдээлэгчийг урамшуулах, боломжит тогтолцоог бий болгох;

4.Холбогдох байгууллагад мөрдөн шалгах бүрэн эрхийг хуулиар олгох;

5.Картелийн үйл ажиллагаа шунаг сэдлээс үүсч ашиг олох зорилгоор явагддаг учир маш өндөр торгууль, хариуцлагын механизмыг боловсронгуй болгох; /АНУ-д Эрүүгийн, захиргааны, иргэний хариуцлага хүлээлгэх бөгөөд хорих ял нэлээд үр дүнтэйд тооцогддог/

6.Картелийн үйл ажиллагаанд оролцсон компанийг тендерт оролцох эрхийг тодорхой хугацаагаар хасах;

7.Компанийн удирдлагыг картелийн үйлдлээс урьдчилан сэргийлэх хөтөлбөртэй байх зэрэг арга замаар тэмцэх оролдлого дэлхийн жишигт байна.

Одоо Монгол Улсад зах зээлийн өрсөлдөөнд картель буюу үгсэн хуйвалдах явдал байгаа эсэх, байгаа бол аль салбарт ямар хэлбэрээр оршиж байна. Энэ талын мэдлэг, мэдээлэл олон нийтэд хэр зэрэг байгаа эсэхэд дүн шинжилгээ хийж түүнтэй тэмцэх арга замыг эрэлхийлэх үүднээс дараах судалгаатай танилцъя. Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газраас 2007 оны 6 дугаар сарын 5-20 нд хийсэн картелийн талаарх тандалтын түгвэр судалгаанд Улаанбаатар хот, Эрдэнэт, Дархан, Өвөрхангай аймгаас нийт 1972 хүн оролцсон

байна¹⁴.

Судалгааны үр дүн: Монгол Улсын хэмжээнд зах зээлийн өрсөлдөөнд картель буюу үгсэн хуйвалдах явдал нэлээдгүй байна. Бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг харилцан тохиролцох, тендер, дуудлага худалдаанд үнийг харилцан тохиролцож оролцох зэрэг хүнд хэлбэрийн картель илүү зонхилж, картель буюу үгсэн хуйвалдах талын мэдлэг, мэдээллийн түвшин судалгаанд оролцогчид тэр дотроо хэрэглэгчдийн дунд маш баг байгаа нь илэрхий харагдлаа.

Өрсөлдөөний эрх зүй дэх картель буюу үгсэн хуйвалдах явдалтай тэмцэхийн тулд дараах арга замыг судлаачийн зүгээс санал болгож байна.

1.Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийг шинэчилж, картель буюу үгсэн хуйвалдах явдлыг зөв тодорхойлж, түүнтэй холбогдсон зохицуулалт оруулж өгөх;

2.Картелийн үйл ажиллагааны талаар үнэлэгдэхүйц, бодит мэдээлэл өгсөн этгээдэд урамшуулал олгох, мэдээллийн нууцлалыг хадгалах, хамгаалах;

3.Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн хариуцлагыг чангатгах; Картелийн үйл ажиллагаа явуулсан аж, ахуйн нэгжид дараах захиргааны хариуцлага ногдуулахаар хуульчилж болно.

-Үйл ажиллагаа нь зогсоох;

-Тусгай зөвшөөрлийг нь хураах;

-Торгууль ногдуулах; *Торгуулийн хэмжээ нь одоогийн хуулиар аж ахуйн нэгжийн хувьд 250,000 төгрөг байдаг, иймээс тухайн аж ахуйн нэгжийн өмнөх жилийн нийт эргэлтийн хөрөнгийн 10 хүртэл хувиар торгох гэж заах/*

4.Холбогдох байгууллагад картельтэй тэмцэх нэгж

14.Картелийн талаарх түгвэр судалгаанаас хэсэгчлэн авав.

13.Тайвань Улсын "Шударга худалдааны тухай хууль" түүний зохицуулалтаас иш татав...

байгуулж, чадварлаг боловсон хүчнээр хангаж, хуулиар мөрдөн шалгах эрх олгох;

5.Шударга бус өрсөлдөөнийг хянах тухай хуулийг олон нийтэд сурталчлах зорилгоор гарын авалга, хэвлэмэл материал бэлтгэж тараах, сургалт зохион байгуулах;

6.Өрсөлдөөний эрх зүйн асуудлыг боловсронгуй болгох үүднээс хууль зүйн их, дээд, сургуулиудын багш, эрдэмтдийн дунд лекц, семинар зохион байгуулах;

7.Холбогдох байгууллагыг бусад хууль хяналтын байгууллагатай нягт уялдаатай ажиллах нөхцлийг бүрдүүлэх;

8.Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийг бизнесийн бусад хууль

тогтоомжтой уялдуулах ялангуяа Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хуультай онолын нэг цогцолбороор авч үзэж, нийтийн эрх зүйн хариуцлага, хувийн эрх зүйн хариуцлагыг ялгамжтай байдлаар томъёолох;

Картьелтай тэмцэх дээрх арга замуудыг хэрэглэх нь нэн чухал болохыг судалгааны ажлын төгсгөлд онцолж байна.



Дүгнэлт: Эцэст нь дүгнэхэд Шударга бус өрсөлдөөнийг хянах тухай хуульд картель буюу үгсэн хуйвалдах явдал түүнтэй тэмцэх арга замыг оновчтой зохицуулаагүйн улмаас хууль батлагдсан 1993 оноос хойш картелийг илрүүлсэн тохиолдол тодорхой бус байгаа энэ хуулийн зохицуулалтын мөн чанарыг



харуулж байна. Иймд ШБӨХТ хуулийг боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа бөгөөд картелийн үйл ажиллагаа манай улсын нефть, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний зах зээл, тендерийн үйл ажиллагаанд хүнд хэлбэрээр оршиж байгаа нь судалгааны ажлын явцад илэрхий байна. Судлаачийн зүгээс Шударга бус өрсөлдөөний эрх зүйн орчинд картелийн асуудлыг шийдэх оновчтой зохицуулалтын нэг бол түүнтэй тэмцэх арга замыг зөв тодорхойлох явдал гэж үзэж, энэ ч үүднээс судалгааны ажлын зорилго болох картельтай тэмцэх арга замуудыг ирэлхийлж түүнд дүгнэлт өгсөнд судлаачийн зорилго оршино.

-оОо- -

1.Та картель буюу үгсэн хуйвалдах явдлын талаар мэдэх үү?

2.Өнөөгийн нийгэмд картел буюу үгсэн хуйвалдах явдал байна уу?






3. Өнөөдөр картель буюу үгсэн хуйвалдах явдлын ямар хэлбэр оршиж байна вэ?



4 Бизнесийн салбарт картелийн хуйвалдах явдал ямар нөхцөлд ямар хэлбэр байна эс?



5. Картелийн хор уршгийн талаар таны мэдлэг ямар түвшинд байна.

Өрсөлдөөний эрх зүй дэх Картел буюу үгсэн хуйвалдах явдалтай тэмцэхийн тулд дараах арга замуудыг судлаачийн зүгээс санал болгож байна.

1.Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийг шинэчилж, картель буюу үгсэн хуувалдах явдлыг зөв тодорхойлж, түүнтэй холбогдсон зохицуулалт оруулж өгөх,

2.Картелийн үйл ажиллагааны талаар үнэлэгдэхүйц, бодит мэдээлэл өгсөн этгээдэд урамшуулал олгох, мэдээллийн нууцлалыг хадгалах, хамгаалах;

3.Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн хариуцлагыг чангатгах; Үүнд: Картелийн үйл ажиллагаа явуулсан аж, ахуй нэгжид дараах захиргааны хариуцлага ногдуулахаар хуульчилж болно.

-үйл ажиллагааг нь зогсоох;
-тусгай зөвшөөрлийг нь хураах;

-торгууль ногдуулах; / Торгуулийн хэмжээ нь одоогийн хуулиар аж ахуйн нэгжийн хувьд 250,000 мянга байдаг, иймээс тухайн аж ахуйн нэгжийн өмнөх жилийн нийт эргэлтийн хөрөнгийн 10 хүртэл хувиар

торгох гэж заах/;

4.Холбогдох байгууллагад картельтэй тэмцэх нэгж байгуулж, чадварлаг боловсон хүчнээр хангаж, хуулиар мөрдөн шалгах эрх олгох;

5.Шударга бус өрсөлдөөнийг хянах тухай хуулийг олон нийтэд сурталчлах зорилгоор гарын авалга, хэвлэмэл материал бэлтгэж тараах, сургалт зохион байгуулах;

6.Өрсөлдөөний эрх зүйн асуудлыг боловсронгуй болгох үүднээс хууль зүйн их, дээд, сургуулиудын багш, эрдэмтдийн дунд лекц, семнар зохион байгуулах;

7.Холбогдох байгууллагыг бусад хууль хяналтын байгууллагатай нягт уялдаатай ажиллах нөхцлийг бүрдүүлэх;

8.Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийг бусад бизнесийн хууль тогтоомжтой уялдуулах ялангуяа Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хуультай онолын нэг цогцолбороор авч үзэж, нийтийн эрх зүйн хариуцлага, хувийн эрх зүйн хариуцлагыг ялгамжтай байдлаар томёолох;

Картельтай тэмцэх дээрх арга замуудыг хэрэглэх нь нэн чухал болохыг судалгааны

ажлын төгсгөлд онцолж байна.

Дүгнэлт: Эцэст нь дүгнэхэд Шударга бус өрсөлдөөнийг хянах тухай хуульд картель буюу үгсэн хуйвалдах явдал түүнтэй тэмцэх арга замыг оновчтой зохицуулаагүйн улмаас хууль батлагдсан 1993 оноос хойш картелийн илрүүлсэн тохиолдол тодорхой бус байгаа энэ хуулийн зохицуулалтын мөн чанарыг харуулж байна. Иймд Шударга бус өрсөлдөөнийг хянах тухай хуулийг боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа бөгөөд картелийн үйл ажиллагаа манай улсын нефт, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний зах зээл, тендерийн үйл ажиллагаанд хүнд хэлбэрээр оршиж байгаа нь судалгааны ажлын явцад илэрхий байна. Судлаачын зүгээс Шударга бус өрсөлдөөний эрх зүйн орчинд картелийн асуудлыг шийдэх оновчтой зохицуулалтын нэг бол түүнтэй тэмцэх арга замыг зөв тодорхойлох явдал гэж үзэж, энэ ч үүднээс судалгааны ажлын зорилго болох картельтай тэмцэх арга замуудыг ирэлхийлж түүнд дүгнэлт өгсөнд судлаачийн зорилго оршино.

-ооо-



**Хан-Уул дүүргийн
нотариатч С.ЦЭНД**

Нотариатын тухай хуульд оруулах гэж буй нэмэлт, өөрчлөлт түүнтэй уялдуулан суурь хууль болох Иргэний хуульд оруулж буй зарим нэмэлт, өөрчлөлт нь хууль зүйн шинжлэх ухаанд нэгэнт тогтсон эрх зүйн ойлголтыг үгүйсгэсэн болжээ.

Иргэний эрх зүй дэх тодорхой тооны хэлцэл нь эрх зүйн хувьд хүчин төгөлдөр байх ёстой хэлбэрийн зохицуулалттай байхыг шаарддаг.

Тэгвэл Иргэний хуулийн 109 дүгээр зүйлийн 109.2, 156 дугаар зүйлийн 156.2 дахь хэсэгт заалтад оруулах гэж буй өөрчлөлт нь хууль зүйн шинжлэх ухаанд нэгэнт тогтсон ойлголтыг гажуудуулж, өмчийн эрх зүйн үүднээс авч үзвэл иргэд, хуулийн этгээд иргэний эрх зүйн харилцаанд орохдоо өөрсдийн хууль ёсны эрх ашгаа хамгаалуулах, иргэний эрх зүйн хамгаалалттай байх эрхээ тодорхой утгаар алдаж байна гэсэн ойлголтыг төрүүлж байна.

Бүр хэлцлийн хэлбэрийн нарийвчилсан зохицуулалт шаардаж байж эрх зүйн хувьд хүчин төгөлдөр болдог хэлцлүүд ч байдаг. Тухайлбал, Иргэний хуулийн 109 дүгээр зүйлийн 109.2 зүйлд заасан "Бүтэн өнчин бага насны болон насанд хүрээгүй иргэний өмчлөлд байгаа үл хөдлөх эд хөрөнгө, мал, хадгаламж зэрэг бусад үнэт зүйлийг өөрт нь зориулан захиран зарцуулах, орон сууц хөлслөх гэрээг

ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙ ДЭХ ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТ

гэрчлүүлэхдээ түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь сум, дүүргийн Засаг даргаас **нэгдүгээрт**, зөвшөөрөл авч, **хоёрдугаарт**, уг зөвшөөрлийг авсны үндсэн дээр тухайн гэрээг гэрчлүүлэх, **гуравдугаарт**, холбогдох бүртгэлийн албанд бүртгүүлж байж хүчин төгөлдөр болж, хуулиар өнчин хүүхдийн өмч, хөрөнгөтэй холбоотой эрх ашгийг нотариатч хамгаалж, эрх зүйн зөв голдрилд нь оруулж байх жишээтэй.

Үндэсний эрх зүйн тогтолцоо бүр өөр өөрийн өнгө аястай ч тухайн орны эрх зүйн тогтолцоонд бусад хөгжингүй улс орны эрх зүйн тэргүүний үзэл санааг зээлдэн нутагшуулах үйл явцыг хуульчид бид байнга дэмжиж ирсэн, дэмжих ч болно. Гэхдээ үүнийг хэт механик байдлаар, зөвхөн нэг өнцгөөс нь харж хийвэл тухайн орны эрх зүйн тогтолцоог эрлийзжүүлэх, тогтолцооныгажигүүсгэх, улмаар эрх зүйн хомсдолд оруулах сөрөг үр дагаврыг алсдаа бий болгоно. Эрх зүйн тэргүүний үзэл санааг зээлдэн нутагшуулах үйл явцын нэг жишээлбэл: Монгол Улсын Иргэний хуулийг ХБНГУ-аас зээлдэн нутагшуулсан.

ХБНГУ-ын Иргэний хууль нь хувь хүний эрх, эрх чөлөөг чиг баримжаа болгосон хөгжингүй хууль. Гэтэлбид өөрийннийгмийн эрх зүйн соёл, сэтгэлгээний онцлог ухамсрынхаа түвшинг бүрэн тодорхойлолгүй өөрчлөлт хийвэл амьдралд тохирохгүй асуудлууд урган гарна. Үүний улмаас соёлын ялгаа гарч эрх зүйн үр нөлөө буурах хандлага бий болно. Иргэний хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 109 дүгээр зүйлийн 109.3 114 дүгээр зүйлийн 114.1, 189 дүгээр зүйлийн 189.5 дахь хэсэг гэрээний эрх чөлөөт байдал, хэлцэлд оролцогчдын бие даасан байдал, нийгмийн тэнцвэрт байдлыг хангах,

итгэл үнэмшлийг хамгаалах зэрэг бизнесийг дэмжсэн зохицуулалт байдаг. Энэ нь гэрээг байгуулагдсан гэж үзэх соёл иргэншлийн нэлээд өндөр төвшний хувь хүний өөрийн бие даасан үйлдлээс шууд хамааралтайгаар зохицуулж өгсөн бол Монголчуудын хувьд хүй элгэний сэтгэлгээний илрэл болох бие биеийн дотоод хэрэгт дүр мэдэн оролцож бие биенээ төлөөлөх, энэ үйлдлээ нөгөө хүнийхээ эрхийг зөрчиж байна гэж үздэггүй бидний үнэлэмж нь нөгөө хүнийгээ иргэний эрх зүйн хариуцлагад унагах, бизнесийн алдагдалд оруулж байх жишээтэй.

Гэтэл өмчийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд өмчийг нэг этгээд нөгөө этгээдээ шилжүүлэх явцад тухайн хэлцлийг нотариатчаас заавал гэрчилж байх хэлцлийн хэлбэрийн зохицуулалт бүхий Иргэний зүйл заалтыг өөрчилснөөс иргэд, хуулийн этгээд эрх зүйн аливаа эрсдэлээс урьдчилан хамгаалагдах, өөрсдийн ашиг сонирхлоо хамгаалуулах иргэний эрх зүйн хамгаалалтгүй болж байгаа нь нотариатчийн иргэд, хуулийн этгээдэд үзүүлэх эрх зүйн туслалцааны үүрэг ролийг бууруулсан алхам болж байна.

Энэ нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогч этгээдүүдийн эрх ашиг хөндөгдөж улмаар эд хөрөнгийн аливаа хохирол үүсэх магадлал өсч, хохирлыг хэрхэн барагдуулах арга зам ч тодорхой бус байгаагаар тайлбарлагдаж байна.

Иймд хэлцлийн хэлбэрийн зохицуулалт дээр хууль тогтоогчид хууль зүйн шинжлэх ухааны эрдэмтэн мэргэд, мэргэжлийн хуульчдын санал бодлыг судлан байж нухацтай авч үзэх шаардлагатай байна.



Цагдаагийн академийн
магистрант Ц.МӨНХЗҮЛ

Гэр бүл нь хүн амыг биеийн болон оюуны талаар нөхөн үйлдвэрлэх хэрэгцээ, нийгмийн шаардлагаар нөхцөлдсөн гэрлэлт, ураг төрлийн харилцаа, ахуй байдлын нийтлэг ёс суртахууны хариуцлагаар холбогдсон гишүүд бүхий нийгмийн бага бүлэг буюу нийгмийн анхдагч нэгж юм.

Тиймээс гэр бүлийн харилцаа нь нийгмийн аль ч байгууллын үед төрийн хяналт, эрх зүйн зохицуулалтын нэг объект байсаар иржээ. Гэр бүлийн харилцааг зохицуулж ирсэн эрх зүйн эх сурвалжийг төр, эрх зүйн уламжлал, түүний түүхэн үечлэлийн онцлогийг харгалзан эртний ба шинэ үеийн эх сурвалж гэж ангилж болох ба эртний үеийн эх сурвалжид "Их засаг", "Монгол Ойрадын хууль", "Халх журам", "Монгол цаазын бичиг" зэргийг, шинэ үеийн эх сурвалжид 1926, 1952, 1967, 1994, 2002 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулиудыг хамааруулж ойлгоно.

Монголын эртний үеийн хууль цаазад гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг хэрхэн тусгаж байсан талаар авч үзвэл:

1.Гэрлэгчдийнтэгшиэрхийн талаар. "Их засаг" хуулиар олон эхнэртэй байхыг зөвшөөрч

ГЭР БҮЛИЙН ХОЛБОГДОЛТОЙ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН УЛАМЖЛАЛ

байсан бөгөөд олон эхнэрийн дотроос анхны авгай ахална гэжээ. Мөн "Монгол Ойрадын хууль"-д гэр бүлд эцгийн эрхт ёс ноёрхож, нөхөр нь хаясан эхнэрээ албал боол хүнийг алсны адил зөвхөн 5 өсөөр торгох, хүү нь эцэг, эхийнхээ ялангуяа эцгийн зөвшөөрөлгүй эхнэр сонгох ёсгүй байжээ. Мөн "Монгол цаазын бичиг"-т эцгийн эрхт ёс гэр бүлийн харилцаанд ноёрхоно гэсэн заалт байжээ. Эдгээр заалт нь тухайн үед гэр бүлд эцгийн эрхт ёс ноёрхож байсантай холбоотой бөгөөд энэ нь гэр бүлийн гишүүдийн тэгш эрхийг хязгаарласан зохицуулалт байжээ.

2.Өмчийн талаар. "Их засаг" хуульд татвар эхнэрээс гарсан хүүхдийг хууль ёсны гэж тооцож зохих хувь олгож өвлүүлнэ. Эцэг нь хөвгүүддээ өмч хуваарилж олгоно. Ах нь дүүгээсээ илүү хувь авна. Отгон хүү нь гал голомтыг өвлөнө гэж заасан бол "Монгол Ойрадын хууль"-д эцэг нь хүүдээ өмч өгөх, өрх тусгаарлан гаргах, хэрэв хөрөнгөгүй бол таван бодын нэгийг өгч бай, хүү өв залгамжилж, охин инж авна гэж өмч, өв залгамжлахтай холбогдсон харилцааг зохицуулж байсан байна.

3.Үрчлэлтийн талаар. "Монгол Ойрадын хууль"-д үрчлэлтийн талаар "9-15 насны эмэгтэй хүүхэд үрчлэхэд нэг өс өгнө" гэжээ. Харин "Монгол цаазын бичиг"-т өөрийн төрсөн эрэгтэй хүүхэдгүй айл овог дотроосоо хүүхэд үрчилж авч болох бөгөөд хүүхэд энэ тохиолдолд эцгийн овгийг авч, түүний хөрөнгийг залгамжлах боломжтойн зэрэгцээ үрчлэлтийг заавал бүртгүүлдэг байсан

байна. Хошуу захирагч зангид мэдүүлж эр төөлөх дансанд буюу хошууны сумын эрийн дансанд, журганд буюу Гадаад Монголын төрийг засах явдлын яамны дансанд бүртгүүлээгүй бол хуулийн хариуцлага хүлээлгэж, хүүхдийг буцааж төрүүлсэн эцэг, эхэд нь өгдөг байжээ.

4.Асран тэтгэх талаар. "Монгол цаазын бичиг"-т галзуу хүнийг эцэг, эх, өвөг зэрэг ураг төрлөөр нь асран хамгаалуулж байх, хэрэв энэ үүргээ биелүүлээгүйгээс хохирол учирсан бол асран хамгаалах үүрэг хүлээсэн хүн хариуцах, мөн эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр зааж байжээ.

5.Гэр бүлийн эрх зүйн харилцаанд баримтлах зарчмын хувьд: Өнөөгийн эрх зүйн зохицуулалт нь "гэрлэлт нь тэгш эрх, хайр сэтгэл, сайн дурын үндсэн дээр бий болдог" бол эртний хуульд зааснаар гэрлэлт инж, бэлэг сэлтийн үр дүнд бий болж байсан байна. Энэ талаар "Их засаг" хуульд эхнэр авахын тулд заавал сүй тавьж авна. Аав, ээж нь охиныхоо төлөө сүй авахгүйгээр эрд гаргадаггүй байв. Харин "Монгол Ойрадын хууль"-д охиноо эрд гаргахын урьд нөхөр болох хүнээс инж буулгаж сүй авч байх сүйн хэмжээ гэрлэж байгаа хүний нийгмийн гарлаар тодорхойлогдох ба гэрлэх нас эмэгтэйчүүдийн хувьд 14-өөс эхлэнэ гэж заажээ.

Ноён хүний охиныг авах гэвэл үнэт зүйл 30, адуу 150, хонь 400 авдаг бол харц хүний охиныг авахад тэмээ хоёр, арван бод, хонь 15 тус тус өгнө. Гэрлэх

1.Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 4 дүгээр зүйл.

ёс үйлдэж байх үед харилцан бэлэг барьдаг. Нэгэнт сүй авсан хүнийг эцэг, эх нь дур мэдэн өөр хүнд өгч болохгүй. Хэрэв охиныг 20 нас хүртэл авахгүй бол хүргэний эцэгт мэдэгдэх, мэдэгдсэний хойно авахгүй бол ноёнд дуулгах, ноёнд дуулгасны дараа авахгүй бол өөр хүнд өгч болно.

Охины талаас өгөх инжийн хэмжээ сүйд өгөгдсөн мал ба бусад зүйлийн хэмжээгээр байх боловч хоёр тал хэлэлцэн багасгаж болдог байсан тухай заасан байв. Энэхүү хууль цаазын бичигт хуримласан охин үхвэл эд, инжийг нь өг. Эс хуримласан бол малаа хагаслаж ав гэж, бэр нь нас барвал инжийг буцаадаг байжээ.

“Халх журам” хуульд ноёдын охиныг гуйваас мөнгөн аяга, сувд, архи хүргэвээс тооцно. Үгүй бөгөөс тооцохгүй. Бас харц хүн өөр зургаан сүйлэх аваас архи болоод хонины гэдэс, дотор, звэр, туурай гүйцэд болбоос тооцох гэж заажээ. Энэ нь гэрлэхэд эрэгтэй, эмэгтэй хоёрын бие биез хайрлах гол биш инж сүйгээр илэрхийлэгдсэн эд хөрөнгө гэрлэх хэмжигдэхүүн болдог байжээ².

Харц хүний сүйт бүсгүйг бусдад өгч болох талаар заахдаа “Ноёд харц хүний хуримт эмийг бусад хүнд өгөх бол хуримт хүний ноёнд нь сонсгож өг. Сонсголгүй өгвөл язгуурын хуримт хүнд хариулж өгтүгэй” гэжээ.

Мөн түүнчлэн уг хуульд хар хүний хүсэл зоригоос хамаарч гэр бүлийн харилцааг дуусгавар болох зохицуулалт буюу “Тавнан авайг гэзвэл /хаях/ ташуураа барьжгарах/гэрээсээ малалавгүй ганцаараа явах, тонилох/. Авай инжээ авч хошуундаа бие мэдэх, тавнангийн талсан эд, малыг хувааж хагасыг нь засагтаа авах хагасыг авайд өгөх” гэсэн заалт байсан байна.

“Монгол цаазын бичиг” – тгэр бүл болоход инж дагуулдаг, боглгох эд зүйл мал буюу элгийг

хэмжээг нарийн журамлан хуульчилж байсан байна. Тухайлбал нөхөр нь эхнэрээ сонгож сүй тавих, эцэг, эх нь охиноо эрд өгөхөд дагуул болгон эд хөрөнгө инж өгөх, харц ноёд гэж ангилан өгөх сүй, инжийн хэмжээг өөр өөрөөр тогтоож байжээ. Харц хүмүүс хоорондоо сүй тавьж болох, боглгох мал буюу хэмжээг хатуу тогтоосон тухай анхны зохицуулалтыг хуульчилж, хоёр харц хүн худ бололцоход боглгох мал хоёр морь, хоёр үхэр, хорин хонь ав. Энэ цаазаас давж илүү өгвөл, илүү малыг засагт ав. Дууту бол ялгүй гэж заасан байв.

Эдгээрээс гадна **“Их засаг”** хуульд садан төрлөө зөвхөн эцгийн шугамаар нэгдүгээр, хоёрдугаар үеийг тооцдог байжээ. Эцгээ нас барахад хөвгүүд нь түүний эхнэргүйдийн хувь заяаг шийдвэрлэнэ. Төрсөн эхээ оролцуулахгүйгээр эцгийнхээ бусад эхнэрийг аваал болгох буюу бусдад өгч болно. Жил бүр өөрийн охидоо хаанд үзүүлэхээр ирүүлж тэдний дотроос хаан өөртөө болон хөвгүүдээ сонгон авдаг байв. Эхнэртэй буюу эхнэргүй хүн хүний эхнэр буюу бэлбэсэн эхнэртэй явалдах аваас цаазаар авах ял ногдуулдаг байжээ.³

Мөн **“Монгол Ойрадын хууль”** –д гэсэн эм хүн дахин хүнтэй гэр бүл болоход “Хүний гэзсэн эмийг тулж авах хүн бэрхтэй ес өгч ав. Дундаас тав, адаг эмээс морь тэмээ ав” гэжээ. Нөхөр нь эхнэрээ зодох буюу хаясныг хуулиар авч хэлэлцэхгүй албал 5 өсөөр торгоно гэх мэтээр гэр бүлийн эрх зүйн хүрээнд үүссэн олон талт харилцааг нарийвчлан зохицуулж ирсэн байна.

Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэж байсан шинэ үеийн эх сурвалжуудыг харьцуулан үзвэл:

Монгол Улсад Ардын хувьсгал ялснаас хойш гэр бүлийн харилцааг зохицуулсан анхны хууль нь 1926 онд батлагдсан

З.А.Дугармаа “Монгол Улсын гэр бүлийн эрх зүй” УБ., 2005.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Шүүн таслах газруудад аливаа хэргийг байцаах ба шийтгэх тухай хууль юм. Тус хуулийн **“Гэр бүлийн эрх үүргийн тухай”** хэмээх гуравдугаар бүлгээр гэр бүлийн харилцааг зохицуулж байсан байна.

Уг хуулийн агуулгыг авч үзвэл:

1.18 насанд хүрсэн хүмүүс эр эм бололцож болох ба тэдний аль нэг нь урьд өмнө хэн нэгэнтэй эр эм бололцсон боловч дансанд бүртгүүлээгүй байвал урьд хүнтэй эр эм бололцсон гэж үзээд бүртгэлд бүртгэхгүй. Мөн эцэг эх төрсөн ах эгч дүү нар нэг эцэг эхийн хүүхэд өөр хоорондоо эр эм бололцож болохгүй.

Эр эм бололцох явдал нь зөвхөн тухайн хоёр этгээдийн санал хүслээр болох ба санал үл нийлвээс эр эм бололцсон хэмээн үзэхгүй.

Лам хувраг хүмүүс болон чавганц гэх мэт эр эм бололцохыг цээрлэсэн хүмүүс эр эм бололцох хүсэлтэй бол хүсэлтийг ёсоор болгох бөгөөд ямар нэгэн саад тавьж үл болно. Эр эм бололцоход үндэс угсаа, шашин шүтлэгийг үл харгалзан хоёр этгээдийн хүслээр шийдвэрлэнэ. Дээрх бүгд нь эр эм бололцох тухай бол гэр бүл цуцлах буюу эр эм хүмүүсийн салалцахыг 1926 оны Иргэний хуульд дараах байдлаар заажээ.

• Эхнэр нөхрийн хэн нэг нь нас барснаар;

• Эр эм хоёрын хэн нэг нь хүсэлт гаргаснаар эр эм салж болох ажээ.

Эр эмийн салалтыг орон нутгийн захиргааны газар, эд хөрөнгийн хувьд маргаантай бол Шүүн таслах газраар шийдвэрлүүлнэ.

2.Хуульд эр эм бололцсон этгээдүүдийн өмч, өмчлөх эрхийг зохицуулж өгсөнөөс гадна эд хөрөнгөтэй холбоотой гэрээ хэлцэл байгуулж болохыг, хэн нэгнийгээ тэжээн тэтгэх үүрэг зэргийг хуульчилж өгчээ. Уг хуульд салсан эр эмийн хэн нэгэнд нь ажил олдохгүй, ажил

2.С.Жалан-Аажва “Халх журам бол монголын хууль цаазын эртний дурсгалт бичиг мөн” УБ., 1958 он.,

хийж чадахгүй болсон байвал салсан эхний өдрөөс нэг жилийн хугацаанд нөгөө этгээдээсээ амьжиргааны аливаа зүйлийг авч болно гэж заажээ. Энэ үед эр эм хүмүүсийн салагцсан үгүй эсэх нь хамаарахгүй болно.

3.Эр, эм болсны дараа завсрын буюу үүсмэл эрх, үүрэг үүсэх үндэслэл мөн үр хүүхэд, эцэг, эх ба ойр төрлийн хүмүүсийн завсрын эрх үүргийг заасан нь эцэг, эх хүүхэд, төрөл садангийн хүмүүсийн хоорондын харилцааг зохицуулахад чиглэгдсэн заалтууд байжээ.

Үүнээс хойш 1950 онд Иргэний гэр бүлийг бүртгэх байгууллагын тухай, мөн 1956 онд БНМАУ-ын гэрлэлт ба гэр бүл асрамж тэтгэмжийн тухай хуулийг батлан гаргасан нь гэрлэлт, гэр бүлийн харилцааг бие даан төрөлжүүлэн зохицуулсан анхны хууль болсон юм. Түүнд гэрлэлт, гэрлэгсдийн эрх, үүрэг, гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн харилцаа, гэрлэлт цуцлах, хүүхэд үрчлэх, үрчлүүлэх журам, эцэг эх, хүүхэд, төрөл саднаа тэжээн тэтгэх, асран халамжлах, харгалзан дэмжих, иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх зэрэг гэрлэлт, гэр бүлийн амин чухал үндсэн асуудлыг өөртөө багтаасан байдаг.

1960 онд Үндсэн хуулийг шинэчлэн баталсантай холбогдуулж, 1967 оны 6 дугаар сарын 29-ний өдөр "Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Иргэний байцаан шийтгэх хууль"⁴-ийг, мөн 1992 онд Үндсэн хуулийг шинээр баталж, эрх зүйн шинэчлэл хийж 1994 онд "Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль"⁵-ийг тус тус шинэчлэн баталжээ.

Дээрх хуулиудад гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх харилцааг хэрхэн зохицуулж байсныг харьцуулан үзвэл:

1.Гэрлэлт цуцлах тухай хэргийг 1967 оны хуульд зааснаар өргөдлөөр авч хэлэлцэж байсан бол 1994

оноос хойш нэхэмжлэлээр авч хэлэлцдэг болсон байна.

2.Гэрлэлт цуцлах тухай хэрэгтэй хамт гэрлэгсдийн дундын эд хөрөнгийг хуваах, хүүхдийн тэтгэвэр гаргуулах, тусалцаа шаардагдаж байгаа хөдөлмөрийн чадваргүй эхнэр буюу нөхөрт тэтгэвэр гаргуулах асуудлыг шийдвэрлэж байжээ.

Монгол Улс нийгмийн байгууллын шинэ харилцаанд шилжсэнтэй холбогдсон өөрчлөлт шинэчлэлийн нэг хэсэг болох Улсын Их Хурлаас 1998 онд баталсан "Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр"-т нийцүүлэн 2002 онд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль шинээр батлагдан гарсан.

1967, 1994 оны хуулиар гэрлэлт цуцлах тухай хэргийг байцаан шийтгэх ажиллагаа хэмээн нэрлэгдэж зөвхөн гэрлэлт цуцлахтай холбогдсон харилцааг зохицуулж байсан бол 2002 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль⁵ "Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа" хэмээн нэрлэгдэж хамрах харилцааны хүрээ нь илүү өргөжсөн байна.

Тус хуульд гэрлэлт цуцлах нэхэмжлэлтэй хамт эхнэр буюу нөхөр нь хүнд өвчтэй, хөдөлмөрийн чадваргүй, эдийн засгийн хувьд зайлшгүй тусалцаа шаардлагатайгаас тэтгэвэр гаргуулах, хамтран өмчлөх дундын эд хөрөнгө хуваах, насанд хүрээгүй хүүхдийг хэний асрамжинд үлдээх талаар гарсан маргааныг шийдвэрлэнэ гэж заажээ. Мөн гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэхдээ шүүгч урьдчилсан арга хэмжээ авах талаар дараах байдлаар заажээ.

Үүнд:

1.насанд хүрээгүй хүүхэд болон хөдөлмөрийн чадваргүй эцэг, эхийг тэжээн тэтгүүлэх;

2.насанд хүрээгүй хүүхдийг эцэг, эхийн хэн нэг дээр байлгах;

3.гэрлэгчдийг тусдаа амьдрахыг даалгах;

4.гэрлэгч хэн нэгийг тэжээн

тэтгүүлэх;

5.орон сууц болон хамтран өмчлөх дундын өмч, үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөх эрхийг бусдад шилжүүлэх, худалдах, бэлэглэх, захиран зарцуулахыг хориглох;

6.шүүхийн зардлын зохих хувийг урьдчилгаа болгон төлүүлэх;

7.зохигчийг эвлэрэх талаар хугацаа заах зэрэг арга хэмжээ орохоор заажээ.

Эцэст нь дүгнэн хэлэхэд нийгмийн аль ч байгууллын үед гэрлэлт, гэр бүлийн харилцааг төр, засгийн бодлого, эрх зүйн зохицуулалтын үндсэн объект байсаар иржээ. Гэхдээ монгол үндэстний уламжлал, зан заншил, амьдралын хэв маяг, нийгмийн байгууллын онцлог, төрийн болон хууль цаазын бодлого зэргээс хамаарч дээрх асуудлыг харилцан адилгүй байдлаар зохицуулсан байна.

Эртний үеийн хууль цааз болон Бүгд найрамдах Монгол Ард Улсын Шүүн таслах газруудад аливаа хэргийг байцаах ба шийтгэх тухай 1926 оны гэр бүлийн талаарх харилцааг материаллаг хуулиар, 1960 оноос хойш процессийн хуулиар зохицуулж байгаа нь агуулгын хувьд эдгээр хуулийг харьцуулах боломжгүй болж байна.

Монгол Улс орчин үед нүүдэлчин соёл иргэншлээс суурьшмал иргэншил рүү шилжиж байгаатай холбоотойгоор гэрлэлт, гэр бүл, түүний хүрээнд үүсэх асуудал зөвхөн хувь хүний болон гэр бүлийн хүрээний асуудал байхаасаа илүүтэй нийгмийн хүрээний асуудал болжээ.

Учир нь хувьсгалаас өмнө гэрлэлт, гэр бүлийн харилцаа нь инж бэлгээр хэмжигдэж, зөвхөн гэр бүлийн хүрээгээр хязгаарлагдаж байсан бол өнөөдөр Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.11-д "Гэр бүлийн харилцаанд эр, эм тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл,

4. БНМАУ-ын хуулиуд. Боть I. УБ., 1980 он.

5. Төрийн мэдээлэл, УБ., 1994 он. №8

6. Төрийн мэдээлэл, УБ., 2002 он. №08

эх нялхас хүүхдийн ашиг сонирхолыг төр хамгаална" гэж зааснаар уг асуудал нь төрийн анхаарлын төвд орших үндсэн асуудлын нэг болжээ.

Гэр бүлийн талаархи хуулийн зарим заалтын зохицуулалтын харьцуулалт /хэвсрэлт/

№	Харьцуулах шалгуур	1926 оны хууль	1967 оны хууль	1994 оны хууль	2002 оны хууль
1		Эр, эм бололцсон этгээдүүдийн өмч, өмчлөх эрхийг зохицуулж өгсөнөөс гадна эд хөрөнгөтэй холбоотой гэрээ эхлэл байгуулж болохыг, хэн нэгнийгээ тэжээн тэтгэх үүрэг зэргийг хуульчилжээ. Салсан эр, эмийн хэн нэгэнд нь ажил олдохгүй, ажил хийж чадахгүй болсон байвал салсан эхний өдрөөс нэг жилийн хугацаанд нөгөө этгээдээсээ амьжиргааны аливаа зүйлийг авч болно гэжээ.	Өргөдлийг хариуцагчийн оршин суугаа газрын шүүхэд гаргана	Н э х э м ж л э л и г хариуцагчийн оршин суугаа газрын шүүхэд гаргана	Нэхэмжлэлийг хариуцагчийн оршин суугаа газрын шүүхэд гаргана
2	Тэтгэвэр гаргуулах ба эд хөрөнгө хуваах	Эр, эм бололцсон этгээдүүдийн өмч, өмчлөх эрхийг зохицуулж өгсөнөөс гадна эд хөрөнгөтэй холбоотой гэрээ эхлэл байгуулж болохыг, хэн нэгнийгээ тэжээн тэтгэх үүрэг зэргийг хуульчилжээ. Салсан эр, эмийн хэн нэгэнд нь ажил олдохгүй, ажил хийж чадахгүй болсон байвал салсан эхний өдрөөс нэг жилийн хугацаанд нөгөө этгээдээсээ амьжиргааны аливаа зүйлийг авч болно гэжээ.	Гэрлэгсдээс хүүхдийн тэтгэлэг гаргуулах, тусалцаа шаардагдаж байгаа чадваргүй хөдөлмөрийн чадваргүй эхнэр буюу нөхөрт тэтгэвэр олгуулах, гэрлэгсдийн дундын эд хөрөнгийг хуваах, гэрлэхийн өмнөх овгийг олгох тухай асуудлыг шүүх гэрлэлт цуцлах тухай хэрэгтэй хамт шийдвэрлэнэ.	Гэрлэгчдийн дундын эд хөрөнгө хуваах, тусалцаа шаардагдаж байгаа хөдөлмөрийн чадваргүй эхнэр буюу нөхөрт тэтгэвэр олгуулах тухай асуудлыг шүүх гэрлэлт цуцлах нэхэмжлэлтэй хамт шийдвэрлэнэ.	Гэрлэлт цуцлах үед эхнэр буюу нөхөр нь хүнд өвчтэй хөдөлмөрийн чадваргүй, эдийн засгийн хувьд зайлшгүй тусалцаа шаардлагатайгаас тэтгэвэр гаргуулах, хамтран өмчлөх дундын эд хөрөнгө хуваах, насанд хүрээгүй хүүхдийг хэний асрамжинд үлдээх талаар гарсан маргааныг шүүх гэрлэлт цуцлах нэхэмжлэлтэй хамт шийдвэрлэнэ.
3	Шүүх хуралдаанд орох	Эр, эм салалтыг орон нутгийн захиргааны газар, эд хөрөнгийн хувьд маргаантай бол Шүүн таслах газраар шийдвэрлүүлнэ.	Гэрлэгсдийн төлөөлөгч шүүх хуралдаанд оролцож байгаа ч гэсэн гэрлэгсэд шүүх хуралдаанд хүрэлцэн ирэх үүрэгтэй	Зохигчдын төлөөлөгч буюу өмгөөлөгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа ч гэсэн гэрлэгчид шүүх хуралдаанд ирэх үүрэгтэй	Зохигчдын төлөөлөгч буюу өмгөөлөгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа ч гэсэн гэрлэгчид шүүх хуралдаанд ирэх үүрэгтэй

4	Урьдчилсан арга хэмжээ	Шүүгч хэргийг шүүх хуралд бэлтгэх явцад гэрлэгсдийг эвлэрүүлэх талаар бололцоотой бүх арга хэмжээ авна гэжээ.	Шүүх гэрлэгчдийг эвлэрүүлэх арга хэмжээ авч болно.	Шүүгч шаардлагатай гэж үзвэл гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэхдээ дараах арга хэмжээг урьдчилан авна. 1. насанд хүрээгүй хүүхэд болон хөдөлмөрийн чадваргүй эцэг эхийг тэжээн тэтгүүлэх 2. насанд хүрээгүй хүүхдийг эцэг, эхийн хэн нэг дээр байлгах 3. гэрлэгчдийг тусдаа амьдрахыг даалгах 4. гэрлэгч хэн нэгийг тэжээн тэтгүүлэх 5. орон сууц болон хамтран өмчлөх дундын өмч, үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөх эрхийг бусдад шилжүүлэх, худалдах, бэлэглэх, захиран зарцуулахыг хориглох 6. шүүхийн зардлын зохих хувийг урьдчилгаа болгон төлүүлэх 7. зохигчийг эвлэрэх талаар хугацаа заах
5	Гэрлэгчдийн хооронд байгуулсан гэрээ биелүүлэх тухай			Гэрлэгчид харилцан тохиролцож байгуулсан эд хөрөнгийн болон тэжээн тэтгэх тухай гэрээг сайн дураар биелүүлээгүй бол аль нэг талын хүсэлтээр эдгээр гэрээг биелүүлэхтэй холбогдуулан шүүгч захирамж гаргана.
6				

СОЛОНГОСЫН САНХҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ЧИГ ХАНДЛАГА БОЛОН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ЖОН ЧАН ХЕН

(Корё Их Сургуулийн хууль
зүйн сургуулийн профессор,
Санхүүгийн эрх зүйн
нийгэмлэгийн тэргүүн)

1. Солонгост Санхүүгийн хууль нь өргөн утгаараа Банкны тухай хууль, Даатгалын тухай хууль, Үнэт цаасны тухай хууль, Шууд бус хөрөнгө оруулалтын хөрөнгийг захиран зарцуулах тухай хууль зэргийг хамруулах бөгөөд явцуу утгаараа бол Банкны тухай хуулийг илэрхийлж байна. Банкны тухай хууль нь түрүүчийн Засгийн газраас аж үйлдвэрийн хөрөнгөд үндэслэсэн банкны удирдлагыг үгүйсгэж байлаа. Гэвч 2008 онд шинэ Засгийн газар Санхүү (банк), аж үйлдвэрийн хөгжлийн төлөө энэхүү заалтыг хөнгөлж, хуульд өөрчлөлт хийх гэж байгаа нь Банкны тухай хуулийн хувьд гол асуудал болоод байгаа юм. Даатгалын тухай хуулийн хувьд Худалдааны хуульд даатгалын талаар (Даатгалын гэрээний тухай) өөрчлөлт хийх төслийг 2007 оны 12 дугаар сарын 31-ний өдөр Засгийн газрын хуралдаанаар шийдэн 2008 оны 1 дүгээр сарын 4-ний өдөр Ассамблейд өргөн барьсан ба энэхүү Даатгалын гэрээний тухай хуулийн төсөл нь саяхан энэ салбарын хууль хэрэгжүүлэгчид болон мэргэжилтнүүдийн дунд ихээхэн маргаан өрнүүлсэн асуудал болоод байна. Үнэт цаасны тухай хууль болон Шууд бус хөрөнгө оруулалтын хөрөнгийг захиран зарцуулах тухай хуулийн хувьд 2007 оны 8 дугаар сарын 3-ны

баталсан "Хөрөнгийн зах зээл болон Санхүүгийн хөрөнгө оруулалтын тухай хууль"-д үндэслэн энэхүү ажил үүрэг нь нэгдсэн ба үүнийг зохицуулдаг Үнэт цаасны арилжааны хууль, Бэлгэглэлийн тухай хууль, Шууд бус хөрөнгө оруулалтын хөрөнгийг захиран зарцуулах тухай хууль, Санхүүгийн нэгдсэн компанийн тухай хуульд хүчингүй болсон нь энэ салбарт сүүлийн үед гарсан томоохон өөрчлөлт гэж хэлж болно.

2. Солонгосын Банкны тухай хуульд нэг хүний банкны хувьцааны эзэмших хязгаарыг зарчмын хувьд 10 хувиар тогтоож, санхүүгийн бус оролцоо нь (аж үйлдвэрийн хөрөнгийн) хувьд дахин 4 хувиар зарчмын хязгаарыг тавьсан байна. Энэ нь аж үйлдвэрийн хөрөнгөд үндэслэн банк эзэмшихийг хатуу чанд хязгаарлах гэсэн хэрэг мөн. Энэхүү санхүүгийн хуваарилалтыг Солонгост эсэргүүцэх, дэмжих 2 бүлгийнхэн байна. Дэмжигч талын үндэслэл нь аж үйлдвэрийн хөрөнгөд үндэслэн банк эзэмшихийг зөвшөөрвөл банк томоохон корпорацийн хувийн сейф болж орхиход санаа зовж байгаа бөгөөд санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг нураах, аж үйлдвэрийн тэнцвэртэй хөгжлийг алдагдуулж болох юм гэж үзэж байна. Харин эсэргүүцэгч талын үндэслэл нь хөрөнгө хуваарилах бодлого нь дотоодын хөрөнгийг хязгаарлаж гадаадын хөрөнгийг тэргүүнд тавин ялгаварлах байдлыг бий болгох талтай, мөн аж үйлдвэрийн хөрөнгийг

санхүүгийн хөрөнгө болгон ашиглах хэрэгцээ шаардлага байгаа, санхүүгийн компанийн олон улсын өрсөлдөх чадварыг бэхжүүлэх шаардлагатай зэрэг үндэслэл гарган асуудлыг дэвшүүлж байгаа юм. Миний бодлоор хөрөнгө хуваарилалтыг дэмжигч талын шалтгаан нь үндсэндээ Солонгосын томоохон корпорацийн талаархи таагүй хандлагатай холбоотой бөгөөд өнөөдрийн байдлаар Солонгосын корпорациуд өнгөрсөн түүхтэй харьцуулахад түүний удирдлага, бүтэц ихээхэн өөрчлөгдөж одоогийнхтой адил хатуу хөрөнгө хуваарилалтыг хөнгөлөх хэрэгтэй гэж үзэж байна. Солонгосын одоогийн Банкны тухай хууль шиг аж үйлдвэрийн хөрөнгөөр банк эзэмшихийг эрс үгүйсгэсэн хууль үндсэндээ гадаадын жишигт ч бараг байхгүй. Мөн Солонгосын Банкны тухай хууль нэг хүний банк эзэмших хувьцаанд хязгаарыг хуульчилж өгснөөр банкны хувьцааг аж үйлдвэрийн хөрөнгөөс давхар хязгаарласан хэрэг гэж үзэж болно. Мөн Солонгост 1997 онд валютын хямрал бий болсноос хойш төрөөс хөрөнгө оруулалттай банкныг дахин хувьчлах шаардлага байгаа ч эдгээр банкныг хувьчилж авах боломжтой хөрөнгө үнэн хэрэгтээ аж үйлдвэрийн хөрөнгөөс өөр байхгүй талыг харгалзах, Солонгосын дотоодын банкууд гадаадын томоохон санхүүгийн байгууллагуудтай өрсөлдөхийн тулд ч их хэмжээний хөрөнгө шаардлагатай, үүний тулд дотоодын аж үйлдвэрийн

хөрөнгийг ашиглах арга замыг эрэлхийлэх зэрэг өнөөгийн Солонгосын санхүүгийн орчин ихэд өөрчлөлттэй байна. Иймд энэхүү өөрчлөлтийг харгалзан Солонгосын Банкны тухай хуульд буй давхар хязгаарлалтын асуудлыг шийдэхийн тулд эхний шатанд банкны хувьцааг эзэмшихэд давхар хязгаар хийж буй заалтыг хүчингүй болгох хэрэгтэй гэж үзэж байна. Мөн банкны хуульд нэг хүний эзэмших хувьцааны тоо хэмжээг хязгаарласнаар банкны салбарт хариуцлагатай томоохон хувьцаа эзэмшигч байхыг үгүйсгэн орлон гүйцэтгэх боловсон хүчний зардлыг нэмэгдүүлж, үр ашигтай менежментийн тогтолцоог бий болгож чадахгүй байна. Тиймээс 2 дахь шатанд Солонгосын банкны дэлхийд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж үр ашигтай менежментийн тогтолцоог бий болгохын тулд томоохон хувьцаа эзэмшигч нарыг төрөн гарахад дөхөм болохуйц нэг хүний эзэмших хувьцааны хязгаар хэмжээг нэмэгдүүлэх хэрэгтэй гэж үзэж байна. Үүний зэрэгцээ банкны хяналтыг чангатган эзших нөхцөлийг хөнгөтгөх үйл ажиллагаатай зэрэгцүүлэн явуулах хэрэгтэй гэж үзэж байна. 2008 оны 3 дугаар сарын 31-ний өдөр Солонгосын Санхүүгийн хороо ч мөн ийм асуудлаар хөрөнгө хуваарилалтыг хөнгөтгөх арга замын талаар төслөө Ерөнхийлөгчид танилцуулсан билээ.

3. Солонгосын Даатгалын тухай хууль нь Даатгалын байгууллагын тухай хууль болон Даатгалын үйл ажиллагааны тухай хууль (Даатгалын гэрээний тухай хууль) зэрэг байдаг бөгөөд Даатгалын байгууллагын тухай хууль нь Даатгалын үйл ажиллагааны хуулиар, Даатгалын үйл ажиллагааны (Даатгалын гэрээний тухай

хууль) хууль нь Худалдааны хуулийн 4 дүгээр бүлгээр тус тус зохицуулагдаж байна. Мөн даатгалын үйл ажиллагааны хяналтын тухай хууль ч хамтдаа үйлчилж байгаа. Солонгосын Засгийн газар 2007 оны 12 дугаар сарын 31-ний өдөр Худалдааны хууль дотор Даатгалын хууль (Даатгалын гэрээний хууль)-ийг шинэчлэх төсөл (Цаашид 'төсөл' гэж нэрлэх)-ийг Засгийн газрын хуралдааны шийдвэрт үндэслэн 2008 оны 1 дүгээр сарын 4-ний өдөр Ассамблейд оруулсан байна. Төслийн 638 зүйлийн 2-т шинээр "Даатгалын гэрээг байгуулагч талууд даатгалын гэрээ байгуулах эрхээ хэрэгжүүлэх, үүргээ биелүүлэхтэй холбогдуулан хамгийн дээд зарчмыг дагах шаардлагатай" гэж хуульчилснаар, даатгалын гэрээний журмыг бататгасан. Төслийн 646 дугаар зүйлийн 2.1-т даатгалын салбар (гэрээг төлөөлөн хийх)-ын эрх, үүргийг шинээр хуульчлан оруулж, уг зүйлийн 3-т даатгалын салбар биш мөртлөө тусгай даатгуулагчийн тулд тууштай даатгалын гэрээ байгуулахад зуучлагч этгээдийн (даатгалын зуучлагч, даатгалын төлөөлөгч гэх мэт) эрхийг шинээр оруулсан. Төслийн 655 дугаар зүйлийн 2-т хууран мэхлэх замаар даатгалын гэрээг хийсэн бол гэрээг хүчингүй болгон мөн 657 дугаар зүйлийн 2-т, шинээр хууран мэхлэх замаар даатгалын нөхөн олговор хүсэхийг хүчингүй болгох зэрэг заалт оруулсан. Төслийн 662 дугаар зүйлд даатгалын нөхөн олговораах, даатгалын хураамж зэрэг хуримтлагдсан хөрөнгөөс нөхөн олговор олгох хүчинтэй хугацааг 2 жилээс 3 жил болгон сунгаж, нөхөн олговор хүсэх хугацааг 1 жилээс 2 жил болгон сунгасан байна. Төслийн 682 дугаар зүйлд 2 заалтыг шинээр

оруулж даатгуулагч, даатгалын гэрээ байгуулагч зэргийн эрх, түүнтэй хамт амьдарч буй гэр бүлийн гишүүд байх тохиолдолд (тэрээр санаатайгаар хохирол учруулснаас бусад тохиолдолд) төлөөлөн олгох эрх байхгүйг хуульчилсан.

Төслийн 2 дугаар бүлэгт даатгалын хохирол, тухай 7 дугаар зүйлд шинээр оруулж даатгалын баталгааны талаархи заалт оруулсан ба энэ заалт даатгалын баталгааны шинж чанарын хувьд даатгалын гэрээний хуулийн дундаас үйлчлэх нь зохисгүй заалтыг үйлчлэхгүй байхаар өөрчилж, мөн даатгалын баталгаат чанарыг харгалзан Иргэнийн хуулийн баталгааны талаархи заалтыг үйлчлэхээр оруулсан байна. Төслийн 727 дугаар зүйлийн 2-т шинээр "1 дүгээр заалтын даатгалын мөнгө нь талуудын гэрээний дагуу хуваан төлж болно" гэж оруулсан, (эвхөн амь насны даатгал төдийгүй) бүх хүний даатгалын онцлогийг тусгажээ. Өөрөөр хэлбэл даатгалын хураамжийг хувааж төлөх нь хүний нас барах, амьдрах, ослын, өвчний гэх мэт бүх хүний төлөөх даатгалтай холбоотой зүйл учир хүнийг даатгах нийт заалтыг хуульчилсан байна. Мөн 730 дугаар зүйлийн "Амь насны даатгалын гэрээний даатгагч нь даатгуулагч нас барах, амьдрах, амьдрал үхэлтэй холбоотой даатгалын алдаа гарах тохиолдолд гэрээнд заасан даатгалын нөхөн олговор олгох үүрэгтэй" гэж оруулан, амь насны даатгалд даатгалын алдаанаас болж гардаг даатгалын төрлийг илүү тодорхой болгон төрөлжүүлж нас баралтын даатгал, амьдралын даатгал гэж оруулсан. Тиймээс одоогийн мөрдөж байгаа Худалдааны хуулийн 735 зүйлийн (өндөр

насны даатгал) нь амьдрах, нас барах тохиолдол хамт орсон даатгалын хувьд 730 дугаар зүйлд хуульчилсан хэрэггүй заалтыг хасч, 735 дугаар зүйлийн 2 (тэтгэвэрийн даатгал) нь амьдралын даатгалтай холбоотой төсөлд 730 дугаар зүйлд багтаж байгаа даатгалын хураамж төлөх аргатай холбогдуулан төслийн 727 дугаар зүйлийн 2-т багтаан оруулж хэрэггүй заалтыг хассан байна. Төсөлд 734 дүгээр зүйлийн 2-т ойрын хамаатан өв залгамжлагч эсвэл гэр бүлийн хүн нь нас барснаар даатгалын нөхөн олговор авах эрхтэй этгээдийн нөхөн олговороос 2-ний 1 хувь хүртэлх хэмжээгээр албадан хурааж авахыг хориглосон байна. Төслийн 737 дугаар зүйлийн 2-т гэнэтийн ослын даатгалд даатгуулагч нь хариуцлагаас чөлөөлөгдөх шалтгааныг хуульчилж өгсөн байна. Тухайлбал, гэнэтийн ослын даатгалд даатгуулагч нь даатгалын осол нь даатгалын гэрээ байгуулагч талын гэх мэт томоохон алдааны улмаас үүсэн гарах тохиолдолд хариуцлагаас чөлөөлөгдөхгүй боловч харин 'хагас нийгмийн чанартай эсвэл өндөр хэмжээний аюултай үйлдэл дундаас Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон үйлдэл' гэсэн тохиолдолд талуудын хооронд өөрөөр гэрээ байгуулж болохыг хуульчилж өгсөн. Төсөлд хүний даатгалтай холбоотой бүлэгт шинээр 4 дүгээр зүйлийг оруулж эрүүл мэндийн даатгалын талаар заалт оруулж, энэ талаар өвчтэй даатгуулагчийн хариуцлага, санаатайгаар өвчнийг хүндрүүлсэн тохиолдолд даатгуулагчийг хариуцлагаас чөлөөлөх, эрүүл мэндийн даатгалын талаар дагаж мөрдөхөөр заалт оруулжээ.

4. Солонгост өнөөг хүртэл хөрөнгийн зах зээл дээр аж ахуйн

нэгжүүдийн хөрөнгийн эргэлт багасч мөн хөрөнгийн зах зээлд бодит эдийн засгийн хэмжээнд тааруулж хөгжиж чадахгүй, үнэт цаас, бэлэглэл, хөрөнгийн эргэлт гэх мэт хөрөнгийн зах зээлийн талаархи хөрөнгө санхүүгийн салбарыг хөгжүүлэх асуудал дутагдалтай байгааг түшиж тулж чадахгүй, аж үйлдвэрийн салбар хоорондын тэнцвэргүй байдал гүнзгийрч, одоогийн хөрөнгийн зах зээлийн талаархи хууль нь 'хөрөнгийн зах зээл ба 'санхүү үйлдвэрийн салбар' эргэлтийн хөгжлийг хөхиүлэн дэмжиж чадахгүйгээс асуудал тулгарч байна. Тиймээс энэхүү асуудлыг шийдвэрлэхийн тулд хөрөнгийн зах зээл болон санхүүгийн хөрөнгө оруулалтын салбарын тухай холбогдох хуулиудыг батлан гаргах шаардлага гарч байгаа бөгөөд эдгээр хууль 4 үндсэн чиг хандлагатайгаар батлагдах болж байна. Нэгдүгээрт, санхүүгийн хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний талаархи ойлголтыг зөвхөн хийсвэрээр тогтоож Хоёрдугаарт, санхүүгийн хөрөнгө оруулалтын салбар, санхүүгийн хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, хөрөнгө оруулалт тус бүрээр эдийн засгийн бодит байдлаа даган дахин төрөлжүүлж, санхүүгийн байгууллагыг үл харгалзан эдийн засгийн бодит нэг байгууллагын үүрэг (санхүүгийн хөрөнгө оруулалтын салбар, санхүүгийн хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, хөрөнгө оруулагч) нэгэн ижил журамлана (функц тус бүрээр журамлана). Гуравдугаарт, бүхий л санхүүгийн хөрөнгө оруулах салбар (хөрөнгө оруулалтын худалдах худалдаалах үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын зуучлалын үйл ажиллагаа, нэгдсэн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөх үйл ажиллагаа,

зуучлалын үйл ажиллагаа) хоорондын хамтарсан үйл ажиллагааг зөвшөөрч, бүх туслах үйл ажиллагааг зөвшөөрөн, хөрөнгө оруулалтын төлөөлөн хийх тогтолцоог оруулж, санхүүгийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай холбогдуулан бүхий л гадаад валютын үйл ажиллагааг зөвшөөрнө. Үүгээр дамжуулан хөрөнгийн зах зээлд санхүүгийн (big bang) гарах төлөвтэй байна (үйл ажиллагааны хүрээг өргөтгөсөн). Дөрөвдүгээрт, тайлбарлах үүргийг шинээр оруулснаар хөрөнгө оруулалтын хязгаар тогтоож, ашиг сонирхолын зөрчлөөс сэргийлэх тогтолцоог бий болгон, банкны өр зээл, нэгдсэн хөрөнгө оруулалтын үнэт цаас, ашигт үнэт цаас зэргийг гаргах компанийн үйлчлэх хүрээг өргөтгөсөн (хөрөнгө оруулагчийг хамгаалах тогтолцоог хөгжингүй орны хэмжээнд хүргэх). Дээрх хуулийг 2007 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн 8635 тоот тогтоол гарч, тунхаглан зарласан. Энэ хууль зарлагдсанаас хойш 1 жил 6 сарын хугацааны дараа буюу (2009 оны 2 сарын 4 өдрөөс) эхлэн хэрэжинэ. (Дурдсан хуулийн хавсралтын 1 дүгээр зүйл). Энэ хууль 10 бүлэг, 449 зүйлтэй том хууль бөгөөд 1 дүгээр бүлэг Ерөнхий зүйл. 2 дугаар нь санхүү хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, 3 дугаар нь Үнэт цаас гаргах болон арилжаа хийх, 4 дүгээр нь Шударга бус арилжааг хязгаарлах, 5 дугаар нь Нэгдсэн хөрөнгө оруулалтын байгууллага, 6 дугаар нь Санхүү хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд хамрагдах байгууллагууд, 7 дугаар нь Солонгосын арилжааны бирж, 8 дугаар нь Хяналт болон зарцуулалт, 9 дүгээр нь бусад журам, 10 дугаар нь шийтгэлийн талаархи бүлгээс тус тус бүрдэж байна.



ГАРМАЕВ ЮРИЙ ПЕТРОВИЧ

/Хууль зүйн ухааны доктор, профессор, Ази номхон далайн улс орнуудын харьцуулсан эрх зүйн төвийн шинжлэх ухаан, судалгааны лабораторийн эрхлэгч, Буриадын Улсын их сургуулийн Хууль зүйн факультетын Эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн тэнхимийн эрхлэгч/

Гурав дахь мянганаас эхлэн Орост амжилттай эхэлсэн эдийн засгийн шинэтгэл нь банкны үйл ажиллагааны бодит хөгжилд шууд нөлөөлж байна. Аль ч улс оронд банк бол эдийн засгийн тэргүүлэх, суурь систем нь байдаг. Зах зээлийн механизм дахь банкны үүрэг, ач холбогдлыг үнэлж баршгүй билээ. Дэлхийн улс орны туршлага, тэр дундаа бидний хөрш болох Ази, номхон далайн бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн амжилтын туршлагаас харахад улс орны банкны системийн хөгжил, доройтол нь төрийн, нийгмийн болон хувийн амьдралын бүхий л хүрээнд шууд нөлөөлдөг. “Эрүүл банкны систем- тогтвортой

ОХУ-ЫН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТЫН ОНЦЛОГ

тер” гэсэн ойлголтын хооронд тэнцүүгийн тэмдэг тавихуйц бүрэн ижилсжээ.

Манай улсад хийж буй шинэтгэлийн хүрээнд санхүүгийн байгууллагын системийн үйл ажиллагааны эрх зүйн үндэсийг боловсруулж өгсөн нь нэгэн чухал алхам болсон. Улс оронд зах зээлийн эдийн засаг тогтох үйл явцад энэ салбарын амжилтын хажуугаар эрх зүйн зохицуулалтын системийн хөгжил учир дутагдалтай байсан бөгөөд хамгаалалтын арга хэмжээг тэр дундаа банкны үйл ажиллагааны эрүүгийн эрх зүйн хамгаалалтыг бий болгож өгөөгүй юм. Энэ нь банкны салбарт гэмт хэргийн шинжтэй нөхцөл байдал бий болох гол шалтгааны нэг болжээ. Банкны салбарт гарч буй гэмт хэргийн улмаас нийгэм болон төрд ихээхэн хэмжээний материаллаг, байгууллагын болон бусад онцлог бүхий хохирол учирдаг. Эдгээр гэмт үйлдлийн нийгэмд үзүүлэх хор уршиг улам бүр өсч байгаа нь зохион байгуулалттай гэмт бүлэглэл, зохион байгуулалттай гэмт хэрэг үйлдэгч нийгэмлэгүүд, бүлэг этгээд урьдчилан хэлэлцэн үйлдэж байгаатай холбоотой. Олон янзын

хэлбэрээр хамтран гэмт хэрэг үйлдэж байгаагийн нэг жишээ нь хяналтын болон хяналт шалгалтын байгууллагын эрх бүхий албан тушаалтан ийм гэмт хэрэгт ихээр холбогдож байгаа явдал юм. Үүний нэг адилаар улс оронд авлига өгч авах явдал нэмэгдэж байна. Нийгмийн хор уршигийн хувьд өсч байгаа гэмт хэрэг нь банкны удирдах болон гүйцэтгэх ажилтнууд, мөн тэдний хамтран ажиллагсад гэмт хэрэгт оролцож байгаагаараа онцлогтой.

Сүүлийн жилүүдэд ОХУ-ын шүүхэд хандаж шийдвэрлүүлж байгаа эрүүгийн хэрэгт банкны болон санхүүгийн бусад байгууллагын удирдлага холбогдсоор байгаа бөгөөд тухайлан хувьцаа эзэмшигчдийн эсрэг гэмт хэрэг (жишээ нь санхүүгийн аргаар луйвар хийх), зээлдүүлэгчийн эсрэг гэмт хэрэг–дампууралтай холбоотой луйвар, дампууруулах зорилготой халдлага (дампуурлын үеийн хууль бус ажиллагаа, санаатайгаар дампууралд хүргэх, хуурамч дампуурал -ОХУ-ын Эрүүгийн хуулийн 195-197 дугаар зүйл), төрийн санхүүгийн тогтолцооны эсрэг гэмт хэрэг (мөнгө угаах гэмт хэрэг ОХУ-ын Эрүүгийн хуулийн

174.1, татварын гэмт хэрэг-ОХУ-ын Эрүүгийн хуулийн 198-199.2 зүйл) болон бусад гэмт хэрэг болно.

Банкны салбар дахь гэмт хэргийн онцлог нь түүнийг бэлтгэх арга, үйлдэх болон гэмт хэргийн ул мөрийг нуун дарагдуулах ажиллагаа нь байнга өөрчлөгдөж, үйлдэх арга нь улам нарийсч байна. Гэмт хэргийн бүлэглэлүүд нь өөрсдийнхээ үйл ажиллагааг өөрчлөгдөж байгаа эрх зүй, санхүүгийн болон зохион байгуулалтын орчинд тохируулан ажиллаж байна. Тэдний орлого нь өсч байгаа бөгөөд мөнгө угаах янз бүрийн нарийн аргыг ашиглан рублийг тэрбум тэрбумаар хууль бус аргаар хилийн чанад руу гаргаж байна.

ОХУ-ын банкны тогтолцоонд учруулж болзошгүй үндсэн аюул нь дэлхийн макро эдийн засгийн өөрчлөлт, тухайлбал валютын ханшийн бууралт, нефтийн үнийн өөрчлөлт гэж үзэх үндэслэлгүй юм. Одоогийн байдлаар Оросын эдийн засаг нь урьд өмнөх түүхэнд байгаагүй тогтвортой байгаа гэж болно. Гэмт хандлага – гэмт явдлын зүгээс ирэх аюул бол эхний байранд тавигдаж байна.

Дээр дурдсан нөхцөл байдал нь банкны салбарын гэмт хэрэгтэй тэмцэх үр дүнтэй аргыг боловсруулж нэвтрүүлэх нь нэн чухал байгааг харуулж байна. Харин эрүүгийн эрх зүйн арга хэмжээ нь гэмт хэрэгтэй тэмцэхэд цорын ганц болон үндсэн арга хэмжээ

гэж үзэж болохгүй юм. Мөн эдгээрээс гарах үр дүнг дутуу үнэлж болохгүй. Иймээс гэмт явдалтай тэмцэх гол хэрэгсэл Эрүүгийн хуулийг боловсронгуй болгох явдал юм.

1997 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөх болсон. ОХУ-ын Эрүүгийн хууль нь Үндсэн Хууль болон нийтлэг хүлээн зөвшөөрөгдсөн зарчим, олон улсын хэм хэмжээнд үндэслэгдсэн (ОХУ-ын Эрүүгийн хуулийн 1 дүгээр зүйл) байдаг учир шинэ хуулиудад эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан бол Эрүүгийн хуулийг заавал мөрдөх ёстой.

Үүний зэрэгцээ ОХУ-ын Эрүүгийн хууль нь батлагдаад харьцангуй удаагүй байгаа, хүчин төгөлдөр болоод 11 жилийн хугацаанд уг хуульд эдийн засгийн салбарын нийгмийн харилцааг зохицуулахтай холбогдсон олон удаагийн нэмэлт өөрчлөлт оруулсан байдаг. (Эрүүгийн хуулийн 8 дугаар хэсэг, Эдийн засгийн салбарын гэмт хэрэг¹).

ОХУ-ын Эрүүгийн хуулийн зарим зүйл, бүтцийн онцлог нь түүний хэм хэмжээг үр дүн муутай болгосон байдаг. Тодорхой бус байдлаар ашиглагдаж байгаа заалт, ихэнх хэм хэмжээг загварлан хэрэглэсэн, үнэлэлт өгсөн тодорхойлолт нь адил байгаа

1. 2003 оны 12 дугаар сар хүртэл хүчин төгөлдөр байсан тухай хэсэгт хамаарах зүйлд 100 хувийн нэмэлт өөрчлөлт оруулсан байдаг. Энэ талаар дэлгэрэнгүй байдлаар, Эдийн засгийн салбар дахь гэмт хэрэг: Эрүүгийн хуулийн зохиогчийн тайлбар (ОХУ-ын Эрүүгийн хуулийн 8 дугаар хэсэг), Полашенко Н.А., М., 2006 он, 11-13 дахь тал.

нь практикт хэрэглэхэд түвэгтэй байдлыг учруулж байна. Иймээс бий болсон нөхцөл байдалд эрүүгийн хууль тогтоомжоор банкны салбар дахь гэмт хадлагаас хамгаалах нэмэлт арга хэмжээ авахад зайлшгүй чиглэгдэх ёстой².

Манай улсад хууль хэрэглэх практикийг судалсан байдлаас үзэхэд мөрдөн байцаагч, шүүгч болон бусад хуульч нар нь банкны салбар дахь гэмт хэргийг эрүүгийн эрх зүйн үүднээс зүйлчлэх асуудал нэлээд хүндрэлтэй байгаа нь ажиглагдаж байна. Хүндрэлтэй байгаа асуудлын гол нь Оросын дээд шүүх өөрийнхээ бүрэн эрхэд хамаарах асуудлаар эрүүгийн хууль тогтоомжийн талаар тайлбарыг дээд шүүхийн тогтоол хэлбэрээр гаргаагүй, уг асуудлаар одоо хүртэл ямар нэгэн тайлбар гараагүй байгаатай шууд холбоотой юм.

Үүнийг хийгээгүйгээс практикийн ажилтнууд ОХУ-ын Эрүүгийн хуулийн хэм хэмжээг янз бүрээр тайлбарлах, заримдаа зөрүүтэй ч тайлбар хийдэг. Энэ нь эрүүгийн хууль тогтоомжийн хууль ёсны зарчмыг мөрдөгдөхгүй байхад хүргэдэг (ОХУ-ын Эрүүгийн хуулийн 3 дугаар зүйл).

ОХУ-ын Эрүүгийн хуулийн Ерөнхий анги нь гэмт хэргийг зүйлчлэхэд эрүүгийн эрх зүйн объектыг хамгаалахад үндэслэгдсэн байдаг учир

2. Арилжааны банкны гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн арга хэмжээг боловсронгуй болгох, Якоби С. Шинэ үеийн эрх зүй, 2005 он, Дугаар 2. 24-25 дахь тал.

банкны салбар дахь гэмт хэрэг, банкны гэмт хэрэг гэдэг нэр томъёо байдаггүй болно³. Харин эдгээр нэр томъёо нь эрүүгийн эрх зүй, криминологийн шинжлэх ухаанд өргөн ашиглагдаж байгаа болно.

Бидний үзэж байгаагаар банкны салбар дахь гэмт хэрэг гэдэг нь улс орон дахь банкны тогтолцооны хэвийн үйл ажиллагаанд халдаж буй нийгэмд аюултай Эрүүгийн хуульд заасан санаатай үйлдэл юм.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн "Эдийн засгийн хүрэн дэх гэмт хэрэг" хэмээх 22 дугаар бүлэгт нэгтгэсэн 35 зүйлээс 11 зүйлийг нь ямар нэгэн хэмжээгээр банкны салбар дахь гэмт хэргийн төрөлд хамааруулж болно:

1.172 дугаар зүйл-Банкны хууль бус үйл ажиллагаа;

2.174 дүгээр зүйл- Бусад этгээдийн гэмт хэргийн замаар олсон мөнгөн хөрөнгө болон бусад эд хөрөнгийг хууль ёсны болгох (угаах);

3.174.1. Гэмт хэргийн замаар олсон мөнгөн хөрөнгө болон бусад эд хөрөнгийг хууль ёсны болгох (угаах);

4.176 дугаар зүйл-Хууль бусаар зээл авах;

5.177 дугаар зүйл- Зээлийн өр төлбөрийг барагдуулахаас санаатайгаар зайлсхийх;

6.183 дугаар зүйл- Худалдааны, татварын, эсхүл банкны нууцыг агуулж буй мэдээллийг хууль бусаар олж авах, тараах;

7.185 дугаар зүйл-Үнэт цаасны эмиссийг урвуулан ашиглах;

8.185.1. ОХУ-ын Үнэт цаасны тухай хууль тогтоомжоор тодорхойлсон мэдээллийг хөрөнгө оруулагч буюу хяналтын байгууллагад гаргаж өгөхөөс санаатайгаар зайлсхийх;

9.186 дугаар зүйл-Хуурамч мөнгөн тэмдэгт буюу үнэт цаас бэлтгэх, нийлүүлэх;

10.187 дугаар зүйл- Зээлийн эсхүл тооцооны карт буюу бусад төлбөрийн баримтыг хуурамчаар бэлтгэх, нийлүүлэх;

11.193 дугаар зүйл-Хилийн чанадаас гадаад валют болгон буцааж төлөхгүй байх.

2000-2007 оны үед бүртгэгдсэн гэмт хэргүүдийн ихэнх хэсгийг ОХУ-ын Эрүүгийн хуулийн 186 дугаар зүйлд (65-аас дээш хувь) заасан үйлдэл эзэлж байсныг тэмдэглэх хэрэгтэй. Энэхүү нөхцөл байдал нь хангалттай шинэ, практикт сорилт болжамжаагүй гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй харьцуулбал дурдсан гэмт хэрэг нь хангалттай уламжлалт, хууль сахиулах байгууллагуудад эртнээс танил гэмт хэрэг байсантай холбоотой юм. Үүний хамт ОХУ-ын Эрүүгийн хуулийн 172, 174, 176, 177, 187 дугаар зүйлд заасан гэмт хэргүүдийн илэрч буй тоо жилээс жилд өссөөр

байна. Гэхдээ 2006-2007 оны баримтаас үзвэл 6 гэмт хэргээс дөнгөж 1 гэмт хэрэгт л шүүхийн яллах тогтоол гарч байжээ. Практик ажилтнууд Эрүүгийн хуулийн 183, 185, 187 болон 193 дугаар зүйлүүдийг "үхмэл" заалт гэж нэрлэдэг. Учир нь эдгээр зүйлийг хэрэглэх нь маш ховор тохиолддог. Ингэхдээ банкны салбар дахь гэмт хэргийн илрүүлэлт дунджаар 34.2 хувьтай байна.

Банкны салбар дахь гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зүйлчлэлийн талаарх тулгамдсан асуудлыг авч үзье.

"Хууль бусаар зээл авах" гэсэн ОХУ-ын Эрүүгийн хуулийн 176 дугаар зүйлд хувиараа аж ахуй эрхэлж буй этгээд буюу зээл олгох байгууллагын удирдлагаас зээл авахдаа, эсхүл хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл авахдаа банк буюу бусад зээлдэгчид өөрсдийн аж ахуйн болон санхүүгийн байдлын талаар илт худал мэдээлэл өгснөөс болж их хэмжээний хохирол учирсан бол эрүүгийн хариуцлага ногдуулахаар заасан.

Энэ гэмт хэргийн бүрэлдэхүүний бүтцэд түүний нийгмийн хор аюулын өндөр түвшинг харгалзан өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн дагуу тооцож буй тусгай субъект(хувиараа аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч ба байгууллагын удирдлага)-ээс гадна үндсэн субъектыг буюу 16 насанд хүрсэн эрх зүйн чадамжтай хувь этгээдийг оруулан тооцох ёстой гэж үзэж байна⁴.

3. Шинжлэх ухааны ном зохиолд эдийн засгийн гэмт хэрэг (ОХУ-ын Эрүүгийн хуулийн 8 дугаар хэсэг), Эдийн засгийн үйл ажиллагаанд дахь гэмт хэрэг (ОХУ-ын Эрүүгийн хуулийн 8 дугаар хэсэг, 22 дугаар бүлэг), ангилан төрөлжүүлэх асуудал яригдаж байгаа. Волженкин Б.В. Преступления в сфере экономической деятельности. – СПб., 2002., с.81-95.

4. Төсөөтэй байр суурийг тухайлбал,

Сүүлийн жилүүдэд ОХУ-д хувь этгээдэд зээл олгох нь олноор нэмэгдсэн. Иргэн бүр банкинд зээлээ буцааж төлөх чадвартай байдаггүй. Иргэн зээл авах зорилгоор санаатайгаар өөрийн санхүүгийн байдлын талаар хуурмаг мэдээлэл өгдөг үзэгдэл үерийн ус мэт нэмэгдсээр байна. Зээл хүсэгч иргэний бүрдүүлсэн мэдээллийг шалгадаггүй, эсхүл үнэн зөвийг нь шалгах боломжгүй богино хугацаатай нөхцөлтэй зээлийн бүрдүүлэлтийн журам ч мөн энэ байдалд нөлөөлдөг.

Банкны үйл ажиллагааны салбар дахь гэмт хэргийн бүрэлдэхүүнд мөн өөр нэг тооцох бүрэн үндэслэл байдаг. Байгууллагын удирдлага болон хувь этгээдийн шүүхийн холбогдох шийдвэр хүчин төгөлдөр болсны дараа үнэт цаасны төлбөр болон их хэмжээний зээлийн өрийг төлөхөөс зугтах тохиолдолд ОХУ-ын Эрүүгийн хуулийн 177 дугаар зүйлийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээнэ.

Гэмт хэргийн энэ бүрэлдэхүүний үндсэн шинж нь их хэмжээний букуу 250 мянган. руб.-ээс их хэмжээний зээлтэй байх (ОХУ-ын Эрүүгийн хуулийн 169 дүгээр зүйл). Ийм найрууллага бүхий зүйлийн хэм хэмжээ нь эрүүгийн хуулийн шударга ёсонд нийцэж буйд эргэлзээтэй. (ОХУ-ын Эрүүгийн

хуулийн 6 дугаар зүйл). Учир нь эрүүгийн хууль нь шүүхийн шийдвэрээр 250 мянган. руб.-ээс бага хэмжээний олгосон зээлээ буцаан авах хохирсон зээлдүүлэгчийн зөрчигдсөн эрхийг хамгаалахгүй.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 177 дугаар зүйлийн диспозицийн "их хэмжээ" гэх нэр томъёог ОХУ-ын эрүүгийн эрх зүйн хууль тогтоомжид үнэлэх боломжтой⁵ нь хүлээн зөвшөөрч ирсэн "их хэмжээгээр хохирол учруулах" гэх нэр томъёогоор өөрчлөх ёстой гэж үзэж байна. Энэ тохиолдолд тухайн үйлдлийн гэмт хэргийн шинжтэй эсэхийг тогтоохдоо хохирогчийн түүнд их хэмжээний хохирол учруулсан талаар субъектив үзлийг харгалзах ёстой. Үүнээс гадна энэ бүрэлдэхүүнтэй гэмт хэргийн субьектийн жагсаалтыг өргөжүүлж байгууллагын удирдлага болон хувь хүнээс гадна хувиараа аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийг субьектод тооцох нь үндэслэлтэй юм.

Бидний үзэж буйгаагаар Эрүүгийн хуулийн 176, 177 дугаар зүйлийн гэмт хэргийн бүрэлдэхүүний бүтэцийг шинэчлэх шаардлага бий болоод удаж байгаа. Өөрөөр хэлбэл түүнд шинээр зүйлчлэлийн (хүндрүүлсэн) шинжийг нэмж оруулах: бүлэг этгээд, зохион байгуулалттай бүлгийн урьдчилан хэлцэн үйлдсэн үйлдэл, урьд нь ял

шийтгэл эдэлж байсан этгээд үйлдсэн, албан тушаалаа урвуулан ашиглан үйлдсэн гэмт хэрэг. Зээлийн өрөө төлөхөөс зайлан зугтаах гэмт хэргийн ялын дээд хэмжээ нь хоёр жил хорих ял байдаг (ОХУ-ын Эрүүгийн хуулийн 177 дугаар зүйл⁶).

Дээрхи хүндрүүлэх нөхцөл байдлаар үйлдсэн гэмт хэрэгт ногдуулах энэ санц нь тухайн гэмт зөрчлийн нийгмийн хор аюулын өндөр төвшинд тохирох нь эргэлзээтэй юм.

ОХУ-д өрнөж буй нийгмийн, эдийн засгийн ба улс төрийн өөрчлөлт шинжлэх ухааны үндэслэлтэй хууль тогтоомжийн болон тэдгээрийг хэрэгжүүлэх талаар шийдвэр гаргахыг онцгойлон шаардаж байна.

Ямар ч улсын эрүүгийн хууль тогтоомж нийгмийн харилцааг зохицуулах тогтолцоонд цорын ганц биш хэдий ч хамгийн хатуу, шийдэмгий болон байнгын шаардлагатай хэрэгсэл болдог.

Шинэтгэлийн үйл явц олон хүндрэл, бэрхшээлтэй тулгарч байдаг хэдий ч энэ үед эрүүгийн эрх зүйн хориглолт нь банкны хууль ёсны үйл ажиллагааг гэмт халдлагаас хамгаалах өөрийн чиг үүргээ гүйцэтгэх болно.

- оОо -

Финогенова О.В. Уголовная ответственность за незаконное получение кредита и злостное уклонение от погашения кредиторской задолженности. Дис.: канд. юрид. наук. М., 2003; Талан М.В. Преступление в сфере экономической деятельности: вопросы теории законодательного регулирования и судебной практики. Дис.: д-ра. юрид. наук. М., 2002.

6. Хүчин төгөлдөр үйлчилж буй хуульд тухайн гэмт хэргийн бүрэлдэхүүн нь зүйлчлэлийн шинжийг агуулаагүй.



"МӨХ-ны чадавхийг
бэхжүүлэх төслийн тухай
товчхон"

Мэргэжилтэн ИИЗУКА МИХА

Энэхүү төсөл нь 2006 оны 9 дүгээр сарын 15-ны өдрөөс 2008 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийг хүртэл үргэлжилсэн. Уг төслийн хугацаанд хийсэн үйл ажиллагааныхаа талаар товчхон танилцуулъя.

А.Монгол Улсын Өмгөөллийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөд санал, зөвлөгөө өгөх ажлын хүрээнд: Одоо мөрдөгдөж байгаа Өмгөөллийн тухай хуулийг шинэчлэх

Одоо мөрдөгдөж байгаа Өмгөөллийн тухай хууль хуулийн төсөл нь бэлэн болсон. Төслийн хугацаанд ХЗДХЯ-наас зохион байгуулсан хурлыг санхүүжүүлж, яаманд саналаа өгч, Өмгөөлөгч сэтгүүлд саналаа нийтлэж, өмгөөлөгчдөөс саналуудыг нь сонсох зэрэг ажлуудыг хийсэн.

В.Монголын Өмгөөлөгчдийн холбооны үйл ажиллагааг идэвхижүүлж, өмгөөлөгчдийг

"ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛ, ТУСЛАЛЦАА" ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

төлөөлөх байгууллагынх нь хувьд холбоонд дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд:

1/Өмгөөлөгч сэтгүүлийн хэвлэлийн санхүүжилт;

Өмгөөлөгч сэтгүүл нь төслийн үргэлжлэх хугацаанд 23 дугаар гарсан. Төсөл эхлэхээс өмнө 2 дугаар гарсан байсан тул нийт 25 дугаар гэсэн үг юм.

2/Өмгөөлөгчдийн хаягийн лавлагааны хэвлэлийн санхүүжилт;

Өмгөөлөгчдийн хаягийн лавлагааг 2007 оны 3 дугаар сар болон 2008 оны 11 дүгээр саруудад шинэчлэн 2 удаа хэвлэсэн. 2008 оны лавлагааг гаргалгүй вэб хуудсанд холбогдох мэдээллүүдийг багтаан оруулж, вэб хуудсыг шинээр хийх зардлыг санхүүжүүлэх төлөвлөгөөтэй байсан боловч, энэ төлөвлөгөө маань хэрэгжээгүй.

3/Өмгөөлөгчдийн холбооны үйл ажиллагаатай танилцах Япон дахь сургалт:

Японы Өмгөөлөгчдийн Холбооны үйл ажиллагаатай танилцах сургалт 2007 оны 1 дүгээр сард 18 өдрийн турш явагдсан бөгөөд Айчи мужийн өмгөөлөгчдийн холбооны дэмжлэг туслалцааг өндөр ач холбогдолтой, үр дүнтэй болсон. Оролцогчид нь МӨХ-ны ерөнхийлөгч, 2 өмгөөлөгч, ХЗДХЯ-ны 1 ажилтан байсан.

4/Өмгөөлөгчдөд зориулсан

сургалт, семинар:

а.Шүүх дэх олон улсын Хүний Эрхийн Конвенцийн хэрэгжилтийн талаарх семинар

б.Эвлэрүүлэн зуучлалын сургалт; (3 удаа)

в.Хуульчийн ёс зүйн сургалт (2 удаа)

г.Шүүхийн шийдвэрийг хэрэглэх аргын тухай

д.Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай сургалт;

5/"Хуульчийн ёс зүй" номыг эрхлэн гаргах

"Хуульчийн ёс зүй" номын хувьд анх 500 хувийг хэвлэсэн байсан ч, орчуулгын алдаа байна гэсний дагуу дахин орчуулж, 1000 хувь гаргасан. Гэвч сургалт семинар явуулж, мэдээлэл цуглуулан харахад Монголын хуульчдын ёс зүйн түвшинд хараахан тохирохгүй байгаа. Мөн Япон Монголын нийгмийн онцлог, хуульчдын өдөр тутмын ажил үүргийн зөрүү зэрэг ялгаатай зүйлүүд байгаагаас үүдэн тохиромжгүй зүйлүүд байхыг үгүйсгэхгүй.

6/Шүүхийн шийдвэрийн эмхтгэлийг эрхлэн гаргах (цуврал 6, 7 болон индекс);

Шүүхийн шийдвэрийн эмхтгэлийг Хууль зүйн үндэсний төв болон УДШ-тэй хамтран иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн цуврал 6, 7-г эрхлэн гаргасан ба цуврал 6-д 60 хэрэг, цуврал 7 –д 68 хэргийг багтаав. Мөн цуврал 7-той зэрэгцүүлэн цаашид

7-той зэрэгцүүлэн цаашид хэрэглэхэд хялбар болгох үүднээс цуврал 1-7-д орсон хэргүүдийн индекс номыг хийлээ. Индекс номонд хуулийн зүйл заалтаар, шүүх болон он, сараар гэсэн 2 төрлийг нэгтгэн нэг жижиг ном болгосон. 7/Радиогийн нэвтрүүлгээр дамжуулан өмгөөлөгчийг олон нийтэд таниулах;

Радиогийн нэвтрүүлгээр дамжуулан өмгөөлөгч болон хууль сурталчлах (үйл ажиллагаа В7) ажлын хувьд ХЗДХЯ болон Шихихутуг хууль зүйн дээд сургуультай хамтран 2007 оны 9 дүгээр сараас 2008 оны 6 сар хүртэлх хугацаанд долоо хоногт нэг удаа (давталт 1 удаа) нэвтрүүлэг явуулсан.

8/Холбооны үйл ажиллагаа болон Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөлийн дэргэдэх үйл ажиллагааны салбар хоорондын үйл ажиллагаанд оролцох, мониторинг хийх.

9/Холбооны вэб сайтыг хийхэд дэмжлэг үзүүлэх.

10/Урьдчилан хорих төв (Ганц худаг)-ийн уулзалтын өрөөг шинэчлэх (хэрэгжээгүй).

11/Өмгөөлөгчийн өмсгөлийг нэвтрүүлэх (хэрэгжээгүй).

С.МӨХ-ны эвлэрүүлэн зуучлах төвийг байгуулах, үйл ажиллагааг нь чиглүүлэх болон төвд ажиллах өмгөөлөгчдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх талаар хийсэн ажил:

1/Эвлэрүүлэн зуучлалын сургалт (3 удаа).

2/Зуучлагч бэлтгэх сургалт (2 удаа).

3/Төвийн үйл ажиллагааг чиглүүлэх (бүртгэлийн

шинэчлэлт, түрээсийн төлбөр, техник хэрэгсэл болон ашиглалт, дүрэмд өөрчлөлт оруулах зэрэг).

4/Эвлэрүүлэн зуучлалын гарын авлага эрхлэн гаргах.

5/Төвийн сурталчилгаа: (телевиз, сонин, сэтгүүл янз бүрийн арга хэмжээ зэрэг).

D.Төлбөрийн чадваргүй иргэдэд эрх зүйн туслалцааг хүртээмжтэй болгоход дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд:

1. Н и й с л э л и й н Өмгөөлөгчдийн Зөвлөлийн "Төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх эрх зүйн туслалцаа" семинарын санхүүжилт.

2.Олон Улсын Барын Холбооны Сингапур дахь хуралд 2 өмгөөлөгч оролцуулсан.

3.Японы Өмгөөлөгчдийн Нэгдсэн Холбооноос Малайз улсад зохион байгуулсан "Өмгөөлөгчдийн Холбооны эрх зүйн тогтолцоо дахь үүрэг роль" сэдэвт олон улсын хуралд 2 өмгөөлөгч оролцуулсан.

Бодит үр дүн:

-*Тайлан*

-(Өмгөөллийн тухай хуулийн төсөл Япон хувилбар);

-Эвлэрүүлэн зуучлах төвийн дүрэм (2008 оны 11 сар);

-Эрх зүйн туслалцаа үзүүлэх төвийн дүрэм (2008 оны 11 сар);

-Өмгөөлөгч сэтгүүл 23 дугаар

-Өмгөөлөгчдийн хаягийн лавлагаа 2 удаа (2007 он, 2008 он);

-"Хуульчийн ёс зүй" номны 2 дахь хэвлэлт;

-Монгол Улсын Иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн

эмхэтгэл цуврал 6, 7;

-Монгол Улсын Иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн эмхэтгэлийн индекс;

-Эвлэрүүлэн зуучлагч нарт зориулсан гарын авлага (хялбаршуулсан хувилбар);

-Эвлэрүүлэн зуучлалын гарын авлага (гарын авлага болон хэргүүдийн эмхэтгэл);

-Төрөл бүрийн семинарын материал, хурлын тайлан, санал асуулгын дүнгийн нэгтгэл;

-Япон дахь сургалтын хуваарь, материал, тайлан (Монгол оролцогчдын);

Өмгөөлөгчдийн өмсгөлтэй холбогдох санал асуулгын дүн;

Эвлэрүүлэн зуучлах төвийн танилцуулга, рекламны хуудас, телевизийн реклам, сурталчлах нийтлэл (сонин, сэтгүүл);

радио нэвтрүүлгийн агуулга;

төслийн танилцуулга хуудас (Монгол болон Япон хувилбар);

Хуульчийн ёс зүй (Монгол) орчуулга (1хэсэг);

Үл хөдлөх эд хөрөнгө барьцааны тухай хуулийн төслийн орчуулга.

Төслийн хугацаанд компьютер 9ш, принтер 4ш, хувилах машин 2ш, факсын аппарат 2ш, ширээ, сандал, хувцасны өлгүүр, номын шүүгээ гэх мэт техник хэрэгслийг нийлүүлсэн.

- оОо- -



Нийслэлийн шүүхийн
Эрүүгийн хэргийн танхимын
тэргүүн **Б.САРАНТУЯА**

Хүн худалдаалах гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байдлыг судлахдаа зөвхөн хүн худалдаалах гэмт хэргээр явцууралгүй ойролцоо төрлийн хэргийг хамт судлах нь энэ төрлийн хэргийг зүйлчилж шийдвэрлэхэд ач холбогдолтой юм.

Сүүлийн гурван жилд нийслэл, дүүргийн шүүхээр Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйл /хүн худалдаалах гэмт хэргэ/, 124 дүгээр зүйл,

/Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах/-д заасан гэмт хэрэгтэй холбоотойгоор 21 хэрэгт 25 хүн ял шийтгүүлсэн бөгөөд хүн худалдаалах гэмт хэрэгт 2006 онд 1 хэрэгт 1 хүн, 2007 онд 2 хэрэгт 3 хүн, 2008 оны эхний хагас жилд 2 хэрэгт 2 хүн ял шийтгүүлжээ. Үүнээс харахад өнөөдрийн байдлаар хүн худалдаалах гэмт хэрэгт нийт 6 хүн 5-15 жил хорих ял эдэлж байна.

Хүн худалдаалах гэмт хэргийг зүйлчлэхэд бэрхшээл

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ

учирч, хүн худалдаалах гэмт хэрэг үү, эсвэл биеэ үнэлэхийг зохион байгуулсан гэмт хэрэг үү гэдэг дээр маргаан үүсч эргэлзээ төрж эцэст нь арай хөнгөн ялтай зүйл болох бусдыг биеэ үнэлэхэд татан оролцуулах гэсэн хүндэвтэр гэмт хэрэг рүү оруулж зүйлчлэх явдал нэлээд байсан.

Монгол Улсын дээд шүүхээс 2008 оны 3 дугаар сарын 26-ны өдөр "Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай" 12 дугаар тогтоол гаргаснаар "хүн худалдаалах гэдэгт тодорхой төлбөртэйгээр /мөнгө авах, эд хөрөнгө болон түүнийг өмчлөх эрхээр солилцох гэх мэт/ эсхүл ямар нэгэн үүргийн гүйцэтгэлд тооцож/ өрөнд өгөх гэх мэт/ хүнийг бусдын мэдэлд бүр мөсөн букуу тодорхой хугацаагаар шилжүүлэхийг ойлгоно" гэж заасан бөгөөд уг тогтоолоор "ашиг олох зорилгоор, хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийсэн, хуурамч мэхэлсэн, эмзэг байдлыг нь далимдуулсан, элсүүлсэн, орогнуулсан, хүлээн авсан, эрх мэдлээ урвуулан ашигласан, эрхшээлдээ байгаа, хил давуулсан, хүнд хор уршиг учирсан, биеийг нь үнэлүүлсэн, бэлгийн хүчирхийлэлд оруулах, албадан хөдөлмөр хийлгэх боолчлох, боолчлолтой ижил

төстэй нөхцөлд байлгах, эд эрхтнийг нь авч ашиглах" гэдгийг нэг бүрчлэн тайлбарласан билээ.

Мөн энэ тогтоолд хүн худалдаалах гэмт хэрэг нь биеэ үнэлэхэд бусдыг татан оруулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргээс ялгагдах шинжийг тодорхойлсон энэ тогтоол нь хүн худалдаалах гэмт хэргийг зөв зүйлчлэхэд туйлын ач холбогдолтой тогтоол билээ. Гэтэл шат шатны шүүх хүн худалдаалах гэмт хэргийн зүйлчлэл дээр маргаж оновчтой зөв зүйлчилж чадахгүй, хэргийг буруу зүйлчлэх, үндэслэлгүй шалтгаанаар хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаах зэргээр чирэгдүүлдэг явдал арилахгүй байна.

Жишээ нь: Яллагдагч М нь 2006 оны 10 дугаар сарын 5-наас мөн оны 11 дүгээр сарын 16-ны хооронд Б, Я, А, Ш, Э нарын 5 эмэгтэйд өндөр цалинтай ажилд оруулна гэж хуурч мэхлэн Сингапур Улсад аваачиж мөлжих зорилгоор биеийг нь үнэлүүлж, Монгол Улсын хил давуулан худалдаалсан гэмт хэрэгт холбогджээ. Энэ хэргийг прокуророос Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн 113.3 дахь хэсэгт зааснаар хүнийг хил давуулан худалдаалсан гэсэн Эрүүгийн хуульд заасан 10-

аас дээш 15 жил хорих ялтай онц хүнд хэрэгт холбогдуулан яллах дүгнэлт үйлджээ.

Чингэлтэй дүүргийн анхан шатны шүүх энэ хэргийг 2008 оны 4 дүгээр сарын 21-нд хэргийг мөрдөн байцаалтыг бүрэн бишхийсэн, түүнийг шүүх хуралдаанаар нөхөн гүйцэтгэх боломжгүй гэж үзэж нэмэлт мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буцаасныг прокурор эс зөвшөөрч эсэргүүцэл бичсэнээр нийслэлийн давж заалдах шатны шүүхээр хэлэлцэж, хэргийн бүрдэл хангагдсан ба нэмж шалгах шаардлагагүй тул хэргийг анхан шатны шүүхээр эцэслэн шийдвэрлүүлэхээр буцаажээ. Анхан шатны шүүх 2008 оны 6 дугаар сарын 27-нд шийтгэх тогтоол гаргаж М-д Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн 113.3 дахь хэсэгт зааснаар 10 жил 1 сар хорих ялыг чанга дэглэмтэй эмэгтэйчүүдийн хорих ангид эдлүүлэхээр шийдвэрлэснийг шүүгдэгчийн давж заалдсанаар Нийслэлийн давж заалдах шатны шүүхээр хэлэлцэж энэ хэрэг нь хүн худалдаалсан гэмт хэрэг биш, харин бусдын биеийг үнэлүүлсэн, биеэ үнэлэхэд татан оруулсан гэмт хэрэг гэж үзэж зүйлчлэлийг хөнгөрүүлэн зүйлчилж 10 жил 1 сарын хорих ялыг 3 жил хорих ял болгон, хорих ялыг тэнссэн байна. Энэ шийдвэрийг прокурор эс зөвшөөрч эсэргүүцэл бичсэнээр Улсын дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаанаараа 2008 оны 10 дугаар сарын 15-нд хэлэлцэж

энэ хүн худалдаалах гэмт хэрэг мөн гэж дүгнэж Нийслэлийн шүүхийн магадлалыг бүхэлд нь хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрийг өөрчлөлт оруулж хэвээр баталсан байна. Нэг хэргийг шийдвэрлэхэд шат шатны шүүх өөр өөрөөр дүгнэлт хийж байгаа нь энэ төрлийн хэргийг зүйлчлэхэд практик тогтоогүйгээс гадна Улсын дээд шүүхийн тогтоол гаргахаас өмнө үйлдсэн хэргийг уг тогтоолд хамруулж хүндрүүлэн зүйлчлэхгүй гэсэн практик зонхилж байгаатай холбоотой байна.

Нийслэл, дүүргийн шүүхээр шийдвэрлэгдсэн Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйл биеэ үнэлэхэд бусдыг татан оруулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэгт сүүлийн 3 жилд нийт 17 хэрэгт 19 хүнд ял шийтгэсэн бөгөөд тоо баримтаас харахад энэ төрлийн гэмт хэрэг өсөх хандлагатай байна.

Дээрх хэргүүдийг судлахад эмэгтэйчүүдийг олноор нь гадаадад дагуулан аваачиж биеийг нь үнэлүүлэхийг зохион байгуулсан, Улаанбаатар хотод сауны газрыг түрээслэхдээ массажист нэрийн дор бусдын биеийг нь үнэлүүлж, орон байраар хангаж ашиг хонжоо олсон, мөн насанд хүрээгүй биеэ хамгаалах чадваргүй байдлыг нь далимдуулсан, айлган сүрдүүлж эрхшээлдээ оруулан ашиг орлого олох зорилгоор биеийг нь үнэлүүлсэн, мөн гудамж талбай, үйлчилгээний төвүүдийн орчмоор эмэгтэйчүүдийг биеэ үнэлэхийг

зохион байгуулсан, бусдыг биеэ үнэлэхэд автомашинаар үйлчилдэг гэх зэрэг үйлдлийг Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйл "биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулсан, биеэ үнэлэхийг зохион байгуулсан" хэрэгт гэм буруутайд тооцож ял шийтгэл ногдуулсан байна.

Шүүхийн практикт Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйл, биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийг үндсэнд нь зөв зүйлчилж байгаа боловч насанд хүрээгүй хүнийг хүч хэрэглэн авч явж, зодож хүчээр биеийг нь үнэлүүлсэн үйлдлийг хүн худалдаалах гэмт хэрэгээр зүйлчлэхгүй Эрүүгийн хуулийн 124 "биеэ үнэлэхэд татан оруулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах" гэсэн хөнгөн зүйлээр зүйлчилж ноцтой гэмт хэрэгтнийг ял завшуулж байгаа буруу хандлага байгааг таслан зогсоох шаардлагатай юм. Ер нь насанд хүрээгүй, юмны учрыг сайн ойлгохгүй бэлгийн бойжилт олоогүй, бэлгийн хүмүүжил, ёс зүйг ч мэдэхгүй балчир охидууд өөрөө хүсч биеэ үнэлнэ гэдэг байж боломгүй асуудал. Жишээ нь: М гэгч нь 2007 оны 9 дүгээр сарын 14-нөөс 18-нд насанд хүрээгүй А,Б нарын 2 охиныг анхаарал халамж үзүүлэх, ойр дотны хүнгүй, биеэ хамгаалах чадваргүй байдлыг нь далимдуулан айлган сүрдүүлэн эрхшээлдээ оруулж биеийг нь үнэлүүлж, олсон бүх орлогыг нь өөрөө авсан гэмт хэргийг прокуророос биеэ үнэлэхийг

зуучилсан гэж Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлийн 124.2 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдсэн байхад Сүхбаатар дүүргийн шүүх энэ нь зуучилсан гэсэн хүндрүүлэх нөхцөл байдал алга байна гэж үзэж бүр хөнгөрүүлэн Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлийн 124.1 дэх хэсэгт зааснаар 6 сар баривчлах ял шийтгэжээ. Үүнээс харахад насанд хүрээгүй хүнийг хуурч мэхэлж зодож айлган сүрдүүлж, хүч хэрэглэн биеийг нь үнэлүүлээд олсон орлогыг бүгдийг нь өөрөө авсан этгээдийг хүн худалдаалах хэргээр зүйлчлэх шаардлагатайг мөрдөн байцаагчид хяналт тавьдаг прокурор, шат шатны шүүх анхаарах шаардлагатай байна. Жишээ нь, Насанд хүрээгүй Н-ийг 2006 оны 7 дугаар сарын 16-ны өдөр гэрлүүгээ явж байхад нь найз охиных нь найз эрэгтэй А гэгч гэрт чинь хүргэж өгье гэж хуурч машиндаа суулган авч явж Хан-Уул дүүргийн нутагт ХААИС-ийн урд байдаг гэр хороололд нэг айлд аваачсан бөгөөд тэр айлын М гэгч эгч, ах зодож хүчээр биеийг нь үнэлүүлж мөнгийг нь өөрөө авдаг байсан талаар насанд хүрээгүй хохирогч мэдүүлсээр байтал прокурор уг хэргийг хүн худалдах хэргээр огт шалгалгүй, биеийг нь үнэлэхэд зуучилсан гэж Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлээр яллах дүгнэлт үйлдэж Баянзүрх дүүргийн шүүхэд шилжүүлснийг Баянзүрх дүүргийн шүүх хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүн байгаа эсэхийг

шалгуулахаар хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаасан байна.

Мөн зарим этгээд биеэ үнэлэхэд бусдыг татан оруулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг үйлдэхдээ зарим эмэгтэйг худалдсан байхад үйлдэл тус бүрийг нарийн шалгаж тогтоолгүй хүн худалдаалах хэргийг нь орхигдуулж хавтгайруулан хөнгөн зүйл болох 124 дүгээр зүйлээр зүйлчилж гэмт этгээдэд ял завшуулах боломж олгож байна. Жишээ нь, хохирогч А-ийн мэдүүлэгт "найз Т-тэй тааралдаж ажил олдохгүй байгаа тухайгаа ярихад Хятад улсад зочид буудалд цэвэрлэгч, тогоочоор ажиллуулахаар ярьж тохирон авч яваад тэнд очсоныхоо дараа намайг биеэ үнэл гэж хятадуудад зарж паспортыг минь хураан авсан" гэж мэдүүлсээр байхад энэ мэдүүлгийг огт шалгалгүйгээр түүнийг биеэ үнэлэхэд зуучилсан гэж Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлээр зүйлчилж ирүүлснийг мөн Баянзүрх дүүргийн шүүхээс хүн худалдаалах хэргээр шалгуулахаар буцаасан байна.

Энэ мэтээр ийм төрлийн хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд шалгаж тогтоовол зохих байдлыг огт шалгалгүй орхих, хэрэг бүртгэлт мөрдөн байцаалт, шүүхийн хэлэлцүүлэгт нэг талыг барих, гүйцэт биш хийх, Эрүүгийн хуулийг буруу хэрэглэх, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчих,

дэндүү урт хугацаагаар шалгаж хохирогчийг залхаах зэрэг зохисгүй байдал арилахгүй байгааг анхаарч арилгах шаардлагатай болжээ.

2008 оны 2 дугаар сард Монгол Улсын Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт орсноор хүн худалдаалах гэмт хэргийн зүйлчлэл илүү ойлгомжтой болж Улсын дээд шүүхийн тайлбар гарсан. Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр баталсан Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц, түүний нэмэлт болох "Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх" тухай 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн протоколд Монгол Улс нэгдэн орсныг 2008 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн Монгол Улсын хуулиар соёрхон баталсан тул хуульчид мөрдөн байцаагчид, прокурор, шүүгчид энэ төрлийн хэргийг мөрдөх, хянах, шүүхэд урьд нь учирч байсан бэрхшээл арилж хуулийг нэг мөр ойлгож зөв хэрэгжүүлэхэд эрх зүйн орчин бүрэн бүрдсэн гэж үзнэ.

Иймд энэ төрлийн хэргийг түргэн шуурхай мөрдөж, зөв зүйлчилж шийдвэрлэх нь чухал байна.

- оОо -



ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ШИНЖТЭЙ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЛЭХ НЬ

Хууль зүйн үндэсний төвийн
Криминологийн судалгааны
секторын эрдэм шинжилгээний
ажилтан, хууль зүйн магистр
Б.ОДОНГЭРЭЛ

Өнөөгийн нөхцөлд хуулийн этгээд нь нийгмийн эдийн засаг, санхүү, улс төр, ба эрх зүйн системийн үндэс болдог. Бизнесийн үйл ажиллагааг гол нь хуулийн этгээд эрхлэн явуулдаг ба үндсэн татвар төлөгч, ажил олгогч болохыг тэмдэглэх нь зүйтэй юм. Ерөнхийдөө санхүүгийн нөөцийн нэлээд хэсгийг эзэмшдэг хуулийн этгээд нь улс төрийн зорилгоо хэрэгжүүлэх өргөн боломжтой, албан татварын орлогод сөргөөр нөлөөлөх, аж ахуйн чухал салбарт үлэмж хэмжээгээр онц эрхтэй болох, санхүү зээлийн системийг эрүүгийн шинжтэй болгох, хүн амын эдийн засгийн идэвхийг багасгах зэргээр нөлөөлдөг.

Өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж (иргэний, захиргааны болон бусад) нь хуулийн этгээдийн сөрөг нөлөөг нийгмийн харилцаанд саармагжуулсан нөлөө үзүүлж чадахгүй байгаа юм.

Хууль хэрэгжүүлж байгаа

практикаас үзэхэд байгууллагад иргэний болон захиргааны хуульд заасан торгуулийн шийтгэл оногдуулж, учруулсан хохирлын хэмжээг заасан нь амьдралд нийцдэггүй. Учир нь хуулийн этгээдийн үйл ажиллагааны улмаас учруулсан хохирол нь зарим хувь хүний учруулж байгаа хохирлоос үлэмж их байдаг.

Шинжлэх ухааны ном зохиолд давамгайлж байгаа зарим үзэл бодлоос үзэхэд хуулийн этгээдийг төлөөлж буй хууль зөрчсөн хувь хүнд зөвхөн ял оноох нь хуулийн этгээдийг дахин ийм төрлийн зөрчил, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх шинж чанаргүй байна. Өөрөөр хэлбэл хуулийн этгээд хууль зөрчсөнөөр учруулж буй хохирол, олж авч байгаа ашиг хоёр нь харьцуулшгүй зөрөөтэй юм. Хуулийн этгээдэд ихэвчлэн торгууль оногдуулдаг ба тэр нь маш бага хэмжээтэй байдаг. Мөн үүссэн нөхцөл байдлаас ихээхэн ашиг олсон хуулийн этгээд хуулийн хүрээний гадуур үлдсээр байна.

Компаниуд өөрийн үйл ажиллагааг хувь хүнээр гүйцэтгүүлэх ба тэрхүү хувь хүнд ял оногдуулсан хэдий ч хуулийн этгээд үйл ажиллагаагаа явуулж ашиг орлогоо олж, мөн гэмт хэрэг үйлдсээр байдаг. Энэ учраас шийтгэл зөв байж зорилгодоо хүрч чадахгүй байх нь цөөнгүй¹.

¹ Иванов Л. "Хуулийн этгээдэд захиргааны хариуцлага хүлээлэх нь", Закон и право. 1998 он, №9. 91 дэх тал.

Эрүүгийн хариуцлага хүлээлгэх институт нь дээрх субъектуудад нийгмийн шударга байдлыг бий болгох, эрүүгийн хуулийн урьдчилан сэргийлэх үүргийг биелүүлэхэд чиглэгдсэн төрийн үйлчлэлийн бусад аргыг ашигладаг.

Хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлагад татах асуудлын талаар зарим эрдэмтэд дараах байдлаар үздэг байна. Үүнд:

Нэгдүгээрт, эрүүгийн эрх зүйд "хуулийн этгээд" гэсэн ойлголтоос татгалзах хэрэгтэй. Учир нь ихэнх зохион байгуулалттай хамтын субъектууд /байгууллага/, түүний дотор алан хядах үйл ажиллагаа явуулдаг байгууллага хуулийн этгээд биш байдаг;

Хоёрдугаарт, ОХУ-ын Эрүүгийн хуульд "хамтын субъектуудын /байгууллагууд/ холбогдох аюулгүй байдлын болон эрүүгийн эрх зүйн арга хэмжээ" гэсэн бүлэг нэмж оруулах, тухайн бүлэгт энэ арга хэмжээний тухай ойлголт, зорилго, зорилт, хэрэглэх нөхцөлийг тусгаж өгөх нь зүйтэй юм;

Гуравдугаарт, хамтын субъектуудын /байгууллагууд/ хувьд аюулгүй байдлын хариуцлагын арга хэмжээг тогтоох. Үүнд: хөнгөлөлт, лицензийг хураах, батлан даалтад шилжүүлэх, эд хөрөнгийг хураах, тодорхой үйл ажиллагаа эрхлэхийг хориглох, татан буулгах, аюулгүй байдлын арга хэмжээг хэрэглэсэн талаар

шүүхийн шийдвэрийг нийтлэх, эд хөрөнгийг бүрэн хураах зэрэг арга хэмжээ байх¹.

Оросын эрүүгийн хуульд зөвхөн хуулиар (ОХУ-ын Иргэний хуулийн 51 дүгээр зүйл) тогтоосон журмын дагуу бүртгэгдсэн байгууллагад (хуулийн этгээд) эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар заах нь зүйтэй. Гэм буруутай хувь хүн нийгэмд аюултай алан хядах бүлэглэл, дээрмийн бүлэг байгуулах болон түүнийг удирдвал эрүүгийн хариуцлага хүлээлгэх заалт ОХУ-ын Эрүүгийн хуульд байдаг.

Үүнээс гадна эрүүгийн ял шийтгэлийн оронд аюулгүй байдлын арга хэмжээний институтыг оруулах нь оросын хуулийн эрүүгийн хариуцлагын үзэл баримтлалтай зөрчилддөг. Эрүүгийн ялын үндсэн мөн чанар нь гэмт хэрэгт оноох гэсгээл шийтгэл байдаг бол аюулгүй байдлын арга хэмжээ нь хор хохирлын үр дагаврыг арилгахад чиглэгдсэн, гэсгээн цээрлүүлэх агуулгагүй арга хэмжээ юм.

Хуулийн этгээдийн учруулсан хохирлын төлөө хүлээлгэх хариуцлагын болон аюултай үйл ажиллагааны үр дүнд учруулж болох хор хохирлын төлөө хүлээлгэх хариуцлагын асуудлыг шийдвэрлэх дээрх бүх хувилбарт асуудлыг шийтгэл хүлээлгэх талаас бус харин материаллаг талаас шийдвэрлэх явдал давамгайлж байгаа юм.

Орчин үед эрүүгийн ялын төрлүүдээс эд хөрөнгө хураах ял нь эрүүгийн эрх зүйн шинж чанартай бусад арга хэмжээнд "шилжсэнтэй" холбоотойгоор дээрх онолын хүрээнд хуулийн дагуу хуулийн этгээдэд хэрэглэх *И.Щедрин Н.В., Востоков А.А. Байгууллагын харилцаанд эрүүгийн санцрыг хэрэглэх нь, Эрүүгийн эрх зүй, 2007 он. 156-158 дахь тал.*

эрүүгийн эрх зүйн шинж чанартай хамгийн оновчтой арга хэмжээ гэж үзэж болох юм.

ОХУ-ын Эрүүгийн хуульд заасан эрүүгийн эрх зүйн шинж чанартай бүх арга хэмжээг *ёс суртахуун-эрх зүйн арга хэмжээ, өмч-эрх зүйн арга хэмжээ, зохион байгуулалт-эрх зүйн арга хэмжээ* гэж ангилж болно. **Эхний арга хэмжээнд:** шүүхээс гарсан шийдвэрийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр олон нийтэд нээлттэй болгох; **хоёрдугаар хэсэгт:** торгох, эд хөрөнгийг хураах (гэмт замаар олсон эд зүйлс, ашиг орлого, гэмт хэрэг үйлдсэн зэвсэг хэрэгсэл); **гуравдугаар хэсэгт:** тодорхой үйл ажиллагаа эрхлэхийг хориглох, хуулийн этгээдийг татан буулгах зэрэг арга хэмжээг оруулна. Гэмт хэргийн төлөө хуулийн этгээдэд үндсэн болон нэмэлт ял, түүнчлэн эрүүгийн эрх зүйн шинж чанартай бусад арга хэмжээг ч нэгэн зэрэг оногдуулж болдог.

Хуулийн этгээдэд дараахь үндсэн ял оногдуулна:

- торгох;
- тодорхой үйл ажиллагаа эрхлэхийг хориглох;
- хуулийн этгээдийг татан буулгах (бүхэлд нь болон хэсэгчлэн: салбар, төлөөлөгчийн газрыг) зэрэг байх ёстой.

Үндсэн ялаас гадна доорх нэмэгдэл ял давхар ногдуулж болно. Үүнд:

- торгох;
- тодорхой үйл ажиллагаа эрхлэхийг хориглох;
- шүүхийн шийдвэрийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулах ("Оросын сонин"-д нийтлэх, Оросын телевизийн холбооны сувгуудын мэдээгээр дамжуулах, тусгай интернет

сайтад байрлуулах) зэрэг

Торгох болон тодорхой үйл ажиллагаа эрхлэхийг хориглох ял нь үндсэн бөгөөд нэмэлт ялын аль алинд ордог, өөрөөр хэлбэл *нийтлэг* шинжтэй ял юм.

Дээрх заагдсан ялын төрлүүдийг **ерөнхий** (торгох, тодорхой үйл ажиллагаа эрхлэхийг хориглох) ба *тусгай* (шүүхийн шийдвэрийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацах, хуулийн этгээдийг татан буулгах) гэж ангилан хувааж болно. **Тусгай** ял нь зөвхөн хуулийн этгээдэд оногдуулдаг ял байдаг.

Хуулийн этгээдэд үндсэн болон нэмэлт ялын хамт эрүүгийн эрх зүйн шинж чанартай бусад арга хэмжээ болох эд хөрөнгийг хураах ялыг оногдуулж болно.

Хуулийн этгээдэд ял оногдуулахдаа гэмт хэргийн нийгэмд аюултай байдал, шинж чанар, хуулийн этгээдийн эд хөрөнгө ба санхүүгийн байдал, ялыг *хөнгөрүүлэх* ба *хүндрүүлэх* нөхцөл байдал зэргийг тооцож үзэх нь чухал юм.

Хуулийн этгээдийн ялыг хөнгөрүүлэх нөхцөл байдалд:

- а) хөнгөн гэмт хэргийг анх удаа үйлдсэн;
- б) гарцаагүй байдал, үндэслэл бүхий эрсдэлийн нөхцөлийн улмаас эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн гэмт хэрэг үйлдсэн;
- в) гэмт хэрэг үйлдсэний улмаас учирсан эд хөрөнгийн хохирол болон сэтгэл санааны хохирлыг сайн дураараа нөхөн төлөх буюу хохирогчид учруулсан гэмээ цагаатгах бусад үйлдэл хийсэн;
- г) гэмт хэргийн хүнд үр дагаврыг зайлуулсан зэрэг нөхцөл байдлыг оруулна.

Хөнгөрүүлэх нөхцөл байдлын жагсаалт нь нээлттэй байж

болно.

Хуулийн этгээдийн ялыг хүндрүүлж байгаа нөхцөл байдал нь хувь хүнд оногдуулах ялыг хүндрүүлэх нөхцөл байдалтай төстэй байдаг. Үүнд:

а) рецидив гэмт хэрэг;

б) гэмт хэрэг үйлдсэний улмаас хүнд үр дагавар бий болох;

в) онцгой байдал, байгалийн болон бусад нийгмийн гамшгуудын нөхцөлд, мөн түүнчлэн олон нийтийн эмх замбараагүй байдлын үед гэмт хэргийг үйлдэх;

г) сэтгэцийн хүнд өвчтэй болон эрүүгийн хариуцлага хүлээлгэх насанд хүрээгүй этгээдийг гэмт хэрэг үйлдэхдээ татан оролцуулсан зэрэг болно.

Эрүүгийн шүүн таслах ажиллагааны журмаар ял шийтгүүлж байсан (хэрвээ үндсэн ял нь торгууль буюу эсвэл тодорхой үйл ажиллагаа эрхлэхийг хориглох ял байсан бол) хуулийн этгээд дахин гэмт хэрэг үйлдэж болох юм. Энэ тохиолдолд түүнд илүү чанга ял оногдуулах ёстой бөгөөд өөрөөр хэлбэл хуулийн этгээдийн хувьд гэмт хэргийн рецидив гэмт хэргийн ойлголтыг хэрэглэх шаардлагатай гэж үзэж байна².

Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэлийг хэрэглэж болох юм. Үүнд хохирогчтой звлэрэх (ОХУ-ын Эрүүгийн Хуулийн 76 дугаар зүйлд нэмэлт оруулах), үйлдсэн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан (ЭХ-ийн 78 дугаар зүйлд нэмэлт оруулах) зэрэг үндэслэлүүд байж болох юм. Эдгээр тохиолдолд хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх

зайлшгүй нөхцөл нь хувь хүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх зайлшгүй нөхцөлтэй адил байж болно.

Хууль тогтоогчийн зүгээс санал болгож буй хуулийн этгээдийг ялаас чөлөөлөх төрлүүдэд ял эдлэх хугацааг хугацаанаас нь өмнө тэнсэн чөлөөлөх (ОХУ-ын Эрүүгийн Хуулийн 79 дүгээр зүйлд нэмэлт хийх), цаг үеийн нөхцөл байдал өөрчлөгдсөнтэй холбоотойгоор ялаас чөлөөлөх (ОХУ-ын Эрүүгийн хуулийн 80 дугаар зүйлийн 80.1-д нэмэлт оруулах), шүүхээс таслан шийдвэрлэх ажиллагаа явуулах хөөн хэлэлцэх хугацаа дууссантай холбоотойгоор ялаас чөлөөлөх (ОХУ-ын Эрүүгийн хуулийн 83 дугаар зүйлд нэмэлт оруулах) зэрэг орно. Сүүлчийн хоёр төрөл нь нөхцөл болон хугацааны хувьд засвар, өөрчлөлтгүй хуулийн этгээдэд хэрэглэж болох юм. Хугацаанаас өмнө тэнсэн чөлөөлөхдөө хуулийн этгээдэд зөвхөн үндсэн ял нь тав хүртэлх хугацаатай жилээр тодорхой үйл ажиллагаа эрхлэхийг хориглох ял оногдуулсан тохиолдолд хэрэглэгдэнэ. Ингэхдээ шийтгэгдсэн этгээд нь шүүхээр оногдуулсан ялын тэн хагасаас багагүй хугацааг бодитоор эдэлсэн байх ёстой.

Хуулийн этгээдэд эрүүгийн эрх зүйн хариуцлага хүлээлгэх талаархи ОХУ-ын зарим эрдэмтний санал бодлыг хүргэлээ.

“Барууны” улсуудын криминологийн шинжлэх ухаанд дээрх ойлголтыг “корпорацийн гэмт хэрэг” гэсэн хүрээнд авч хэлэлцдэг байна. Үүнийг “цагаан захтаны гэмт хэрэг” буюу албан тушаалтны гэмт

хэргийн нэг төрөл гэж үздэг. Энэ гэмт хэрэгт корпораци болон бусад бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг компани, аж ахуйн нэгж зэргээр үйлдэгдсэн гэмт хэргийг хамруулан ойлгодог байна.

Тэгвэл манай Улсын Эрүүгийн хуульд хуулийн этгээд мөн л эрүүгийн хариуцлага хүлээх субъект болдоггүй ба харин Захиргааны хариуцлагын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 4-т “Иргэний хуульд заасны дагуу хуулийн этгээд болох аж ахуйн нэгж, байгууллага захиргааны хариуцлага хүлээнэ.” гэсэн байдаг. Захиргааны хариуцлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн дагуу зөрчил гаргасан хуулийн этгээдэд торгох, тусгайлан олгосон эрх хасах /тээврийн хэрэгсэл жолоодох/, хууль бусаар олсон орлого, эд зүйл буюу зөрчил гаргахад ашигласан тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, байрыг хураах гэсэн захиргааны шийтгэл ногдуулж болно гэсэн заалт байдаг. Торгох, баривчлах шийтгэлийг үндсэн, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэлийг үндсэн болон нэмэгдэл, хууль бусаар олсон орлого буюу эд зүйлийг хураах шийтгэлийг нэмэгдэл шийтгэлийн хэлбэрээр хэрэглэнэ гэсэн байна.

Цаашдаа манай улсын хууль тогтоомжийн хүрээнд хуулийн этгээдэд эрүүгийн эрх зүйн хариуцлага хүлээлгэх талаар нарийвчлан судлах асуудлууд байсаар байгааг энд дурдах нь зүйтэй байна.

- оОо- -

2. Л.А. Абашина, “Закон и право”, 2008 он, № 9, 86-87 дахь тал



ХЗҮТ-ийн Криминологийн
судалгааны секторын
эрдэм шинжилгээний
ажилтан, хууль зүйн магистр
Г.ОЮУНБОЛД

Онц байдал тогтоосонтой холбогдуулан хүмүүс янз бүрийн байр суурийг дэвшүүлж, өөр өөрсдийн үзэл бодлоор энэ асуудлыг тайлбарлаж байна. Энэхүү өгүүллийг бичихдээ 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш гарсан нийтлэл, мэдээ, баримтыг уншиж, ном сурах бичиг, онолын ойлголтууд, холбогдох хууль тогтоомжид судалгаа, шинжилгээ хийж, хууль зүйн үнднээс тайлбарлахыг зорилоо.

Жагсаал: Монгол Улсын нутаг дэвсгэрт хаана ч жагсаал, цуглаан хийхэд заавал зөвшөөрөл авч байх ёстой гэж хуульчилсан. **“Монгол Улсын иргэдээс улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон асуудлаар үзэл бодол, санал, шаардлагаа нийтэд илэрхийлэх зорилгоор зохион байгуулж байгаа үйл ажиллагааг цуглаан гэдэг.”**¹

Жагсаал, цуглааныг Монгол Улсын иргэн, улсын бүртгэлд 1. Жагсаал цуглааны хийх журмын тухай хуулийн 3 дугаар зүйл

бүртгэгдсэн улс төрийн нам, төрийн бус байгууллага зохион байгуулах эрхтэй байдаг.² Нийслэл Улаанбаатар хотын Сүхбаатарын талбайн Төрийн ордны нутаг дэвсгэрт хамаарах хэсэгт жагсаал, цуглаанхийгийг хориглосон байдаг.³

Гудамж, талбайд жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлийг сум, дүүргийн Засаг даргад өгч бүртгүүлэх бөгөөд мэдэгдэлд түүний зорилго, эхлэх, дуусах хугацаа, оролцогчдын баримжаа тоо, хэрэглэх техник хэрэгсэл, цуглах, жагсан явах гудамж, талбай зэргийг тодорхой заасан байх ёстой гэжээ.

Гадаадын ихэнх оронд жагсаал, цуглаанхийгээд заавал зөвшөөрөл авах албагүй, ямар нэг шаардлага, “болзол” тавьдаггүй байна.⁴ Хуулийн зохицуулалтад шүүмжлэлтэй хандах нэг зүйл бол Засаг дарга зөвшөөрөл өгөх асуудал

2 Жагсаал, цуглааны хийх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйл.

3 Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 7 дугаар зүйл.

4 “Монгол Улсын хувьд Лактаар баталгаажуулсан тодорхой эрхүүдийг эзлэхэд дотоодын хуулиар хязгаарлалт хийхийг зөвшөөрсөн нь хэт олон бөгөөд өргөн хүрээтэй байна. Иймд эдгээр жагсаал, цуглаан хийх зөвлөлдөн нэгдэх эрхийг үр нөлөөтэй эзлэхэд нэгдэл хязгаарлаж байна” гэж Хүний эрхийн хороо үзжээ. Энэ нь тухайлбал” олон нийтийн хурал, цуглаан хийхэд урьдчилан зөвшөөрөл авах шаардлага ба ийм хурал, цуглаан хийхийг хориглоход үндэслэх шалгуурыг заан тэмдэглэсэн нь тус улсад эвсэн нэгдэх, хурал цугларах, зорчих эрх чөлөө гэсэн суурь эрхийг бүрэн хангадагт эргэлзсэн төрж байна гэжээ. /НҮБ-ын баримт бичиг, GAOR A/47/40 (боть I), заалт 194, 151 дэх тал/

юм. Засаг дарга нь намын харъяаллын дагуу томилогддог нь эсэргүүцлийн жагсаал, цуглаан хийх зөвшөөрөл өгөхөд нөлөөлөхийг үгүйсгэх аргагүй.

“Эсэргүүцлийн жагсаал” гэдэг нь санал нэгдэхгүй байгаагаа илэрхийлэн олон нийтээрээ, тайван цуглаж, үзэл бодлоо илэрхийлж байгаа улс төрийн цуглааныг хэлдэг.⁵ Тэгвэл тухайн үед болсон эсэргүүцлийн гэх жагсаал, цуглаан нь зөвшөөрөл аваагүй, урьдчилан мэдэгдээгүй зэрэг эхнээсээ л хууль зөрчсөн үйлдэл болон хувирч, нийгмийн хэв журам алдагдаж, нийтийн эмх замбараагүй байдал үүснэ. Цагдаагийн байгууллага нь гудамж, талбай, үйлчилгээний газар, нийтийн тээврийн буудал, орон сууц зэрэг олон нийтийн газар хууль тогтоомжоор болон төрийн эрх бүхий бусад байгууллагаас тогтоосон нийтээр дагаж мөрдөх журмыг сахиулж, хүн амын амгалан тайван байдлыг хамгаалах үүргийнхээ дагуу⁶ жагсаал, цуглааны явцад бий болсон нийгмийн хэв журам зөрчсөн үйл ажиллагааг таслан зогсоох, объектыг хамгаалах үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна.

“Нийгмийн хэв журам”

гэдэг ойлголтод нийгмийн амгалан тайван байдал, хүний халдашгүй чөлөөтэй байх эрх, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, аж ахуйн нэгж, байгууллагын

5 “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь”. Э.Пүрэвжав нар. 2008 он, 865 дэх тал

6 Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 11 дүгээр зүйл “Нийгмийн хэв журам хамгаалах”

хэвийн үйл ажиллагааг хангаж буй нийгэмд тогтсон хүмүүсийн хоорондын харилцааны болон аж төрөх ёсны хэм хэмжээг ойлгодог. Энэхүү хэм хэмжээг хууль тогтоомж, зан заншил, ёс суртахууны шаардлагын алинаар тогтоосон ч болдог.⁷

“Нийгмийн хэв журмыг бүдүүлгээр зөрчсөн, /нийгэмд тогтож хэвшсэн ёс журмыг зөрчиж, олон нийтийг хамарсан арга хэмжээг тасалдуулах, хамтын аж байдлын ёс горимд харшилсан санаатай үйлдэл/ захиргааны “танхайрах” зөрчлийн шинжтэй үйлдэл нь даамжирч, нийгмийн хор аюул нь нэмэгдэж олон нийтийг /Олон нийт” гэдэг нь нийтийн нэг хэсгийг тодорхойлсон ойлголт⁸/ хамарсан эмх замбараагүй байдал болон хувирч, гэмт хэрэг үйлдэгдэж эхэлсэн байна. Нийтийг хамарсан арга хэмжээний үед оролцогчдоос хууль зөрчих, зохион байгууллагчийн хяналтаас гарах зэргээр үйл ажиллагаа хурцадмал хэлбэрээр өрнөвөл олон нийтийг хамарсан үеийн эмх замбараагүй байдал үүсдэг.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, тусгай хэрэгсэл

Цагдаагийн байгууллага, алба хаагч гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэхдээ дараахь тусгай хэрэгсэл, мэх ашигладаг.⁹ Үүнд: **1/олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл; 2/нэг бүрийн**

тусгай хэрэгсэл; 3/ тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл; 4/ хамгаалах тусгай хэрэгсэл; 5/самбо, каратэ зэрэг зэвсэггүйгээр тулалдах мэх; 6/ албаны нохой.

Цагдаагийн тусгай хэрэгслийг олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл, нэг бүрийн тусгай хэрэгсэл гэж ангилдаг. **“Нийтийн эмх замбараагүй байдлыг болон нийгмийн хэв журмыг блэлэглэн зөрчиж байгааг таслан зогсоох, байгууллага, иргэдийн мэдэлд байгаа барилга байгууламж, орон байрыг эзлэн авсан, гудамж замын хөдөлгөөнийг бүслэн хаасныг чөлөөлөх зэрэг хэд хэдэн зорилгоор олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг хэрэглэдэг”¹⁰** Долдугаар сарын 1-нд чухамхүү тийм тусгай хэрэгслийг хэрэглэх нөхцөл, шаардлага үүссэн. Гэтэл олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл цагдаагийн байгууллагад байгаагүй байна.

Резинэн сумтай буу бол олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл биш, нэг бүрийн тусгай хэрэгсэл. Олон хүнд хэрэглэх тусгай хэрэгсэл байгаагүй нь үйл явдлыг даамжруулах, ялангуяа цагдаагийн алба хаагч нар олноороо бэртэж гэмтэх гол нөхцөл болсон. Нэг хүнд нөлөөлөх хэрэгслийг нэг бүрийн тусгай хэрэгсэл гэх бөгөөд дараахь хэрэгсэл хамаарна. Үүнд: **гар, хөл, хурууны гав; хүлэг, ороох цамц, резинэн бороохой; цахилгаан бороохой, нулмис асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүр; резинэн ба хуванцар сумтай буу** 10.Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 42 дугаар зүйл.

ордог. Цагдаагийн алба хаагч цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг зориуд биелүүлээгүй, эсхүл эсэргүүцсэн тохиолдолд нэг бүрийн тусгай хэрэгслийг хэрэглэж болдог.

Галт зэвсэг хэрэглэлт: “Байлдааны зориулалттай галт зэвсэг” гэж зэвсэгт хүчин, бусад цэрэг, цагдаа, тагнуул, хорих байгууллага хуулиар олгогдсон чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор ашиглаж байгаа галт зэвсгийг хэлдэг”¹¹.

Гэмт үйлдлийг таслан зогсоох зорилгоор цагдаагийн алба хаагч галт зэвсэг хэрэглэх асуудлыг хоёр хэсэгт хуваан үзэж болно. Мөн цагдаа, цэргийн биш хүмүүс ч тодорхой тохиолдолд галт зэвсэг хэрэглэж болно. Цагдаагийн алба хаагч үүргээ гүйцэтгэж байхдаа **галт зэвсэг хэрэглэж болох долоон нөхцөлийг тодорхой зааж**¹² **зохицуулсан.** нэгдүгээрт, “цагдаагийн алба хаагч болон бусад хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй байдлаар довтолсон” этгээдэд галт зэвсэг хэрэглэхийг зөвшөөрсөн байдаг. Хуулийн энэ заалтыг 7 дугаар сарын 1-ний үйл явдалтай холбож хэлбэл, чулуу барин довтолж байгаа хүмүүсийн эсрэг **“нийтийн дунд”** буудаж болохгүй. Харин хайсны шовх үзүүртэй төмрийг салган авч цагдаагийн гуяыг жадалсан, бүлэглэн цагдааг зодож бэртээсэн, чулуугаар хүний тархийг хагалсан зэрэг гэмт үйлдэл хийж

7. УДШ-ийн 2007.10.29-ний өдрийн №41 дүгээр тогтоол -“Танхайрах гэмт хэргийг ойролцоо төрлийн гэмт хэрэг болон захиргааны зөрчлөөс ялгаж, зөв зүйлчлэхэд анхаарах зорим асуудлын талаар”

8. УДШ-ийн 2007.10.29-ний өдрийн №40 дүгээр тогтоол.

9. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 41 дүгээр зүйл.

11. Галт зэвсгийн тухай хуулийн 3 дугаар зүйл.

12. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 40 дүгээр зүйл.

байгаа тодорхой хүнд галт зэвсэг хэрэглэж болно. Энэ тохиолдолд цагдаагийн алба хаагч хэнээс ч зөвшөөрөл, тушаал авахгүй өөрөө шийдэж галт зэвсэг хэрэглэн, гарах үр дүнг өөрөө хариуцахаар заасан байдаг. Өөрөөр хэлбэл тухайн довтолгоо өнгөрсөн хойно нь биш үйлдэгдэж байх үед нь, түүнийг өөр аргаар зогсоох боломжгүй тохиолдолд хэрэглэхийг хэлж байгаа юм.

Дээр хэлсэн хоёр нөхцөлөөс гадна **гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, саатуулах тухай Эрвнгийн хуулийн 41 дүгээр зүйл, гарцаагүй байдлын тухай Эрүүгийн хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан цагдаагийн алба хаагч галт зэвсэг хэрэглэх тохиолдол гарч болно.** Эрүүгийн хуульд заасан аргагүй хамгаалалт гэдэг ойлголтын хүрээнд галт зэвсэг хэрэглэх эрх¹ иргэн хүмүүст ч бий. Төр, нийгмийн ашиг сонирхол, өөрийн болон бусдын амьд явах, халдашгүй чөлөөтэй байх зэрэг хууль ёсны эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгоор халдагч этгээдэд гэм хор учруулбал түүнийг гэмт хэрэг гэж тооцохгүй² гэж заасан байдаг. Энэ бол манай улсын нутаг дэвсгэрт оршин сууж байгаа хүн бүрт албан тушаалын байдал, хуулиар хүлээлгэсэн үүрэг, нас, хүйс харгалзахгүйгээр олгосон эрх байдаг.

Долдугаар сарын 1-нд нийслэлийн төв хэсэгт болсон үймээний үед бусдын, түүний дотор цагдаагийн алба хаагч хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулахаар

хүйтэн зэвсэг барин бүлэглэн довтолсон, бусдын эд хөрөнгийг галдан шатаах, эвдэж устгах, дээрэмдэх зорилгоор дайрсан этгээдийг буудаж аргагүй хамгаалалт хийх эрх Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин байгаа хүн бүрт, цагдаагийн байгууллагын ажилтнууд, төрийн болон хувийн өмч хөрөнгө хамгаалж байгаа харуул, хамгаалалтын ажилтнуудад ч байсан. Тэгэхдээ довтолсон, дайрсан олны эсрэг **“дунд”** нь галт зэвсэг хэрэглэж болохгүй, гэмт үйлдэл хийж байгаа тодорхой хүний эсрэг галт зэвсэг хэрэглэж болно гэснийг онцгой анхаарвал зохино. 2002 оны Эрүүгийн хууль батлагдан гарахаас өмнө аргагүй хамгаалалтын үйлдэл нь учруулах гэм хорын хэмжээгээрээ халдагч этгээдийн учруулж болох байсан хохирлоос их байж болохгүй гэсэн хязгаарлалт байсан ч одоо мөрдөж байгаа Эрүүгийн хуулиар тэр хязгаарлалт байхгүй болсон.³

Цагдаагийн алба хаагч нь бүх төрлийн тусгай хэрэгсэл, мэх хэрэглэсний дараа хүний эрүүл мэндийн байдалд өөрчлөлт гарах болон гэмтэл учирвал эмнэлгийн тусламж үзүүлж, эмчийн магадлагаа гаргуулна. Мөн тусгай хэрэгсэл, мэх хэрэглэсэн үндэслэл, хэрэглэсэн тусгай хэрэгсэл ба мэх, хүний эрүүл мэндийн байдалд гарсан өөрчлөлт, эмнэлгийн тусламж үзүүлсэн тухай даргадаа нэн даруй илтгэнэ. Чухамхүү ийм эмнэлэгийн анхан шатны тусламж үзүүлэх арга хэмжээг тухайн үед цагдаагийн албан

хаагчид хэрэгжүүлээгүй.

Төрийн бус байгууллагаас явуулсан судалгаанд оролцсон сэмжитэн 71 хүний 49 нь өөрийн хэрхэн баривчлагдсан тухай мэдээлэл өгсөн бөгөөд тэдний 21 нь буюу 42,9 хувь нь Сүхбаатарын талбай, түүний ойр орчмоос баривчлагдсан ажээ. Баривчлагдах үедээ тэдний дийлэнх олонх нь онц байдал зарлагдсан тухай сонсоогүй болон урьдчилсан анхааруулга сонсоогүй байна. Баривчлах үедээ цагдаагийнхан хүч болон тусгай хэрэгсэл хэрэглэсэн гэж судалгаанд оролцогчдын 97,7 хувь нь хариулсан бөгөөд тэдний 78,6 хувь нь бороохой, 21,4 хувь нь буу тулгасан гэсэн байна.⁴ Бүх төрлийн тусгай хэрэгсэл, мэхийг үндэслэлгүй, буруу хэрэглэсэн буруутай албан хаагчид сахилгын арга хэмжээ авах буюу эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр эрх бүхий байгууллагад шилжүүлдэг байна.⁵ Энэ үндсэн дээр Улсын ерөнхий прокурорын дэргэдэх ердөн байцаах алба галт зэвсэг хэрэглэж хүний амь нас хохироосон үйлдэлд цагдаагийн албан хаагчидад Эрүүгийн хуулийн 91 зүйлийн 91.1-д зааснаар эрүүгийн хэрэг үүссэн мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж байна.

Цагдаагийн удирдлага тушаал өгөх: Цагдаа галт зэвсэг хэрэглэх асуудлыг хоёр хэсэгт хувааж болно гэсний нэг нь буюу бүлэглэн довтолж байгаа хүмүүсийн гэмт үйлдлийг таслан зогсоох зорилгоор “нийтийн эсрэг”

4. Онц байдалтай холбоотой хүний эрхийн талаар Төрийн бус байгууллагуудын зөслийн явуулсан мониторинг судалгааны дүнгээс.

5. Цагдаагийн ерөнхий газрын даргын 1994 оны 75 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

1. Энэ эрх төрийн албан хаагчдад ч хамаатай.

2. Эрвнгийн хуулийн 40 дүгээр зүйлэнх 40.1.дэх хэсэг

3. ЦЕГ-ын дарга асан, генерал Б.Пүрэв: “Амтай болгон цагдаа руу дайрч, гартай болгон чулуу шиддэг болжээ” Өдрийн сонин

буудаж, галт зэвсэг хэрэглэх явдал юм. Энэ тохиолдолд Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 40 дүгээр зүйлийг удирдлага болгоно. Тэгэхдээ ийм байдлаар галт зэвсэг хэрэглэх зөвшөөрөл, тушаалыг цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан өгдөг. Эрх бүхий албан тушаалтан гэдэгт цагдаагийн төв болон нутаг дэвсгэрийн байгууллагын удирдлага, тухайн ажиллагааг удирдаж байгаа албан тушаалтан хамаарна.

Олон нийтийг хамарсан үймээн, эмх замбараагүй байдлыг таслан зогсоох үеийн үйл ажиллагаа:

Еөнхийдөө жагсаал цуглаанд оролцогчдыг хоёр ангилж үздэг:

- зохион байгуулагч ;
- оролцогч

Цагдаагийн алба хаагч нь олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн үед гэмт хэрэг, хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн аюулгүй байдлыг хангахад чухал үүрэгтэй. Үүнд: Жагсаал цуглааны үед ажиллах сэтгэл зүйн бэлтгэлтэй байж, гүйцэтгэх үүргээ бүрэн мэдсэн байх, өөрийн аюулгүй байдлыг хангах, зэвсэг, нэг бүрийн тусгай хэрэгслийг бэлтгэсэн байх, бусдалба, ажилтнуудтай харилцан ажиллах журмаа бүрэн ойлгосон байх хэрэгтэй.

Олон нийтийн үймээн, эмх замбараагүй байдал эхлэх үед түүнийг таслан зогсоох тактикийг зөв сонгож авсан байх нь чухал: Үүнд: Олон нийтийг хамарсан үймээн, эмх замбараагүй байдлыг зогсоохдоо аль болон хүч хэрэглэх бус, ухуулга,

сурталчилгаахийж, тайлбарлан таниулах аргаар зохицуулахыг хичээх, цагдаагийн алба хаагч өдөөн хатгалгыг цаг тухайд нь мэдэрч байх нь эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх буюу эхэлсэн үймээнийг газар авахуулахгүй таслан зогсоох, бусдыг буруу үйлдэлд уруу татаж болзошгүй хүмүүс, өдөөн хатгагчдыг илрүүлж тусгаарлах, хурсан олныг тараах, хууль журам зөрчсөн хүмүүсийг олж илрүүлэх зорилгоор цагдаагийн бусад алба хаагчтай хамтарч ажиллах, зохион байгуулагч этгээдтэй ярилцах, хэв журам зөрчихгүй байх талаар иргэдэд зөвлөх, хүсэлт тавих ажиллагааг хийж гүйцэтгэх ёстой.

Үйл явдлыг дүрс бичлэг, фото зургаар баримтжуулах, хурсан олны дотор энгийн хувцастай үүрэг гүйцэтгэх, үймээн эрчимжиж газар авсан тохиолдолд нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч, усан хөөрөг, утаат хөшиг үүсгэгч зэрэг олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг заавар журмын дагуу даргын шийдвэрээр хэрэглэх эрхтэй байдаг.

Нийтийг хамарсан үймээн, эмх замбараагүй байдалд нэрвэгдсэн, хүч хэрэглэсний улмаас хохирсон иргэдэд туслалцаа үзүүлэх, өмч хөрөнгийг хамгаалалтад авах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр цагдаагийн байгууллагын заавар, журамд тодорхой зааж өгсөн.⁶ Гэвч тухайн үед дээрх заавраар цагдаагийн байгууллага татикаа боловсруулаагүй, бэлэн биш байсан нь ажиглагдаж байсан.

⁶. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2006 оны 150 дугаар тушаалын хавсралт

Онц байдал: Монгол Улсын Ерөнхийлөгч 194 дүгээр зарлиг гаргаж, нийслэл хотод 7 дугаар сарын 1-нд 24 цагаас онц байдал зарласан. Хууль бус үйл ажиллагааны улмаас үүссэн нийтийн эмх замбараагүй байдлыг төрийн байгууллага эрх хэмжээнийхээ дотор ердийн арга хэрэгслээр тохиуулах боломжгүй болсон бол онц байдал зарлахаар Үндсэн хуульд заасан байдаг. Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараахь онцгой нөхцөл бий болсон үед үр дагаврыг нь арилгах, хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн болгохын тулд онц байдал зарлаж болно. Үүний гол үндэслэл нь: **“Үндсэн хуулийн дэг журам, нийгмийн хууль ёсны тогтолцоо оршин тогтноход заналхийлсэн аливаа байгууллага, бүлэг хүний зохион байгуулалт бүхий хүч хэрэглэсэн хууль бус үйл ажиллагааны улмаас үүссэн нийтийн эмх замбараагүй байдлыг төрийн байгууллага эрх хэмжээнийхээ дотор ердийн арга хэрэгслээр тохиуулах боломжгүй болсон... бол онц байдал зарлана” гэсэн заалт байсан.**

Онц байдлын тухай хуулиар үүний хэрэгжих арга замыг нарийвчлан тодорхойлж УИХ-ын чуулганы чөлөөт цагт Монгол Улсын Ерөнхийлөгч зарлиг гаргаж онц байдал тогтоох асуудлыг шийдвэрлэхээр заасан байдаг.⁷ Тухайн үед эмх замбараагүй байдал хяналтаас гарч ердийн арга хэрэгслээр

⁷. УИХ-ын Үндсэн хуулийн 33 дугаар зүйл 12 дахь хэсэг

зохицуулах боломжгүй болж, хяналтаас гарсан нь цаг алдалгүй онц байдал зарлан тогтоох үндэслэл болсон байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хязгаарлалт: Үндэсний олон нийтийн телевизээс бусад телевизийн дотор ажиллагааг онц байдал тогтоосон дөрөв хоногийн хугацаагаар түр зогсоох арга хэмжээ авсан ч бусад FM, болон сонин хэвлэлүүдийг энэ хязгаарлалтад хамруулаагүй. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн нэн ялангуяа телевизүүдийн үйл ажиллагааг хязгаарласан нь хууль зөрчсөн гэж зарим хуульч үздэг.

Энэ телевиз бол олон нийтийн статустай, тэнцвэртэй, бодитой мэдээлэл хүргэх үүргийг хуулиар хүлээсэн мэдээллийн хэрэгсэл гэдэг үүднээс хандсан гэж ойлгогдож байгаа. Хэдийгээр Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд хэвлэл мэдээллийн хэрэгслийн эрх чөлөөг хязгаарласан хууль баталж гаргахыг хориглодог боловч Онц байдлын тухай хуульд **"Олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд хяналт тогтоох, эсхүл онц байдлыг цуцлах хүртэл үйл ажиллагааг нь зогсоож болно"** гэж заасан.

Үндсэн хуульд ч онц байдал зарласан тохиолдолд хүний эрх, эрх чөлөөг хуулиар хязгаарлаж болохыг заасан байдаг. Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заахдаа **"Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль**

нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө" гэжээ. Ингэхдээ тэр хязгаарлалтад хамааруулж болохгүй эрхүүдийг тоочин заасны дотор хэвлэл мэдээллийн хэрэгслийн эрх чөлөөний талаар дурдаагүй. Энэ нь хэвлэл, мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг онц байдлын үед түр хязгаарлалт хийхийг зөвшөөрөх үүднээс хийсэн зохицуулалт гэж үзэж болно.

Засгийн газар нь өөрөө хэвлэл мэдээллийн хэрэгслийн хамгийн том эзэмшигч байдаг нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн жинхэнэ хараат бус байх зарчмыг алдагдуулдаг. Жишээлбэл; Төрийн нууцын тухай хууль гаргаж төр засгийн тухай иргэд мэдээлэл авах, эвлэн нийтлэх эрхийг нь ихээхэн хэмжээгээр хязгаарлах явдлыг дэмждэг бөгөөд тэд хэвлэлийнхэн хариуцлагагүй үйлдэл хийж магадгүй гэдгээр үүнийгээ хаацайлдаг юм. Мексик, Энэтхэг зэрэг улсад сэтгүүлчид хариуцан сурвалжилдаг байгууллагаасаа урамшуулал авч бага цалиндаа нэмэрлэдэг байдал нь сэтгүүлчдийн зүгээс төрийн дээгүүр өндөрлөгт гарч буй зүй бус үйлдлийг сурвалжлах хүсэлгүй болгох том хүчин зүйл болдог байна.¹

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа

Үймээн самууны үеэр үйлдэгдсэн гэмт хэргийг шалгах ажлын хэсгийг Улсын *1.Д.Золжаргал "Бие даасан чөлөөт хэвлэл мэдээлэл" эрдэм шинжилгээний өгүүлэл*

мөрдөн байцаах газарт байгуулсан. Нийт 30 гаруй мөрдөн байцаагч, 250 гаруй хүнд холбогдох эрүүгийн хэргийг шалгаад ихэнхийг нь прокурорт шилжүүлсэн байна. Прокурорын байгууллага харьяаллын дагуу хавтаст хэргүүдийг Хан-Уул, Чингэлтэй, Баянзүрх, Сүхбаатар дүүргийн шүүхэд шилжүүлэн шийдвэрлэж эхлээд байна. Үймээнд оролцсон 200 гаруй хүний хэрэг анхан шатны шүүхээр оржээ.²

Судалгаагаар тухайн үед баривчлагдсан хүмүүсийн 88 хувьд нь цагдаагийн ажилтан холбогдох эрх, үүргийн талаар тайлбар мэдээлэл өгөөгүй гэсэн нь эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тодорхой заалтууд зөрчигдсөнийг харуулж байна.

Зарим тохиолдолд эрүүгийн хэрэгт мөрдөн байцаалт явуулж байсан мөрдөн байцаагч нь 7 дугаар сарын 1-нд өөрөө бэртэж, гэмтэж байсан хохирогч, эрүүгийн хэрэгт гэрчээр байцаагдсан этгээд нь үймээнд оролцсон хэргээр ял шийтгүүлсэн шүүгдэгч байсан гэх мэт ноцтой зөрчлүүд илэрсэн байна.

Долдугаар сарын 1-ний шөнө онц байдал зарлахаас өмнө болон зарласан үед нийгмийн хэв журам зохицуулж ажилласан цагдаагийн алба хаагчаас 471 хүн гэмтэл авсан, үүний 100 гаруй нь хүндэвтэр гэмтэл авсан гэсэн шүүх эмнэлгийн дүгнэлт гарсан байна. Түүнчлэн Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйл **"Бусдын зүйлийг хулгайлах", 146 дугаар зүйл "Бусдын эд зүйлийг булаах", 147 дугаар зүйл "Бусдын эд зүйлийг дээрэмдэх, 153**

² ЦЕГ-аас сэтгүүлчдэд өгсөн мэдээллээс /2008 оны 11 дүгээр сард/

дугаар зүйл **“Бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгах гэмтээх, 155 дугаар зүйл “Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг авах, барлуулах, 181 дүгээр зүйл “Танхайрах”, 177 дугаар зүйл “Зандалчлах”, 179 дүгээр зүйл “Нийтийн эмх замбараагүй байдал бий болгох”, 230 дугаар зүйл “Төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг эсэргүүцэх”** гэмт хэрэг үйлдсэн хэмээн ял сонсгосон байна.

Нийслэлийн Цагдаагийн газрын харъяа Албадан саатуулах байр болон ШШГЕГ-ын 0461 дүгээр ангид цагдан хорих ажиллагаа явагдаж эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа нэгэнт эхэлсэн учраас өмгөөлөгч зайлшгүй оролцох ёстой. Тэнд хоригдож байгаа хүмүүсийн өмгөөлүүлэх эрхийн асуудал зөрчигдөж байна гэж тухайн үед Хүний эрхийн Үндэсний комисс үзэж байсан. Төрийн бус байгууллагаас хийсэн судалгаанд оролцогчдоос дөнгөж 4 нь л өмгөөлөгч авсан ч тэдний 3 нь өмгөөлөгчийнхөө талаар хангалттай мэдээлэлгүй байсан байна.

2008 оны 7 дугаар сарын 1-нээс 2-нд шилжих шөнийн баривчилгаа явагдаад 2 хоногийн хугацаа өнгөрөөд байхад цагдаагийн байгууллагаас 72 хүний тодорхой мэдээлэл авч чадаагүй байв.³ Энэхүү байдал нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн “...сэжигтнийг баривчилсан болон хаана байгааг 24 цагийн дотор түүний гэр бүлийн насанд хүрсэн гишүүн,

төрөл, садангийн хүн, эсхүл өмгөөлөгчид нь мэдэгдэх, эсхүл өөрөө мэдэгдэх” боломжийг баривчлагдсан этгээдэд олгох” тухай 61.1 дэх хэсгийг ноцтой зөрчсөн хэлбэр юм.

Зүйлчлэлийн талаар:

Зандалчлах гэдэг нь зандалга гэдэг үгээс гаралтай, угтаа хараал, зүхэл гэсэн утгатай бөгөөд дээрэм, тонуул зэрэг харгис муу үйлдэл хийхийг хэлнэ гэсэн байна.⁵

2002 оны эрүүгийн хуульд **зандалчлах**⁶ гэж **терроризмыг** нэрлэж байсан бөгөөд ⁷ Эрүүгийн хуулийн 177.2 гэсэн зүйл анги нь 20-

1. Хүний эрхийн хороон тайлбарласнаар эрүүгийн ялыг нэн даруй мэдэгдэх шаардлагын хамгийн чухал үндэслэл нь хоригдсон хүн өөрийг нь хууль ёсоор хорьсон эсэхийг эрх бүхий шүүх эрх мэдлийн байгууллагаар нэн даруй шийдвэрлүүлэхийг шаардах явдал юм. “Шүүн таслах ажиллагаанд хүний эрхийг хангах нь” гарын аялага. УБ., 2003 он., 177 дахь тал.

5. “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь” Э.Пүрэжав нар, 2008 он, 981 дэх тал

6. Эрүүгийн хуулийн 177 дугаар зүйлд “Зандалчлах” гэмт хэргийн бүрэлдэхүүнийг заахдаа “Эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас тодорхой шийдвэр гаргуулах буюу гаргах аас татгалзуулахад шууд буюу шууд бус нөлөөлөх зорилгоор, олон нийтэд айдас төрүүлэхэд чиглэсэн нийтэд аюултай хүч хэрэглэсэн буюу хэрэглэхээр заналхийлсэн бол аравас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

26. Эрүүгийн хуулийн 177 зүйлийн 177.2-т Энэ хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулалтай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол хориос дээш хорин таван жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл цазаар авах ял шийтгэнэ гэжээ.

2008 онд Эрүүгийн хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр ЭХ-ийн 178 дугаар зүйлийн 178.1-т “Терроризм” Хууль бус эвсээст бүлэглэл, террорист этгээд өөрийн улс төр, шашин, үзэл суртлын зорилгыг хэрэгжүүлэхийн тулд нийгмийг, эсхүл түүний тодорхой хэсгийг айдас атуулахаар иргэдийн амь нас, эрүүл мэндийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн, хүчирхийлэхээр заналхийлсэн, энэхүү үйлдлээрээ гоц халдварт өвчин, гал түймэр болон гамшгийн нөхцөлийг бүрдүүлсэн бол...”

25 жил гянданд хорих, эсвэл цаазаар авах ялтай, Монгол Улсын Эрүүгийн хуулиар онц хүнд гэмт хэрэгт тооцогддог. **“Зандалчлах”** хэмээх ойлголт нь гадаадын зарим оронд террорист болон алан хядах үйл ажиллагаа зохион байгуулсан гэмт хэрэгт хэрэглэгддэг. Тэгвэл **вандализм** бол санаатай болон утга учиргүй соёлын болон материаллаг үнэт зүйлийг устгахыг хэлдэг ба тухайн үйлдлийг хийж буй этгээдийг **вандалууд** гэж нэрлэдэг.⁸ ОХУ-ын Эрүүгийн хуульд зандалчлах гэмт хэргийг хуульчлахдаа:

“барилга, байгууламжийг бузарлах, нийтийн тээврийн хэрэгсэл болон олон нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг эвдэн гэмтээх” гэсэн байна. Зандалчлах гэмт хэргийн үндсэн шинж бол иррациональ үйлдэл, уг үйлдлийн улмаас учирсан хохирол байдаг юм. Эрүүгийн хуулийн Зандалчлах зүйлд санхүүн хувьд торгох ял, баривлах, заасан хүмүүжүүлэх ялаар шийтгэхээр заасан байна.⁹

Судлаачийн зүгээс “зандалчлах” нь иргэдийн амь насанд халдах, айлган сүрдүүлэх замаар эд хөрөнгө, өмчлөх эрхийг авахаар,

8. [www.wikipedia.org/...](http://www.wikipedia.org/)

9. Вандализм - умышленное и бессмысленное уничтожение культурных и материальных ценностей. Лиц, совершающих подобные действия, называют вандалами. Уголовный кодекс Российской Федерации даёт следующее определение вандализма: «оскорбление здания или иных сооружений, порча имущества на общественном транспорте или в иных общественных местах». Признаками вандализма являются ирациональность действий, а также серьёзный ущерб от этих действий. На бытовом уровне понятие вандализма стало распространяться на повседневные проявления хулиганства, связанные с порчей чужой собственности. Вандализм следует отличать от хулиганства.

3. http://www.ontsbaidal_hunierh.blog.mn

тодорхой үйлдэл, эс үйлдэхүй хийлгэхээр заналхийлсэн гэмт үйлдэлийг тооцвол зохино гэж үзэж байна. Одоогийн дагаж мөрдөж байгаа Эрүүгийн хуульд тодорхой эрх бүхий байгууллага албан тушаалтанаас тодорхой шийдвэр гаргуулах, гаргуулахаас татгалзуулахад чиглэсэн заналхийлсэн үйлдлийг задалчлах гэмт хэрэгт тооцохоор заасан байгаа юм.

Практикт иргэдийг "заналхийлсэн" тодорхой хэргийг шийдвэрлэхэд ихээхэн хүндрэл учирч байна. Тодорхой жишээ аваад үзье: Сүүлийн үед бусдын амь насанд заналхийлэх, айлган сүрдүүлэх байдал нэлээдгүй гарах болсон. Үүнтэй холбоотойгоор Эрүүгийн хуулийн 149 дүгээр зүйлд **"Бусдын эд хөрөнгийг авахаар далайлган сүрдүүлэх"** гэмт хэргийн бүрэлдэхүүнийг зааж өгсөн ч хуулийн энэ заалт иргэдийг ямар нэг заналхийлэл, айлган сүрдүүлээс хамгаалж чадахгүй байна.¹ Өөрөөр хэлбэл иргэнийг тодорхой үйлдэл хийлгэхээр, түүнээс татгалзуулахаар дарамталсан, заналхийлсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндэс байхгүй байна.

Судлаачийн зүгээс үзэхэд тухайн үед Эрүүгийн хуулийн 179 дүгээр зүйлээр²

1. "Өмчлөгч, эд хөрөнгийг итгэмжлэгдэн хариуцаж буюу хамгаалж байгаа этгээдэд болон тэдний ойр дотны хүмүүст хүч хэрэглэх, нэр хүндийг нь гутаасан мэдээ баримт тараах буюу эд хөрөнгийг нь устгахаар заналхийлж эд хөрөнгө, эсхүл түүнийг өмчлөх эрхийг шилжүүлэн өөхийг шаардсан үйлдэл нь энэ гэмт хэргийн объектив тал.

2. Эрүүгийн хуулийн 179 дүгээр зүйлд "Нийтийн эмх замбараагүй байдал бий болох" гэмт хэргийн бүрэлдэхүүнийг заахдаа "Туйвзан үймүүлэх, эвдэн буснуулах, аялдан шатаах, эд хөрөнгө устгах, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис

ял сонссон эрүүгийн хэрэгт галдан шатаах, эд хөрөнгө устгах үйлдэлд нэмж Эрүүгийн хуулийн 153 дугаар зүйлээр давхар зүйлчилж байгаа нь буруу гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл Эрүүгийн хуулийн 179 дүгээр зүйлд заасан гэмт хэргийг үйлдэх аргыг түйвээн үймүүлэх, эвдэн буснуулах, галдан шатаах, эд хөрөнгө устгах, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис хэрэглэх буюу төрийн төлөөлөгчийг зэвсэглэн, эсэргүүцэх гэж тодорхой заасан байна.

Шүүхээр шийдвэрлэгдэж байгаа эрүүгийн хэргийн хувьд Эрүүгийн хуулийн 179 дүгээр зүйлд заасан хэрэгт хамтран оролцогчоор тооцож ял ногдуулж байгаа. Хамтран оролцогч гэдэгт юуг ойлгох вэ?³

Эрүүгийн хуулийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэгт заасан **"...бүлэглэн гүйцэтгэгч" гэдэгт гэмт хэрэг хамтран үйлдэх талаар хэрэг үйлдэхээсээ өмнө урьдчилан тохиролцоогүй боловч, хэрэг үйлдэх явцад санаатай хамтран оролцсон этгээдийг ойлгоно.**⁴ гэж тайлбарлажээ. хэрэглэх буюу төрийн төлөөлөгчийг зэвсэглэн эсэргүүцэх замаар нийтийн эмх замбараагүй байдлыг зохион байгуулсан, өдөөн турхирсан..." гэжээ. 3. "Эрүүгийн хуулийн 34, 35, 36, 37 дугаар зүйлүүдэд заасан зарим ойлголтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх зорилгоор Монгол Улсын дээд шүүхээс гаргасан тайлбарт..."

4. Улсын дээд шүүхийн тогтоол №10 "Эрүүгийн хуулийн 34, 35, 36, 37 дугаар зүйлийг тайлбарлах тухай-д "Эрүүгийн хуулийн 34 дүгээр зүйлд заасан "Гэмт хэрэгт хамтран оролцох" гэдэгт гэмт хэрэг үйлдэхээр санаатайгаар хамтарсан, Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн субъект болох насанд хүрсэн, гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадвартай, хоёр буюу түүнээс дээш этгээдийн нэгдсэн нэгдсэн ойлгоно. Гэмт хэрэгт хамтран оролцох нь санаатай үйлдэл, эс үйлдэхгүйгээр илрэх бөгөөд нэг хэрэгт зарим хамтран оролцогчид нь санаатайгаар үйлдэл

Жишээлбэл: тухайн жагсаалд оролцож байсан А танхайран, цагдаагийн албан хаагчийг эсэргүүцэх явцад А-тай хамт явсан Г урьд нь үгсэн тохиролцоогүй боловч төрийн албан хаагчийг эсэргүүцэх, биед нь гэмтэл учруулах үйлдэлд оролцож А-гийн хамт гэмт хэрэг үйлдсэн бол уг хоёр этгээд бүлэглэн гүйцэтгэгч болно. Өөрөөр хэлбэл жагсаал цуглаанд оролцож нийтийн эмх замбараагүй байдалд хүргэсэн хүмүүс тухайн хэрэгт болох явцад үйлдлээрээ хамтран оролцогч болж байна.

Тэр үеийн байдалд улстөрийн дүгнэлт гаргах комисс байгуулах санал зарим хүнээс гарч байсан. Шүүх, прокурор, цагдаагийн ажлыг улстөрийн дүгнэлтээр хөдөлгөх болбол хууль зүйн үндсэн агуулга, ёс зүй алдагдаг. Тэгэхлээр энд ямар нэгэн улстөрийн гэмт хэргийн тухай, улстөрийн хоригдлын тухай асуудал байх ёсгүй юм.⁵

Өөрөөр хэлбэл улс төрийн хэрэгт яллагдан хоригдож байгаа этгээдийг улс төрийн хоригдол гэх бөгөөд энэ нь үзэл бодол, тодорхой үйлдлээрээ "улс төрийн гэмт хэрэг" үйлдсэн байдаг.

- оОо- -

хийж гэмт хэрэг үйлдэхээс гадна бусад хамтран оролцогч нь санаатайгаар эс үйлдэхүй хийж гэмт хэрэгт хамтран оролцогч болно. Гэмт хэрэгт хамтран оролцогч бүр үйлдэх гэмт хэрэгт туйлд нь хүргэхэд чиглэсэн нэгдсэн зорилготой, гүйцэтгэгчийг нийгэмд аюултай үйлдэл хийхийг хүсч байдаг онцлогоороо дангаараа гэмт хэрэг үйлдэхээс ялгагдана" гэсэн байна. 5. Р.Жаргалант (2008-09-05) УИХ-ын гишүүн асан Ц.Шараадоржтой хийсэн ярилцлагаас



**Баянгол дүүргийн
нотариатч, хуульч
Ч.БАЯНЖАРГАЛ**

Иргэдийн эрх, хуулиар иргэдэд олгогдсон боломжийг хангах, өмчлөгчийн эрхийг хамгаалах нь төрийн чиглүүллийн нэг хэсэг бөгөөд үүнийгээ мэргэжлийн хуульчдын оролцоотой хэрэгжүүлдэг. Нөгөө талаас төр, иргэн, хуулийн этгээд хоорондын эрх зүйн харилцаанд төр эсвэл хэн аль нэг тал нь давуу байдлаар оролцох байдал нэлээдгүйн учир талуудын эрх ашгийг тэгш хангах үүднээс хөндлөнгийн мэргэжлийн хуульч буюу нотариатчийг иргэний эрх зүйн харилцаанд оролцуулдаг. Энэ нь Та бидний эрх ашгийг хамгаалах зорилгоор төрөөс хийж буй ажил гэж ойлгож болно.

Иргэд, байгууллага өдөр тутмын ажил амьдрал, бизнесээ эрхлэх явцад өөр хоорондоо гэрээ байгуулах замаар иргэний гүйлгээнд орж байдаг. Гэрээг хуулийн дагуу байгуулах, гэрээний оролцогч талууд хүсэл зориггоо үнэн зөв, бодитой илэрхийлж тусгасан байх нь гэрээ хууль

НОТАРИАТААР ГЭРЭЭГ ГЭРЧЛҮҮЛЭХ ХУУЛЬ ЗҮЙН АЧ ХОЛБОГДОЛ

ёсны үйлдэлд тооцогдож, хүчин төгөлдөр болох үндсэн нөхцөл болдог. Аливаа гэрээг байгуулахдаа талууд бие биедээ шударга хандах, өөрийн хүсэл зориггоо үнэн зөв илэрхийлэх, гэрээний агуулга нь хуульд нийцсэн байх, гэрээт харилцааны үр дүнд эрх ашиг нь хангагдсан байх, хохиролгүй байх, талуудын эрх ашиг адил тэгш хамаарагдах нөхцөлийг хангахын тулд гэрээнд оролцогч нь мэргэжлийн хуульчийн туслалцаа авах, гэрээний төслөө хянуулбал зохилтой.

Иргэд нийгмийн даатгалд ирээдүйд учирч болзошгүй нийгмийн, тэр тусмаа хөдөлмөрийн чадваргүй болох, эд хөрөнгө нь аливаа эрсдэлд орволтүүнийг эзнэхөнтөлүүлэх зорилгоор даатгуулдгийн адил гэрээ талуудын жинхэнэ хүсэл зоригийг албан ёсны болгох, гэрээ нь хуульд нийцсэн байх, аливаа нэг шалтгаанаар хүчин төгөлдөр бус болох, маргаан гарах зэрэг хууль зүйн эрсдэлээс урьдчилан сэргийлэх баталгааг бий болгохын тулд нотариат гэрээг гэрчлэх хууль үйлчилж байна. Гэрээ нь хуульд заагдсан шаардлагыг хэрхэн хангаж, аль нэг талын эрх ашиг зөрчигдсөн эсэхийг зөвхөн хөндлөнгийн мэргэжлийн этгээдийн хяналт баталгаажилтаар хангадаг нь хууль зүйн тогтсон жишиг

стандарт юм. Хувьцаат компанийн удирдлагууд хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хэрхэн хангаж байгааг хянахын тулд хөндлөнгийн санхүүгийн хяналт болох аудитын дүгнэлтийг заавал гаргуулдаг билээ. Нотариатч мэргэжлийн хуульчийн үүднээс гэрээг гэрчилж, гэрээнд оролцогч талуудын жинхэнэ хүсэл зориг бодитойгоор илэрхийлэгдээгүй, хуульд нийцээгүй бол түүний үр дагаврыг тайлбарлаж гэрчлэхээс татгалзах үүрэгтэй төдийгүй хууль зөрчиж гэрээг хуурамчаар гэрчилсэн бол мэргэжлийн хариуцлага хүлээдэг нь нотариатч талуудын өмнө гэрээг үнэн зөв гэрчлэх үүрэг хүлээж, ажлаа үнэнч шударгаар хэрэгжүүлэх нөхцөлийг хангаж өгдөг. Нотариатч гэрээг хуулийн дагуу хянаж баталгаажуулахын тулд гэрээний талуудыг биечлэн оролцуулах, тэдгээрийн жинхэнэ хүсэл зориг бичгээр үнэн зөв илэрхийлэгдсэн, гэрээний утга агуулга хуульд нийцсэн, гэрээнд хамаарч буй бичиг баримт хууль ёсны зэргийг хянаж, талуудад тухайн гэрээний утга агуулга, үр дагавар, үүрэг, хариуцлагыг тайлбарлан өгөх арга хэмжээ авсаны үндсэн дээр гэрээг гэрчилдэг.

Нотариатч гэрээг гэрчлэхдээ

үндэслэл болгосон өмчлөх эрхийн гэрчилгээ, иргэний үнэмлэх, хуулийн этгээдийн гэрчилгээ, итгэмжлэл, лиценз зөвшөөрөл зэрэг холбогдох бичиг баримтыг нягтлан үзэж, шалган хуулбарыг нь гэрээний нэг хувийн хамт архивын баримт болгон авч үлддэг. Нотариатчийн бүрдүүлсэн архивын материал нь тухайн гэрээнээс үүдэн гарсан аливаа хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд үндсэн нотлох баримт болдог онцлогтой. Гэрээнд холбогдох бичиг баримтыг эх хувиар нь үзэж шалгасны дараа талууд уг гэрээг байгуулах бүрэн эрхтэй эсэх, гэрээг гэрчлэх хууль зүйн боломж нөхцөл хангагдсан эсэхийг тодорхойлох боломжтой болох бөгөөд тухайн гэрээ нь хуульд нийцсэн хүчин төгөлдөр байх нөхцөлийг хангаж өгдөг. Ингэснээр ард иргэд хуулийн мэдлэгийгээс өмчлөлийн аливаа зүйлээ хууль бусаар иргэний гүйлгээнд оруулах, өмчлөгчийн эрх зөрчигдөх, гэрээний талуудын хэрэгцээшаардлагыг хангаагүй, хууль бус гэрээ байгуулагдсан нөхцөлийг хааж, иргэн хуулийн этгээдийн эрх ашгийг хамгаалах нэг чухал институт нь нотариат болж байна. Хуулиар иргэн хуулийн этгээдийн амин чухал эрх ашигтай холбогдсон зарим гэрээг нотариат заавал гэрчлэх журам үйлчилдэг. Нотариат гэрээг заавал гэрчлэх нь талуудад хүлээлгэсэн адил үүрэг төдийгүй гэрчлүүлэхээс чөлөөлөх, гэрчлүүлэхгүй байх үндэслэлийг хуулиар тогтоодоггүй журамтай. Энэ нь төрөөс өмчлөгч болон иргэдийн эрхийг хуулиар хамгаалж буй хэлбэр юм.

Иргэд нийгмийн даатгал мөн аливаа бусад даатгал заавал гэрчлүүлснээр үл дүнд нас хөгшрөх, аливаа эрсдэл тулгарах үед тэтгэвэр

тэтгэмж авдаг нь ирээдүйдээ хийж буй хөрөнгө оруулалт билээ. Үүнтэй адилаар иргэд байгууллагын амин чухал эрх ашиг, өмчлөлийн зүйлтэй холбогдсон гэрээг байгуулахад нотариат заавал оролцож ингэснээр гэрээнээс маргаан үүсэх, хуульд нийцээгүйгээс хүчин төгөлдөр бус болох, гэрээний аль нэг талын эрх ашиг хохирохоос урьдчилан сэргийлж чадна. Иймээс нотариат гэрээг гэрчлэх явдлыг хүнд суртал, төлбөрийн дарамт гэх зэргээр үзэх нь гэрээт харилцааг дархлаагүй болгож, гэрээнээс үүдэн хууль зүйн аливаа эрсдэл гарахад хүрнэ.

Нотариатч гэрээг гэрчлэхдээ гэрээний талуудад адил тэгш үйлчилгээ үзүүлж, гэрээний агуулга, гэрээнээс үүдэн гарах үр дагаврыг сануулах зэргээр эрх зүйн үйлчилгээ үзүүлдэг бөгөөд аль нэгэнд нь илүү үйлчлэх ёсгүй. Иргэд байгууллагын ажил хэргийн хүрээнд нэгэнт тогтсон хэв маяг бол нотариатч гэрээг гэрчилсэн бол бидний байгуулж буй гэрээ хүчин төгөлдөр гэж үздэг явдал нь нотариатаар үйлчлүүлэхийн ач тусыг нийгэм хэрхэн үнэлж буйг харуулах гол үзүүлэлт гэж хэлж болно.

Нотариатч гэрээг гэрчлэх, хуульд заасан үндэслэлээр гэрээг гэрчлэхээс татгалзах нь гэрээний талуудын хүсэл зориг үнэн зөв, бүрэн, бодитой илэрхийлэгдэх нөхцөлийг хангах, хүсэл зоригийн бодит байдлыг хангаагүй хууль зөрчсөн гэрээ байгуулахаас урьдчилан сэргийлэх үндсэн нөхцөл болно. Шүүхээр иргэний маргаанаа шийдүүлэхийн тулд тэмдэгтийн хураамж төлдгийн адил нотариатаар гэрээг гэрчлүүлэхдээ үйлчилгээний хөлс төлдөг нь үүнийхээ хариуд гэрээгээ хуулийн дагуу байгуулж, мэргэжлийн хуульчийн туслалцаа

аваагүйгээс гэрээнээс үүдэн гарах аливаа хууль зүйн эрсдэлээс урьдчилан сэргийлж чадна.

- оОо -

Ц.САРАНТУЯА МОНГОЛЫН АНХНЫ ЭМЭГТЭЙ ЭРХ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ДОКТОР БОЛЛОО

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, Германы Ханнс-Зайдел сангийн Монгол дахь төслийн удирдагч, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн, доктор, профессор Ц.Сарантуяагийн "Монгол Улс дахь Үндсэн хуулийн процессын эрх зүйн үүсэл, төлөвшил, тулгамдсан асуудал" сэдэвт эрх зүйн шинжлэх ухааны докторын зэрэг горилсон хамгаалалт 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр МУИС-ийн дугуй зааланд танхим дүүрэн хүнтэй боллоо.

Эрх зүйн шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалуулах эрдмийн зөвлөлийг Академич Ж.Амарсанаа даргалж, орлогч даргаар Академич С.Нарангэрэл, Эрдэмтэн нарийн бичгийн даргаар эрх зүйн шинжлэх ухааны доктор Л.Баасан нар удирдав.

Эрх зүйн шинжлэх ухааны нэрт эрдэмтэд, доктор профессоруудын бүрэлдэхүүнтэй хэлэлцсэн эрдмийн зөвлөл Эрх зүйн зүйн шинжлэх ухааны докторын зэрэг горилгогч Ц.Сарантуяад эрх зүйн шинжлэх ухааны доктор цол олгохыг санал нэгтэй шийдвэрлэв. Ийнхүү Монголын анхны эмэгтэй эрх зүйн шинжлэх ухааны доктор цолыг Ц.Сарантуяа хүртсэнээрээ эрх зүйн салбарын эрдэмтэд, шавь нараа баярлуулсан төдийгүй монголын эрх зүйн салбарын түүхэнд тэмдэглүүштэй томоохон үйл явдал боллоо.

- оОо -



Нийслэлийн шүүхийн
Эрүүгийн танхимын шүүгч
Ц.БАТЦЭРЭН

Монгол Улсад хүний эрхийг дээдэлсэн хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлон хөгжүүлж, иргэд аюулгүй, хууль, эрх зүйн баталгаат орчинд ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэх нь Монголын ард түмний Үндсэн хуульдаа зарлан тунхагласан. Та бидний шийдвэрлэх нэн тэргүүний эрхэм зорилго билээ.

Эрх зүйт төр, иргэний ардчилсан нийгмийн үнэт зүйл нь хүний эрх, эрх чөлөө байдаг бөгөөд түүнийг хүлээн зөвшөөрч, хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг төр иргэнийхээ өмнө хариуцдаг бол эрх нь зөрчигдсөн иргэн өөрийн эрх, эрх чөлөөг хуулиар хориглоогүй бүхий л арга хэрэгслээр хамгаалах эрхтэй байдаг.

Манай улс хүний эрх, эрх чөлөөг хэлбэрэлтгүй сахиулах, тэдний эрх, ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд сэргээх

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ АЖИЛЛАГААН ДАХЬ ӨМГӨӨЛӨХ, ӨМГӨӨЛҮҮЛЭХ ЭРХ

үр нөлөөтэй, боловсронгуй, дэлхийн жишиг, монголын нөхцөлд тохирсон эрх зүйн тогтоолцоог бүрдүүлэх талаар өнгөрсөн он жилд чамгүй амжилтад хүрснийг бусад улс орон хүлээн зөвшөөрч, ази тивд ардчиллыг амжилттай хөгжүүлж байгаа загвар улс хэмээн өргөмжлөх болжээ.

Хүний эрхийн асуудал төрийн эрх бүхий байгууллага, хуульч, эрдэмтэд, судлаачдын байнгын анхааралд байж, судалгааны нэг гол объект болж байдаг хэдий ч энэ салбарын хууль тогтоомжид нэг мөр шийдэгдээгүй, эрх зүйн үзэл баримтлал, зарчимтай зөрчилдсөн зарим нэг заалт байгаагаас гадна иргэдийн зөрчигдсөн эрхийг хамгаалах асуудал хүссэн хэмжээнд хэрэгжихгүй, Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад иргэдийн өөрсдийгөө өмгөөлөх, бусдаар өмгөөлүүлэх эрхтэй холбоотой зарим нэг ойлгомжгүй байдал үүсч байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Тухайлбал, эрүүгийн хэрэгт өмгөөлөгчийг сонгон авах талаар Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38, 39 дүгээр зүйлд заасан заалтыг нэг мөр ойлгож хэрэглэхэд практикт зарим нэг хүндрэл бэрхшээл гарч байгаа нь холбогдох хуулийн зохицуулалт боловсронгуй биш, хуульчдын үйл ажиллагаа олон нийтийн итгэлийг бүрэн дүүрэн хүлээж чадахгүй, нөгөө талаар

иргэдийн эрх зүйн ухамсар, мэдлэг доогуур, зөрчигдсөн эрхээ хэрхэн хамгаалах болон хамгаалуулахаа сайн мэдэхгүй байгаагаас эрх ашиг нь хохирч байгаа юм.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, хууль зүйн бусад туслалцаа авах эрхтэй", мөн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 35 дугаар зүйлийн 35.2.7, 36 дугаар зүйлийн 36.3.3-т сэжигтэн, яллагдагч нь "өөрийгөө өмгөөлөх, энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу өмгөөлөгч авах" эрхтэй, мөн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 241 дүгээр зүйлийн 241.4-т "Энэ хуулийн 40 дүгээр зүйлд зааснаас бусад тохиолдолд шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх хүсэлтийг бичгээр гаргасан бол хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэж болно" гэж заасны дагуу тэдгээр нь өөрийгөө өмгөөлөх хүсэлт гаргасан тохиолдолд хууль хэрэгжүүлэгч нарын зүгээс энэ эрхийг нь ямар нэг шалгуургүйгээр хүлээн зөвшөөрдөг атлаа тэднийг өөрсдийн итгэл үнэмшлийн дагуу хэн нэгнийг өмгөөлөгчөөр сонгон авсан тохиолдолд зөвхөн өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан иргэнд Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгчөөр оролцох "монополия" эрх

олгож, тусгай зөвшөөрөл аваагүй иргэнийг өмгөөлөгчөөр оролцуулахгүй байгаа явдал нь өнөөдөр шүүхийн практикт нэлээд зөрчил маргаан үүсгэж байгаа, тулгамдсан асуудлын нэг болсон гэж үзэж байгаа тул холбогдох хуулийн заалтыг Монгол Улсын Үндсэн хууль, нэгдэн орсон олон улсын гэрээ, бусад улс орны хуулийн заалтуудтай харьцуулан судалж, дүгнэлт өгөхөөс гадна эрүүгийн хэрэгт холбогдсон этгээд өмгөөлөгчөө чөлөөтэй сонгож, хууль зүйн туслалцаа авах өнөөгийн боломж нөхцөл ямар байгаа болон Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгчөөр оролцох этгээдэд хуулиар тодорхой шалгуур тогтоосон явдал нь хүний эрхтэй хэрхэн холбогдохыг тал бүрээс нь хөндөж авч үзэхийг хичээлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т "хүн бүр өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрхтэй", мөн Үндсэн хуулийн 55 дугаар зүйлд "Шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх эрхтэй, шүүгдэгч энэ эрхээ эдлэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ" гэж тус тус зааснаас гадна Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлд "хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг төр иргэнийхээ өмнө хариуцна" гэж зааснаас үзэхэд өмгөөлүүлэх эрхийг хангах нь төрийн үүрэг гэж ойлгож болно.

Иймд хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргээ төр Үндсэн хуульд заасан чиг

үүргийнхээ дагуу зохих ёсоор хэрэгжүүлэхийн тулд иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг мэргэжлийн байгууллага болох Монголын Өмгөөлөгчдийн холбоонд даалгаж, түүний гишүүн хуульч - өмгөөлөгч нар төрийн зохих байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр төрийн энэ чиг үүргийг хэрэгжүүлэхээр Өмгөөллийн тухай хуульд тусгаж өгсөн нь Үндсэн хуулийн үзэл санаанд нийцэж байна.

Ийнхүү Монгол Улсын Үндсэн хуульд иргэдийн хууль зүйн туслалцаа авах буюу өмгөөлүүлэх эрхийг баталгаажуулсан заалт нь хүний амьдрал, хувь заяа, ашиг сонирхол, эрх, эрх чөлөөг хамгийн их хөнддөг эрүүгийн эрх зүйн салбарт илүү хамааралтай тул иргэдийн хууль ёсны ашиг сонирхол, зөрчигдсөн эрхийг цаг алдахгүй, түргэн шуурхай, үр нөлөөтэй хамгаалах асуудал юу юунаас чухал гэдгийг Та бидний өнгөрсөн түүх, өнөөдрийн манай нийгэмд өрнөж буй халуун үйл явдлууд илтгэн харуулж байна.

Өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхтэй холбоотой асуудалд дүгнэлт хийхийн тулд юуны өмнө "өмгөөлөгч" гэж хэнийг хэлэх вэ гэдгийг авч үзье.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.1-д "Хуульд заасан журмын дагуу сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохилогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, хууль зүйн туслалцаа үзүүлж байгаа этгээдийг өмгөөлөгч гэнэ" гэж заасан нь хүний эрхэлж байгаа үйл ажиллагаатай холбоотой гаргасан тодорхойлолт гэж ойлгогдож байгаа бөгөөд хууль тогтоогчийн зүгээс хүний эрх, эрх чөлөөг хангах зорилгоор

өмгөөлөл хийх субъектыг ЭБШХ-д өргөн хүрээтэй тогтоосон гэж үзэж болохоор байна.

Гэтэл Өмгөөллийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Хууль зүйн дээд боловсролтой, ял шийтгэлгүй, тогтоосон журмын дагуу мэргэшлийн шалгаруулалтад орж, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан иргэнийг өмгөөлөгч гэнэ".

Мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д "Өмгөөллийн үйл ажиллагааг өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ" гэж өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх субъектэд хууль зүйн талаас тавигдах шаардлагыг тодруулан заасан нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38.1-д заасан тодорхойлолттой утга агуулгын хувьд зөрчилдөөгүй, харин ч түүнийг тодотгосон шинжтэй гэж үзэхээр байна.

Гэвч шүүхийн практикт өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхийн талаар маргаан гарвал аль хуулийн заалтыг баримтлах вэ, хууль тогтоогч өмгөөлөгчийн талаар хоёр өөр янзын тодорхойлолтыг хуульчилсан атлаа удаа дараа Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа энэ асуудлыг багаад хөндөхгүй орхигдуулсан бэ, тусгай зөвшөөрөл аваагүй иргэнийг заавал өмгөөлөгчөөр оролцуулан гэсэн маргаан гарсан тохиолдолд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т заасан "... Эрүүгийн хууль болон энэ хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид

ашигтайгаар шийдвэрлэнэ” гэсэн зарчим үйлчлүүлэх үү, тусгай зөвшөөрөл аваагүй иргэнийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38.2-т заасны дагуу үйлчлүүлэгчийн хүсэлтээр Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгчөөр оролцохыг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3-т “Нэг этгээд хэд хэдэн өмгөөлөгчтэй байж болно” гэж заасны дагуу сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нь эрх авсан өмгөөлөгчөөс гадна өөрийн итгэл үнэмшилээр тусгай зөвшөөрөл аваагүй нэг буюу хэд хэдэн иргэнийг давхар өмгөөлөгчөөр сонгох боломжтой юу, түүнчлэн шүүгдэгч өөрөө өөрийгөө өмгөөлсөн, эсхүл Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2-т заасны дагуу тусгай зөвшөөрөл аваагүй иргэн Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгчөөр оролцсон тохиолдолд тэдгээр нь хяналтын шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй юу, эцэст нь Өмгөөллийн тухай хуулийн 5.1 дэх хэсгийг баримтлан тусгай зөвшөөрөл аваагүй иргэдийн өмгөөлөгчөөр ажиллах, бусдад хууль зүйн туслалцаа үзүүлэх эрхэд хязгаарлалт тогтоох нь Үндсэн хууль болон хүний эрхийн талаар Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний заалтуудыг зөрчих үү гэх мэт олон асуудал ар араасаа урган гарч ирнэ.

Эдүгээманайулсад 1000 гаруй хүн тусгай зөвшөөрлийн үндсэн дээр өмгөөллийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хэдий ч янз бүрийн хүчин зүйлээс, тухайлбал, тухайн эрүүгийн хэргийн нөхцөл байдлаас шалтгаалан тусгай

мэдлэг мэргэшил шаардагдах хэрэг маргааны тоо, төрөл өсөн нэмэгдэж байгаа өнөө үед ур чадвар, мэдлэг туршлагын хувьд үйлчлүүлэгчийн санаанд нийцэхгүй, түүнчлэн ашиг сонирхлын зөрчилтэй, үйлчлүүлэгч нь өмгөөллийн хөлс төлөх чадваргүй, мөн хөдөө, орон нутагт тусгай зөвшөөрөл авсан өмгөөлөгчийн тоо цөөн гэх мэт олон шалтгаанаар мэргэжлийн өмгөөлөгч хүн бүрт хүртээмжтэй биш байдаг, нөгөө талаар эрх нь зөрчигдсөн этгээд эрх ашгаа хамгаалуулахын тулд өөрийн хүсэл сонирхол, итгэл үнэмшилээр өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл аваагүй этгээдийг, тухайлбал өөрсдийн хамгийн их итгэж хүндэлдэг эцэг эх, ойрын төрөл садан, олон нийтийн дунд нэр хүнд бүхий иргэн, төрийн бус байгууллагын төлөөлөгч, гадаад улсын иргэн, тусгай мэргэшил бүхий мэдлэг ур чадвар эзэмшсэн гэх мэт хэн нэгнийг өмгөөлөгчөөрөө сонгон оролцуулах, тэдгээр сонгогдсон хүмүүс нь ч гэсэн тухайн иргэний эрх ашгийг хамгаалахаар холбогдох байгууллагад хүсэлт гаргаж, шүүх хуралдаанд хэн нэгнийг өмгөөлж үг хэлэх, байр сууриа илэрхийлэх зөвшөөрөл хүсдэг хэдий ч тэдгээр нь нэгэнт байцаан шийтгэх ажиллагааны оролцогч биш гэдэг утгаар хүсэлтийг нь хүлээж аваагүй тохиолдолд хуулийн байгууллагад гомдох, сэтгэл дундуур үлдэх явдал шүүхийн практикт нэлээд гардаг.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг зөвхөн тусгай зөвшөөрөл авсан, “Монголын Өмгөөлөгчдийн холбоо” төрийн бус байгууллагын

гишүүн эдэлнэ гэж хуулийн холбогдох заалтыг тайлбарлан хэрэглэж, өмгөөлөх эрхэд хуулиар хатуу шалгуур тогтоох нь нэг талаас тусгай зөвшөөрөл авсан өмгөөлөгч нар төмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх монополь эрхийг олгож байгаагаас гадна эрх нь зөрчигдсөн иргэдийн өмгөөлөгчөө чөлөөтэй сонгох эрхэд хязгаарлалт тогтоосон явдал болох нь тодорхой.

Өнөөдөр шүүхийн практикт тусгай зөвшөөрөл аваагүй атлаа үйлчлүүлэгчийн хүсэлтээр Иргэдийн шударга шүүх төрийн бус байгууллагын тэргүүн Х.Бат-Ялалт, шүүгч асан П.Сарантуяа, өмгөөлөгч асан Л.Нямзундуй, иргэн А.Эрдэнэбилэг зэрэг хэд хэдэн хүн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2-т заасны дагуу Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгч буюу төлөөлөгчийн статустай оролцож байгаа нь нууц биш. Харин өмгөөлөгч нар харьцангуй цөөн байдаг хөдөө орон нутагт Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38.2 дахь хэсгийн хэрэгжилт ямар байгааг мэдэхгүй байна. Ямар ч байсан тусгай зөвшөөрөл аваагүй дээрх нэр дурдсан иргэдийг байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгчөөр оролцуулж байгаа явдал нь зарим хууль хэрэгжүүлэгч нарын зүгээс иргэдийн өмгөөлөгчөө чөлөөтэй сонгох субъектив болон объектив эрхийг хүлээн зөвшөөрсөнтэй холбоотой юм.

Нэгэнт тусгай зөвшөөрөл аваагүй иргэнийг байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгчөөр оролцохыг Үндсэн хуулийн хүний эрхтэй холбоотой заалт болон Эрүүгийн байцаан

шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийг үндэслэн хүлээн зөвшөөрсөн тохиолдолд тэдгээр нь Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны аль үе шатанд оролцох эрхтэй вэ гэсэн зүй ёсны асуулт урган гарч ирнэ.

Дээрх асуудал нь Үндсэн хуульд заасан хүний эрхтэй холбоотой чухал асуудал тул практикийн хуульч, судлаачдын анхаарлыг зүй ёсоор татаж байгаа бөгөөд энэ талаар зарим хуульчтай санал солилцоход хуулийн дээрх заалтын талаар эсрэг тэсрэг, өөр өөр санал дүгнэлтүүд гарч байна.

Тухайлбал, Үндсэн хуулийн 55 дугаар зүйлд "Шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх эрхтэй, шүүгдэгч энэ эрхээ эдлэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслагчаа үзүүлнэ", мөн Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлд "хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг төр иргэнийхээ өмнө хариуцна" гэж заасны дагуу шүүгдэгчийн гаргасан хүсэлтийг хүлээн авч, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийг үндэслэн өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл аваагүй иргэнийг зөвхөн шүүх хуралдааны ажиллагаанд өмгөөлөгчөөр оролцуулах боломжтой, энэ нь иргэний өмгөөлөгчөө чөлөөтэй сонгох эрхийг хүндэтгэн хангаж байгаа явдал гэж үзэн, дээр нэр дурдсан иргэдийг шүүх хуралдаанд өмгөөлөгчөөр оролцуулсан байхад, Нөгөө хэсэг нь өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл аваагүй иргэнийг зөвхөн шүүхээс өмнөх шатанд сэжигтэн,

яллагдагчийн өмгөөлөгчөөр оролцуулах боломжтой гэж үзэж байх юм. Учир нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д "Шүүн таслах ажиллагаа нь эрх тэгш бүхий яллах, өмгөөлөх талын мэтгэлцээний үндсэн дээр явагдана" гэж заасан тул шүүхийн мэтгэлцээнийг хэрэгжүүлэх зорилгоор улсын яллагчтай зөвхөн тусгай зөвшөөрөл авсан, мэргэжлийн өмгөөлөгч мэтгэлцэх боломжтой гэж үзэх хүмүүс ч байгаа юм.

Гэвч дээрх зарчмын зөрүүтэй тайлбарууд хоёулаа үндэслэл муутай гэдгийг дараахь үндэслэлээр тайлбарлая. Үүнд: Нэгдүгээрт, "Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл аваагүй иргэн Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны аль үе шатанд өмгөөлөгчөөр оролцох эрхтэй талаар Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2-т тусгайлан заагаагүй.

Хоёрдугаарт, Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.13-т "Монгол Улсын иргэн халдашгүй чөлөөтэй байх эрхтэй, ... хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч ... баривчлахыг хориглоно, баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ" гэж, мөн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, хууль зүйн бусад туслагчаа авах эрхтэй" гэж, харин Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.3-

т "Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 172 дугаар зүйлийн 172.3-т заасан хойшлуулшгүй ажиллагаа явуулж эхэлсэн, ийм ажиллагаа явуулаагүй бол гэмт хэрэгт сэжигтнээр тооцсон үеэс эхлэн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох эрхтэй" гэж зааснаас үзэхэд тусгай зөвшөөрөл аваагүй иргэн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2-т заасны дагуу байцаан шийтгэх ажиллагааны аль ч үе шатанд өмгөөлөгчөөр оролцох боломжтой гэж ойлгож болохоор байна.

Гуравдугаарт, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2-т "... сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өөрөө өмгөөлөгчөө сонгоно" гэж зааснаас үзэхэд байцаан шийтгэх ажиллагааны аль ч үе шатанд зохих этгээдийн хүсэлтээр өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл аваагүй этгээд өмгөөлөгчийн статустай оролцох боломжтой байна. Хэрэв тусгай зөвшөөрөл аваагүй иргэнийг шүүх хуралдаанд өмгөөлөгчөөр оролцуулах боломжгүй гэж хууль тогтоогч үзсэн бол Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38.2-т "сэжигтэн, яллагдагч" гэж, эсхүл зөвхөн шүүхээс өмнөх шатанд өмгөөлөгчөөр оролцох боломжтой гэж үзсэн бол "шүүгдэгч" гэж заахгүй байх байсан.

Дараагийн авч үзэх асуудал бол Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2-т "байцаан шийтгэх ажиллагаанд оролцоход харишлах шалтгаангүй этгээдийг ... өмгөөлөгчөөр сонгоно" гэж заасан. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, түүнчлэн

тэдгээрийн зөвшөөрснөөр буюу хүссэнээр түүний хууль ёсны төлөөлөгч, гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн нь өөрсдийн үзэмжээр байцаан шийтгэх ажиллагаанд оролцоход харшлах шалтгаангүй хэнийг ч боловч өмгөөлөгчөөр сонгох эрхтэй гэж Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 39.2-т заасан байна.

Энд "байцаан шийтгэх ажиллагаанд оролцоход харшлах шалтгаангүй этгээд" гэснээс өөр тусгай зөвшөөрөл аваагүй иргэнийг байцаан шийтгэх ажиллагаанд оролцоход нь хуулиар хязгаарлалт тогтоож өгөөгүй байх тул дээрх заалтыг мөн тайлбарлах хэрэгтэй болж байна.

Миний үзэж байгаар энд хамгийн гол шалгуур нь тухайн хэрэгт хувийн сонирхолгүй, мэдлэгчадварын хувьд өмгөөлөл хийх боломжтой, ял шийтгэлгүй, эрх зүйн бүрэн чадамжтай этгээд байх нь ойлгомжтой юм. Бусад шалгуурыг мөн л хууль тогтоогч, эсхүл улсын дээд шүүх бүрэн эрхийнхээ дагуу тайлбарлах нь зүйтэй болов уу.

Гэвч өнөөгийн шүүхийн практикт тусгай зөвшөөрөл аваагүй иргэнийг өмгөөлөгчөөр оролцох явдлыг огт хүлээн зөвшөөрөхгүй гэсэн ойлголт, хандлага дийлэнх хуульчдад бат бэх тогтсон тул хууль зүйн туслалцаа авахаар ийм хүсэлт гаргасан иргэд болон тэдэнд туслалцаа үзүүлж өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх гэсэн иргэдийн хувьд ч гэсэн ихээхэн эсэргүүцэл, хүндрэл бэрхшээлтэй тулгардаг нь нууц биш. Өнөөдөр дээр нэр дурьдсан зарим хүнийг эс тооцвол тусгай зөвшөөрөл аваагүй иргэнийг өмгөөлөгчөөр

оролцуулах явдал шүүхийн практикт бараг хэрэгжихгүй байгаа гэж ойлгож болно.

Нөгөө талаар Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2-т заасан заалтыг хэрэгжүүлэх механизм ойлгомжгүйгээс хууль хэрэгжүүлэгч нар уг хуулийн заалтыг өөр өөрөөр ойлгож, тайлбарлаж, хэрэгжүүлж байгаа явдал нь энэ талаар Улсын Дээд шүүх тайлбар гаргах шаардлагатай болсныг харуулж байна.

Түүнээс гадна тусгай зөвшөөрөл аваагүй иргэнийг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгчөөр оролцуулах тухай хүсэлтийг эрх бүхий албан тушаалтан хянан шийдвэрлэхдээ үндэслэл бүхий эрхийн акт гаргаж байх нь зүйтэй боловч энэ талаар Эрүүгийн байцаан шийтгэх хуульд тодорхой зохицуулалт байхгүйгээс хүсэлтийг ямар үндэслэлээр хүлээн авсан буюу татгалзсанныг гэдэгд ойлгомжгүй үлддэг. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 42.2-т "Иргэн, хуулийн этгээдийг хохирогчоор тогтооход...", Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 43.2-т "Иргэний нэхэмжлэчийг тогтооход..." мөн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 44.2-т "Иргэний хариуцагчаар татахад...", мөн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 46.1-д "шинжээнийг томилоход хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана" гэж тус тус заасны адилаар Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2-т заасны дагуу тусгай зөвшөөрөл аваагүй иргэнийг байцаан шийтгэх ажиллагаанд сэжигтэн,

яллагдагч, шүүгдэгчийн хүсэлтээр тэдгээрийн өмгөөлөгчөөр оролцуулах тухай асуудлыг хэрхэн шийдвэрлэхийг хуульчлах шаардлагатай гэж үзэж байна.

Монгол Улсын хамгийн ойрын хөрш болох, эрх зүйн ижил тогтолцоотой ОХУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 49 дүгээр зүйлийн 2 дахь заалтад: яллагдагчийн хүсэлтээр түүний ойрын төрөл садны хүн болон бусад этгээдийг байцаан шийтгэх ажиллагаанд мэргэжлийн өмгөөлөгчтэй нь хамт өмгөөлөгчөөр оролцуулах асуудлыг шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар шийдвэрлэнэ гэж заасныг анхааралтай судалж үзэхэд шүүхийн оролцоотой энэ асуудлыг шийдвэрлэж байгаа нь дэвшилттэй боловч өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл аваагүй иргэн дангаараа эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгчөөр оролцох боломжгүй болох нь харагдаж байна.

Харин Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38.2-т "Мэргэжлийн өмгөөлөгч оролцох боломжгүй бол байцаан шийтгэх ажиллагаанд оролцоход харшлах шалтгаангүй этгээдийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өөрөө өмгөөлөгчөөр сонгоно" гэж заасан нь илүү өргөн боломж олгосон, хүний эрхийг хангахад чиглэгдсэн гэж үзэж болохоор байгаа боловч энэ асуудлыг хууль хэрэгжүүлэгч нар хэрхэн шийдвэрлэх талаар ямар нэг зохицуулалт үгүйлэгдэж байна.

Иймд тусгай зөвшөөрөл аваагүй иргэнийг байцаан шийтгэх ажиллагаанд сэжигтэн,

яллагдагч, шүүгдэгчийн хүсэлтээр тэдгээрийн өмгөөлөгчөөр оролцуулахдаа хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх ОХУ-ын эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасны адилаар шүүхийн тогтоол буюу шүүгчийн захирамжийг үндэслэж байх нь нэг талаас тэдгээрийн хууль ёсны эрх ашиг зөрчигдөхгүй байх нэгэн чухал баталгаа болох бөгөөд иргэдийн өмгөөлүүлэх эрхийг хангах талаарх Үндсэн хуулийн үзэл санаанд нийцнэ гэж үзэж байна.

Гэхдээ тусгай зөвшөөрөл аваагүй иргэнийг байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгчийн статустай оролцуулах эсэх асуудлыг шийдвэрлэхэд энэ талаар сонирхогч этгээдийн хүсэл зоригоос гадна дараахь хэд хэдэн нөхцөл байдлыг харгалзан үзэх хэрэгтэй болно. Үүнд:

1. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 18.1-д "Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, хууль зүйн бусад туслалцаа авах эрхтэй" гэж,

мөн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 18.2-т "Энэ хуулийн 40 дүгээр зүйлд заасан тохиолдолд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийг өмгөөлүүлэх бололцоогоор заавал хангах үүрэгтэй"

мөн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4-т "Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч өмгөөлөгчөө сонгон аваагүй бол түүний хүсэлтээр эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох боломжийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч,

прокурор, шүүх хангах бөгөөд өмгөөлөгчөө сонгоход нь тодорхой хүний нэр зааж тулгаж болохгүй" гэж тус тус заасан хэдий ч өмгөөлөл явуулах этгээд нь мэдлэг туршлагын хувьд шаардлагын хэмжээнд хүртэл бэлтгэгдээгүйгээс гарч болох үр дагавараас сэргийлж, энэ асуудалд туйлын няхуур хандах.

2. Тусгай зөвшөөрөл аваагүй иргэнийг эрүүгийн хэрэгт өмгөөлөгчөөр оролцуулах талаар эрх бүхий албан тушаалтан шийдвэр гаргасан тохиолдолд тухайн эрхийн актад хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлага хангагдсан байх ёстой.

Эрх бүхий албан тушаалтан энэхүү шийдвэрийг гаргахдаа иргэдийн өмгөөлөгчөө чөлөөтэй сонгох эрхэд хүндэтгэлтэй хандах хэрэгтэй бөгөөд эцсийн шийдвэрийг /өөр хэн нэгэн биш/, гол нь хууль зүйн буюу өмгөөллийн туслалцаа авахыг хүссэн этгээд гаргах ёстой гэдгийг харгалзан үзэх нь зүйтэй.

Тусгай зөвшөөрөл аваагүй иргэнийг тухайн эрүүгийн хэрэгт өмгөөлөгчөөр оролцуулах талаар сонирхогч этгээдийн гаргасан хүсэлтийг эрх бүхий албан тушаалтан хүлээн авахаас татгалзсан тохиолдолд хүсэлт гаргагч нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т заасны дагуу давж заалдах эрхээр хангагдах ёстой боловч тусгай зөвшөөрөл аваагүй иргэнийг эрүүгийн хэрэгт өмгөөлөгчөөр оролцох боломжийг хязгаарлаж байгаа шийдвэр нь хэний эрх ашигт нийцэх вэ, тэднийг оролцуулснаар шүүх болон тусгай зөвшөөрөл авсан монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн өмгөөлөгчид, эсхүл хууль

хамгаалах бусад байгууллагын эрх ашиг зөрчигдөх үү гэдэгт нэг мөр хариулт олдохгүй л байна.

Цаашилбал, тусгай зөвшөөрөл аваагүй иргэний эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгчөөр оролцуулах нь Үндсэн хуулиар хамгаалагдсан үндэсний болон хүн амын аюулгүй байдал, нийгмийн хэв журамд аюул занал учруулахгүй гэдэг нь тодорхой.

Гэтэл эрх зүйт нийгэмд бид юуны өмнө хувь хүний эрх ашгийг дээдэлж, хүнийг бүх талаар дэмжих ёстой биш билүү, Ямар ч тохиолдолд өмгөөлөгчийн асуудлыг хэрхэн шийдвэрлэснээс шалтгаалж хүний эрх, хууль ёсны ашиг сонирхол хохирох ёсгүй гэдэгтэй бүгд санал нийлэх байх.

Иймд хууль зүйн туслалцаа авахын тулд өөрийн итгэл үнэмшлээр хэн нэгнийг өмгөөлөгчөөр сонгож авах эрхэд хуулиар хязгаарлалт тогтоож, тусгай зөвшөөрөл аваагүй иргэнийг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгчөөр оролцуулах талаар сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гаргасан хүсэлтийг Өмгөөллийн тухай хуулийн 5.1, 16.1 дэх заалтуудыг үндэслэн хүлээж авахгүй байгаа шүүхийн шийдвэр нь иргэд Үндсэн хуулиар олгогдсон өөрийгөө өмгөөлөх, бусдаас хууль зүйн туслалцаа авах эрхийг зөрчиж байгаа эсэх,

мөн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 312 дугаар зүйлийн 312.2-т "Шүүх хуралдаанд оролцох хүсэлт гаргасан ялтныг шүүх хуралдаанд оролцуулж болно" гэж заасны дагуу цагдан хоригдож байгаа этгээд давж заалдах шатны шүүх

хуралдаанд биечлэн оролцох талаар гаргасан хүсэлтийг тодорхой бус шалтгаанаар хүлээж авахгүй байгаа өнөөгийн давж заалдах шатны шүүхийн практик нь Үндсэн хуульд заасан хүний өөрийгөө өмгөөлөх эрхийг зөрчиж байгаа эсэх,

мөн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 342 дугаар зүйлийн 342.1-д "Хяналтын журмаар гомдол гаргах эрхийг зөвхөн шүүгдэгч, цагаатгагдсан этгээд, хохирогчийн өмгөөлөгч эдлэхээр Эрүүгийн байцаан шийтгэх хуульд 2007 оны 8 дугаар сарын 9-нд нэмэлт өөрчлөлт оруулсан нь иргэний Үндсэн хуулиар олгогдсон өөрийгөө өмгөөлөх эрхийг зөрчсөн эсэх талаар сонирхогч этгээд Үндсэн хуулийн Цэцэд гомдол гаргаж шийдвэрлүүлэх боломж нээлттэй байгаа гэдгийг энд онцлон тэмдэглэх нь зүйтэй гэж үзэж байна. Нөгөө талаар хууль тогтоогч холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах, эсхүл улсын дээд шүүх тайлбар гаргах замаар дээрх ойлгомжгүй асуудлуудыг нэг мөр шийдвэрлэх боломжтой юм.

Өмгөөллийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл аваагүй зарим иргэнийг тэдний үйлчлүүлэгчийн гаргасан хүсэлтээр шүүх хуралдаанд өмгөөлөгчөөр оролцохыг хүлээн зөвшөөрсөн зарим шүүгчийн шийдвэр нь Өмгөөллийн тухай хуулийн 5.1, 16.1 дэх заалтуудтай зөрчилдөж байгаа хэдий ч шүүхийн байгууллага өмгөөллийн үйл ажиллагаа явуулах тусгай эрх аваагүй иргэдийг байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгчөөр оролцуулах талаар гаргасан хүсэлт бүрийг шүүх хүлээн

зөвшөөрч, хангах бодлого баримталж байгаа гэж үзэж болохгүй.

Шүүхээр хянан шийдвэрлэсэн хэд хэдэн хэргийн шүүх хуралдааны тэмдэглэлийг судалж үзэхэд энэ асуудалтай холбоотойгоор шүүх хуралдааны танхимд нэлээд маргаан зөрчил үүсдэг, үүнээс болж шүүх хуралдаан удаа дараа хойшлогдсон, тусгай зөвшөөрөл аваагүй иргэнийг өмгөөлөгчөөр оролцуулахгүй гэж шүүх шийдвэрлэсэнтэй холбогдуулан шүүх бүрэлдэхүүнийг татгалзан гаргах, энэ асуудлаар шүүхийн сахилгын хороонд хандах, эсхүл шүүхийн шийдвэрт захирагдаагүй оролцогч нарт шүүх хариуцлага тооцсон, эцэст нь шүүгдэгчийн хувьд өмгөөлөгчөө солихоос өөр аргагүй байдалд хүрсэн зэрэг жишээ хэд хэдийг дурьдаж болохоор байна.

Тэгвэл Монгол Улсад тусгай зөвшөөрөл авсан 1000 гаруй өмгөөлөгч өмгөөллийн үйл ажиллагаа эрхэлж байхад зарим иргэнд яагаад хүндрэл бэрхшээл, эсэргүүцлийг үл хайхран тусгай зөвшөөрөл аваагүй иргэнийг өөрсдийн өмгөөлөгчөөр оролцуулах хүсэлт гаргаад байна вэ, нөгөө талаар өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх сонирхолтой иргэд яагаад мэргэшлийн шалгаруулалтад орж, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахгүйгээр өмгөөллийн үйл ажиллагаа эрхлээд байна вэ гэдгийг судалж үзэхэд хэд хэдэн хүчин зүйл нөлөөлж байна. Үүнд:

Тусгай зөвшөөрөл авсан өмгөөлөгч нь өмгөөллийн хууль, өмгөөлөгчийн ёс зүйн дүрмээс гадна шүүхийн

тавьсан шаардлагыг сахих хэрэгтэй болдог бөгөөд зөрчсөн тохиолдолд түүний өмгөөлөх эрхийг хасах хүртэл сахилгын шийтгэл ногдуулж болдог нь түүнд нэмэлт дарамт учруулдаг байна. Тэгвэл тусгай зөвшөөрөл аваагүй этгээдэд хэн нэгэн хариуцлага тооцох боломжгүй тул шүүх болон бусад байгууллагын дарамтаас айхгүйгээр харьцангуй чөлөөтэй өмгөөллийн үйл ажиллагаа явуулах боломжтой гэж үздэг, нөгөө талаар мэдлэг туршлага, ёс зүйн хувьд мэргэшлийн шалгаруулалтын босгыг давж чадахгүй, түүнээс гадна Өмгөөллийн тухай хуулийн 16.3-т "Шүүгч, прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч ажлаасаа чөлөөлөгдсөнөөс хойш гурван жилийн хугацаанд өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно" гэж заасантай холбоотой байж болох юм.

Энэ бүхнээс дүгнэлт хийхэд: Эрүүгийн хэрэгт өмгөөлөгчөө чөлөөтэй сонгох эрх нь сэжигтэн, яллагдагч өөрийн хүсэлтээр хэнийг ч хамаагүй өөрийн өмгөөлөгчөөр сонгох, нөгөө талаар хэн ч хамаагүй байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгчөөр оролцох боломжтой гэсэн үг биш. Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т заасан "өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах" эрхтэй гэж заасныг ерөнхий утгаар нь ойлгож, Үндсэн хуулийн 55 дугаар зүйлийн 2-т "шүүгдэгчид энэ эрхээ эдлэх нь хүсэлтээр нь буюу хуульд зааснаар "хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ" гэсэн заалттай холбож хэрэглэх нь зүйтэй бөгөөд Үндсэн хуулийн дээрх 2 заалтыг нэг нэгнээс нь салгаж тайлбарлах боломжгүй

гэж үзэж байна.

Өөрөөр хэлбэл иргэдийн "хууль зүйн туслалцаа авах" эрхийг баталгаажуулахын тулд төрөөс хэд хэдэн арга хэмжээ авсан байх ёстой. Үүнд:

Нэгдүгээрт: Иргэд хуулийн янз бүрийн чиглэлээр, түүний дотор эрүүгийн эрх зүйн чиглэлээр хууль зүйн туслалцаа үзүүлэх мэргэжлийн хуульч, боловсон хүчнийг бэлтгэх нөхцөлийг бүрдүүлэх. Тэгвэл өнөөдөр Монгол Улсад хэд хэдэн хууль зүйн дээд сургуульд үйл ажиллагаа явуулж, жил бүр хангалттай олон хүнийг эрх зүйч мэргэжлээр бэлтгэн гаргаж байна.

Хоёрдугаарт: Дээрх зорилгоор хуульчдад мэргэжил, мэргэшлийн зүгээс тавигдах шалгуур үзүүлэлтүүдийг тогтоох, учир нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гаргасан хүсэлтээр байцаан шийтгэх ажиллагаанд хэнийг ч хамаагүй тэдний өмгөөлөгчөөр оролцуулахыг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд шаардлагатай мэргэжлийн дадлага туршлага эзэмшээгүй этгээд хувийн болон бусад ашиг сонирхлоор хэрэгт оролцож, шүүн таслах ажиллагаанд саад учруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хохироох, улмаар Үндсэн хуульд заасан төрөөс иргэдэд "хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх" чиг үүрэгтэй зөрчилдөх болно. Өнөөдөр Монгол Улсад өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахын тулд Хууль зүйн дээд сургуулийг эрх зүйч мэргэжилтэй төгсөж 2 жил мэргэжлээрээ ажилласны дараа Хуульчдын болон өмгөөлөгчийн сонгон шалгаруултад орж тэнцсэн тохиолдолд сая үйл

ажиллагаа явуулах эрхтэй болно.

ОХУ-ын Үндсэн хуулийн шүүх өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл аваагүй иргэнийг байцаан шийтгэх ажиллагаанд оролцуулах эсэх асуудлыг зарим иргэдийн гомдлоор хянан хэлэлцээд /1997.01.28-ны №2 тоот тогтоолоор/ өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл аваагүй этгээд байцаан шийтгэх ажиллагаанд дангаараа өмгөөлөгчөөр оролцох боломжгүй гэсэн шийдвэр гаргасан байдаг.

Одоо "Мэргэжлийн хууль зүйн туслалцаа" гэдэгт юуг ойлгох вэ гэдгийг авч үзье.

Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т иргэн хууль туслалцаа авах эрхтэй, 55 дугаар зүйлийн 2-т төрөөс хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ гэж тус тус заасан нь иргэдийн өмгөөлөгч авах, өмгөөлөгчөөр ажиллах эрхийг хэрэгжүүлэхэд ямар нэгэн хязгаарлалт тогтоож, тодорхой бүлгийн эрх ашгийн төлөө иргэдийн эрх, эрх чөлөөг хясан боогдуулах зорилго агуулаагүй гэдэгт эргэлзэхгүй байна.

Түүнээс гадна Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өмгөөлөгчдөд мэргэжил, мэргэшлийн зүгээс тавигдах шалгуурын талаар ямар нэг заалт байхгүй. Ийм нөхцөлд эрх, ашиг сонирхол нь хөндөгдсөн хүн өөрийн эрх, эрх чөлөөг хуулиар хориглоогүй бүхий л арга хэрэгслээр хамгаалах эрхтэй гэсэн Үндсэн хуулийн үзэл санаанд үндэслэн эрүүгийн шүүн таслах ажиллагаанд эрх ашиг нь зөрчигдсөн хэнд ч гэсэн иргэд хууль зүйн туслалцаа үзүүлэх

боломжтой гэж ойлгож болох юм. Нөгөө талаар өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан атлаа эрхэлсэн ажилдаа хайнга хариуцлагагүй хандаж, чанаргүй өмгөөлөл явуулснаас үйлчлүүлэгчийнхээ эрх ашгийг хохироосон жишээ шүүхийн практикт мэр сэр гардгийг ч бас тооцож, өөрийн сонгож авсан өмгөөлөгчид итгэл алдарч олон нийтийн байгууллагын төлөөлөгчид хандан эрх ашгаа хамгаалуулах гэсэн иргэний хүсэлтийг хууль хэрэгжүүлэгч нар хүндэтгэн үзэхээс өөр аргагүй юм.

Хэргийн нөхцөл байдлаас шалтгаалан нэр хүнд бүхий олон нийтийн байгууллагын төлөөлөгч тухайн хэрэгт стратегийн өмгөөлөл явуулж, олон нийтийн анхаарлыг хандуулан тэднээс дэмжлэг авснаар илүү амжилтад хүрэх боломжтойг ч энд үгүйсгэж болохгүй.

Бид бүхний үйл ажиллагаандаа дагаж мөрддөг Өмгөөллийн тухай хуулийн 4.1.5-д "иргэд, байгууллагын хүсэлтээр хууль тогтоомжид заасан хууль зүйн туслалцаа үзүүлнэ" гэж, харин ЭБШХ-ийн 41.1-д "Өмгөөлөгч нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, хууль зүйн туслалцаа үзүүлэх үүрэгтэй" гэж тус тус заасан болохоос хууль зүйн туслалцааг зохих ёсоор үзүүлээгүй буюу "мэргэжлийн түвшинд" ажиллаж чадаагүй өмгөөлөгчид хүлээлгэх хариуцлагын талаар тухайлсан заалт байхгүй байна.

Энэ бол иргэдийн зүгээр нэг хууль зүйн туслалцаа авах эрхийг биш, харин Үндсэн хуулийн 55 дугаар зүйлд заасан хууль зүйн

"мэргэжлийн" туслалцаа авах эрхийг зөрчсөн явдал бөгөөд үүнийг хүмүүсийн ярьдгаар хуулийн цоорхой гэж үзэхээс өөр аргагүй бөгөөд зарим өмгөөлөгч нарын хайнга хариуцлагагүй ажиллагаанаас болж "нэг үхрийн эвэр доргивол мянган үхрийн эвэр доргино гэдгийн адилаар "өмгөөллийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэнэ" гэсэн Өмгөөллийн тухай хуулийн 16.1 дэх заалтад иргэд эргэлзэхэд хүрч болзошгүй юм.

Иймд дээрх логик тайлбарыг үндэслэн өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх нь зөвхөн "Монголын Өмгөөлөгчдийн холбоо" ТББ-ын гишүүнчлэлээс гадна өмгөөллийн үйл ажиллагааг "мэргэжлийн түвшинд" эрхлэх мэдлэг, ур чадвар эзэмшсэн, ёс зүйн хувьд төлөвшсөн эсэхээс шууд хамаарах ёстой.

Тусгай зөвшөөрөл аваагүй боловч Хууль зүйн ухааны доктор, профессор, гавьяат хуульч, насаараа хуульч мэргэжлээр нэр төртэй ажилласан шүүгч, прокурор зэрэг хүн дөнгөж тусгай зөвшөөрлөө авсан өмгөөлөгчөөс мэргэшил, ур чадварын хувьд дутна гэж үү? Нөгөө талаар Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т заасан "өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах" эрхтэй гэснийг зөвхөн монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авах боломжтой буюу үүрэгтэй гэж ойлгож болно гэж үү.

Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нарыг зөвхөн монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авах үүрэгтэй гэж хуульд заагаагүй тул тэдний зүгээс өмгөөлөгч

авахаас татгалзаж, өөрөө өөрийгөө өмгөөлөх чадвартай эсэхээ хэн нэгэнд батлах ямар ч шаардлагагүйгээр Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т заасны дагуу "өөрийгөө өмгөөлөх" эрхээ хэрэгжүүлэх, эсхүл Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 40 дүгээр зүйлд заасан өмгөөлөгч заавал оролцуулахаас бусад тохиолдолд өөрийгөө өмгөөлөхөөс бүрмөсөн татгалзах боломж хуулиар нээлттэй байгаа билээ.

Дээрх тайлбар нь гэмт хэрэгт холбогдсон этгээдийн эрхийг хангах талаар Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцийн заалтад нийцнэ гэж үзэж байна. Тухайлбал, Монгол улс 1968.1.5-нд гарын үсэг зурж, 1974.11.18-нд соёрхон баталсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 3 дугаар зүйлийн 14-т: "Хүн бүр өөрийг нь яллагдагчаар татсан аливаа эрүүгийн хэргийг хянан хэлэлцэхэд бүрэн тэгш эрхийн үндсэн дээр дараахь наад захын баталгаагаар хангагдах эрхтэй. Үүнд:

Д. өөрийгөө биечлэн өмгөөлөх буюу өөрийн сонгон авсан өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх; өмгөөлөгчгүй байгаа бол өмгөөлүүлэх эрхийнх нь тухай өөрт нь мэдэгдсэн байх; шүүн таслах ажлын эрх ашиг шаардаж байвал ямар ч тохиолдолд, өөрт нь томилсон өмгөөлөгчтэй байх, ийм аливаа тохиолдолд өмгөөлөгчийн хөлсийг төлөх хүрэлцээтэй мөнгө хөрөнгө байхгүй бол үнэ төлбөргүй үйлчлүүлэх;

мөн 1990 онд НҮБ-ийн Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ба эрх зүйн зөрчил үйлдэгсдэд хандах асуудлаар Кубын

Гавана хотноо хуралдсан 8 дугаар Их хурлаас баталсан "Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчмууд" гэсэн баримт бичигт байцаан шийтгэх ажиллагааны аль ч үе шатанд яллагдагч нь өөрийн эрх ашиг сонирхлыг хамгаалуулахаар ямар ч хуульчид хандах эрхтэй гэж зааснаас үзэхэд: Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т заасан "иргэн хуулийн туслалцаа авах эрхтэй" гэсэн заалт нь түүний бусдаас хууль зүйн туслалцаа авахаар хандах эрхэд хязгаарлалт тогтооход биш, харин холбогдох хууль хэрэгжүүлэх байгууллагуудын зүгээс хүндэтгэн үзэх шалтгаанаар өмгөөлөгчөө сонгон авах боломжгүй байгаа яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх "мэргэжлийн өмгөөлөгч"-өөр хангах үүргийг хүлээлгэхэд чиглэсэн заалт гэж дүгнэж болохоор байна.

Эндээс Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2, Өмгөөллийн тухай хуулийн 5.1, 16.1 дэх заалтуудыг үндэслэн тусгай зөвшөөрөл аваагүй хуульчийг Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгчөөр оролцохыг хууль хэрэгжүүлэгч нарын зүгээс хүлээн зөвшөөрөхгүй байгаа явдал нь нэг талаас монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн бус хуульчдыг өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх боломжийг хязгаарласан, нөгөө талаас өмгөөлөгчөө чөлөөтэй сонгох, хуулиар хориглоогүй бүхий л арга хэрэгслээр өөрийн эрх ашгийг хамгаалах буюу Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т заасан иргэдийн хууль туслалцаа авах эрхээ хэрэгжүүлэх боломжийг

хязгаарлаж байна гэж тайлбарлаж болно.

Түүнээс гадна зөвхөн Монголын Өмгөөлөгчдийн холбооны гишүүдэд өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх монополь эрх олгох нь хууль зүйн үйлчилгээ үзүүлэх салбарт зах зээлийн чөлөөт өрсөлдөөнийг сулруулах, түүний зүй ёсны хөгжилд саад учруулна гэж ч үзэж болно.

Тэгвэл хууль тогтоогчийн зүгээс эрүүгийн хэрэгт оролцдог өмгөөлөгчдийн мэргэжлээрээ ажилласан хугацаа, мэргэшсэн байдлыг харгалзан төрийн албан хаагчдын адилаар өмгөөлөгч нарт зэрэглэл тогтоох нь эргээд иргэдийн өмгөөлөгчөө чөлөөтэй сонгох эрхэд сөргөөр нөлөөлөх болно гэж үзвэл өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхэд хуулиар тогтоосон хязгааруудыг хүчингүй болгож, зөвхөн сонирхогч этгээд болох үйлчлүүлэгчийн хүсэл зоригийг харгалзан үздэг байж болох юм.

Иймд хууль тогтоогчийн зүгээс иргэдийн хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах эрхийг хангах гэсэн хүсэл зориг нь иргэдийн өмгөөлөгчөө чөлөөтэй сонгож, хууль зүйн туслалцаа авах гэсэн эрхэд саад учруулах ёсгүй гэж үзэж байна. Төрөөс иргэдийнхээ хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахын тулд мэргэжлийн шалгаруултанд тэнцэж, хуулиар тогтоосон тодорхой шалгууруудыг давсан иргэнд өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, өөрөөр хэлбэл эрх авсан өмгөөлөгч мэргэжлийн түвшинд үйл ажиллагаа явуулна гэдэгт итгэж болно гэсэн баталгааг төрөөс иргэддээ өгөх зүй ёсны шаардлагыг үгүйсгэх хэрэггүй. Монгол улсад мэргэжлийн

Өмгөөлөгчдийн байгууллага үүсч хөгжсөн 80 жилийн түүхэн хугацаанд, түүний гишүүн өмгөөлөгчид иргэддээ хууль зүйн туслалцаа үзүүлж, эрх ашгийг нь хамгаалах чиг үүргээ нэр төртэй хэрэгжүүлсээр ирсэн, цаашид ч хэрэгжүүлэх нь тодорхой. Гол нь хууль зүйн туслалцаа үзүүлэх салбарт чөлөөт өрсөлдөөн жам ёсоор хөгжиж буй нөхцөлд өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх субъектуудын хүрээг хязгаарлах нь өнөө цагийн шаардлагад хэр нийцэхийг эргэн харах хэрэгтэй болов уу. Дээр дурьдсан үзэл санааг иш үндэс болговол иргэн бүр, түүний дотор, эрх зүйч мэргэжил эзэмшээгүй, хуульчаар ажиллаж байгаагүй, өмгөөлөгчдийн холбооны гишүүн бус, түүнчлэн өөр улсын иргэн болон иргэний харьяалалгүй этгээд хэн ч болов өөрт нь хандаж тусламж хүссэн этгээдийг өмгөөлөх талаар ижил тэгш эрхтэй байх ёстой.

Харин Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн ы 40 дүгээр зүйлд заасан өмгөөлөгч заавал оролцох дараахь тохиолдолд Үүнд: сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нар нь төлбөрийн чадваргүй, хэлгүй, дүлий, хараагүй зэрэг эрхтэн дутуу буюу сэтгэцийн өвчний улмаас өөрийгөө өмгөөлөх болон өмгөөлүүлэх эрхээ эдэлж чадахгүй, насанд хүрээгүй, монгол хэл, бичиг мэддэггүй бол гэхдээ эрх ашиг нь хөндөгдсөн тухайн иргэн өмгөөлүүлэх эрхээ хэрэгжүүлж чадахгүй, эсхүл хэрэгжүүлэхийг хүсэхгүй байгаа бол төрөөс түүнд өмгөөлөгч томилж, хууль зүйн туслалцааг "мэргэжлийн" түвшинд үзүүлэх үүргээ биелүүлэх учиртай гэж үзэж байна. Энэ нь Монгол

улсын хүний эрхийн талаар нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцийн заалтуудад нийцэх болно.

Дээр хөндөгдсөн өмгөөлүүлэх эрхийн талаарх асуудал бол шүүн таслах ажиллагаанд нэг мөр ойлгож, шийдвэрлэх шаардлагатай, Үндсэн хуульд заасан хүний эрхтэй холбоотой чухал асуудал тул Ардчилсан төрийн үндсэн зарчим, Үндсэн хуулийн хуулийн үзэл санаанд тулгуурлан цаг алдахгүй нэг тийш шийдвэрлэх хэрэгтэй гэж үзэж байна.

Монгол улсад эрх зүйт төр төлөвшиж хөгжихийн хэрээр хуульчдын нийгэмд гүйцэтгэх үүрэг, хариуцлагаулам нэмэгдэж, тэдэнд олон нийтийн зүгээс тавих шаардлага эрс өндөрсөж байна. Иймд Монголын Өмгөөлөгчдийн холбоо үйл ажиллагаагаа улам эрчимжүүлж, олон нийтэд нээлттэй ажиллаж, өндөр мэдлэг, туршлага, ур чадвартай, ёс зүйн эрхэм дээд чанарыг эзэмшсэн хуульчдаар эгнээгээ улам зузаатгах, нөгөө талаар өмгөөлөгч бүхэн холбооныхоо үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, эрхэлсэн ажлаа нэр төртэй, хариуцлагатай, мэргэжлийн өндөр түвшинд хашиж, нийгэмд шудрага ёсыг тогтоох чиг үүргээ амжилттай хэрэгжүүлэн, өөрсдийн үйл ажиллагаагаар хуулийг сахин биелүүлэхийн үлгэр дууриаллыг үзүүлж, олон нийтийн итгэлийг бүрэн дүүрэн хүлээсэн, тэдний эрэлт хэрэгцээг хэзээ ч хангах байнгын итгэлтэй үйлчлэгч нь байхыг хүсч байна.

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2008 оны 11 дүгээр
сарын 25-ны өдөр

Дугаар 45

Улаанбаатар
хот

**ЭД ХӨРӨНГӨ ӨМЧЛӨХ ЭРХ, ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ ЭД ХӨРӨНГИЙН БУСАД
ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ХЭСЭГ,
ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ**

Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг нэг мөр ойлгох, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5.-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс **ТОГТООХ НЬ:**

1.Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн (цаашид хууль гэх) 3 дугаар зүйлийн зарим зохицуулалтыг доорх байдлаар тайлбарласугай.

1.1.Энэ зүйлийн 3.2.-т заасан өмчлөх эрхтэй холбоотой бусад эрхийн бүртгэл нь тухайн үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх мөн зүйлийн 3.1.-д зааснаар улсын бүртгэлд бүртгэгдсэн тохиолдолд хийгдэнэ.

1.2.Мөн зүйлийн 3.3.-т заасан зохицуулалт Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 13, 15 дугаар зүйлд заасан төрийн байгууллага, албан газраас гадна төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн

газарт хамаарна.

1.3.Энэ зүйлийн 3.4.-т заасан "төрийн өөрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгө" гэдэгт Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1. дэх хэсэг, 16, 21, 74, 79 дүгээр зүйлүүдэд заасан аж ахуйн тооцоотой төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын үл хөдлөх эд хөрөнгө, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрд ногдох хувь хөрөнгөд хамаарах үл хөдлөх эд хөрөнгө гэж ойлгоно.

Мөн хэсэгт заасан **"төрийн өмчийн асуудал эрхэлсэн байгууллагын албан ёсны тодорхойлолт"**-д Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11, 78 дугаар зүйлд заасан төрийн болон орон нутгийн өмчийн асуудал эрхэлсэн байгууллагаас хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.-т зааснаар гаргаж өгсөн тодорхойлолт хамаарна.

1.4.Мөн зүйлийн 3.5.-д заасан "Иргэн Газрын тухай хуулийн 52.7-д заасны дагуу эзэмшиж байгаа газар дээрээ өөрийн хөрөнгөөр барьж байгуулсан барилга байгууламж, өвөлжөө, хаваржааны хашааг өмчлөх эрх, түүнтэй холбоотой энэ хуулийн

3.2.1-3.2.4-т заасан эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлж болно" гэснийг энэ зүйлийн 3.7., Иргэний хуулийн 182 дугаар зүйлийн 182.2.-т заасан үндэслэлээр бүртгүүлэх эсэхийг тухайн эд хөрөнгийг өмчлөгч өөрөө, барьцаа, түрээс, узуфрукт, сервитутын гэрээний талууд харилцан тохиролцож болно гэж ойлгоно.

2.Хуулийн 4 дүгээр зүйлийн зохицуулалтыг доорх байдлаар тайлбарласугай.

2.1.Иргэний 1994 оны хуулийн 122 дугаар зүйлийн 2, Иргэний 2002 оны хуулийн 110 дугаар зүйлийн 110.1.-д зааснаар үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх уг эрхийг улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсдэг тул хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.-д заасан "өмчлөгч нь үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхээ энэ хуульд заасны дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгүүлж гэрчилгээ авснаар түүний өмчлөх эрх баталгаажна" гэснийг Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн тухай 1997 оны хуулийг дагаж мөрдөгдөхөөс өмнө буюу 1997 оны 05 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө үүссэн үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхэд хамааруулж, уг эрхийг Үл хөдлөх эд хөрөнгийн улсын

бүртгэлийн тухай хуулиар улсын бүртгэлд бүртгүүлээгүй бол энэ хуулийн дагуу бүртгүүлснээр бүртгэлээс өмнө үүссэн өмчлөх эрх баталгаажна гэж ойлгоно.

2.2.Энэ зүйлийн 4.2.-т заасан “Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх хэлцлийн үндсэн дээр нэг этгээдээс нөгөөд шилжиж байгаа бол уг өөрчлөлтийг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлснээр өмчлөх эрх шинэ өмчлөгчид шилжиж, өмнөх өмчлөгчийн өмчлөх эрх дуусгавар болно” гэдгийг үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх шилжүүлэх тухай хэлцлийг бүртгүүлснээр өмчлөх эрх үүсэх, дуусгавар болохыг зохицуулсан Иргэний хуулийн 110 дугаар зүйлийн 110.1. дэх хэсэгтэй холбон үзэж, улсын бүртгэлд шинэ болон хуучин өмчлөгчийн үүссэн буюу дуусгавар болсон өмчлөх эрхээс гадна, энэ эрхийг шилжүүлэх үндэслэл болсон хэлцлийг мөн бүртгүүлнэ гэж ойлговол зохино.

2.3.Мөн зүйлийн 4.3.-т “үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхтэй холбоотой, энэ хуулийн 3.2-т заасан эрх нь эрхийн улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөрт тооцогдоно” гэж заасан нь Иргэний хуулийн 150, 151, 152, 156, 166, 318 дугаар зүйлүүдтэй уялдаа холбоотой тул эдгээр зүйлд үл хөдлөх эд хөрөнгө эзэмших, ашиглах эрхийг шилжүүлсэн гэрээ улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болохоор зохицуулсан бол энэ зүйлд заасан эрх гэрээний

хамт хүчин төгөлдөр болно.

3.Эрхийн улсын бүртгэлийн талаарх мэдээлэл нээлттэй байх тухай хуулийн 6 дугаар зүйлийн зарим заалтыг доорх байдлаар тайлбарласугай.

3.1.Энэ зүйлийн 6.1.-д заасан “**нээлттэй байх**” гэдэг нь мөн зүйлийн 6.2.- 6.6., 7 дугаар зүйлийн 7.8., 37 дугаар зүйлд заасан үндэслэл, журмын дагуу мэдээлэл өгөх ажиллагаагаар хэрэгжих бөгөөд улсын бүртгэлд бүртгэгдсэн өмчлөх болон түүнтэй холбоотой бусад эрхийн талаар хэзээ, хэн, ямар мэдээлэл авсан талаар өмчлөгчид өөрт нь мэдээлэл өгөхийг мөн адил хамааруулна.

3.2.Мөн зүйлийн 6.4-т зааснаар “**өмчлөгчийн овог, эцэг/эх/-ийн нэр, нэр, оршин суугаа газар, өмчлөгч нь хуулийн этгээд бол түүний нэр, оршин байгаа газар**” зэрэг нь зөвхөн тухайн үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотойгоор бусдад өгөх мэдээлэлд тусгагдана. Харин үл хөдлөх тодорхой эд хөрөнгөтэй холбоогүйгээр зөвхөн өмчлөгч этгээдийн талаар мэдээлэл авах зорилгоор түүний өмчлөлийн эд хөрөнгийг сонирхсон явдал нь “**нээлттэй байх**” гэдэгт хамаарахгүй.

4.Хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.-д заасан “**эрхийн улсын бүртгэл үнэн зөв байх**” нь бүртгэлийн хувийн хэрэгт тусгагдсан бүх мэдээлэлд хамааралтай бөгөөд үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн шилжилт, хөдөлгөөнийг хувийн хэрэгт

нь бичиж, хувийн дугаар бүхий тэмдгээ дарж, гарын үсэг зурж баталгаажуулсан улсын бүртгэгчийн ажиллагаа үнэн зөв байдлын баталгаа болно.

5.Хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1.-д заасан эрхийн улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь “**хянан үзэх, эрх зүйн дүгнэлт өгөх**” чиг үүргийг хэрэгжүүлэхдээ мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.4.- т заасан эрхийн дагуу үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх болон түүнтэй холбоотой бусад эрхийг улсын бүртгэлд бүртгэсэн, бүртгэхээс татгалзсан, эсхүл мэдүүлгийг хүлээн авахаас татгалзсан нь хуульд заасан үндэслэл, журамд нийцэж байгаа эсэхийг нягтлан шалгаж, дүгнэсний эцэст энэ тухай шийдвэр гаргана.

6.Хуулийн 12 дугаар зүйлийн 12.7.-д заасан “**Улсын ерөнхий бүртгэгчийн шийдвэр**” гэдгийг энэ хуулийн 7 дугаар зүйлийн 7.3., 7.5., 12 дугаар зүйлийн 12.6.-д заасны дагуу Эрхийн улсын бүртгэлтэй холбогдох асуудлаар улсын ерөнхий бүртгэгчийн гаргасан захиргааны акт гэж ойлгоно.

7.Хуулийн 13 дугаар зүйлийн 13.5.1.-д заасан “**үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөх эрхтэйг нотолсон баримт бичиг**” гэдэгт энэ зүйлийн 13.5.2.-13.5.5.- д заасан баримтуудаас гадна тухайн этгээд уг үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөх

эрхтэй болохыг нотолсон бусад баримтуудыг мөн хамааруулна.

8.Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1.-д заасан **“баттай нотлох баримт байхгүй”** гэж өмчлөх эрхийг бүртгүүлэхээр бүртгэлийн байгууллагад хандсан мэдүүлэг гаргаж, уг үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч мөн болохоо батлах энэ хуульд заасан баримтуудыг мэдүүлэгт хавсаргаагүй байхыг хэлнэ.

9.Хуулийн 15 дугаар зүйлийн зарим заалтыг доорх байдлаар тайлбарласугай.

9.1.Мэдүүлэг болон түүнд хавсаргасан баримтыг хүлээн авсны дараа хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.-д заасан мэдүүлгийг хүлээн авахаас татгалзах үндэслэлүүдийн аль нэг илэрвэл бүртгэлийн байгууллага энэ зүйлийн 15.4.-т заасны дагуу бүртгэхээс татгалзана.

Энэ хэсэгт заасан **“тайлбар”** гэдгийг үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн бүртгэл хийхээс татгалзсан үндэслэлийг заасан улсын бүртгэгчийн бичгийн шийдвэр гэж ойлгоно.

9.2.Мөн зүйлийн 15.5.-д заасан захиргааны журмаар урьдчилан шийдвэрлүүлэх журмыг зөвхөн үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан улсын бүртгэгчийн шийдвэрт хамааруулан хэрэглэнэ.

Энэ хуульд заасан улсын бүртгэлтэй холбогдсон маргааныг шүүх хянан шийдвэрлэхдээ улсын

бүртгэл, түүнийг үндэслэн олгосон Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээний асуудлыг хамт шийдвэрлэж байвал зохино.

10.Хуулийн 18 дугаар зүйлийн 18.5.-д **“бүртгэлийн гэрчилгээ нэгдмэл дугаартай байна”** гэж заасны дагуу мөн хэсгийн **“мэдүүлэг гаргасан огноо”** гэдгийг эрхийн улсын бүртгэлийн дугаарыг мэдүүлэг хүлээн авсан өдрөөр буюу энэ хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.-т заасан журмын адил мэдүүлэг хүлээн авсан өдөр гэж ойлгоно.

Харин шүүх, арбитрын шийдвэрийн үндсэн дээр өмчлөгч өөрчлөгдөж байгаа тохиолдолд улсын бүртгэл, гэрчилгээний нэгдмэл дугаарын зарчим үйлчлэх боловч улсын бүртгэлд бүртгүүлэх мэдүүлгийг хэзээ гаргаж, бүртгэлийн байгууллага хүлээн авснаас үл хамааран мэдүүлэг гаргасан огноог хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.-д зааснаар шүүх, арбитрын шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөр тогтооно.

11.Хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.-д заасан **“зайлшгүй шаардлагатай мэдээлэл”** гэдэгт мөнхуулийн 17 дугаар зүйлийн 17.1.-д заасан зүйлүүд хамаарна.

Дээрх мэдээлэл шүүх, арбитрын шийдвэрт тусгагдаагүй хэдий ч тэдгээрийг мэдүүлэг гаргагчаас олж авах боломжгүй, эсхүлтүүний өгсөн мэдээлэл үндэслэл бүхий

эргэлзээ төрүүлж байвал энэ байдлыг тодруулах талаар **“хүсэлт”**-ийг ерөнхий бүртгэгч нь шүүх, арбитрын байгууллагад хандан гаргана.

Шүүх, арбитр нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд холбогдох хуульд заасан журмын дагуу хүсэлтэд хариу өгнө.

12.Хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.-д заасан эрхийн бүртгэлд шаардлагатай мэдээлэл тухайн гэрээнд бүрэн тусгагдсан эсэх, хуульд зааснаар гэрээ нотариатаар гэрчлэгдсэн эсэх нь мөн зүйлийн 26.2.-т заасан **“хууль тогтоомжийн шаардлагыг хангаж байвал”** гэсэн ойлголтод хамаарна.

13.Хуулийн 27 дугаар зүйлийн 27.2., 27.3.-т тус тус заасан тэмдэглэл, нэмэлт тэмдэглэл зэрэг ажиллагааг энэ хуульд заасан журмын дагуу гаргасан мэдүүлэгт үндэслэнэ.

14.Хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.-д заасан **“хуульд өөрөөр заагаагүй бол”** гэдэгт Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.-д заасан журам хамаарна.

ТАНХИМЫН ТЭРГҮҮН
Д.БАТСАЙХАН
ШҮҮГЧ

Б.УНДРАХ
П.ЦЭЦГЭЭ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2008 оны 11 дүгээр
сарын 25-ны өдөр

Дугаар 47

Улаанбаатар
хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛСАН ХУУЛИУДЫН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Нийгмийн даатгалын харилцааг зохицуулсан хуулиудын зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс **ТОГТООХ НЬ:**

Нэг. Нийгмийн даатгалын тухай хууль

1.1.Нийгмийн даатгалын тухай /цаашид хууль гэх/ хуулийн 4 дүгээр зүйлийн 3-т заасан **“тодорхой хөдөлмөр эрхлээгүй”** гэдэгт ажил, хөдөлмөр огт эрхлээгүйгээс гадна энэ зүйлийн 2-т зааснаас бусад хэлбэрээр хөдөлмөр эрхэлж байгаа хүнийг хамааруулан ойлгоно.

1.2.Хуулийн 6 дугаар зүйлийн 2-т заасан **“ажил олгогчийн буруугаас нийгмийн даатгалын шимтгэл төлөгдөөгүй”** гэж нийгмийн даатгалын шимтгэлийг тооцох, нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлэх ажиллагааг ажил олгогч энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан хэмжээ, хугацаа, 16 дугаар зүйлд заасан журмын дагуу явуулаагүй, эсхүл зөрчиж явуулсныг хэлнэ.

Энэ зүйл, хэсэгт заасан **“даатгуулагчид учирсан**

хохирол” гэдгийг ажил олгогчийн дээрх буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан даатгуулагч болон түүний гэр бүлийн гишүүд нийгмийн даатгалын харилцааг зохицуулсан хуулиудын дагуу олгогдвол зохих тэтгэвэр, тэтгэмжийг авч чадахгүй болох, эсхүл хугацаа нь хойшлогдох, тогтоогдвол зохих тэтгэвэр бага хэмжээгээр тогтоогдох, зөрчигдсөн эрхээс сэргээлгэхийн тулд тодорхой зардал гаргах зэргээр нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах эрх нь зөрчигдсөнөөс даатгуулагчид учирсан эдийн хохирлыг ойлгоно.

Мөн зүйл, хэсэгт заасан **“ажил олгогч бүрэн хариуцна”** гэж ажил олгогчийн буруутай ажиллагаанаас шалтгаалан даатгуулагч болон түүний гэр бүлийн гишүүдэд нийгмийн даатгалын харилцааг зохицуулсан хуулиудын дагуу тэтгэвэр, тэтгэмж олгогдох үндэслэлгүй болсон бол олгогдвол зохих тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээгээр, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ багассан, олгогдох хугацаа хойшлогдсон бол зөрүүлгээр, хохирсон этгээдээс гарсан нэмэгдэл зардлын хэмжээгээр ажил олгогч Иргэний хуулийн гэм хор учруулснаас үүсэх үүргийн холбогдох зохицуулалтаар эд хөрөнгийн хариуцлага хүлээхийг хэлнэ.

1.3.Ажил олгогч, даатгуулагчийн төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгө нь хуулийн 3 дугаар зүйлийн 2-т заасан нийгмийн даатгалын төрөл тус бүрээр бие даасан санг бүрдүүлдэг тул мөн хуулийн 9 дүгээр зүйлд заасан сангийн төрөл тус бүрийг хуулийн 7 дугаар зүйлд заасан **“нэг төрлийн сан”** гэж үзнэ.

Хуулийн 7 дугаар зүйлд заасан **“нэг төрлийн сангаас тэтгэвэр буюу тэтгэмжийг давхардуулан олгохгүй”** гэдгийг даатгуулагчид мөн хуулийн 9 дүгээр зүйлд заасан нэг төрлийн санд хамаарагдах хэд хэдэн тэтгэвэр, тэтгэмжийг авах эрх үүссэн хэдий ч түүнд тэтгэврийн даатгалын сангаас хоёрбатүүнээс дээш тэтгэврийг, тэтгэмжийн даатгалын сангаас цаг хугацааны хувьд нэг дор хоёр ба түүнээс дээш тэтгэмжийг, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмжийг нэг зэрэг, хоёр ба түүнээс дээш тэтгэврийг, эсхүл хоёр ба түүнээс дээш тэтгэмжийг цаг хугацааны хувьд нэг дор олгож болохгүй гэж ойлгоно.

Харин эрүүл мэндийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж олгогддоггүй, ажилгүйдлийн даатгалын сангаас зөвхөн нэг төрлийн тэтгэмж олгогдог тул эдгээр

Нийгмийн даатгалын харилцааг зохицуулсан хуулиудын зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тогтоогдох зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс **ТОГТООХ НЬ:**

Нэг. Нийгмийн даатгалын тухай хууль

1.1.Нийгмийн даатгалын тухай /цаашид хууль гэх/ хуулийн 4 дүгээр зүйлийн 3-т заасан **“тодорхой хөдөлмөр эрхлээгүй”** гэдэгт ажил, хөдөлмөр огт эрхлээгүйгээс гадна энэ зүйлийн 2-т зааснаас бусад хэлбэрээр хөдөлмөр эрхэлж байгаа хүнийг хамааруулан ойлгоно.

1.2.Хуулийн 6 дугаар зүйлийн 2-т заасан **“ажил олгогчийн буруугаас нийгмийн даатгалын шимтгэл төлөгдөөгүй”** гэж нийгмийн даатгалын шимтгэлийг тооцох, нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлэх ажиллагааг ажил олгогч энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан хэмжээ, хугацаа, 16 дугаар зүйлд заасан журмын дагуу явуулаагүй, эсхүл зөрчиж явуулсныг хэлнэ.

Энэ зүйл, хэсэгт заасан **“даатгуулагчид учирсан хохирол”** гэдгийг ажил олгогчийн дээрх буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан даатгуулагч болон түүний гэр бүлийн гишүүд нийгмийн даатгалын харилцааг зохицуулсан хуулиудын дагуу олгогдвол зохих тэтгэвэр, тэтгэмжийг авч чадахгүй болох, эсхүл хугацаа нь хойшлогдох, тогтоогдвол зохих тэтгэвэр бага хэмжээгээр тогтоогдох, зөрчигдсөн эрхээ сэргээлгэхийн тулд тодорхой зардал гаргах зэргээр нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах эрх нь зөрчигдсөнөөс

даатгуулагчид учирсан эдийн хохирлыг ойлгоно.

Мөн зүйл, хэсэгт заасан **“ажил олгогч бүрэн хариуцна”** гэж ажил олгогчийн буруутай ажиллагаанаас шалтгаалан даатгуулагч болон түүний гэр бүлийн гишүүдэд нийгмийн даатгалын харилцааг зохицуулсан хуулиудын дагуу тэтгэвэр, тэтгэмж олгогдох үндэслэлгүй болсон бол олгогдвол зохих тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээгээр, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ багассан, олгогдох хугацаа хойшлогдсон бол зөрүүгээр, хохирсон этгээдээс гарсан нэмэгдэл зардлын хэмжээгээр ажил олгогч Иргэний хуулийн гэм хор учруулснаас үүсэх үүргийн холбогдох зохицуулалтаар эд хөрөнгийн хариуцлага хүлээхийг хэлнэ.

1.3.Ажил олгогч, даатгуулагчийн төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгө нь хуулийн 3 дугаар зүйлийн 2-т заасан нийгмийн даатгалын төрөл тус бүрээр бие даасан санг бүрдүүлдэг тул мөн хуулийн 9 дүгээр зүйлд заасан сангийн төрөл тус бүрийг хуулийн 7 дугаар зүйлд заасан **“нэг төрлийн сан”** гэж үзнэ.

Хуулийн 7 дугаар зүйлд заасан **“нэг төрлийн сангаас тэтгэвэр буюу тэтгэмжийг давхардуулан олгохгүй”** гэдгийг даатгуулагчид мөн хуулийн 9 дүгээр зүйлд заасан нэг төрлийн санд хамаарагдах хэд хэдэн тэтгэвэр, тэтгэмжийг авах эрх үүссэн хэдий ч түүнд тэтгэврийн даатгалын сангаас хоёрбатүүнээс дээш тэтгэврийг, тэтгэмжийн даатгалын сангаас цаг хугацааны хувьд нэг дор хоёр ба түүнээс дээш тэтгэмжийг, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмжийг нэг зэрэг, хоёр ба түүнээс дээш тэтгэврийг, эсхүл хоёр ба түүнээс дээш тэтгэмжийг цаг

хугацааны хувьд нэг дор олгож болохгүй гэж ойлгоно.

Харин эрүүл мэндийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж олгогддоггүй, ажилгүйдлийн даатгалын сангаас зөвхөн нэг төрлийн тэтгэмж олгогдог тул эдгээр сангуудаас олгогддог тусламж, үйлчилгээ, тэтгэмжид энэ зүйлийн зохицуулалт хамаарахгүй.

Түүнчлэн, тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалын сангуудаас олгогдох тахир дутуугийн хийгээд тэжээгчээ алдсан тэтгэврүүд, хөдөлмөрийн чадвар түр алдсан тэтгэмж нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалан өвчний даатгалын сангаас олгогддог адил төрлийн тэтгэвэр, тэтгэмжээс шалтгаан ялгаатай нөхцөлтэй тул өөр төрлийн санд хамаарч байгаа хэдий ч тэдгээрийг давхардуулан олгохгүй.

Тэтгэмжийн даатгалын сангаас олгогддог оршуулгын тэтгэмж нь эдгээр сангуудаас олгогддог бусад тэтгэмжтэй цаг хугацааны хувьд давхцах боломжгүй тул давхардуулан олгогдох үндэслэлгүй болно.

Мөн зүйлд заасан **“даатгуулагч илүү таатай нөхцөлтэй тэтгэвэр буюу тэтгэмжийг ... сонгон авах эрхтэй”** гэдэгт даатгуулагч нэг төрлийн сангаас хэд хэдэн тэтгэвэр, эсхүл тэтгэмж авах үндэслэл үүсвэл хэмжээ, нөхцөл, эрх зүйн үр дагавар зэрэг нөхцлөөр өөрт ашигтай гэж үзсэн тэтгэвэр, тэтгэмжийн төрлийг сонгохыг хэлнэ.

Уг сонголтыг **“зөвхөн нэг удаа”** хийнэ гэдэг нь тухайн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ, нөхцөл, эрх зүйн үр дагавар өөрчлөгдөөгүй байхад өөрийн хүсэлтээр урьд хийсэн сонголтоо даатгуулагч өөрчлөх эрхгүй байхыг хэлэх бөгөөд энэ нь тодорхой цаг хугацааны дараа даатгуулагчаас шалтгаалахгүй үндэслэлээр нөхцөл байдал өөрчлөгдсөн

тохиолдолд сонголт хийх даатгуулагчийн эрхийг хязгаарлахгүй.

Түүнчлэн, даатгалын өөр төрлийн сангаас адил төрлийн тэтгэвэр, тэтгэмж авах үндэслэл зэрэг бүрдсэн нөхцөлд даатгуулагч сонголт хийхэд энэ зохицуулалт мөн үйлчилнэ.

1.4.Хуулийн 8 дугаар зүйлийн 2-т "өргөдөл шийдвэрлэх хугацааг хуулиар тогтооно" гэж зааснаар тухайн асуудлыг шийдвэрлэх хугацааг хуулиар тусгайлан тогтоогоогүй бол Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан хугацааг баримтална.

1.5.Хуулийн 11 дүгээр зүйлийг дараах байдлаар тайлбарласугай.

1.5.1.Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасан "нийгмийн даатгалын байгууллага, үндэсний болон салбар зөвлөлийн үйл ажиллагааны зардал" гэдэгт зөвхөн нийгмийн даатгалын чиглэлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зардал хамаарах бөгөөд үүнийг эдгээр байгууллагын үйл ажиллагааны зардлаас бусад нийгмийн даатгалын сангийн хөрөнгөнөөс санхүүжүүлэхгүй гэж ойлгоно.

1.5.2.Мөн зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасан "хууль тогтоомжид заасан бусад төлбөр, зардал" гэдэгт зөвхөн энэ хууль болон нийгмийн даатгалын харилцааг зохицуулсан бусад хуулиудад заасан төлбөр, зардлыг хамааруулна.

1.5.3.Энэ зүйлийн 2-т заасан "хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг сан хооронд шилжүүлэн зарцуулах, зориулалтын бус чиглэлээр ашиглах, байршуулахыг хориглоно" гэдгийг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1-д зааснаар Улсын Их Хурлын бүрэн эрхийн хүрээнд гаргасан

хуулийн зохицуулалтаар тухайн заалтыг

өөрчлөхөөс өөр байдлаар нийгмийн даатгалын төрөл бүрд байрших мөнгөн хөрөнгийг сан хооронд шилжүүлэх, ашиглах, захиран зарцуулж болохгүй гэж ойлгоно.

1.5.4.Мөн зүйлийн 3-т заасан "Хуримтлалын сангийн хөрөнгийг Засгийн газрын бонд болон Монголбанкнаас гаргасан үнэт цаас худалдан авах, арилжааны банкинд байршуулах"-аас өөр хэлбэрээр буюу хуульд заагаагүй бусад байдлаар ашиглах, байршуулж болохгүй.

1.6.Хуулийн 15 дугаар зүйлийн 5-д зааснаар ажил олгогч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын шимтгэлийг төлсөн явдал нь Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.-д заасан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний хохирлыг нөхөн төлөх үүргээс чөлөөлөгдөх, мөн түүний төлөх шимтгэлийн хэмжээ ялгавартай тогтоогдсон нь дээрх нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлох үндэслэл тус тус болохгүйг анхаарвал зохино.

1.7.Хуулийн 16 дугаар зүйлийн 1-д заасан "...хөдөлмөрийн хөлс" гэдэгт төрийн албан хаагчийн хувьд төрийн албан тушаалыг эрхэлж, бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т зааснаар төрөөс олгож буй цалин хөлсийг ойлгоно.

Харин хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ажилтанд ажил олгогчоос олгож буй "хөдөлмөрийн хөлс" гэдэгт үндсэн цалин, ажлын үр дүнгээр олгосон нэмэгдэл хөлс, ажилтан үндсэн ажлынхаа зэрэгцээ мэргэжил, ажил, албан тушаал хавсран буюу хослон ажилласан, эзгүй байгаа ажилтны үүргийг орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил үүргийг биелүүлсэн,

шөнийн болон илүү цагаар ажилласан тохиолдолд үндсэн цалингаас нь тооцож олгосон нэмэгдэл хөлснөөс гадна мэргэжлийн зэргийн, хөдөлмөрийн нөхцлийн хийгээд бусад нэмэгдэл хамаарна.

1.8.Мөн зүйл, хэсэгт заасан "...хөдөлмөрийн хөлстэй адилтгах орлого" гэж цалин хөлснөөс гадна Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлд тодорхойлсноор ажил олгогчоос олгож байгаа байнгын шинжтэй орлогыг хэлнэ.

1.9.Ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогод ногдох шимтгэлийг төлөх үүргээ шимтгэл ногдох орлогоо нуух хэлбэрээр гүйцэтгээгүй, эсхүл бууруулах хэлбэрээр зохих ёсоор гүйцэтгээгүй тохиолдолд хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д "орлоготой тэнцэх хэмжээний алданги ногдуулна" гэснийг Иргэний хуулийн 232 дугаар зүйлийн 232.5-д заасан анзынагуулаар нуусан буюу бууруулсан орлогод ногдох шимтгэлтэй тэнцэх хэмжээний торгууль ногдуулна гэж ойлгоно.

1.10.Нийгмийн даатгалын тухай хуулийн 25 дугаар зүйлийг дараах байдлаар тайлбарласугай.

1.10.1.Хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасан "тогтоосон хугацаанд шимтгэл төлөөгүй ажил олгогчийн банкин дахь харилцах дансны зарлагын гүйлгээг шимтгэлээ төлж дуустал түр зогсоох" ажиллагаа нийгмийн даатгалын байгууллагын бүрэн эрхэд хамааралтай тул уг байгууллагын дарга, эсхүл эрх олгогдсон этгээдээс ирүүлсэн дансны зарлагын гүйлгээг зогсоох тухай мэдэгдлийг банк болон банк бус санхүүгийн байгууллага заавал биелүүлнэ.

1.10.2.Мөн зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасан "зохих хууль тогтоомжийн дагуу гаргуулах" гэж хуулийн 26

дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4-т зааснаар үл маргах журмаар буюу шүүхийн бус журмаар төлбөр төлөгчийн харилцах данс, хөрөнгөөс төлбөрийг шууд гаргуулахыг хэлнэ.

1.11. Хуулийн 26¹ дүгээр зүйлийн 1-д заасан “албан үүргээ гүйцэтгэх явцад” гэснийг ажлын байрандаа болон ажил үүргээ бусад газарт гүйцэтгэх явцад, түүнчлэн ажилдаа ирэх, буцах замд гэж ойлгоно.

1.12. Хуулийн 27 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2-т заасан “даатгуулагчийн төлөөлж нийт ажилтны дийлэнх олонхийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалсан үйлдвэрчний эвлэлийг төлөөлсөн 3 хүн” гэдгийг үйлдвэрчний эвлэлийн байгууллага нь нийт ажилтны дийлэнх олонхийн ашиг сонирхлыг хамгаалдаг байгууллага тул үйлдвэрчний эвлэлийг төлөөлөх 3 гишүүн нь даатгуулагчийн төлөөллөөр Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлд орно гэж ойлговол зохино.

Хоёр. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль

2.1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай/цаашидхууль гэх/ хуулийн 3 дугаар зүйлийн 2-т заасан “тэтгэврийн болон тэтгэмжийн шимтгэлийг ажил олгогчоос болон даатгуулагч өөрөө төлсөн нийт хугацаа”-нд БНМАУ-ын Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хуулийг дагаж мөрдсөн 1991 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг хамааруулана.

Мөн зүйл, хэсэгт заасан “шимтгэл төлсөн хугацаанд оруулан тооцохоор хуульд заасан бусад хугацаа” гэдэгт энэ зүйлийн 3 дахь хэсэг, Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын

тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хугацааг тус тус хамааруулан ойлгоно.

2.2. Хуулийн 5 дугаар зүйлийн 3-т заасан “Тахир дутуугийн тэтгэвэр авч байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон даатгуулагчийн тэтгэврийг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан жил тутамд нь 1 хувиар бодож нэмэгдүүлнэ” гэдгийг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсаны улмаас тахир дутуугийн тэтгэвэр авагч иргэн тэтгэвэр тогтоолгосноос хойш шимтгэл төлж ажилласан эсэхээс үл хамааран нэмэгдлийг авна гэж ойлгоно.

Харин тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20 жилээс илүү төлж, мөн зүйлийн 2-т заасан өндөр насны тэтгэвэр тогтоолгон, хөдөлмөрийн хөлсний 1.5 хувиар нэмэгдэл авч буй даатгуулагчид тахир дутуугийн тэтгэврийн нэмэгдлийг давхардуулан олгохгүй.

2.3. Хуулийн 6, 10, 15 дугаар зүйлд тус тус заасан “нас барсны дараагийн сар дуустал олгоно” гэдгийг нас барсан сарын тэтгэврээ тэтгэвэр авагч аваагүй байсан тохиолдолд тухайн сарын тэтгэврийг дараагийн сарын тэтгэврийн хамт, харин тэтгэврээ авсан бол дараа сарын тэтгэвэр л тус тус олгогдоно гэж ойлгоно.

2.4. Хуулийн 11 дүгээр зүйлийн 2-т заасан “даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээгдэхгүй болсныг” Нийгмийн даатгалын тухай хуулийн 28, 29 дүгээр зүйлүүдэд заасны дагуу Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын магадлагаагаар тогтооно.

2.5. Хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан “сургуульд суралцаж байгаа бол” гэж Боловсролын тухай хуульд заасан бага, дунд, дээд боловсрол олгох, боловсролын нэг буюу хэд хэдэн түвшний боловсролын агуулгыг хэрэгжүүлдэг сургалтын байгууллагад өдрийн, оройн, эчнээ, екстернат

хэлбэрээр албан болон албан бус сургалтад хамрагдаж байгааг хэлнэ.

2.6. Хуулийн 24 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 1-д заасан “хүндэтгэх шалтгаан” гэдгийг Хөдөлмөрийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай Монгол Улсын Дээд шүүхийн 2006 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 33 дугаар тогтоолын 28-д заасантай адил ойлгож хэрэглэнэ.

2.7. Хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасан “ажил, хөдөлмөр эрхэлж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн тэтгэвэр авагч” гэдэгт Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 6-д зааснаар ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээгээр, эсхүл Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасны дагуу иргэнтэй байгуулсан гэрээний дагуу ажиллаж байгаа, Нийгмийн даатгалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 5-д зааснаас бусад төрлийн даатгалд даатгуулсан тэтгэвэр авагчийг хамааруулна.

Мөн зүйлийн 4-т заасан “тэтгэврийн хэмжээг анхны тэтгэвэр тогтоолгосон дундаж цалингаас бодож өөрчлөн тогтооно” гэснийг тэтгэвэр авагчийн тэтгэвэр тогтоолгосноос хойш хугацаанд Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 6-д зааснаар ажиллаж авсан цалингийн болон төлсөн шимтгэлийн хэмжээнээс үл хамааран тэтгэврийн хэмжээг анхны тэтгэвэр тогтоолгосон дундаж цалингаас тооцож өөрчлөн тогтооно гэж ойлгоно.

2.8. Хуулийн 29 дүгээр зүйлийн 2-т заасан “нийгмийн даатгалын байгууллагын ажилтны алдаагаар буруу олгогдсон тэтгэвэр, тэтгэмж” гэж нийгмийн даатгалын байгууллагын ажилтан албан үүрэгтээ хайнга хандсанаас шалтгаалан тэтгэвэр, тэтгэмж үндэслэлгүйгээр илүү тогтоогдсон, эсхүл тогтоогдсон

хэмжээнээс илүү олгогдсон байхыг хэлнэ.

Тэтгэвэр, тэтгэмж үндэслэлгүйгээр илүү тогтоогдсон тохиолдолд нийгмийн даатгалын байгууллага тэтгэвэр тэтгэмж буруу тогтоосон шийдвэрийг Нийгмийн даатгалын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6-д заасны дагуу хүчингүй болгож, тэтгэвэр авагчид илүү олгогдсон төлбөрийг буруутай албан тушаалтнаар төлүүлнэ.

Мөн тэтгэвэр, тэтгэмжийг тогтоогдсон хэмжээнээс илүү олгосонд нийгмийн даатгалын байгууллагын ажилтан гэм буруутай нь тогтоогдвол түүнээс нөхөн гаргуулна.

Харин нийгмийн даатгалын байгууллагын ажилтны алдаагаар тэтгэвэр, тэтгэмж дутуу тогтоогдсон, эсхүл дутуу олгогдсон тохиолдолд энэ зүйлийн зохицуулалт хамаарахгүй ба тэтгэвэр авагчид учирсан хохирлын асуудлыг Иргэний хуулийн 52 дугаар бүлэгт заасны дагуу шийдвэрлэнэ.

Гурав.Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль

3.1.Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн /цаашид хууль гэх/ 2 дугаар зүйлийг дараах байдлаар тайлбарласугай.

3.1.1.Хуулийн 2 дугаар зүйлийн 1-д заасан “**Даатгуулагч...**” гэж энэ зүйл, хэсэг болон Нийгмийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1-д тодорхойлсон болзол, шаардлагыг хангасан, ажил хөдөлмөр эрхлээгүй хүнийг хэлнэ.

Мөн зүйл, хэсэгт заасан “**...ажилгүйдлийн тэтгэмж...**” гэдэгт ажилгүй болохоосоо өмнө ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг энэ хуульд

заасан болзол, журмын дагуу төлсөн ажилгүй хүнд нийгмийн даатгалын сангаас амьжиргааны эх үүсвэр болгож, эргэж төлөгдөх нөхцөлгүйгээр олгох мөнгөн хөрөнгийг ойлгоно.

3.1.2. Ажилгүйдлийн тэтгэмжийг хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан болзол, шаардлагыг хангасан, хөдөлмөрийн насны, ажил хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөр эрхлэлтийн алба, уг алба байхгүй бол нийгмийн даатгалын байгууллагад бүртгүүлсэн хүнд олгоно.

3.2.Хуулийн 5 дугаар зүйлд заасан “**тооцоо хийж дууссанаас хойш 14 хоногийн дотор**” гэдгийг Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлд зааснаар ажилтан ажлаа хүлээлгэн өгч, ажил олгогчоос хөдөлмөрийн гэрээ цуцалсан тухай шийдвэр, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын дэвтэр, хуульд заасан бол ажлаас халагдсаны тэтгэмж авснаас хойш 14 хоногийн хугацаанд гэж ойлгоно.

Ажилтнаас хамаарахгүй шалтгаанаар ажил олгогчтой тооцоо хийх хугацаа хойшилсон явдал энэ зүйлд заасан хугацааг хэтрүүлсэн гэж үзэх үндэслэл болохгүй.

Мөн зүйлд “**оршин суугаа нутаг дэвсгэрийнхээ хөдөлмөр эрхлэлтийн алба, угбиржбайхгүйболнийгмийн даатгалын байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй**” гэж заасан тул ажилгүйдлийн тэтгэмж авах, мэргэжлийн сургалтад хамрагдах эрх ажлаас халагдсан даатгуулагч нийгмийн даатгалын байгууллагад бүртгүүлснээр үүсэх бөгөөд энэхүү үүргээ биелүүлээгүй даатгуулагч ажилгүйдлийн тэтгэмж авах, мэргэжлийн сургалтад хамрагдахыг шаардах эрхгүй.

3.3.Хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4-т зааснаар “**хорих ял эдлүүлэх тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон**” нь даатгуулагчид

олгож байгаа ажилгүйдлийн тэтгэмжийг зогсоох үндэслэл болох бөгөөд энэ нь тэтгэвэр, тэтгэмж үргэлжлүүлэн авах ялтны эрхийн талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 115 дугаар зүйлийн 115.1.8.-д заасан зохицуулалтад хамааралгүй болно.

Дөрөв.Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль

4.1. Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн /цаашид хууль гэх/ 4 дүгээр зүйлийн 4.1.-д “**Иргэний эрүүл мэндийн даатгал нь төр, иргэн, хуулийн этгээдээс хуульд заасан журмын дагуу даатгалын шимтгэл төлж, даатгалын санг урьдчилан бүрдүүлэх, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний зардлын уг сангаас төлөх нийгэм, эдийн засгийн арга хэмжээ мөн**” гэж заасны дагуу эрүүл мэндийн даатгал төлсөн даатгуулагчаас амбулаторид үзүүлэх, эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх зэрэг үйлчилгээнд Эрүүл мэндийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.-т зааснаас бусад тохиолдолд төлбөр авах эрх зүйн үндэслэлгүй гэж үзнэ.

4.2.Хуулийн6дугаарзүйлийн 6.1.5.-д заасан “**тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй**” болох нь татварын байгууллага болон оршин суугаа газрын баг, хорооны Засаг даргын тодорхойлолтоор тогтоогдсон байвал зохино.

5.Энэтөгтоолбатлагдсантай холбогдуулан Монгол Улсын Дээд шүүхийн 2007 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 21, 2007 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 22, 2007 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 23 дугаар тогтоолуудыг хүчингүй болсонд тооцсугай.

ТАНХИМЫН
ТЭРГҮҮН Д.БАТСАЙХАН
ШҮҮГЧ Л.БЯМБАА

**“Хууль дээдлэх ёс” СЭТГҮҮЛ
НИЙТЛЭЛИЙН ЖАГСААЛТ /2008 он/**

№	Сэдвийн нэр	Зохиогчийн нэр, эрхэлсэн ажил	Нийтлэгдсэн дугаар
1.	“Эрх зүйт төр-Хууль ёсны хэрэгжилт” Үндэсний зөвлөгөөнд Монгол Улсын ерөнхийлөгч Н.Энхбаярын хэлсэн үг	Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр	2008 он №1(20)
2.	“Хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын үр нөлөөг дээшлүүлэх нь” “Эрх зүйт төр-Хууль ёсны хэрэгжилт” Үндэсний зөвлөгөөнд Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Мөнх-Оргилын тавьсан илтгэл	Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Мөнх-Оргил	2008 он №1(20)
Төрийн байгуулалтын хууль тогтоомж			
1.	Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай	Б.Нармандах /Цагдаагийн дээд сургуулийн багш, докторант/	2008 он №1(20)
2.	Золиослох сэтгэлгээ	Э.Лхагвасүрэн /Үндсэн хуулийн цэцийн ажилтан/	2008 он №1(20)
3.	Монгол Улс дахь хууль тогтоох үйл ажиллагаа ба хууль тогтоомжийн шинэтгэл	Б.Чимид /ХЗҮТ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга доктор, профессор, гавъяат хуульч/	2008 он №2 (21)
4.	Хууль тогтоох үйл ажиллагаа ба Үндсэн хуулийн хяналт	Ж.Амарсанаа /Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн, ХЗҮТ-ийн захирал, гавъяат хуульч, академич/	2008 он №2 (21)
5.	Үндсэн хуульд Ашигт малтмалын тухай хуулийг нийцүүлэх асуудалд	Д.Батболд /МУИС-Хууль зүйн сургуулийн Төр захиргааны эрх зүйн тэнхимийн багш, докторант/	2008 он №2 (21)
6.	Үндсэн хуулийн эрх зүйн гэрээ Үндсэн хуулийн эрх зүйн эх сурвалж болох нь	С.Эрдэнэболор, Н.Эрдэнэбаяр /Отгонтэнгэр их сургуулийн хууль зүйн сургуулийн Олон улсын эрх зүйн тэнхимийн багш/	2008 он №2 (21)
7.	Эрх чөлөө-Эрх зүйн үнэт зүйл болох нь	Х.Сэлэнгэ /МУИС-ийн ХЗС-ийн багш, проф. (Ph.D)/	2008 он №2 (21)
8.	Засаг даргын дэргэдэх агентлагууд болон тамгын газрын хэлтсийн дүрмийн харьцуулсан судалгаа	Д.Батболд /МУИС-Хууль зүйн сургуулийн Төр, захиргааны эрх зүйн тэнхимийн багш, докторант/	2008 он №2 (21)

9.	Монгол Улс дахь хууль тогтоох үйл ажиллагаа ба хууль тогтоомжийн шинэтгэл	Б.Чимид /ХЗҮТ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор, профессор, Ардын багш, гавъяат хуульч/	2008 он №3 (22)
10.	Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа ба хүний эрх	С.Жанцан /Цагдаагийн академийн Эрүүгийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор/	2008 он №3 (22)
11.	Засаг даргын дэргэдэх агентлаг болон тамгын газрын хэлтсийн дүрмийн харьцуулсан судалгаа	Д.Батболд /МУИС-Хууль зүйн сургуулийн Төр, захиргааны эрх зүйн тэнхимийн багш, докторант/	2008 он №3 (22)
12.	Монгол Улсын их хурлын хууль тогтоох үйл ажиллагаа	Ц.Шаравдорж /УИХ-ын Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн дарга/	2008 он №3 (22)
13.	Чингис Монголын нэгдсэн Улс байгуулахын төлөө тэмцэлд тагнуулийн үйл ажиллагааг ашигласан нь	М.Цогтоо /ТЕГ-ын дээд суруулийн Гүйцэтгэх ажлын тэнхимийн эрхлэгч/	2008 он №4 (23)
14.	Хэвлэл мэдээллийн эрх чөлөө	Д.Золжаргал /Докторант, Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтсийн мөрдөн байцаагч, комиссар/	2008 он №4 (23)
15.	Төрийн албан дахь ашиг сонирхлын зөрчлийн эрх зүйн зохицуулалт	П.Өнөрмаа /Засаглалыг дэмжих төсөл"-ийн зөвлөх/	2008 он №4 (23)
Иргэний хууль тогтоомж			
1.	Хувь хүний нэр төр, алдар хүндийг хамгаалж хүндлэх асуудлын мөн чанар	Ш.Сүхбаатар /МУИС-ийн докторант/	2008 он №1(20)
2.	Хөршийн эрх	Н.Баярмаа /Хууль зүйн магистр/	2008 он №1(20)
3.	Гэрээний стандарт нөхцөл	Ш.Хишигсүрэн /ХЗҮТ-ийн Иргэний хууль тогтоомжийн секторын эрдэм шинжилгээний ажилтан/	2008 он №2 (21)
4.	Нотариатын үүсэл хөгжил, тогтолцоо	Х.Цогзолмаа /Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш/	2008 он №3 (22)
5.	Монгол Улсын иргэний хууль дахь эзэмшлийн талаархи зохицуулалт, зөрчилдөөнт байдал	А.Дэлгэрмаа /Хууль зүйн магистр/	2008 он №3 (22)
6.	Шүүхийн журмаар гэрлэлт цуцлах нь гэрлэлт дуусгавар болох нөхцөл мөн	О.Отгонтуяа /ХЗҮТ-ийн Иргэний хууль тогтоомжийн секторын ЭША, хууль зүйн магистр/	2008 он №3 (22)
7.	Гэр бүлийн эрх зүйн зарим төрлийн харилцаа	О.Отгонтуяа /ХЗҮТ-ийн Иргэний хууль тогтоомжийн секторын ЭША, магистр/	2008 он №4 (23)

8.	Хөдөлмөрийн тухай хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэх зарим асуудал	С.Боловсон /ОХУ-ын Эрхүү мужийн Байгалийн эдийн засаг, эрх зүйн Улсын их сургуулийн аспирант/	2008 он №4 (23)
9.	Монголын Үнэт цаасны зах зээлийн төлөвшил, тулгамдсан асуудал	Д.Дүгэржав /Санхүүгийн зохицуулах хорооны гишүүн, дэд дарга/	2008 он №4 (23)
10.	Банкны эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал	Г.Банзрагч (Ph.D), МУИС-ийн ХЗС-ийн Төр, захиргааны эрх зүйн тэнхимийн багш, ХЗҮТ-ийн сургалтын төвийн эрхлэгч	2008 он №4 (23)
11.	Иргэний эрх зүй дэх иргэн хуулийн этгээдийн эрх зүйн хамгаалалт	С.Цэнд /Хан-Уул дүүргийн нотариатч/	2008 он №4 (23)
12.	Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын түүхэн уламжлал	Цагдаагийн академийн магистрант Ц.Мөнхзул	2008 он №4 (23)
13.	Өрсөлдөөний эрх зүйн дэх картелийн асуудал түүнтэй тэмцэх арга зам	Шихихутуг ХЗДС-ийн багш, С.Батбуян /Хууль зүйн магистр/	2008 он №4 (23)
Шүүх эрх мэдэл			
1.	Шүүхийн жишгийг ашиглах нь	Танабэ Масанори /Өмгөөлөгч Япон/	2008 он №1(20)
2.	Гомдлыг урьдчилан шийдвэрлэх хүрээнд Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэх эрх нээгдэх нөхцөлийг үнэлэх асуудал	Б.Эрдэнэхуяг /МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутан/	2008 он №1(20)
3.	Иргэнийнэртөрийгхамгаалахтай холбоотой эрх зүйн зохицуулалт, түүнийг шүүх хэрглэж буй байдал	Б.Мэргэн /МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутан/	2008 он №1(20)
4.	Дүүргийн зарим шүүхийн хэргийн хөдөлгөөнд хийсэн судалгааны үр дүн	Н.Дагва /Нийслэлийн шүүхийн Тамгын хэлтсийн дарга/, Д.Уран /"Шүүх эрх мэдлийн шинэтгэл" төслийн ажилтан/	2008 он №2 (21)

Олон улсын эрх зүй, харьцуулсан эрх зүй

1.	Гадаад орнуудын Иргэний эрх зүй болон иргэний хууль тогтоомж дахь "Эзэмшил"-ийн талаарх эрх зүйн зохицуулалт	А.Дэлгэрмаа /МУИС-ийн Хууль зүйн сургуулийн магистрант/	2008 он №1(20)
2.	АНУ-ын эрүүгийн эрх зүйд гэмт хэргийн тухай ойлголтыг авч үзсэн нь	Ц.Доржняма /ТЕГ-ын дээд сургуулийн ахлах багш, докторант/	2008 он №1(20)
3.	Гадаад орнууд дахь гадаадын хөрөнгө оруулалтын төлөв байдал, эрх зүйн зохицуулалт	Ж.Соёлмаа /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан /	2008 он №1(20)
14.	БНСУ-ын Үндсэн хуулийн шүүхийн арга ажиллагаа ба процесс	Сон Ин Хёг /Үндсэн хуулийн шүүхийн судлаач/	2008 он №2 (21)
15.	Тагнуулын үйл ажиллагаанд тавих хяналт, түүний эрх зүйн зохицуулалт	Л.Батдолгор /Тагнуулын ерөнхий газрын дээд сургуулийн Судалгаа, эрдэм шинжилгээний төвийн ахлах судлаач/	2008 он №2 (21)
16.	Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэлтийн талаар зарим улсын хууль тогтоомжийн харьцуулсан судалгаа	Т.Жаргалсайхан /ХЗҮТ-ийн Криминологийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан	2008 он №2 (21)
17.	Худалдааны зохицуулалт ба хүний эрхийн олон улсын эрх зүйд эзлэх байр суурь	П.Баяр /ХЗҮТ-ийн Олон улсын эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан/	2008 он №2 (21)
18.	Монгол Улс ба ХБНГУ дахь хөршийн нөлөөллийн эсрэг иргэний эрх зүйн хамгаалалт харьцуулсан судалгаа	Э.Байгал /МУИС-ийн ХЗС-ийн Олон улсын эрх зүйн тэнхимийн багш, хууль зүйн магистр/	2008 он №2 (21)
19.	Герман улсын захиргааны шүүхийн хөгжлийн тухай тойм	Г.Банзрагч /МУИС-ийн ХЗС-ийн Төр, захиргааны эрх зүйн тэнхимийн багш, доктор (PhD)	2008 он №3 (22)
20.	БНСУ-ын Үндэсний их хурлын хууль тогтоох ажиллагаа	Сун Су Ми /БНСУ-ын Үндэсний их хурлын хууль зүйн албаны хуульч/	2008 он №3 (22)
21.	БНСУ-ын хууль зүйн мэдээлэл, түүний удирдлага	Сон Хи Ду /БНСУ-ын Хууль тогтоомжийн хүрээлэнгийн хууль зүйн солилцоо, хамтын ажиллагааг дэмжих төвийн захирал/	2008 он №3 (22)
22.	БНСУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа ба хүний эрх	Ли Хю Вон /Сөүлийн их сургуулийн хууль зүйн сургуулийн доктор/	2008 он №3 (22)

23.	Гадаадын иргэдийн ангилал, тэдгээрийн эрх зүйн байдлыг тодорхойлсон нэр томъёоны тухайд	Н.Мөнхтуяа /ХЗҮТ-ийн Олон улсын эрх зүйн секторын эрдэм шинжилгээний дэд ажилтан/	2008 он №3 (22)
24.	Солонгосын санхүүгийн эрх зүйн чиг хандлага болон тулгамдсан асуудал	Жон Чан Хён /Корё их сургуулийн профессор/	2008 он №4 (23)
25.	ОХУ-ын банкны үйл ажиллагааны эрүүгийн эрх зүйн хамгаалалтын онцлог	Гармаев Юрий Петрович /Буриадын Улсын их сургуулийн хууль зүйн факультетийн эрүү болон эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн тэнхимийн эрхлэгч/	2008 он №4 (23)
26.	Эрх зүйн шинэтгэл туслалцаа төслийн хэрэгжилт, үр дүн	Ийзүка Миха /Эрх зүйн шинэтгэл туслалцаа төслийн удирдагч/	2008 он №4 (23)
Криминологи			
1.	Монгол Улс дахь 2007 оны гэмт хэргийн нөхцөл байдал	П.Ихзаяа/ЦЕГ-ын мэдээлэл, судалгааны төвийн дарга, цагдаагийн хурандаа/	2008 он №1 (20)
2.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх онол, арга зүйн зарим асуудал	Л.Цэрэнлхам /НЦГ-ын Олон нийтийн харилцааны хэлтсийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тасгийн ахлах байцаагч, цагдаагийн хошууч, магистрант/	2008 он №1(20)
3.	Шинэ төрлийн зарим гэмт хэргийн шалтгаан, нөхцөл	Г.Оюунболд /ХЗҮТ-ийн Криминологийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан, хууль зүйн магистр/	2008 он №1(20)
4.	Монгол Улсын эрүүгийн эрх зүйн эх сурвалжийн асуудалд	Г.Гантөмөр /ОХУ-ын ДЯЯ-ны Их сургуулийн докторант, цагдаагийн дэд хурандаа/	2008 он №1(20)
5.	Эрх зүйч мэргэжилтнийг бэлтгэх стандарт ба "Криминалистикийн хичээл"	Б.Жаргалсайхан /НЦГ-ын Эрэлч нохойн алба, үнэрийн лабораторийн эрхлэгч /	2008 он №1(20)
6.	Эрүүгийн эрх зүй дэх давтан гэмт хэргийг авч үзэх нь	С.Энхцэцэг /МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутан/	2008 он №1(20)
7.	Прокурорын байр сууриас Криминологийн асуудалд хандах нь	Ц.Мөнхбат/Сүхбаатар аймгийн прокурор, Хууль цаазын итгэмжит зөвлөх, МУИС-ийн докторант/	2008 он №1(20)

8.	Компьютер, мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн криминологийн зарим асуудал	Д.Золжаргал /Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөн байцаагч, комиссар, докторант, Г.Оюунболд /ХЗҮТ-ийн Криминологийн секторын эрдэм шинжилгээний ажилтан/	2008 он №2 (21)
9.	Виртуал гэмт хэрэг	Ц.Хүрэл-Очир /МУИС-ийн Хууль зүйн сургуулийн эрх зүй, төрийн онол, түүхийн тэнхимийн ахлах багш/	2008 он №2 (21)
10.	Торгох ялын хэрэгжилтэнд анхаарах зарим асуудал	Ц.Ариунболд /Улсын Ерөнхий прокурорын туслах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга/	2008 он №2 (21)
11.	Нийгмийн хяналтын онол	Б.Одонгэрэл /ХЗҮТ-ийн Криминологийн судалгааны секторын Эрдэм шинжилгээний дэд ажилтан/	2008 он №2 (21)
12.	Гадаадын зарим орны шүүхийн шинжилгээний байгууллагын зохион байгуулалт, үйл ажиллагаа	Г.Оюунболд /ХЗҮТ-ийн Криминологийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан, хууль зүйн магистр/	2008 он №3 (22)
13.	Олон улсын эрүүгийн шүүхийн дүрмийг монгол улсын эрүүгийн байцаан шийтгэх хуультай харьцуулахад	Б.Одонгэрэл /ХЗҮТ-ийн криминологийн судалгааны секторын эрдэм шинжилгээний дэд ажилтан, хууль зүйн магистр/	2008 он №3 (22)
14.	Хуулийн этгээдэд эрүүгийн эрх зүйн шинжтэй арга хэмжээг хэрэглэх нь	Б.Одонгэрэл /ХЗҮТ-ийн криминологийн судалгааны секторын эрдэм шинжилгээний дэд ажилтан, хууль зүйн магистр/	2008 он №4 (23)
15.	Онц байдал, түүний эргэн тойронд	Г.Оюунболд /ХЗҮТ-ийн Криминологийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан, хууль зүйн магистр/	2008 он №4 (23)
16.	Хүн худалдаалах гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байдал	Нийслэлийн шүүхийн шүүгч Ц.Сарантуяа	2008 он №4 (23)
Шүүхийн шийдвэр гүйцэтгэл			
1.	Ял ногдуулах нийтлэг зарчим, түүний хэрэгжилт	Д.Батжаргал /Цагдаагийн академийн магистрант, цагдаагийн ахмад /	2008 он №1(20)
Эрх зүйн үйлчилгээ			
1.	Консулын Нотариатын үйлдэл хийх үүрэг	В.Оюумаа /МУИС-ийн ХЗС-ийн Олон улсын эрх зүйн тэнхимийн ахлах багш/	2008 он №2 (21)

2.	Яагаад зарим хэлцлийг нотариат гэрчлэх ёстой вэ?	Д.Янжинхорлоо /МУИС-ийн ХЗС-ийн ахлах багш/	2008 он №2 (21)
3.	Нотариатын үйлчилгээний хөлс, тариф нь иргэдэд төлбөр, хураамжийн дарамт болоогүй	Е.Гульжан /Нийслэлийн Баянзүрх дүүргийн нотариатч/	2008 он №2 (21)
4.	Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь өмгөөлөх, өмгөөлүүлэх эрх	Ц.Батцэрэн /Нийслэлийн шүүхийн шүүгч/	2008 он №4 (23)
5.	Нотариатаар гэрээг гэрчлүүлэх хууль зүйн ач холбогдол	Хуульч Ч.Баянжаргал	2008 он №4 (23)

Монгол Улсын Дээд шүүхийн тогтоол

1.	Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай	Монгол Улсын дээд шүүхийн тогтоол, 2008 оны 2 дугаар сарын 28-ны өдөр, Дугаар 9	2008 он №1(20)
2.	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай	Монгол Улсын дээд шүүхийн тогтоол, 2008 оны 3 дугаар сарын 7-ны өдөр, Дугаар 11	2008 он №1(20)
3.	Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн улсын бүртгэлийн тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай	Монгол Улсын дээд шүүхийн тогтоол, 2008 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр, дугаар 45/	2008 он №4(23)
4.	Нийгмийн даатгалын харилцааг зохицуулсан хуулиудын зарим зүйл заалтыг тайлбарлах тухай/	Монгол Улсын дээд шүүхийн тогтоол, 2008 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр, дугаар 47	2008 он №4(23)

Монголын Өмгөөлөгчдийн холбооны 80 жилийн ойд

1.	Энэрэнгүй үйлстний байгууллага	Д.Тогтохжаргал / Өмгөөлөгчдийн холбооны гишүүн, Хүндэт өмгөөлөгч/	2008 он №1 (20)
2.	Өмгөөлөгчдийн коллеги байгуулагдаж хөгжсөн нь	Д.Тогтохжаргал / Өмгөөлөгчдийн холбооны гишүүн, Хүндэт өмгөөлөгч/	2008 он №2 (21)

JICA

1.	ЖАЙКА-гийн "Эрх зүйн шинэтгэл, туслалцаа төсөл"-ийн товч тайлан	Ийзүка Мйха	2008 он №2 (21)
----	--	-------------	--------------------

ШИНЭ НОМ



МОНГОЛ УЛСЫН
МЭДЭЭЛЭХ ЭРХНИЙН ХАМТ



МОНГОЛ УЛСЫН
МЭДЭЭЛЭХ ЭРХНИЙН ХАМТ



Хууль зүйн үндэсний төвөөс "Иргэн таны хуулийн лавлах" хуулийн эмхтгэлийг эрхлэн гаргалаа. Уг эмхтгэлд "Иргэний бүртгэлийн тухай", "Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай", "Гэр бүлийн тухай", "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай", "Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай", "Газрын төлбөрийн тухай", "Газрын тухай" гэх мэт иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд ач холбогдолтой нийт 33 хуулийг нэмэлт өөрчлөлтийн хамт оруулсан байна.

Энэхүү номыг худалдан авах хүсэлтэй хүмүүс 319144 /номын худалдаа/ утсаар холбоо барина уу.





“МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ” 4 БОТЬ ХЭВЛЭГДЭН ГАРЛАА.

Энэхүү 4 ботид Монгол Улсын Хууль зүйн үндэсний төв мөрдөгдөж буй бүх хуулийг 2008 оны 5 дугаар сарын 30-ны байдлаар Монгол Улсын хуулийн тусгай зөвшөөрлийг нь тусган эмхтгэн орууллаа. Монгол Улсын хуулийн 4 ботид хялбар, цаашил нэмэлт, өөрчлөлтийг оруулан сольж болохуйц судалгаа, хялбар, цаашил нэмэлт, өөрчлөлтийг хатуу хавтастайгаар хэвлэсэн болно. Дээрхи 4 ботид цаашил нэмэлт, өөрчлөлтийг хатуу хавтастайгаар хэвлэсэн болно. захиалгын дагуу түгээх болно. (Хууль зүйн үндэсний төв 1 багц болно.)



БИЗНЕСИЙН ХОЛБОГДОЛТОЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ МОНГОЛ, АНГЛИ ХЭЛЭЭР 2 БОТИОР ХЭВЛЭГДЭН ГАРЛАА.

Бизнесийн үйл ажиллагаа эрхлэгч хэн бүхний гол хэрэглэгдэхүүн болох бизнесийн холбогдолтой Монгол Улсын 70 хуулийг эмхтгэн монгол, англи хэлээр 2 ботиор хэвлэн гаргалаа.

Энэхүү 2 ботийг хэрэглэхэд хялбар, сугалбар хуудас, төмөр цоожлогч бүхий хатуу хавтастайгаар хэвлэсэн болно.

Үнэ: 1. Бизнесийн холбогдолтой Монгол Улсын хууль (монгол хэлээр) 28.000 төг
2. Business Laws of Mongolia 45.000 төг

Та эдгээр хуулийн эмхтгэлийг худалдан авахыг хүсвэл доорх хаяг, утсаар хандана уу.

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Сүхбаатарын талбай 7,
Хууль зүйн үндэсний төв Утас: 317494, 315735, 88007557, Факс: 315735